# ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ



# АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР
# АСУУЛТ ХАРИУЛТ

## НЭГДҮГЭЭР БОТЬ

# АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР

## *Асуулт Хариулт 1*

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн

Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани

# АГУУЛГА

1. ХАЙР ЭНЭРЛИЙН ЗАМНАЛ
Эдүгээ цагийн Төгс Гэгээрсэн Их Багшийн амьдралын зам мөр ....5

2. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
АНУ, Калифорни муж, Сан Франциско, Холидэй Инн. 1989 оны 5 дугаар сарын 24 ....8

3. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
АНУ, Калифорни муж, Сан Франциско, Холидэй Инн. 1989 оны 5 дугаар сарын 25 .... 24

4. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
АНУ, Калифорни муж, Сан Хосе, Эвэргрийн Олон нийтийн төв. 1989 оны 5 дугаар сарын 27 ....40

5. Багшийн лекцийн асуулт, хариулт
АНУ, Калифорни муж, Сан Хосе, Эвэргрийн Олон нийтийн төв. 1989 оны 5 дугаар сарын 28. ....58

6. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
Коста Рика, Сан Хосе, Архитекторуудын Нийгэмлэг. 1989 оны 6 дугаар сарын 8 ....73

7. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
Коста Рика, Сан Хосе, Архитекторуудын Нийгэмлэг. 1989 оны 6 дугаар сарын 9 ....81

8. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
Бразил улс, Сан-Паулу хот, Японы Соёлын Нийгэмлэг. 1989 оны 6 дугаар сарын 15 ....89

9. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
Бразил улс, Сан-Паулу хот, Японы Соёлын Нийгэмлэг. 1989 оны 6 дугаар сарын 16 ....94

10. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
Бразил улс, Сан-Паулу хот, Японы Соёлын Нийгэмлэг. 1989 оны 6 дугаар сарын 17 ....101

11. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
Бразил улс, Сан-Паулу хот, Японы Соёлын Нийгэмлэг. 1989 оны 6 дугаар сарын 18 ....106

12. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
Малайз улс, Пенан, Хятад хорооллын өргөө. 1989 оны 10 дугаар сарын 1 ....113

13. Их Багшийн лекцийн асуулт, хариулт
Малайз улс, Пенан, Хятад хорооллын өргөө. 1989 оны 10 дугаар сарын 2 ....126

АВШИГ ХҮРТЭХҮЙ - АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА ....154
ҮГИЙН ХЭЛХЭЭС....157
НОМ ХЭВЛЭЛ....164
БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ? ....170

# ТОВЧ ИЛГЭЭЛТ

Оройн Дээд Бурхан болоод Хамгийн Дээд Сүнсний тухай ярихдаа Их Багш Бурхан эр, эсвэл эм хүйстэй алин болох тухай гарч болзошгүй маргаанаас зайлсхийж, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүйсийн ялгаа заадаггүй нэр томъёог хэрэглэдэг билээ.

She + He = Hes (Bless гэдэгтэй адил дуудна)

Her + Him = Hirm (Firm гэдэгтэй адил дуудна)

Hers + His = Hiers (Dear гэдэгтэй адил дуудна)

Жишээлбэл: Бурхан хүсвэл Тэрээр (Hes) юмыг Өөрийн (Hirmself) таалалд нийцүүлж, Түүний (Hiers) хүсэл зоригийн дагуу зохицуулдаг.

Уран бүтээлч, бурханлаг багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дотоод гоо сайхны аливаа илэрхийлэлд дуртай. Тиймээс ч Тэрбээр Вьетнамыг "Ау Лак", Тайванийг "Формоса" хэмээн нэрлэдэг. Ау Лак гэдэг нь "Аз жаргал" гэсэн утгатай Вьетнам орны эртний нэр юм. "Үзэсгэлэнтэй" гэсэн утгатай Формоса хэмээх нэр энэ арлын орон болон хүн ардынх нь гоо сайхныг илүү төгс төгөлдөр илэрхийлдэг. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэ нэрсийг хэрэглэх нь нутаг орон хийгээд оршин суугчдад нь сүнслэг хөгжил дэвшил, аз хийморь авчирна гэж үздэг юм.

*“Би Буддын болон Католик шашинтны аль нь ч биш. Би үнэнд харьяалагдаж, Үнэнийг л номлодог. Та үүнийг Буддын шашин, Католик шашин, Бумбын шашин гэх юмуу, аль хүссэнээрээ л нэрлэ. Би бүгдийг нь дуртайяа хүлээн авна!”*

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай~

*“Дотоодын амар амарлингуйгаа олж авснаар бид бусад бүх зүйлийг олж авна. Сэтгэлийн бүрэн ханамж, тэнгэрлиг диваажин болоод газар дэлхийн хүсэл бүхэн биелэх нь бидний мөнхийн нийцэл зохирол, мөнхийн билгүүн ухаан, хамгийг чадагч хүчний дотоод ухаарахуй болох Оройн Дээд Бурханы Орноос ирдэг юм. Энэ бүхнээ эс олвоос бид хичнээн их мөнгө хөрөнгө, эрх мэдэлтэй, нийгэмд хичнээн өндөр дээд байр суурьтай байлаа ч хэзээ ч сэтгэл хангалуун болж чадахгүй.”*

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай~

*“Сургаал маань та энэ дэлхий дээр юу л хийх ёстой байна, түүнийгээ хий. Хамаг зүрх сэтгэлийнхээ угаас хий. Хариуцлагатай байж, үүнийхээ зэрэгцээ өдөр бүр бясалгал хий гэдэгт оршино. Та өөртөө болон дэлхийд үйлчлэхийн тулд улам их эрдэм мэдлэг, улам их билгүүн ухаан, улам их амар амарлингуйг олж авна. Таны дотор өөрийн тань сайн сайхан чанар оршин буйг бүү март. Бие махбодод тань Оройн Дээд Бурхан оршин буйг бүү март. Зүрх сэтгэлд тань Будда оршин буйг бүү март.”*

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай~

# Хайр энэрлийн замнал

## Эдүгээ цагийн Төгс Гэгээрсэн Их Багшийн амьдралын зам мөр

Хорвоогийн өнцөг булан бүхний
Хамаг амьтанд зориулах гэж
Дэндүү жаахан хайрыг
Дэндүү жаахан хайрыг
Дээгүүр доогуур, хаа сайгүй
Эрэн хайнам, бид.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол арьс өнгө, үндэс угсааны бүхий л саад хязгаарыг даван хүн төрөлхтөнд асрал энэрэл, хайраа зориулдаг дэлхий даяар нэр алдар нь түгсэн хүмүүнлэг үйлстэн, байгаль орчныг хамгаалагч, зохиолч, уран бүтээлч, уран зураач, загвар зохион бүтээгч, хөгжимчин, кино найруулагч, оюун санааны багш билээ. Тэрбээр тэртээх 1980-аад оны эхэн үеэс байгаль орчныг хамгаалах, биологийн төрөл зүйлүүдийг хамгаалах, ойжуулах, байгаль орчинд ээлтэй амьдрах, нэн ялангуяа уур амьсгалын хямралыг хамгийн хурдан бөгөөд үр дүнтэй шийдвэрлэх арга зам болох органик веган хоолны дэглэмийг таниулан сурталчилсаар ирсэн манай дэлхийн хамгийн үнэнч шударга, экологийн анхдагчийн нэг юм.

Их Багш уур амьсгалын өөрчлөлтийн хор хөнөөлтэй үр нөлөө болон түүний веган шийдлийг дэлхий дахинд ухааруулан сэнхрүүлэхэд цаг хугацаа, нөөц боломжоо шантралгүй зориулдаг бөгөөд 2006 оноос 2008 он хүртэл *“Өөрөөр амьдарцгаая”* болон “SOS – Дэлхийн дулаарал”-ын ухуулан сэнхрүүлэх арга хэмжээнүүдийг эхлүүлсэн ажээ. Түүнчлэн мэдээний сэтгүүл, ном зохиол туурвидаг бөгөөд 2005 онд *“Жинхэнэ Баатрууд”* хэмээх ургамал хоолны баримтат кино*, “Хаан ба Харьяатууд”* телевизийн олон ангит кино бүтээлээ гаргаж, Суприм Мастер Телевизийн сувгаараа толилуулсан юм. Суприм Мастер Телевиз нь уур амьсгалын өөрчлөлт, веган хооллолтын тухай болон соён гэгээрлийн олон сэдэв чиглэлээр нэвтрүүлэг, мэдээ, мэдээллүүдийг дэлхий дахинаа 7 хоногийн 24 цагийн турш тасралтгүй түгээдэг сансрын хиймэл дагуулын суваг билээ. Түүнчлэн 2007 оноос хойш дэлхийн 13 улс оронд уур амьсгалын өөрчлөлтийн сэдвээр 27 гаруй бага хурлыг сансрын хиймэл дагуулын ТВ суваг болон радиогоор шууд дамжуулан хийж, хүрээлэн буй орчны шинжээч мэргэжилтнүүд, төр засгийн удирдагч, эрхэм хүндэт зочид хийгээд иргэдтэй мэдлэг, мэдээллээ хуваалцжээ.

Энэ бүх хүчин чармайлтын үрээр Түүний “Гараг дэлхийгээ аврахын тулд Веган байж, Байгаль орчноо хамгаалъя!” болон “Веган байж, Энхтайванг цогцлооё!” хэмээх уриа дэлхий дахинаа түгэн тархаж, байгаль дэлхийдээ ээлтэй, ургамал хоолоолтын эрүүл хэв маягаар амьдрах урам зоригоор хүн төрөлхтнийг тэтгэж, ингэснээрээ энх тайван, эв зохирлыг улам өндөр төвшинд биелэл болгож байгаа билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гайхамшигтай үлгэр дууриалал нь хүн төрөлхтөнд Бурханы бүхий л бүтээлд асрал хайрын сэтгэлээр хандаж, хүмүүний дотоод сайн сайхан чанараараа амьдрахыг хүн төрөлхтөнд сануулж байдаг билээ. Түүний оюун санааны гэгээрлийн гүн гүнзгий мэдлэг нь хүмүүний зовлон зүдүүр, нийгмийн тэмцэл зөрчилдөөн, байгаль орчны доройтлын үндсэн шалтгаан нь хүмүүс бусад төрөлтнөө, тэр дундаа гэм зэмгүй анд найз-амьтдыг хүчирхийлдэгт оршиж байгааг олж тогтоох боломж олгожээ. Иймээс Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай тэрхүү сул дорой, дуу хоолойгоо өргөж чадахгүй амьтдыг энэрэн нигүүлсэх сэтгэлээр “Шувууд миний амьдралд”, “Миний амьдрал дахь нохол”, “Эрхэм ариун амьтад” хэмээх зохиолуудыг бичсэн нь олон улсад шилдэг борлуулалттай ном зохиол болсон билээ. Дэлхийн олон хэлээр хөрвүүлэгдсэн энэхүү нандин уран зохиолууд нь бидэнтэй зэрэгцэн оршдог эрхэм нандин амьтдын гүн гүнзгий бодол санаа, мэдрэмжийг нээн дүрслэхдээ тэдний бурханлаг мөн чанар, хариу нэхдэггүй хайрын сэтгэлийг онцлон илэрхийлсэн байдаг.

## *Амьдралын эхэн үе*

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай төв Ау Лак (Вьетнам) нутагт мэндэлсэн бөгөөд хожим нь Европт боловсрол эзэмшиж, тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажиллажээ. Тэрбээр дэлхийн аль ч газар зовлон зүдүүр ялгаагүй байдгийг удалгүй ухаарч, үүнээс гэтлэн гарах арга замыг эрж олохыг амьдралынхаа эрхэм зорилго болгожээ. Ийнхүү оюун санааны гэгээрлийг хайх аянд гарч, Хималайн уулсад дотоодын Гэрэл болон Аялгууны бясалгалын аргыг уламжлан авсан бөгөөд хожим үүнийгээ бясалгалын Арьяабалын (Гуан Инь) Арга гэж нэрлэх болсон ажээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгаснаар төгс гэгээрэлд хүрч чадсан билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Хималайн уулсаас эргэж ирээд төд удалгүй эргэн тойрны хүмүүсийнхээ гуйлт хүсэлтээр Арьяабалын аргыг бусадтай хуваалцаж эхэлсэн бөгөөд шавь нартаа өөрийгөө танин мэдэж, дотоодын аугаа чанараа олохыг урамшуулан дэмжсэн юм. Удалгүй Америк, Ази, Европ, Австрали, Африк тивээс ном сургаал айлдах урилгыг хүлээн авдаг болжээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн өгөөмөр нигүүлсэнгүй сэтгэлийн илрэл нь ядуу зүдүү, зовлон гачигдалтай хүмүүст үзүүлдэг анхаарал, хайр халамж юм. Тэрбээр уран бүтээлийн орлогоороо сан хөрөнгө бүрдүүлснээр дэлхий даяарх байгалийн гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх болон буяны хандив өргөх замаар Бурханы хүүхдүүдэд гачигдсан үед нь туслах болсон билээ.

## *Амьдарч буй дэлхийгээ үзэсгэлэн төгөлдөр болгоё*

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүмүүнлэг ажил үйлсийнхээ хариуд аливаа гавьяа шагнал горьддоггүй ч дэлхийн улс орнуудын төр засаг, хувийн байгууллагууд түүнд хүндэт шагналаа олгосон байдаг бөгөөд үүнд Дэлхийн Энх тайвны Шагнал, Дэлхий Оюун санааны Удирдагч шагнал, Хүний эрхийг хөхиүлэн дэмжигч шагнал, Дэлхийн Иргэн хүмүүнлэгийн шагнал, Хүн төрөлхтний Гарамгай Нийгмийн үйлчилгээний шагнал, 2006 Гүүсийн Энхтайвны шагнал, Лос Анжелесийн Хөгжмийн Долоо Хоногийн Сайшаалын гэрчилгээ, 2006 оны 27 дахь Телли шагналын Тэргүүн байрын Мөнгөн цом, АНУ-ын Ерөнхийлөгч асан Жорж Бушийн нэрэмжит Идэвхтэй Амьдралын хэв маяг Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал, АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагаас хүртсэн 2010 оны Ерөнхийлөгчийн Сайн дурын үйлсийн шагнал зэрэг шагнал зүй ёсоор дурдагддаг билээ.

Түүнчлэн АНУ-ын Хавай болон Иллинойс мужийн төр засгийн удирдлага жил бүрийн 10 дугаар сарын 25 болон 2 дугаар сарын 22-ныг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” хэмээн зарлан тунхагласан юм. Иллинойс мужийн удирдлагаас ийнхүү зарлан тунхагласан тэрхүү өдөр АНУ-ын ерөнхийлөгч асан Клинтон, Буш, Рейган нар Их Багшид талархлаа илэрхийлж баярын мэндчилгээ ирүүлж байжээ.

Мөн ариун журамт хүмүүсийг магтан сайшааж, тэдний үлгэр жишээгээр бусдыг урамшуулах зорилгоор Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүмүүс болон амьтдын онцгой баатарлаг үйлс, энэрэнгүй сэтгэл, манлайлал, эр зориг, оюун ухааны гавьяаг үнэлэн олгодог *Shining World Awards* буюу Дэлхийн Гарамгай үйлсийн цуврал шагналыг санаачлан бий болгосон билээ.

## *Их Багшийн мөрөөдөл*

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ийнхүү бид бүхний хайрт гараг дэлхий болон түүний эрхэм нандин оршин суугчдын сайхан ирээдүйг бүтээхийн төлөө амьдралаа зориулдаг билээ. Түүхэнд үе үеийн аугаа зөн билигтнүүд мөрөөдөлтэй байсан лугаа адил Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ч мөрөөдлөө ийнхүү өгүүлсэн байдаг:

*«Бүх дэлхий даяараа амар амгалан болоосой гэж би мөрөөддөг.*
*Бүх аллага зогсоосой гэж би мөрөөддөг.*
*Бүх хүүхэд амар амгалан, эв зохиролтой алхаасай гэж би мөрөөддөг.*
*Бүх улс үндэстэн гар гараасаа барилцаж, бие биеэ хамгаалж, харилцан туслаасай гэж би мөрөөддөг.*
*Үзэсгэлэнт гараг дэлхий маань бүү мөхөж сүйрээсэй гэж би мөрөөддөг.*
*Олон тэрбум, их наяд жилийн хөдөлмөрөөр бүрэлдэн тогтсон энэ гараг маань машид үзэсгэлэнтэй бөгөөд гайхамшигтай.*
*Түүнийг энэ л чигээрээ, гэхдээ амар амгалан, үзэсгэлэнтэй сайхан, хайраар дүүрэн үргэлжлэн оршоосой гэж би мөрөөддөг».*

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт

## АНУ, Калифорни муж, Сан Франциско, Холидэй Инн
## 1989 оны 5 дугаар сарын 24

***Асуулт 1:** Өөрийгөө их багш гэж зарладаг хүн олон байдаг. Бид буруу тийшээ залагдчихгүйн тулд тэдний жинхэнэ их багш мөн эсэхийг яаж мэдэх вэ?*

**Багш:** Үнэхээр чин сэтгэлийн асуулт байна, үнэнхүү чин сэтгэлээсээ, шулуун шударга асуулаа. Энэ их амархан гэж би танд хэлэх байна. Нэгдүгээрт, жинхэнэ их багш өөрийнхөө төлөө, өөртөө хэрэглэх гэж ямар ч хандив авдаггүй. Тэрхүү их багш өөрийгөө тэжээж амьдардаг. Энэ бол хамгийн эхний шалгуур. Учир нь Бурхан бусдад өгдөг л болохоос биш авдаггүй. Та доош бууж ирээд хүмүүсээс өргөл барьц авч байгаа Бурханыг ер нь харсан уу? Тиймээс... үгүй. Дотооддоо Бурханы хүчтэй, өөрийгөө Бурханы төлөөлөл, эсвэл би Бурханы төлөө ажилладаг хэмээн нэрийдэж байгаа л бол тэр хүнд Бурханы энэ шинж чанар заавал байх ёстой. Тэр хүн хувьдаа ашиглахаар ямар ч өргөл барьц, тусламж хандив авах ёсгүй.

Хоёрдугаар онцлог шинж бол тэр хүн танд гэгээрлийн ямар нэг баталгаа өгөх ёстой. Жишээлбэл, тэр эмэгтэй багш, эсвэл тэр эрэгтэй багш... ямар ч байсан эрэгтэй юмуу эмэгтэй тэр хүн, алин болохыг би мэдэхгүй байна л даа. Дотоодод бол эрэгтэй, эмэгтэй гэсэн юм байдаггүй юм шүү дээ. Тэр их багш, хэрвээ өөртөө Гэрэл байгаа гэж зарлан мэдэгдэж байгаа бол, Хэрвээ тийм бол тэр танд бас Гэрлийг өгөх ёстой, танд Гэрэл харуулна, та харж чадна, Библид гардаг "Үг" хэмээх Бурханы "үг"–ийг сонсох болно гэсэн баталгааг өгөх ёстой. Хэрвээ тэд, хэн ч бай тэр хүн танд энэ хоёр зүйлийн, Бурханы Гэрэл болон Үг хэмээх Бурханы хэлбэлзлийн баталгааг өгч чадаж байгаа бол итгэж болох хүн чинь байна гэсэн үг. Тийм биш бол тэр эмэгтэй, эсвэл тэр эрэгтэйд ямар нэгэн юм байна гэдгийг та хэрхэн мэдэх юм бэ?

Хэн нэг хүн танд өөрийгөө "Би саятан. Надад маш их мөнгө бий" гээд байвал та тэр мөнгөнийх нь барааг харахыг хүснэ ээ дээ. Гэтэл тэр хүн "Аа, чи надад итгэх ёстой. Итгэчихэд л болно" гэвэл энэ нь хангалттай биш шүү дээ. Тэр танд ядаж л зээлийн карт юм уу, мөнгөний баримт үзүүлэх хэрэгтэй шүү дээ. Хэрвээ тэр хүн их өгөөмөр нэгэн бол танд жаахан мөнгө өгнө, тэгвэл тэр мөнгө нь танд бодитой тус

болно. Эс бөгөөс тэр өөрийгөө мөнгөтэй хүн гэж зуун жил яриад ч танд юуных нь ашиг байх вэ? Ямар ч нэмэргүй шүү дээ. Өлсөж цангаж байхад чинь мөнгөөр туслаагүй л бол ямар ч нэмэргүй саятан, эсвэл саятны ч хэрэг алга гэсэн үг. Саятан мөн биш аль нь ч бай бид огт тоохгүй.

Жинхэнэ их багшийг таних хоёр нөхцөл байдаг. Нэгд гэвэл, тэр их багш өөртөө зориулж ямар ч өргөл барьц авдаггүй байх. Хоёрт гэвэл тэр танд дотоод гэгээрлийн ямар нэгэн баталгааг өгөх ёстой, танд Гэрэл үзүүлэх ёстой. “Гүрү” гэдэг нь Гэрэл өгөгч, харанхуйг хөөгч гэсэн утгатай юм. Өдөр болгон харанхуйг хардаг танд Гэрэл үзүүлсэн бол тэр хүн Гүрү гэсэн үг. Мөн аялгуу сонсгох ёстой, учир нь ***Анхандаа “Үг” л байсан бөгөөд тэр “Үг” нь Бурхан байсан*** гэдэг шүү дээ. Хэрвээ танд аялгуу сонсогдохгүй байгаа бол та Бурхантай хараахан гүйцэд холбоо бариагүй байна гэсэн үг. Гэрэл нь Бурханы зөвхөн нэг шинж ч гэлээ төгс биш. Та бас аялгууг нь сонсох хэрэгтэй.

“Яагаад тийм байдаг юм бэ? Яагаад зөвхөн Гэрэл хараад болчихдоггүй, дээр нь заавал Аялгуу сонсох ёстой юм бэ? Яагаад заавал сонсох аргыг хэрэглэх ёстой юм бэ? ” гэж та асуух байх л даа. Би та нарт хэлье л дээ. Бидний энэ физик нүд зөвхөн нэг хэмжээсийг л харж чаддаг. Урдхаа л харна гэсэн үг. Та энэ талыг харъя гэвэл зүүн тийш эргэж, баруун талаа харъя гэвэл баруун тийшээ эргэж, харин ар талаа харъя гэвэл арагшаа эргэх хэрэгтэй болдог. Бидний дотоод нүд ч бас төстэй. Дотоод нүд тань нээгдсэн байлаа ч гадаад нүдтэйгээ л адилхан үр нөлөө үзүүлнэ; өөрөөр хэлбэл зөвхөн урьд талаа харна, эсвэл харж буй тэр зүг лүүгээ л харна гэсэн үг (харахдаа “нүд”-ээрээ “хардаг”-гүй хавьгүй өндөр дээд хэмжээст байгаа л биш бол).

Тэгвэл бидний чих үүнтэй адилгүй. Бидний физик чих маш олон чиглэлд ажиллах зориулалттай. Та дээрээс, доороос, баруунаас, зүүнээс, ардаас, урьдаас ч сонсдог. Бидний дотоод чих үүнтэй яг адилхан; та бүхий л чиглэлд сонсож чадна. Тэгээд л бид бүхнийг-мэдэгч болдог юм. Зөвхөн хараад, харин сонсдоггүй байх юм бол бид дүлий л гэсэн үг. Нэг эрхтэн маань ажиллахгүй, хэрэглэгдэхгүй байна гэсэн үг. Тийм бол бид төгс төгөлдөр төрөлтөн биш гэсэн хэрэг биз дээ.

Сонсох эрхтэн маань гадаад болон дотоод аль нь ч нүднээс ч илүү төгс юм. Ийм учраас л бид энэ сонсох аргыг дадуулах ёстой юм шүү дээ. Гаднахыг харахдаа бид физик нүдээ, гаднахыг сонсохдоо физик чихээ ашигладаг. Харин диваажингийн нүдээрээ дотоодыг харж, диваажингийн чихээрээ дотоодоо чагнана, учир нь аялгуунууд бүхий л чиглэлээс ирдэг. Төгс төгөлдөр төрөлтөн байхын тулд гадаад, дотоод сонсох эрхтнээ хэрэглэх ёстой. Хэрэв чих маань ажиллахгүй бол бид төгс төгөлдөр хүн төрөлхтөн биш. Тийм болохоор төгс төгөлддөр төрөлтөн байхын тулд бидний дотоод чих ч мөн ялгаагүй төгс ажилладаг байх учиртай. Яг одоо бол бидэнд дотоод чих байгаа ч хараахан нээгдээгүй байна. Авшиг хүртээх үед Би та нарт тэр чихийг тань нээж тусална, ингээд та нар янз бүрийн хэмжээсээс ирэх төрөл бүрийн тэнгэрлиг Хэлбэлзлэлийг сонсох болно.

Тэр Хэлбэлзлэл буюу Библид “Үг” хэмээдэг тэр зүйлтэй холбогдсоноор бид бүхнийг-мэдэгч болно, хүрээлэн буй орчин дахь хүмүүст, бүр эргэн тойрны зүйлс дээр ч асгаран буух бүхий л – хүч, хайр адислал, сэтгэл ханамж, аз жаргал, баяр хөөр болж хувирдаг. Бидний оршихуй эргэн тойрныг маань адислах болно. Биднийг хаана ч очсон тэр газар орон, эсвэл тэр бүх хүн ариун гэгээн болох болно. Тэд өөрсдөө мэдсэн ч, мэдээгүй ч адислагдаж, улам аз жаргалтай болж, хүмүүний ухамсар нь улам дээшилж байдаг юм. Гэвч тэд ихэнхдээ энэ талаар мэдэхгүй өнгөрдөг. Тэд бидэнтэй уулзаж харилцахад ухамсарт нь өөрчлөлт гарч буйг зүгээр л мэдэрдэг, харин чухам юу болохыг ухаардаггүй, учир шалтгааныг нь мэддэггүй. Энэ чинь л бид Бурханы хайр адислалыг энэ дэлхийд түгээж байгаа нь тэр билээ. Бид Бурханы энэхүү хүчтэй нэвтрэлцсэн бол үүнийгээ бид түгээж чадна, энэ чинь л дэлхийдээ оруулж байгаа бидний хувь нэмэр юм. Энэ бол хамгийн сайн, хамгийн дээд хувь нэмэр юм; бие махбод, мөнгө санхүүгээр туслахаас хамаагүй илүү билээ. Энэ л Бурханы хайр адислал, билиг ухаан юм, үүн дээр өөр бусад зүйл ч бас бий.

Их Багшийг танихад хугацаа хэрэгтэй. Юун түрүүнд ийм хоёр үндсэн нөхцөлөөр та их багш хүнийг таньж мэдэх нь байна, гэсэн ч тэр Их Багшийн хичнээн аугаа болохыг ухааран танихын тулд та өөрөө ухамсрын бүр өндөр төвшин лүү орох ёстой болно. Харин тэр таны мөнгө санхүү, эсвэл биеэр хүргэх тус нэмрийг тань шамшигдуулахгүй гэдэг нь баталгаатай, танд аюулгүй гэсэн үг. “Ядаж л энэ хүн надаас юу ч хүсээгүй юм байна. Тэгэхлээр би аюулгүйгээр түүнээс суралцаж болох юм байна. Тэгээд түүний сайн, мууг нь харъя. Хэрвээ тэр сайн биш бол би хэдийд ч явчихаж болно, надад алдах зүйл алга.” гэж бодно.

Таны аюулгүй байдлын талаас бол ийм байна. Танд алдах юм юу ч байхгүй гэж л хэлж байгаа юм л даа. Танд ямар ч нөхцөл болзол тулгахгүй учраас наанадаж л аюулгүй байдал чинь хангагдаж байна. Тэр их багшийн сайн, мууг дараа ярилцъя. Ядаж л тэр багш таны гэнэн занг ашиглахгүй, танаас хувь нэмэр авах хүсэлгүй байна гэдэг чинь жинхэнэ Их Багшийн шинж. Багаар бодоход л та аюулгүй байна шүү дээ. Энэ чинь болж байна.

Мөн Их Багшийн хүч гэх зүйл байдаг бөгөөд авшгийн үед тэр хүчний хэсгийг та мэдрэх болно. Цаашлан өдрөөс өдөрт та бясалгаж, өөрийгөө ариусгаж, билиг ухаан тань нээгдэн илүү ихийг ойлгосноор Их Багшийнхаа хэр аугаа болохыг ухаарна. Их Багшийг таньж мэднэ гэдэг бол ганц нэгхэн өдрийн ажил биш, гэхдээ гэгээрлийг дамжуулах үе буюу авшиг хүртээх үед танд өгсөн баталгаа нотолгоогоор нь түүнийг бага ч гэсэн мэдэж магадгүй юм. Гэхдээ наад зах нь тэр танаас юу ч хүсэхгүй. Энэ чинь л аюулгүйн дохио. Өөр бусад юмыг мэдэхэд бага зэрэг хугацаа хэрэгтэй, гэхдээ та мэдэж авч магадгүй. Зарим хүн өдөр бүр адислалт хүч, аз жаргалыг нь хүртэж, амьдрал нь өдрөөс өдөрт өөрчлөгдсөөр байгаа болохоор Их Багшийгаа их хурдан танин мэддэг. Харин заримд нь нэлээн их хугацаа ордог. Ингээд л болоо. Ер нь дамжуулалтын үед их ч бай, бага ч бай та үүнийг мэднэ.

***Асуулт 2:** Их Багш Чин Хай Та энэ улсад одоо өрнөж эхлээд байгаа амьтны эрхийг хамгаалах хөдөлгөөний талаар ямар үзэл бодолтой байна вэ? Та тэдний энэ арга барилтай санал нийлж байна уу?*

**Багш:** Би бүрэн дэмждэг. Бид чинь ургамлын суурьтай ногоон хооллолтыг (веган) дэмжигчид шүү дээ. Би гэм зэмгүй амьтдыг хүчирхийлж байгаа явдалтай огт санал нийлдэггүй. Мэдээжээр би энэ хөдөлгөөнийг бүрэн дүүрэн дэмждэг.

***Асуулт 3:** Бурханы шашны сургаал номыг үзэж судлах ямар зөв арга байдаг вэ? Хаанаас нь эхлэж судлах вэ?*

**Багш:** Бурханы шашныг үзэж судлах зөв арга бол өөрийнхөө дотоод руу орж, Будда хаана байгааг харах явдал юм; ном судар дотор бус, өөрийн чинь дотор байдаг юм шүү дээ, учир нь “***Будда дотор чинь бий.***” гэж Будда хэлсэн. Тэрбээр Будда ном судар юмуу, аль нэг сүм дуган дотор байгаа гэж хэлээгүй. Бид үүнийг мартчихсан байна. Буддаг өөд болсны дараа олон сүм хийд барьж, хиймэл дүрийг нь бүтээн модон хөшөө барималд мөргөчихөөд л Түүнээс элдэв зүйлийг гуйж хүсэх болсон билээ. Модон баримал юу ч өгч чадахгүй, тэгээд бид бухимдаж, Буддад ямар ч хүч чадал байхгүй юм байна гэж бодох болсон. Бид буруу зүг рүү хараад байгаад л учир оршиж байгаа хэрэг шүү дээ. Буддын шашныг судлая гэж байгаа бол дотоод руугаа л ор! Харин тэр дотоод руу – орох арга нь Надад байна! Буддаг яаж олохыг Би танд хэлж өгч чадна.

***Асуулт 4:** Яаж үргэлж аз жаргалтай, үхэлгүй мөнх байх вэ?*

**Багш:** Тийм ээ, арга чарга бий. Хүссэн бүхэнд маань хүргэдэг тийм арга бий. Түүнийг хаанаас олохыг бид мэдэх ёстой. Та үүрд мөнх амьдарч, аз жаргалтай байхыг хүсэж л буй бол тэр аргыг би танд өгье. Энэ их амархан. Түүнд хүрэхийн тулд та өдөр бүр багаахан цагийг л зориулах хэрэгтэй, ахархан хугацааны дараа та мэдэх болно. Зарим хүн үүнийг ердөө хэдхэн өдрийн дотор, зарим нь анхны өдрөө л мэдчихдэг. Тэд өөрийгөө үхэшгүй мөнх гэдгийг мэддэг. Гэвч үүнийг би хүний хэлээр тайлбарлаж чадахгүй. Та үүнийг биеэрээ үзэж мэдрэх ёстой, тэгж байж л мэднэ. Харин дараа нь хүн танаас “Тэр нь ямаршуу байдаг юм бэ?” гэж асуухад та яг л над шиг хэлэх үггүй таг болно (Их Багш инээв). Бид гавьтай ихийг ярьж чадахгүй, зөвхөн өөрөө таньж, ухаарч, үзэж, мэдэрч л чадна.

***Асуулт 5:**. Авшиг гэж юу вэ, мөн ямар шаардлагууд тавьдаг вэ?*

**Багш:** Авшиг гэдэг нь дотооддоо буй Бурхантай холбогдох агшин юм. Авшгийн дараа та өдөр болгон Бурхантай холбоотой байж, түүнтэй уулзаж байх болно. Тавигдах шаардлагууд нь гэвэл та бүрэн ургамал (веган) хоолтон болсон байх, ёс суртахуунтай амьдрах, өдөр бүр хоёр цаг гучин минут бясалгах ёстой. Та дэлгэрэнгүй мэдээллийг гаднаас авч болно. Зарим шаардлагыг гадаа бичээд тавьчихсан байгаа. Үнэндээ би өөрөө та нараас юу ч шаарддаггүй; та нар л өөрөөсөө тодорхой сахилга батыг шаардах ёстой юм. Жишээлбэл, та амьтны мах иддэг бол энэ чинь таны оюун санааны амьдралд хор нөлөөтэй. Одоо танд

хэлэхэд үүнийгээ таслан зогсоох нь таны л тусын тулд юм гэдэгт л нууц нь оршиж байгаа юм. Би та нараас өөртөө юу ч гуйж шаардахгүй. Танд эхнэр юмуу, нөхрөө солих, ажлаа өөрчлөх, нийгэм дэх холбоо сүлбээ, эсвэл алид нэг шашнаа өөрчлөх шаардлага байхгүй. Та Христийн шашинтай бол тэр хэвээрээ л бай; Жүүдийн шашинтай бол тэрэндээ л итгэ; ямар нэгэн шашин, бүлэгт байдаг бол тэндээ чөлөөтэй үлдэж болно. Би танд зөвхөн хамгийн дээд Хүчээ дотоодоосоо хэрхэн олж авахыг л хэлнэ. Тэр чинь л та өөрөө буюу аливаа шашны хамгийн дээд гэж нэрлээд байдаг тэр зүйл юм. Буддын шашин үүнийг л хамгийн дээд нь гэдэг, Христын шашин ч хамгийн дээд нь гэдэг. Харин Би таныг тэр Хүчээ олоосой гэж хүсэж байна. Ердөө л энэ.

Гэвч та бие, хэл, сэтгэлээр ариун байх ёстой. Жишээлбэл, та сэтгэлдээ ямарваа харгис хэрцгий зүйл бодож болохгүй; харин хайр энэрэл, өршөөл уучлал, хүлцэл тэвчээр, нигүүлслэлийг бодох хэрэгтэй. Үг хэлээрээ бид билиг ухааны, эргэн тойрныхныхоо сэтгэлийг амраан тайтгаруулах зүйлийг ярих ёстой. Биеэрээ цэвэр ариун, эгэл ариунаар амьдрах учиртай. Эгэл ариун амьдрал гэдэг нь эхнэр авахгүй, эсвэл нөхөрт гарахгүй байх гэсэн үг биш, харин зөвхөн нэг эхнэртэй, эсвэл нэг нөхөртэй байж, түүнээсээ салахгүй байх явдал юм. Ямар л эхнэр, эсвэл нөхөртэй байна, үргэлжлүүл, түүнтэйгээ эвлэрэн таарч тохир (Их Багш инээв). Энэ л эгэл амьдрал. Дараа нь эгэл ариун хүн байхын тулд бүх төрлийн согтууруулах ундааг хаях ёстой. Сэтгэл санааг самууруулж, биеийг тань сул дорой болгодог зүйлсийг би хэлж байна. Сэтгэцийг өвчлүүлдэг хар тамхи, архи дарс, мөрийтэй тоглоом гэх мэт зүйлсийг хэлж байна. Эгэл жирийн буюу цэвэр ариун амьдрал гэж үүнийг л хэлнэ.

Тэгэхлээр та бие, хэл, сэтгэлээ Бурханы шинж чанарт, Түүний хэлсэнд нийцүүлэх хэрэгтэй, учир нь та Бурхан болохыг хүссэн, та ***Би Эцэгтэйгээ нэгэн цогц*** гэдэг шиг болохыг хүссэн шүү дээ. Та одоо Бурхан мөрийтэй тоглоом тоглож, архи ууж, үгүй бол элдэв аймшигтай завхайрал юмуу, элдэв дорд хүсэл шуналыг үйлдсэн юмуу гэж гайхаж байгаа байх, тийм үү? Хэрвээ бид Бурхантай нэгэн цогц болохыг хүсч буй бол мэдээж бие, хэл, сэтгэлээ Түүнийхтэй эн тэнцэхүйц байлгах ёстой. Тэгэхээр энэ л тэр нөхцөл болзол нь юм. Та ургамал хоолтон байх хэрэгтэй, тэгээд л боллоо; бие, хэл, сэтгэлээрээ эгэл ариун, мөн хайр энэрэлтэй, харгис хэрцгий бус байх хэрэгтэй. Тэгээд л боллоо.

Жишээ нь, өмнө нь та хүн зодох дуртай байсан бол энэ аргаар бясалгамаар байвал цаашид хүн зодохоо больчих. Тэгээд л боллоо. Урьд нь амьтны мах идэх дуртай байсан бол одоо амьд амьтныг хайрлан нигүүлсэх сэтгэлээр махнаас татгалзчих. Ердөө л Бурханы ухамсрын хувьд өөрийгөө илүү өндөр, нэг алхам өндөрт буйг, илүү их нигүүлсэх сэтгэлтэй, өршөөл уучлал болон хайрыг бясалгаж дадуулж байгаа гэдгээ л харуулчих. Энэ л нөхцөл нь юм. Маш амархан. Бид үүнийг хийж чадна. Бид чадна.

***Асуулт 6:*** *Бидний урьдын үйлийн үр одоогийн амьдралд нөлөөлдөг үү? Үүнд яаж итгэх вэ? Үүнийг батлах зүйл юу байна вэ? Баярлалаа.*

**Багш:** Үүнийг батлах хэцүү хэдий ч би хичээе. Энгэл хүмүүний ухамсарт хүрч ойлгогдомгүй урьд төрлийн тухай ярих шаардлага бидэнд байхгүй. Одоогийн энэ амьдралынхаа талаар л ярилцъя. Ингэх нь ойлгоход амар. Жишээ нь, өдөр бүр, өглөө болгон та архи уудаг бол үд дунд бие тань ямар байх вэ? Сайхан байх уу? Гайхалтай байх уу? Эсвэл согтуу, аймаар, толгой нь өвдсөн, олиггүй олхиогүй байх уу? Бие чинь аймшигтай байна биз? Архи уусны үр дагавар нь энэ, үүнийг л “урьдын үйл үр одоод нөлөөлөх” гэж нэрлээд байгаа юм. Өглөө тэгж их уугаагүй бол үдээс хойш, үд дунд бие чинь хаанаас тийм их өвдөх билээ. Толгой чинь сэргэлэн, жаргалтай, хэвийн сайхан байна биз дээ. Үүнийг үйл үрийн нөлөө, “өнгөрсөн нь одоод нөлөөлөх“ гэж нэрлээд байгаа юм. Энэ их амархан.

Яг одоо цагт болж өнгөрч байгаа болохоор үүнийг ойлгоход хялбар. Харин аль эрт, хэдэн зууны тэртээ болоод өнгөрсөн юмыг бид мэдээж ойлгохгүй. Дахин төрөл авч, шинэ хувцас болох энэ биеэ солих бүртээ хамгийн сүүлд ямар хувцас өмсч байснаа мартчихдаг. Урьд төрлөө мартдаг нь бидний хувьд бас л адислал, учир нь сүүлчийн төрөлдөө бар, чоно, эсвэл тун аймшигтай ерөнхийлөгч, эсвэл хаан байснаа санахын хэрэг юу байна? Түүнийгээ санах нь маш хүнд дарамт болно. Өдөр тутмынхаа дарамтыг яая гэж байхад урьд төрлийнхөө үйл үрийн ачаа, сэтгэл зүйн дарамт нэмэгдвэл яах болж байна.

Тэгэхлээр өнгөрсөн төрлөө санадаггүй нь адислал, хайр юм. Үүрч даах хэмжээндээ амьдраг гээд биднийг урьд төрлөө санахгүй байхаар Бурхан, үйл үрийн бурханы тусгайлан зохицуулсан нь энэ юм. Гэвч угтаа бид ямар нэгэн бясалгал, манай бясалгал биш юмаа гэхэд бүр энгийн нэг бясалгал хийхэд ч зарим хүн урьд төрлүүдээ хардаг. Бидний өнгөрсөн амьдралуудын хором бүрийг бичиж тэмдэглэсэн зарим нэгэн ертөнц байдаг бөгөөд тэрхүү номын сан гэгдэх газар хүрч чадвал бид яг л ном нээж байгаа юм шиг өөрийнхөө төдийгүй, өрөөл бусад бүх хүний амьдралыг харж чадна. Ингэх нь танд хэрэг тустай байвал Их Багш танд харах боломж өгнө; харин тус болохгүй, тэсэж даах хүчээс чинь давсан байвал Их Багш түүнийг халхлаад, өөрт чинь үзүүлдэггүй юм.

Тийм болохоор амьдралын нууц гэх юм юу ч байдаггүй. Харин зөв номын сандаа хүрч очоод урьд нь, бас дараа нь юу байгааг тэр нөөцнөөс харах л тухай юм. Тэгэхээр та үүнийг бүр өөртөө ч нотолж чадах нь байна. Үүнийг та өөртөө л нотолж чадна, өөр хэн ч танд нотолж өгч чадахгүй. Жишээ нь, та надаас өөрийнхөө үйлийн үрийг нотлож өгөөч гэж гуйлаа гэхэд Би танд “Та Бар байжээ“ гэж хэлнэ, энэ жишээ л юм шүү, битгий итгээрэй. Тэгтэл, та надаас нотлохыг гуйна. Энэ чинь миний хувьд хэцүү зүйл, учир нь та тэнд, би энд байна. Би юмыг таны харж байгаагаас өөрөөр хардаг. Таван давхарт байгаа хүн хоёр давхарт байгаа хүнээс илүү холыг сайн харна, хоёр давхрын хүн гурван давхраас хэлэхэд хэлсэн зүйлийг нь өөрөө хараагүй тул итгэхгүй. Тэгэхээр баталгаа байсан, байгаагүй үүнийг дараа гээд орхиё. Та одоогийн энэ амьдралдаа илүү санаа тавих хэрэгтэй. Жишээ нь, бид өнгөрсөн амьдралаа өөрчилж чадахгүй, тэр чинь өнгөрсөн зүйл, болоод өнгөрчихсөн. Тэгэхээр бидний хамгийн их санаа зовох, мөн өөрчилж чадах зүйл бол одоогийн амьдрал болон ирээдүй маань юм. Үгүй гэж үү? Одоо цагт бид

ирээдүйг өөрчилж чадна, энэ чинь сайхан хэрэг. Бидэнд одоо болон ирээдүй цаг л их чухал болохоос бус өнгөрсөн нь биш. Өнгөрснийг бид яах ч аргагүй. Бүр одоогийн амьдралаа ч гэсэн бид тийм ихээр зохицуулж чадахгүй, гэхдээ дотооддоо орших Бурханы хүчээрээ түүнийг багасгаж, зөөллөж болно. Өдөр бүр тэр хүчнээсээ гаргаж ирэн хэрэглээд байж болно.

Жишээлбэл, танд эцэг эхээс чинь үлдсэн алт эрдэнэс, өв хөрөнгө байжээ, сая долларыг хаа нэгтээ нуучихсан, хаана байгааг нь та мэдэхгүй; тэгтэл та өдөр бүр гадагш гарч, маш их ажиллаад өчүүхэн жаахан мөнгө олно. Энэ тохиолдолд хаа нэг газар байгаа гэж таны мэдэж байгаа тэр алт, эрдэнэс танд тус нэмэр болох уу? Харин байгаа газрыг нь мэдчихвэл гаргаж ирээд өдөр бүр хэрэглэнэ. Харин одоо та хүнээс зуун мянган доллар авчихаж, үүнийгээ өөрчилж чадахгүй, учир нь аль хэдийнээ зээлчихсэн тул та энэ үйлээ өөрчилж чадахгүй. Гэхдээ та мөнгөө аваад түүнд өгчихвөл болчихно. Та амьдралаа илүү амар, тавтай сайхан болгож чадна. Тэр хүндээ хэдэн төгрөг өгөөд л та шүүхэд дуудагдахгүй, зээлсэн мөнгөнөөсөө болж хүмүүст хөөгдөж, загнуулж, зодуулах асуудалгүй болно. Та одоогийн амьдралаа ингэж л өөрчилж болно.

Бидний энэ насны амьдрал үйлийн үр гэж нэрлэгддэг өнгөрсөн үеэс маань тогтчихсон байдаг: ***Юу тарина, түүнийгээ хураана.*** Тиймээс урьд хийсэн үйлүүдээс хамааран бидний гуниг зовлон, жаргал цэнгэл зурагдчихсан байдаг, энэ нь бид хэн нэгнээс мөнгө зээлээд үрчихсэнийхээ дараа буцааж өгч чаддаггүйтэй адил юм. Тэгэхлээр бид одоо үүнийгээ үүрэхээс өөр аргагүй, эсвэл мөнгөтэй бол өрөө төлөөд эрх чөлөөтэй болж болно. Үүн шиг байдлаар урьд төрөлдөө юмуу өнгөрсөн жилүүдэд хийсэн буруу үйлдлийхээ үрээр бидний энэ насны амьдрал зовлон зүдгүүртэй юмуу, баяр жаргалгүй байж болно. Гэсэн ч бид одоо бясалгавал хэрэглэх дотоод адислалын хүчтэй болж, түүгээрээ энэ зовлон гунигаа нимгэлж болно, бид ингэж л одоог өөрчилж, тус болно. Мэдээж ирээдүйд ямар нэгэн тааламжгүй зүйл тохиолдохгүй, учир нь нөөцөнд маань хадгалагдсан ирээдүйгээ өөрчлөх буян маш их бий.

Энэ нь эрдэнэсээ олж илрүүлээд өртэй хүндээ хэдэн төгрөг төлчихөж байгаатай ижил. Тийм биш гэж үү? Цаана нь ирээдүйд хэрэглэх маш их мөнгө үлдсэн. Ирээдүйд хүнд өр тавихгүй, ядуу зүдүү ч амьдрахгүй. Тийм биш гэж үү? Үүнтэй л ижил! Бид өнгөрснийг өөрчилж чадахгүй ч одоогийн амьдралаа жигдэлж, ирээдүйгээ өөрчлөх хэрэгтэй. Энэ чинь л бясалгалын Арьяабалын бясалгалын арга (Гуан Инь) агшин зуур гэгээрэх энэ бясалгалыг дадуулахын зорилго юм. Гуан гэдэг нь төвлөрөн ажихуй гэсэн утгатай. Инь гэдэг нь дотоод Хэлбэлзлэл, дотоодын Аялгуу гэсэн утгатай. Тиймээс Гуан Инь гэж хэлдэг. Энэ нь дотоодын Хөгжмийг ажихуй гэсэн Хятад үг юм.

***Асуулт 7:*** *Би Роман Католик хүн л дээ. Есүс Христийг аврагчаа гэж үзэж зөвшөөрсөн. Саяхнаас би Буддын шашны тарни ном уншдаг болсон юм. Энэ хоёр*

*байдал нэг нь нөгөөдөө харшлах болов уу? Маани мэгзэм унших нь Эцгийн минь нэр Яхве*-тэй (JAHWEN) зөрчилдөх үү?*

**Багш:** Би ойлгож байна. Үгүй, та ямар ч буруу юм хийгээгүй. Гэгээрлийн төлөөх тэмүүллийг тань Бурхан өршөөнө. Бурханыг хайж олох гэсэндээ л та нэгээс нөгөө хаалгыг татаж яваа юм. Та муу юм хийхийг хүссэн юм ч биш. Тийм атаач Бурхан байдаг гэдэгт би итгэхгүй. Хэрэв Бурхан тийм атаач юм бол би Түүнийг ус зайлуулах суваг руу хаячихна (Инээв). Гэхдээ юутай ч, энэ бол Жи Лиений урсгал, Бадамлянхуа урсгал юм. Жи Лиен гэдэг нь бадамлянхуа урсгал гэсэн Хятад үг, тэгэхээр та Бадамлянхуа Судрын аргаар хичээллэдэг юм байна, тэд Бадамлянхуа судрын нэрээр уншлага хийдэг юм. Гэхдээ миний ойлгож ухаарснаар бол судар номын нэрийг давтан унших нь Бурхантай ямар ч хамаагүй. Бурхан судар ном дотор биш, харин та бидний өөр дотор минь бий.

Тэгэхлээр, Баптист Жоноор адислуулж байхдаа Есүс юу харсан билээ? Тэр Диваажингаас Гэрэл яг л тагтаа шиг бууж ирэхийг харсан байдаг. Тэгэхлээр та Бадамлянхуа судрын нэрийг давтан уншиж байхдаа ямар ч тагтаа доош буухыг хараагүй бол энэ чинь та буруу аргаар хичээллэж байна гэсэн үг, та үүнийгээ Буддын шашин, эсвэл Католик шашин юу ч гэж нэрлэсэн бай, надад хамаа алга. Би уг нь Буддын шашинтан, гэвч Буддын шашны ихэнх арга Буддагийн сургаалтай зөрчилдөж байгааг би мэдэрдэг. Тэд яриад л, яриад л, үгээ давтаад л байхаас бус, дотоодын Гэрэл, эсвэл дотоод ахуй ойлголт үзээгүй байдаг.

Тиймээс танд Католик шашнаа бүү орхи гэж хэлье, харин Би танд дотоодоосоо Гэрлийг хэрхэн олох аргыг зааж өгье, тэгээд л боллоо. Намайг битгий шүт, битгий Буддын шашинтан бол, аль нэгэн Буддын сүм рүү бүү яв, бүр над дээр ч ирэх хэрэггүй. Энэ бүхнийг би огт тоохгүй. Би ердөө л хэрхэн дотоод руугаа орж, Бурханыг харахыг, хүссэн зүйлээ харахыг хэлж өгье. Та үргэлж тэр Бурхан, тэр Яхве, эсвэл хэн ч гэж нэрлэдэг юм, Түүнийгээ хүсэмжилдэг шүү дээ. Та нар Түүнийг хэдэн арав, хичнээн зуун янзаар нэрлэсэн ч Тэр ер тоохгүй. Түүнд нэр байдаггүй юм. Тэр тухайн цагт дэлхийд заларч байгаа Их Багш ямар нэртэй байна, тэр нэрийг нь л өөртөө авдаг.

Тийм болохоор Есүсийг ирэхэд тэд Бурханы хүү, эсвэл бүр Эцэг хэмээн Түүнийг шүтсэн. Буддаг ирэхэд хүмүүс Бурхан хэмээн шүтсэн. Учир нь Бурханы хүч тэр хүнд, тэр хүмүүний биед хувилсан байснаас л нь тэр. Хүмүүн гэдэг ердөө л дотроо тог гүйдэг цахилгааны утас шиг юм. Тэр утас нь улаан байна уу, шар байна уу, хамаагүй. Дотор нь цахилгаан эрчим хүч байна уу гэдэг нь л чухал; тийм биш бол цахилгаан утас гэж ч нэрлэхгүй, магадгүй хоосон төмөр утас л гэнэ биз, тийм ээ?

---

* *Яхве, Йахве* (евр. YHWH) Иудын шашин дахь Бурханы нэр

Тэгэхлээр хэрвээ танд эрчим хүч өгдөггүй, Гэрэл, эсвэл Бурхан юмуу, Диваажингийн орныг үзүүлж өгдөггүй бол бүх арга хоосон төмөр утас гэсэн үг. Цахилгааны утас биш байна гэсэн үг. Тэр бол Есүсийн арга биш. Тэр бол гадаад арга байна. Тэр арга Буддын, эсвэл Мусульман шашин ч байна уу, ер юу ч байсан надад хамаагүй; бүгд хоосон, яг л хоосон хальс гэсэн үг. Тийм учраас л та дотроо зөрчилдөөд байгаа хэрэг.

Та надаас энэ аргыг суралцвал Буддын шашинтан болж өөрчлөгдөх ямар ч шаардлагагүй, ямар ч уншлага хийх хэрэггүй. Та зөвхөн өдөр бүр Гэрэл харж, баяр хөөр эдэлж, Бурхантай хамт байх болно. Тэгээд Бурхан танд ямар нэр хэлж өгнө, Түүнийг тэр нэрээр нь дуудаж болно. Түүнийг та янз бүрийн, хэдэн зуун нэрээр мэдэж, эсвэл бүр ямар ч нэргүйгээр нь ч таних болно. Түүнийг асар их хайр гэж л та мэдэх болно. Тэр таныг хайрлаж, өршөөж, өдөр бүр өчүүхэн зүйл дээр ч халамжилна. Тэр мөчид л та Бурханд жинхэнээсээ талархахыг мэдэрнэ, түүнийг жинхэнээсээ мэдэж, жинхэнээсээ шүтэх болно, энэ л Бурханыг жинхэнээсээ шүтэхүй юм. Хэрвээ та Түүнийг таньж мэддэггүй бол энэ чинь жинхэнэ шүтэхүй биш. Түүний хичнээн аугаа болохыг та мэдэхгүй, зүгээр л "Ай, Та аугаа их, Та маш өршөөнгүй!" гэхчлэн да- да- да л гэнэ.

Тэгсэн хэрнээ өөрөө маш их зовж зүдэрнэ. Ер нь тэгээд Тэр танд юугаар тусалдаг юм бэ? Юугаар ч тусалдаггүй. Тэгвэл та худлаа хэлдэг болчихож байна. Та ердөө л "Бурхан минь, Та хичнээн нигүүлсэнгүй юм бэ, та их хайр энэрэлтэй, та маш их өршөөнгүй" гэж хэлж л чаддаг. Түүний хичнээн нигүүлсэнгүй гэдгийг, танд хэзээ, яаж, ямар замаар тусалдаг, өдөр бүр өөрийг чинь хэрхэн халамжилдгийг та мэдэх цагт л үг чинь үнэн, бишрэл чинь чин сэтгэлийнх болдог юм. Ингээд та Түүний өлмийд сөгдөж, Түүнтэй нэгэн цогц болдог.

Энэ бол Бурханд хүрэх жинхэнэ зам; энэ бол шашин биш; хоосон номлол биш, сохор сүсэг биш, ямар нэг да да да гэх уншлага биш; тэгсэн хэрнээ мэдэж, ухаарч, үзэж харж, холбоо барьж болдог; энэ л жинхэнэ зам мөр юм. Надад Католик, Буддист, Бадамлянхуа, "Сараана цэцгийн" зам мөр байхгүй. Надад цорын ганц зам мөр бий - тэр бол Бурханы зам мөр. Хэрэв та тэр Гэрлийг мэддэг бол Бурханыг мэддэг юм байна; тэр чинь жинхэнэ Бурхан, жинхэнэ үнэн зам.

Харин битгий дотооддоо зөрчилд. Хэдий та Бадамлянхуа урсгалд итгэдэг байсан ч Бурхан таныг шийтгэхгүй. Энэ нь Та Бурханаас урвасан хэрэг биш. Тэр зөвхөн таны зориулал, өөрийгөө олох гэсэн сохор эрэлд сэтгэл уярах болно. Та чин сэтгэлтэй байгаа учраас тэр танд зөвхөн тусална. Ийм л учраас Бадамлянхуаг уншиж биш, судар номоор биш, харин жинхэнэ өөрийн чинь ухаарлаар Түүнийг хэрхэн олохыг та нарт зааж өг хэмээн Тэр намайг нааш нь илгээсэн юм. Тэр таныг шийтгэхгүй. Та ямар ч Бурханаас урваагүй. Чин сэтгэл тань л үнэлэгдэнэ. Таны хаашаа явах хамаагүй, харин сэтгэлдээ Бурханыг тээж яваа тань л чухал, тийм биш үү? Та зөвхөн Түүнийг л таньж мэдэхийг хүссэн, тиймдээ ч энд тэнд очиж, энэ хүн, тэр багшаас "Та Бурханыг мэдэх үү?" гэж асууж яваа юм. Тэгээд тэр хүн "Энэ замаар яв" гэхээр нь та дагадаг. Гэтэл та ямар ч Бурханыг олохгүй болохоороо

дахиад зүдэрдэг. Өөр тийшээ явна, "Бурханыг хэрхэн олохыг мэдэх үү?" гэж дахиад л асууна. Нөгөөдүүл нь "Тийм ээ, тийм!" гэж хэлнэ, тэр нь мөнөөх л хоосон амлалт байдаг!

Есүс хүмүүст усан баталгаа өгөхдөө тэдэнд Гэрэл өгдөг байсныг та нар мэдэж авах ёстой. Есүс өөрөө Баптист Жоноос усан баталгаа хүртэж байхдаа тагтаа байдлаар Дивааажингийн Гэрлийг хүртсэн. Тиймээс та ч бас тэрийг харах ёстой. Тэр Гэрлийг харвал энэ нь та Есүсийнхтэй адилхан аргаар бясалгаж буйн баталгаа. Тийм биш бол энэ чинь тэр чигтээ буруу, бүгдээрээ төөрөгдөл юм.

***Асуулт 8:*** *Бурханы дуу хоолойг өөрийнхөө би үзлийн дуу хоолойноос Та яаж ялгаж таньдаг вэ? Бурханы дуу хоолойг бид яаж мэдэх вэ?*

**Багш:** Тэр өөр л дөө. Тийм л учраас бид бясалгах ёстой юм. Бид Бурханы хүчтэй нэвтрэлцэхэд л би үзэл алга болно. Одоогийн энэ агшинд бид бүх зүйлийг би үзэлтэй хийж байна: "Бид энэ хүнд тусалсан, бид тэр хүнд тусалсан" гэж ярьдаг. Энэ бүхэн бүгд би үзэл. "Тэр эмэгтэйд тусалсан, би түүний төлөө үүнийг хийсэн" гэсэн сэтгэл ханамжийн мэдрэхүйг бид мэдэрч байдаг. Харин энэ хамгийн Оройн Дээд Хүчтэй (Supreme Power) нэвтрэлцэнгүүт бид "Би" эдгээрийг хийж байна гэсэн мэдэрхүйгээ гээж, Бурхан бүгдийг хийж буйг харна. Бурхан энэ биеийг ашигладаг юм. Тэр бие нь ч бас Бурхан. Тусалж байгаа нь ч, туслуулж байгаа нь ч бүгд Бурхан. Тэгээд та цаашид тэрхүү тусгаарлалтыг мэдрэхээ болино.

***Асуулт 9:*** *Гэгээрэлд хүрэх агшин зуурын арга гэж чухам юу вэ?*

**Багш:** Өө! Түүнийг Би танд дамжуулах үедээ заах болно. Учир нь тэр аргыг заахад хүний хэл яриаг хэрэглэдэггүй юм, Би тэнд чимээгүй сууж байхад л та тэрийг авчихна. Одоо бол Би дэндүү их ярьлаа. Энэ бүхэн ердөө л жигнэмэгийн сурталчилгаа (Инээв).

***Асуулт 10:*** *Орчлон ертөнцөөр зугаалахад хэдий хэр хугацаа орох вэ?*

**Багш:** Өө, их хурдан. Дамжуулалтын үед та үүнийг авч магадгүй, гэхдээ зарим хүн арай урт удаан хугацаа зориулдаг. Энэ нь таны урьд төрлүүддээ хэр их буянтай байсан, мөн Их Багшийн хүчинд хэр их итгэдэг зэргээс хамаарна.

***Асуулт 11:*** *Та намайг бялхтал адислаж өгөөч гэжээ - "Мэри".*

**Багш:** Танд баярлалаа, өршөөгөөрэй. Та их сайхан сэтгэлтэй юм, энд бүр хаягаа ч бичихжээ. Хүмүүс хаягаа энд хэдийнээ тавьчихжээ. Их сайн. Зөвхөн та л өөрийгөө адислаж чадна. Би таныг адислаж чадахгүй. Мэри, би таныг адислаж чадахгүй. Таны дотоодод адислалын Хүч бий. Би танд Түүнийг хэрхэн ашиглахыг л харуулж чадна. Хэрэв би таныг адислаж чадах байсан бол дэлхийг ч бас бүхэлд нь адислаж чадах л байсан, тэгчихвэл надад энд ирэх шаардлага байхгүй болно. Би гэртээ суугаад л адислаж болно гэсэн үг (Инээв).

Би таныг мэхэлж чадахгүй. Таны төлөө би бүхнийг хийж чадна гэж хэлж, таныг хуурч чадахгүй. Та хамгийн эхний алхмыг хийж, ямар нэгэн юмаа золиосолж, Бурханд чин сэтгэлээ харуулах ёстой. Та ургамал хоолтон болсон байх ёстой, Түүнтэй холбоо барихаар өдөр бүр цаг заваасаа хэсэгхэн хугацааг зориулах учиртай. Бурхан өдөр бүр таныг хүлээж байдаг боловч та завгүй, өдөр болгон таныг адислая гэтэл та өөрөө завгүй байдаг. Би ч бас таныг адислаж болно л доо, гэхдээ зөвхөн та эхний алхмыг хийж, авшиг хүртэх аваас бид хамтдаа болно, бид холбогдож чадна. Одоо энэ мөчид миний болон та нарын харилцах утас тасарсан байна, юутай ч гэсэн адислалаа гэхэд дунд хэрд нь очоод л буцаад над руу ирчихнэ. Энэ нь би утсан дээр ганцаараа өөртэйгээ яриад л, нөгөө үзүүрт буй та юу ч сонсохгүйтэй ижил юм, учир нь харилцах утаснууд хоорондоо холбогдоогүй байна.

Тэгэхлээр авшиг хүртэх үед бид холбогдож, телефон утаснууд маань дахин засагддаг, тэгснээр миний бүх адислал таных болно. Би өөртөө юу ч хадгалж үлдээхгүй. Та миний бүх адислалыг авах нь чөлөөтэй. Харин яг одоо бол та авахгүй, тодорхой хэмжээнд чадахгүй. Мэдээжээр бага зэрэг адислуулалгүй яахав, гэхдээ “Намайг бялхтал адислаач“ гэж гуйсан шигээ дүүртлээ адислуулж чадахгүй. Үүнийг та хичээл зүтгэлээрээ өөрөө хийж чадах зүйл. Би хүртэл таныг бага зэрэг л адислаж чадна.Тэгэхээр та өөрөө л үүнийг хий дээ.

***Асуулт 12:*** *Энэ ямар арга вэ? Энэ бясалгал мөн үү? Хэр удаан үргэлжилдэг вэ?*

**Багш:** Тийм ээ, энэ бол бясалгал, гэхдээ та нарын байнга төсөөлдөг шиг нь биш. Энэ бясалгалд ямар ч хичээл зүтгэл шаардлагагүй. “Хэр удаан үргэлжилдэг вэ?” гэлээ. Маш хурдан. Та авшиг хүртсэн даруйдаа мэдчихнэ, маш хурдан. Ердөө л хормын дотор та Бурханы хүчтэй холбогдоно. Дэндүү удаан хүлээх хэрэг байхгүй.

***Асуулт 13:*** *Та Ганди болон Мартин Лютер Кинг нарыг юу гэж боддог вэ?*

**Багш:** Өө! Би тэднийг биширч, маш их хүндэлдэг. Ганди, Мартин Лютер Кинг нар шиг хүмүүсээр дэлхий дүүрэн байсан бол би энэ ажлаа орхих сон. Тийм ээ, бүгдээрээ хамтдаа өдөр болгон дуулж хуурдаад л их сайхан байхсан. Даанч тэдэн шиг хүмүүс ховор байдаг нь харамсалтай.

***Асуулт 14:*** *Танд Католик шашинтай байх боломж байжээ, бас Та Буддын болон Католик шашны хооронд адил төстэй зүйл олон бий гэж дурьдсан, тэгвэл Та яагаад Буддын шашныг нь сонгосон юм бэ?*

**Багш:** За, Би өөрчилж болно. Би маргааш Католик шашинтан болж чадна. Гэхдээ тэгэх хэрэг юу байна вэ? Та ямар л байна, тэндээ л үлд гэж би та нарт хэдийнээ хэлсэн шүү дээ, учир нь энэ бол ердөө л гадна талын харагдах байдал. Дотроо бол ямар ч ялгаа байхгүй. Та гэгээрчихвэл, Буддын шашинтай ч бай, Католик шашинтай ч бай, гэгээрсэн хэвээрээ л байна. Тийм болохоор би Католик гэлэнмаа болоод өөрчлөгдчихвөл, хүмүүс надаас “Өө, Та яагаад Католик шашныг сонгож

байгаа юм бэ?" гэж асууна. Тэгээд л төөрөгдөл үүснэ. Тиймээс би энэ байгаа хэвээрээ үлдье дээ.

***Асуулт 15:*** *Амьдралын зорилго гэж юу вэ? Дахин төрөл авахыг үнэхээр байдаг гэдгийг хүн хэрхэн мэдэх вэ? Сүнс гэж юу вэ, түүний эх сурвалж нь юу вэ?*

**Багш:** Маш олон асуулт байна. Амьдралын зорилго нь юу вэ? Үүнийг зөвхөн гэгээрснийхээ дараа л мэдэж чадна гэж би боддог. Одоо би хичнээн хэллээ ч та ойлгохгүй. Бас надад итгэх ч үгүй. Амьдралын зорилго юу вэ гэвэл өөрийн дотоод Хүчээ ашиглан энэ дэлхийг адисла гэж Бурхан биднийг илгээсэн явдал юм. Гэвч бид маш их адисласаар, өөрсдөө ядарч туйлджээ. Бидний эрдэнэс шавхагдаж байна, эрч хүч дуусаж байна, одоо түүнийгээ дахин цэнэглэх шаардлагатай байна. Гэтэл бид үүнийг мэддэггүй. Тийм учраас би та нарыг дахин цэнэглэх даалгавартай ирсэн юм. Тэгж гэмээнэ та нар энэ амьдрал, энэ дэлхийгээ дахин адислаж чадна. Дараа нь та нар гар хоосон бус, харин эхлэлгүй цагаас хойш, анх байсан шигээ дүүрэн бөгөөд адис хайртайгаар Гэртээ харьж чадна.

***Асуулт 16:*** *Дахин төрөл олох гэдэг зүйл үнэхээр оршдгийг бид яаж мэдэх вэ?*

**Багш:** Би танд хэдийнээ хэлсэн шүү дээ. Есүс Өөрийгөө ийм, тийм аугаа Их Багшийн хойд дүр гэж бас Библид хэлсэн байдаг. Хэдий тийм ч бид Хоёрдугаар Ертөнцөд очиж, тэндэхийн амьдралын номын санд орж үзэхээс наашТүүний хэлсэнд итгэж чадахгүй, тийшээ орж үзэж байж л эргэлзэлгүй итгэнэ. Ийм ч учраас урьд төрлүүдээ мэддэг Буддын болон Католик шашны олон лам хувраг, хүмүүс байдаг. Асуудлын гол нь бид тэдэнд итгэхэд бэрх, тийм биш гэж үү?

***Асуулт 17:*** *Тэгвэл сүнс гэж юу вэ?*

**Багш:** Би танд хэлсэн. Сүнс гэдэг бол яг одоо хөдөлгөөнгүй, нам жим буй бидний жинхэнэ Би юм. Бид түүнийг сэрээх ёстой, үүнийг л сэрэхүй буюу гэгээрэхүй гэж нэрлээд байгаа юм. Сэрж, гэгээрч гэмээнэ та сүнс гэж юу болохыг мэднэ. Одоо бол та ердөө л бие гэж юу юм, тархи гэж юу юм гэдгийг л мэднэ, харин сэрснийхээ дараа сүнс гэж юу болохыг мэднэ.

***Асуулт 18:*** *Эмчлүүлж буй сэтгэл мэдрэлийн өвчтэй хүний хувьд гэгээрэх боломж бий юу?*

**Багш:** Хэрэв тэр хүн миний ярьж буйг ойлгож байгаа бол авшиг хүртэн тусыг нь авч өдрөөс өдөрт улам сайжирч болно. Эм хэрэглэх шаардлагагүй. Та энд ирээд миний яриаг ойлгож байгаа нь та сэтгэцийн өвчтэй биш гэдгийн баталгаа. Магадгүй та сэтгэл гутарсан, сэтгэхүй саатсан, эсвэл нийгмээс тасарсан байх, учир нь заримдаа бид нийгэмтэй адил биш бодож сэтгэдэг, тэгээд хүмүүс биднийг сэтгэцийн өвчтэй гээд бодчихдог. Тийм биш байж болно шүү дээ. Тийм биш байх. Бид нийгмээс ирэх дарамт шахалтыг тэвчиж өнгөрөөж чадахгүй бол хүмүүс биднийг мэдрэл муутай гэдэг. Заримдаа ийм зүйл тохиолддог.

***Асуулт 19:*** *Та агаарт хөвөх, нисэх, хүний бодол унших, нэгэн зэрэг олон газар үзэгдэх зэрэг ид шид үзүүлж чадах уу? Эдгээр нь чухал биш гэж үү?*

**Багш:** Үгүй ээ, чухал биш. Иймэрхүү ид шидийн хүч чухал биш. Шувууд нисч чадна, тэд нисч л байна, онцгой юм юу ч алга. Онгоц нисч чадна, гэхдээ онгоц их багш биш, хорхой шавьжнууд хаа сайгүй л нисч байна, тэглээ гээд тэд их багш биш. Жинхэнэ багш гэдгээ батлахын тулд шувуу, эсвэл хорхойг дуурайх шаардлага байхгүй. Хэдийгээр би ниссэн байлаа ч хүмүүс шувуу гэж бодоод буудчихвал яана, тиймээс би нисэхгүй (Багш Инээв). Би тэнэг биш ээ. Хүмүүс буутай. Ийм нийгэмд тэнгэрт хүн нисэж байна гэж та нар төсөөлж чадах уу? Та ч асуудал үүсгэх нь дээ, тийм үү? (Инээв.) Та тэгж бодохгүй байна уу? Тийм. (Алга ташив.) За, та нарт баярлалаа.

Нэгэн зэрэг олон газар үзэгдэхийн тухайд бол, тийм ээ, би тэгж чадна, гэхдээ энэ бие махбодоор биш, харин хувилгаан биеэрээ. Би та нарт хэлж байсан. Хувилгаан биеийг минь харахын тулд та өөр нүдээ хэрэглэх ёстой, эсвэл их онцгой адислалт нөхцөлд байх учиртай. Гэхдээ Би ердөө л өөрийгөө батлахын төлөө ингэхгүй. Есүс "***Бурханаараа бүү оролд***" гэж хэлсэн байдаг. Хэрвээ би үргэлж өөрийгөө батлан харуулах ёстой юм бол та нарын итгэлийг хүлээх хүн биш гэж бодож байна. Өөрийнхөө хэр аугаа болохыг харуулах гэж хичээж буй хэн ч бай, тэр үнэндээ аугаа биш гэсэн үг. Хүмүүсийг өөрийнхөө учир зүй, билиг ухааныг хайж олохыг нь учирлан ярья гэвэл та учир зүй, билиг ухаан гаргах ёстой.

Хэрэв тэд хангалттай билиг ухаантай бол танд итгэнэ. Хэрвээ энэ мэт ид шидийн ов мэх, хүүхдийн тоглоомыг ашиглаж, хүмүүсээр тоглож даажигнавал энэ чинь сайн бодол биш байна, тийм үү? Уучлаарай! Та яваад зарим илбэчинг ч олж болно, тэд үүнийг хийчихнэ, тэд агаарт ниснэ, хөвнө, хүүхдийн бүхий л тоглоомыг тоглочихно. Хэрвээ шавь нар маань тэгэх юм бол, би тэднийг болгож өгнө (Их Багш Инээв). "Чи чинь чөтгөр болох нь уу" гээд л би зэмлэнэ дээ. Энэ чинь шалихгүй зүйл, үнэ цэнэгүй юм.

Бясалгаж байхдаа та нэгэн төрлийн хөвөх байдалд нэг, хоёр удаа эсвэл нэг минутын туршид орж магадгүй. Энэ нь дотор чинь чөтгөр байна гэсэн үг, үүгээр бахархан онгирч, яриад байх юм юу ч байхгүй. Энэ талаар бүр ярих ч хэрэггүй, юманд эзлэгдсэнээ л хүмүүст мэдэгдэх хэрэг. Аугаа Их Багш иймэрхүү ов мэх хэзээ ч хийхгүй. Өршөөгөөрэй. Энэ бол Барууныхнаас гаралтай буруу мэдээллийн нэг байна.

***Асуулт 20:*** *Бурхан байна гэдгийг бид яаж лавтай мэдэж болох вэ?*

**Багш:** Бид мэдэж чадна. Арьяабалын бясалгалын аргаар бясалгах үедээ бид өдөр бүр Бурхантай холбогддог. Бид Бурханыг яг л би та нарыг харж байгаа мэт, бүр миний харж байгаагаас ч илүү тод нүд, Билгийн мэлмийгээрээ хардаг болохоос биш, энэ булингартай нүд, хүмүүний ухамсрын хязгаарлагдмал үзэгдлээр хардаг юм биш. Бид Бурханыг илүү тод харна.

***Асуулт 21:*** *Хойд төрөл олно гэж Есүс Христ хэлсэн нь зөв үү?*

**Багш:** Есүс Христийн зөв өө. Тэрбээр ***Энэ дэлхий дээр байгаа цагтаа Би энэ дэлхийн Гэрэл нь*** гэж хэлсэн. Энэ нь хожим ирэх дараа дараагийн хүмүүс байгаа гэсэн үг. Тэр бас, ***Миний араас бүү гашууд, явсныхаа дараа Би та нарт Тайтгаруулагчдыг илгээнэ*** гэж хэлсэн. Тийм биш гэж үү? ***дараа Би та нарт Тайтгаруулагчдыг илгээнэ*** гэж Тэр хэлсэн байна шүү дээ. Энэ нь өөр хойд төрөл "ирнэ", ондоо гэгээнтэн, өөр элч нар "ирнэ" гэсэн үг. Тэгэхээр Тэр зөв хэлсэн байна.

***Асуулт 22:*** *Их Багш Чин Хай танаас би хоёр асуулт асуух гэсэн юм. Эхнийх нь, та надад зааж буй бясалгалынхаа талаар товч дүрсэлж өгнө үү? Хоёрт, таны энэ бясалгалын арга өөр бусад аргатай зөрчилдөх үү?*

**Багш:** Товчхон тайлбарлавал, тэнгэрлиг Бурханы хүч буюу дотоодын Гэрэлтэй холбогдох болон дотоодын үг буюу дотоод дахь Бурханы Үгийг сонсохын тулд өөрийгөө хэрхэн төвлөрүүлэхийг Би та нарт харуулна. Энэ л үндсэндээ арга гэгдэх зүйл юм даа. Гэхдээ үүнийг хийхэд Би ямар ч хэл яриа хэрэглэдэггүй. Би та нарт бүх төрлийн диваажингийн дүрс байдлыг, эсвэл ухамсрын чинь янз бүрийн төвшинг тайлбарлан ярьж өгч болно, ингэвэл та хаана ч явж байсан өөрийнхөө ямар төвшинд буйгаа мэдэж магад. Би та нарт энэ бүх гадна талын зүйлийг тайлбарлаж өгч болох юм, харин энэ арга маань анир чимээгүй дамжуулагддаг. Би чимээгүй байж байх нь та нарт дамжуулж байгаа үе юм, тэгээд л Гэрэл харж, Аялгуу сонсоно. Харин одоо бол би яриад байгаа ч та нар юу ч харж, сонсохгүй байгаа.

Тэгэхлээр энэ арга нь угтаа арга биш юм. Энэ бол дотоод Хүч хүнээс хүнд, зүрхнээс зүрхэнд дамжиж байгаа явдал юм. Тийм учраас бид үүнийг Зэнд "Иенг Шин" (Хятадаар) гэж нэрлэдэг юм. "Зүрхний тамга" гэсэн үг. Ийм л юм. "Зүрх" гэдэг нь энэ физик зүрх биш, харин бидний Хүч, дотоод билиг ухаан юм. Үнэндээ Бурхантай холбогдсон байгааг эс тооцвол арга гэж яриад байх юм байхгүй. Энэ үед та түүнийг дамжуулж чадна. Тэр танд үүнийг зөвшөөрнө.

Харин тэгснээр та юу ч харсан байлаа гэсэн та гэгээрнэ. Гэрэл харна, Аялгуу сонсоно, зарим тэнгэрлиг орныг харна. Магадгүй Есүсийг харна, Буддаг харна. Тэднээс эртний билиг ухааныг суралцаж магадгүй. Энэ нь энэхүү аргаас хүртэж буй өгөөж, ололт амжилт юм, харин энэ арга өөрөө бол арга биш. Зөвхөн Гэрлийн чимээгүй дамжуулалт л юм.

***Асуулт 23:*** *Тэгвэл гэгээрэл, билиг ухааны зах зухаас хүртэхийн тулд хийвэл зохих хамгийн эхний алхам юу вэ?*

**Багш:** Хамгийн эхний алхам юу вэ гэж үү? Тэр нь Авшиг хүртэхүй юм. Та билгийн нүдийг тань нээж өгөхийг надад дуртайяа зөвшөөрөх, билгийн чихийг тань нээж өгөх, дотоодод тань буй Бурханы адислалын Хүчийг танд нээж өгөхийг надад дуртайяа зөвшөөр, тэгээд өдөр бүр түүнийгээ хэрэглэ. Яагаад гэвэл надад түлхүүр

нь байна. Петрт диваажинд хүрэх түлхүүр байсан гэхийг сонссон биз дээ? Тэгвэл одоо тэр түлхүүрээ надад өгчихсөн байна.

***Асуулт 24:*** *Биднийг энэлэл шаналалд гацаадаг тэр уй гашуугаас хэрхэн ангижрах вэ?*

**Багш:** Тийм ээ, энэ үнэн. Тийм биз? Бид түүнээс салах ёстой. Авшиг хүрт, сэтгэл санаагаа өргө, тэгэнгүүт хамаг л зовлон дарамт тань угаагдана. Эцэг, эх тань өөд боллоо ч та тэдний хаашаа явж буйг мэдэх тул тэгтлээ их гашуудахгүй. Их Багшийн хувилгаан дүр нь ирээд тэднийг Диваажин руу аваачихыг та харах учраас уй гашуудалд автахгүй. Бясалгал дадуулж эхэлснээр та бүх найз нөхөр, төрөл садан тань илүү жаргалтай газар луу явахыг харах болно. Тиймээс гашуудахын оронд та жаргалтай байх болно. Энэ л аз жаргалын нууц юм, учир нь мянга сонсохоор нэг үз гэдэг шүү дээ.

Хэн нэгэн таныг орхих юмуу, нас нөгчихөд яагаад гашууддаг юм бэ? Учир нь тэр хүний хаашаа явж байгааг та мэдэхгүй байгаа болохоороо л тэр, тиймээс л та гарз хохирлыг мэдэрдэг хэрэг. Харин түүний хаашаа явахыг, тэр хаа нэг газарт жаргалтай байхыг, бүр түүн дээр зочилж чадахаа мэдчихвэл та уйлж гашуудахгүй. Бясалгал дадуулахын нууц нь энэ л юм. Ач тус нь энэ, ийм учраас бид бясалгах ёстой.

***Асуулт 25:*** *Хүн дан өөрөө зүтгээд гэгээрэлд хүрэх боломжтой юу эсвэл заавал нэг шаши, юмуу дүрэм зарчим дагах ёстой юу?*

**Багш:** Үгүй, үгүй. Бид гэгээрэлд өөрсдөө л хүрэх ёстой. Шашнууд бидэнд тусалж чадахгүй. Шашнууд бол урьд цагийн гэгээрсэн их багш нарын үлдээсэн сургаал номлол л юм. Бид түүнээс ердөө л мэдээлэл авч, эш татаж, өөрийнхөө гэгээрэлтэй харьцуулж л болно. Бидний явж буй зам мөр эртний багш нарынхтай таарч байгаа эсэх, бясалгалын арга маань зөв эсэх, гэгээрэл маань тэднийхтэй ижил буй эсэхийг харахыг тулд л юм шүү дээ. Сургаал номлолын сайн тал нь энэ л юм.

Би түрүүхэн Есүс авшиг хүртэх үедээ буюу адислуулахдаа диваажингаас бууж ирж буй тагтаа шиг гэрлийг харсан гэж дурдсан - угтаа “баптизм” гэдэг нь “Авшиг хүртсэн” гэсэн үг. Тэгвэл одоо Их Багш Чин Хайгаас авшиг хүртвэл бид тагтаа адил диваажингаас буух тэр гэрлийг, эсвэл өөр юуг ч юм харна, тэгээд л бид “Тэр яг адилхан аргыг дамжуулдаг юм байна” гэж хэлж чадна. Сургаал номлол бол ердөө л бидний гарын авлага юм. Түүнээс биш Библи биднийг гэгээрүүлж чадахгүй. Аль ч шашин, аль ч шашны Библи бидэнд дотоодын Гэрэл, дотоодын аз жаргал, сэтгэл ханамжийг хүртэхэд туслаж чадахгүй. Зөвхөн жинхэнэ, амьд Бурханы хүчээс ирэх дамжуулалт л бидний хамаг хүслэнг гүйцээдэг юм.

***Асуулт 26:*** *Авшиг хүртээд өдөрт хоёр цаг гучин минут бясалгах ёстой юм байна. Тэгвэл би энэ хоёр цаг гучин минутын бясалгалыг орлуулж “Нам–мёо-хо-ренге-кёо”–г уншиж болох уу? Би энэ шашнаа орхимооргүй байна л даа.*

**Багш:** Үнэндээ та үүнийгээ уншина уу, үгүй юу над ямар ч ялгаагүй. Таны шашин шүтлэгийг үгүйсгэхгүй. Би ердөө л үүнийг уншихад цаг заваа зориулаад байвал танд энэ аниргүй хүчтэй холбогдох хангалттай нам гүм байдал олдохгүй болов уу гэж л айж байна. Учир нь амаа ашиглаж байх үедээ бид завгүй болчихдог. Маани уншихлаар Бурхан ирдэг юм биш. Бурхан үргэлж анир чимээгүйд ирдэг.

Уншмаар байвал, уншиж болно. Уншихийг тань би зөвшөөрнө, гэхдээ та чимээгүй сууж, зөвхөн оюун ухаанаа л хэрэглэх ёстой. Би бас танд нэг унших ном зааж өгье, гэхдээ амаараа уншихгүй, билиг ухаанаараа уншина, тэгээд та хамтад нь нэмж нийлүүлээд жаргалтай болно. Мөн манай аргаар та Гэрлийг олно, тэгээд бас баяр жаргалтай болно, учир нь танд энэ дадлаа орхих шаардлага гарахгүй. Та надтай наймаалцлаа (Инээв).

***Асуулт 27:*** *Хүн цэцэрлэгээ арчилж, хүнсний ногоо тарьж байхдаа ногоо иддэг амьтдыг хороож байгаа нь Буддын шашинтай зөрчилдөж байна уу? Иймэрхүү доод хэлбэрийн зүйлсийг яах вэ?*

**Багш:** Таны сэтгэл зөрчилдөөд байгаа бол Би бүгдээрээ өлсөж үхье гэж л хэлэх байна. Учир нь бид бүр амьсгалахдаа хүртэл маш олон нүдэнд үл үзэгдэх амьтныг хороож байдаг. Тэгэхлээр бид яах болж байна вэ? Амьд бүхнийг хороох учраас ногоо идэж болохгүй, тарьж ургуулж ч болохгүй, бүр амьсгалж, явж ч болохгүй нь ээ. Тэгвэл ямар шийдэл байна вэ?

Бясалгаж, үйл үрээ, зайлсхийх аргагүй энэ үйлээ угаахаас өөр ямар ч шийдэл байхгүй. Энэ дэлхийд амьдрахын тулд бид их ч, бага ч бусдыг, шавж, өт хорхойг хөнөөхөөс өөр аргагүй байдаг. Гараа угаах бүртээ хөнөөж байна. Юмсыг халдвагүйжүүлэх нь амь хороож л байгаа хэрэг. Гэвч бид үүнийг яах болж байна аа? Бид ингэхээс аргагүй, тэгтэл бас өөр гэм нүгэл байна. Бид үүнийг санаатай үйлддэггүй бол энэ нь харгислалаас ялгагдах ялгаа. Бид энд амьдрах ёстой болохоор амьдрахын тулд ямар нэг юм идэх ёстой. Бид амьсгалах ёстой, гараа угаах ёстой, гэлээ ч бид санаатай хийгээгүй ч энэ зайлсхийх аргагүй үйл үр нь ямар ч үйл тариагүй гэсэн үг биш. Бидэнд үйлийн үр байсаар л байгаа, нүгэл ч байж л байгаа.

Тиймээс бид Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж, өдөр бүр үүнийгээ арилгах ёстой. Тэгж л үйл үрээсээ ангижирна, ингэхгүй л бол бидэнд аллагаас чөлөөлөгдөх арга зам байхгүй. Уучлаарай. Ийм учраас бид угаан ариусгагч аргаар бясалгах шаардлагатай. Тийм биш бол та сайн үйл хийгээд амь хөнөөхгүй байхад хангалттай байх байсан. Тийм биш, тийм биш, ногоо идэх чинь хүртэл амь хөнөөлт. Ногоонууд амьтай. Тиймээс та эрх чөлөөтэй болж, энэ жаахан үйл үрийг цэвэрлэхийн тулд ямар нэг чадалтай хүчийг хэрэглэх ёстой.

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт

**АНУ, Калифорни муж, Сан Франциско, Холидэй Инн**
**1989 оны 5 дугаар сарын 25**

***Асуулт 28:*** *Хулгай гэж юу вэ?*

**Багш:** Та мэддэггүй гэж үү? Өөрийн биш юмыг зөвшөөрөлгүй, эсвэл урьдчилан асуулгүйгээр авахыг хулгай гэнэ. Шил, ганц зүү, бүр дэндүү их ярих ч бас хулгай юм. Хүний цаг зав, хүч, энергиэс хулгайлж байна. Та ийм төрлийн хулгайг маш сайн мэднэ. Зарим найз тань өөр лүү чинь утасдаад хэдэн цагаар ярьдаг, та утсаа тавьж чадахгүй бүр ядарч орхидог. Эелдэг зан, өрөвдөх сэтгэлээсээ болж та сонсоод л байдаг..., тун залхмаар учраас юу яриад байгааг нь ч ойлгохгүй. Энэ чинь бас л хулгай, тийм шүү! Дэмий юмны тухай ярьж байхын оронд Бурханыг таньж мэдэхэд цаг заваа зориулсан нь бидэнд хэрэгтэй.

***Асуулт 29:*** *Арьяабалын бясалгалын арга, дотоодын Аялгуу гэж юу вэ?*

**Багш:** За. Ийм юм л даа, энэ нь та өөрөө Бурханы адислалыг хүлээн авахад нээлттэй байх үед тэр зүйл хүрч ирдэг. Тэгэхлээр энэ арга угтаа бол Бурханы адислал. Энэ нь миний юм биш. Зөвхөн сэтгэл оюун тань нээлттэй, бүрэн дүүрэн буулт хийж, хүлээн авахыг хүссэн байх үед л та энэ аргыг авч чадна. Энэ арга нь үггүй арга, үүнийг дамжуулахад бид ярьдаггүй, ингээд та дотоод Хэлбэлзлийг хүлээн авна. Энэ хэлбэлзлийг сонсоно, гэхдээ энэ чихээрээ биш, Бурханы Гэрлийг, эсвэл диваажингийн орнуудыг энэ нүднийхээ оролцоогүйгээр харна. Энэ бол манай энэ аргаас танд ирж буй зүйл болохоос биш, арга нь өөрөө биш. Учир нь би энэ аргыг хүний хэлээр ярьж болдоггүй. Ийм учраас л бид зүрхнээс зүрхэнд буюу сэтгэлээс сэтгэлд уламжлах гэж нэрлэдэг юм.

***Асуулт 30:*** *Дотоодын Аялгуу хүнийг хэрхэн гэтэлгэдэг юм бэ?*

**Багш:** Учир нь дотоодын Аялгуу бол Бурхан юм. Хэрэв та тэр аялгуунуудыг мэддэг бол энэ нь та Бурханыг мэддэг, Түүнд их ойртсон гэсэн үг. Бурханд ойртоно гэдэг чинь чөтгөрүүдээс холджээ гэсэн үг. Энэ чинь энгийн зүйл. Бурхантай ойр байна гэдэг чинь гэтэлсэн буюу Буддатай ойр байна гэсэн үг. Будда болно гэдэг нь сүнс гэтлэгдсэн, хүлээснээс чөлөөлөгдсөн, үхэж төрөхийн хүрднээс чөлөөлөгдлөө гэсэн үг. Энэ нь гэтэлсэн гэсэн үг. Гэхдээ өөр илүү тодорхой зүйл бий, энэ дамжуулалтыг

хүлээн авах үедээ та агшин зуур үхлийг хэтийдэн давдаг. Бидний гэтлэгдэх гэж нэрлэдэг тэр зүйл бол энэ л юм.

Өчигдөр би бараг гучаад хүнд аргыг уламжлахад тэдний зарим нь үхэх туршлагыг амссан байна лээ. Энэ нь дахин төрсөн гэж нэрлэдэг тэр зүйл. ***Дахин төрөхгүй л бол Бурханы оронд нэвтэрч чадахгүй.*** Тэгэхлээр "Дахин төрнө", эсвэл "Би өдөр бүр үхдэг" гэж юуг хэлдэг хэрэг вэ. Католик шашны нэгэн гэгээнтэн "***Би өдөр бүр үхдэг***" гэсэн байдаг. Би өдөр бүр үхдэг гэдэг чинь юу юм бэ? Бид амьдарч байна, харин тэр би үхдэг гэж хэлсэн байдаг. Тэр өдөрт хэдэн зуун удаа үхдэг гэсэн. Амьд байхдаа үхнэ гэсэн үг. Та үхнэ, тэгсэн атлаа үхэхгүй. Та ердөө л үхлийн хязгааруудыг давдаг хэрэг, тэгээд үүрд амьдарна. Үхлийн айдас замхран үгүй болмогц л өчүүхэн сул дорой, айж дагжсан сүнс маань ойлгож давчихад л бид үүрд мөнхийнх болно. Бид хэвийн байгаа хэрнээ үхэшгүй мөнх болно. Тэр үүнийг л хэлсэн юм.

Өчигдөр нэгэн бясалгагч маань бясалгаж байхдаа ердөө хэдхэн секунд, минутын турш агшин зуур Гэрэл, бас хонгил харсан гэсэн. Та нар харанхуй хонгилыг мэднэ дээ, дотроо Гэрэлтэй. Тэгээд тэр нөгөө хонгилоор яг л завиар яваа мэт хөвсөн байна. Тэр ингэж л хэлсэн юм. Тэгвэл энэ юу юм бол? Та нар үхлийн ирмэгт очсон хүмүүст тохиолдсон явдлын тухай зурагтаар сонсож, номоос уншсан байх. Та үзээгүй юу? Тэр хүмүүс энэ том хонгилыг харж, түүгээр хөвөн өнгөрөх ёстой болдог юм, дараа нь асар том Гэрэл үзнэ, гэтэл хэн нэгэн хүн тэдэнд та үхсэн гэж хэлж өгдөг. Гэхдээ цаг нь арай болоогүй тул тэд дэлхий рүү дахин буцаад л ирнэ. Тиймээс тэдний зарим нь гэртээ ирдэг юм. Нэгэн эмэгтэй хоёр долоо хоногийн турш байн байн уйлсан гэсэн, учир нь өнөөх гайхамшигт ертөнцийг орхин энэ аймшигтай газар буцаж ирэхээс өөр аргагүй болсон болохоор л тэр. Тэр бол үхэл амьдрал хоёрын хоорондох хязгаар. Зарим хүн үхлийн ирмэгт тулсан үедээ үүнийг үзсэн байдаг.

Яагаад гэвэл тэд буян хариулалтай байсаар ирсэн тул тэд үхэлтэй тулах үедээ агшин зуур Гэрлийн бүсэд ордог. Гэхдээ тэрхүү Гэрлийн бүс нь хамгийн дээд нь биш, үүнийг би та нарт хэлье. Бүр илүү өндөр дээд бүсүүд бас бий. Харин энэ бол манай дэлхий болон бусад ертөнцийн хоорондох хил хязгаар төдийхөн юм. Энэ нь ердөө л бусад ертөнцийн эхлэл. Бусад ертөнцүүд бүр өндрөөс өндөрт байх бөгөөд Гэрлийн хязгааргүй хүрээнүүдтэй байдаг. Тэгээд та бүр өндөр лүү нь явахын хэрээр хэлэх үггүй болно. Хэлэх ч үггүй, юуны ч тухай ярих зүйлгүй болно. Үүнийг бусдад илэрхийлэн хэлэх гэж буй Их Багш Чин Хай мэтийн хэдэн тэнэг хүмүүсийг эс тооцвол яриад байх юм юу ч байхгүй. Тэгсэн хэрнээ л Чин Хай ахиухан юм хэлж чадаагүй. Өчигдөр энэ эрэгтэй, бас бусад хүн үүнийг үзэж мэдэрсэн болохоор л би энэ талаар ярьж байна. Тэд үхэл, амьдралын хязгааруудыг нэвтэрч, бас үхээд буцаад ирсэн байна. Үхсэн, эсвэл үхлийн ирмэгт очсон хэдэн зуун тохиолдол болон үхээд буцаж амьдарсан өвчтөнүүдийн туршлагын тухай энэ тэр эмчийн бичиж тэмдэглэсэнтэй ижил зүйлийг тэд үзэж мэдэрчээ. Тэгэхлээр энэ бол дахин төрөх буюу үхэл болон амьдралыг давсан, үхэх болон амьдрахаас чөлөөлөгдөх гэж нэрлэдэг тэр зүйл юм. Амьд байхдаа хэрхэн үхэж болдгийг мэдчих л юм бол та үхлээс цаашид айхгүй болно, хэдийд ч бай хэрхэн үхэхийг мэднэ. Тэгээд энэ

дэлхийд байх цаг чинь дуусахад түүнийгээ бүр урьдчилаад мэдчихнэ. Их Багш чинь танд "Гурван хоногийн дараа чиний явах цаг чинь болно. Эсвэл долоо хоногийн дараа өөр газар руу явна шүү, бэлтгээрэй. Хүнд өртэй бол даруй буцааж өг, эсвэл хүүхдэд чинь ямар нэгэн юм хэрэгтэй байна, даатгал, амь даатгал үлдээ." гэхчлэн хэлнэ. Бид иймэрхүү зүйлээ зохицуулах ёстой болно.

Авшиг хүртсэний дараа Их Багш таныг өчүүхэн жижиг зүйл дээр хүртэл харж хандана. Энэ бол түүний ажил. Тэрээр маш их ажил амжуулдаг бөгөөд үүнд нь бүр бичиг цаас, захиргааны ажил ч багтана. Өч төчнөөн төвөг бэрхшээлээр дүүрэн энэ дэлхийд амьдарч байгаа болохоор Их Багш хэдий өөрийнх нь ажил биш ч гэлээ тэр бүхнийг зохицуулахаас өөр аргагүй болдог. Тэгэхгүй л бол бишрэгч нь чөлөөлөгдөж чадахгүй. Ийм учраас л бид үхэл амьдралыг давах, үхэл, амьдралаас чөлөөлөгдөх зэргийг өчнөөн сонсдог хэрнээ яг юу юм бэ гэдгийг нь мэддэггүй. Үхэл, амьдралаас чөлөөлөгдөх гэдэг нь чухамхүү энэ л юм. Авшиг хүртэх үедээ та чанагуухид одож, амьдрал гэж юу юм бэ, үхэл гэж бас юу болохыг мэднэ, ингээд танд ямар ч айдас хүйдэс үгүй болно.

***Асуулт 31:*** *Нирваан буюу Гэгээрэлд хүрсний дараа хүн энергийн биеэ төгс эзэмших чадвартай болох хэцүү юу?*

**Багш:** Үгүй, тийм биш. Гэгээрэлд хүрэхээр харин ч энергийн биеэ хянахад хялбар болдог. Энэ чинь зорилго нь шүү дээ. Хэрвээ бид сэтгэцээ, эсвэл энерги болон Гэрлэн биеэ хянаж чадахгүй юм бол гэгээрэлд хүрэхийн хэрэг юун? Өөрийгөө хянаж чадахаа больчих юм бол бид өмнөхөөсөө ч дордох биш үү.

Иймэрхүү зүйл тохиолдох нь төгс биш багштай байх, эсвэл номоос олсон мэдлэгээрээ бясалгах, номоос олсон ухаарал зэргээс үүдэлтэй байж магадгүй. Энэ нь бага зэрэг аюултай. Тийм ээ. Мэдээж шүү дээ! Тийм учраас бие даан бясалгасан, эсвэл төгс сайн биш багш дагаж бясалгаж буй хүмүүс сэтгэцийн өвчтэй болдог юм. Тийм. Энэ үнэн шүү. Би одоо ойлгож байна. (Эзлэгдчихдэг гэж нэг хүн хэлэв.) Тийм ээ, зарим нь чөтгөрт эзлэгдчихдэг, зарим нь төөрөгдөлдөө эзлэгдчихдэг, учир нь тэд далдын болон илүү өндөр дэсийн хүч асар ихээр сулран гадагшлахад нь зохицуулж чаддаггүй. Тэд ийм зүйлд дасаж дадаагүй болохоор тэр. Тэд дэндүү нялхаараа байгаа юм. Тэд тэр хүчийг яахаа мэдэхгүй тул өөрсдөө хэвийн бус болчихдог.

Тийм учраас төгс сайн Их Багштай бясалгах нь илүү дээр. Их Багштай байх ёстойгийн шалтгаан энэ юм, эс бөгөөс тийм хэрэг байхгүй шүү дээ. Хэрэв тухайн Их Багш сургаалаа биечлэн уламжлах шаардлагагүй байдагсан бол ном бичиж зараад л алдар цуутай ч юмуу хамгийн шилдэг номын зохиолч болчихож болох биш үү. Тийм ээ. Тэгж болдог бол бүр ч амар л даа. Та гэртээ суугаад л, ном бичээд шилдэг номын зохиолч болчихно, өдөр бүр ашиг орлоготой сууж байна биз дээ.

***Асуулт 32:*** *Нохойд Бурхан Чанар бий юу?*

**Багш:** Ямар уйтгартай юм? Үгүй гэж үү? (Их Багш нохой хуцахыг дуурайж, хүмүүс инээв.) Ийм л байдаг. "Chan" буюу Зэн-д, дэлхийн хүмүүс маш олон аргыг зохиодог.

Будда Нирваан дүрийг үзүүлсний хойно хүн бүр л гэнэт их багш болцгоосон. Тэгээд жинхэнэ хүчээр дутсан тэд “Нохойд Бурхан чанар бий юу?” гэх мэтээр ямар нэг төрлийн нохойн Мөн чанар гэгчийг сэдэж олсон. Тэгээд л тэр нь “Коан” шиг болчихдог юм. Үүнийг мэдэх үү? Коан гэдэг нь таны өөртөө тавих ёстой асуулт, толгой чинь хагарч, эсхүл яадаг ч юм, тархи чинь дэлбэрэх хүртэл тэр асуултаа тавиад л байна гэсэн үг. Харин хариултаа олж чадахгүй бол ичиж үхэх ёстой гэсэн үг. Бүр урьд нь үүнээс ч долоон дор нөхцөл Японд байжээ. Багшийгаа асуухад “Моо” гэж юу болохыг мэдэхгүй, хариулж чадахгүй бол тэрээр амиа хорлох ёстой байсан гэдэг. Тэгээд тэрхэн агшиндаа тэр хүн гэгээрч магадгүй гэнэ, гэхдээ ихэнх тохиолдолд гэгээрээгүй. Тиймээс хүмүүс хашаа явах гэж буйгаа мэдэхгүй, уй гашуу, ичгүүртэйгээр нас нөгчдөг байжээ. Бид үүнийг шалгаж үзэж болно шүү, гэвч тийм өндөр биш юм байна лээ.

Амиа хороосон хүн сайн биш. Тэд маш харанхуй бүс рүү явдаг. Тухайн хүний амиа хорлох зорилго нь юу байсан, баатарлаг үйлсийн төлөө юу, үгүй юу гэдэг нь үүнд огт хамаагүй. Учир нь Бурхан бидэнд амь амьдралыг өгдөг, түүнийг буцааж авах нь хүмүүс бидний мэдлийнх биш. Бидний хэдийд, хэрхэн буцаж явахыг Бурхан л шийддэг. Тиймээс амиа хорлож буй хүн өөрийн хар муу бодлынхоо маш муу ертөнцөд очдог. Тэрээр өөрийгөө муу бодлынхоо шоронд түгжчихдэг, энэ бол маш аюултай. Хэдэн галавын дараа түүний энэ хүч хорогдож дуусах хүртэл тэр хүн ер гэтлэгдэж чадахгүй. Тэглээ ч энэ нь хэвийн гэтлэгдэлт биш; тэр зөвхөн тэрхүү харанхуй бүсээсээ л чөлөөлөгдөнө гэж би хэлж байна л даа. Тэр хүн магадгүй өөр нэгэн төрөлхийтөн болж дахин төрөл авах хэдий ч хүмүүн төрлөөс дорд төрөл байх магадлалтай. Бурхан л мэдэх хэрэг!

Харин “Нохойд Бурхан чанар бий юу?” гэсэн асуулт нь Будда нирваан дүр үзүүлснээс хэдэн мянган жилийн дараа Хятадад бий болжээ. Хүмүүс Гэрлийн дамжуулалтаа алдаж, дотоодын залгамж холбоо хэлхээгүй болжээ, бид “Fa Mai” гэдэг шүү дээ, хүч энергийн залгамж холбоо, тэгээд тэд зүгээр л ямар нэгэн юм зохиожээ. Хэрэв хүмүүс тэдэн дээр ирж хэрхэн бясалгахыг асуувал тэд эртний Их Багш нарын ярьсан зүйлээс эш татаад л үүнийг өөрөөсөө асуу, судал гэж хэлдэг байжээ. Тэгээд та мэдээж нэг, эсвэл нөгөө нэг санаан дээр анхаарлаа төвлөрүүлэхэд зарим нэг хүч бий болох нь ойлгомжтой. Төвлөрлийн хүчийг дутуу үнэлж болохгүй.

Харин би та нарт номдоо аль хэдийн хэлсэн. Тухайн хүн хичнээн оюун ухаантай байлаа ч хамаагүй, тэр хүн ердөө л оюун ухаанаар аугаа нэгэн болохоос бус Өөрийгөө – гэтэлгэсэн хүн биш, билиг ухааны Гэгээнтэн биш юм. Оюун ухаан бол тархи болон материйн бүсэд хамаарагддаг болохоос биш, сүнс болон Бурханых биш. Оюун ухаан бол бодож сэтгэдэг юм, тэгвэл бодох нь хаанаас үүсдэг билээ? Мэдээ өгөгдөл, сурсан мэдсэн зүйлс, бусдын бодол, тархи угаах санаа онооноос үүсдэг. Сүнс болон Бурхан, Мөн чанар бол угаасаа өөрөө-төрсөн, өөрөө-оршдог, өөрөө-өөрийгөө тэтгэдэг, өөрөө-ариун юм. Тэгэхээр нийгэм, бодол, гүн ухаан, аливаа хэл яриа зэргийн нөлөөнд автдаг юу л байна, тэр бүхэн оюун ухаан болохоос биш, билиг ухаан биш.

Тэгэхлээр өөртөө асуулт тавихдаа, эсвэл ямар нэгэн байдлаар гэгээрэхийн тулд хүний энэ хэлийг ашиглаж байгаа бол энэ чинь оюун ухааны л ертөнц шүү дээ, сэтгэлтэйгээ зууралдаж байгаа л хэрэг, ингэх нь их зүдгүүртэй шүү дээ. Тиймээс би иймэрхүү сэтгэлтэйгээ зууралдах аргыг заадаггүй. Учир нь бид өдөр бүр ажиллаж, асуудал бэрхшээлүүдтэйгээ тэмцэлдсээр хангалттай ядардаг. Гэртээ хариад завилж суух үедээ дахин тэмцэлдэхийн хэрэг юу байна.

Будда хэзээ ч ийм арга заагаагүй. Би та нарт үүнийг эргэн сануулмаар байна. Будда тэнд суугаад Би хэн бэ? Би юу юм бэ? Би хэн бэ? Би юу вэ? Нохойд Бурхан чанар (дотоод Мөн чанар) бий юу? Тэрэнд үнэхээр Бурхан чанар бий юу? Үнэхээр байгаа юу?…. хэмээн асууж байгаагүй. Тэр иймэрхүү юм хийж байгаагүй. Будда хэрхэн гэгээрснийг та нар мэдэх үү? Тэр дотоод ертөнцүүдийг харсан. Тэр дотоодын чөтгөрүүдийг дарж чадсан. Энэ нь тэр дотооддоо чөтгөрүүдийг харж, тэднийг номхотгон дарсан гэсэн үг, Тэр бас дотоодын Оддыг харсан бөгөөд энэ нь Тэр гэгээрсэн гэсэн үг юм.

Бид одоо харин өдөр бүр оддыг хардаг хэрнээ яагаад гэгээрэхгүй байна вэ гэж боддог. Энэ нь Будда тэнгэрийн одыг биш дотооддоо орших Оддыг харснаас болжээ. Тэгэхлээр манай олон шавь тэр Оддыг харсан болохоор гэгээрсэн хэмээн нэрлэгдэж бас болох нь. Одоо та өөрөө гайхаж байж магад, дотоодын Оддыг харсан бол үүнд сүйд болоод байх юм юу байна вэ гэж. Энэ үнэхээр сүйд болохоор том зүйл, учир нь Оддыг харсанд гол нь байгаа юм биш. Гол нь Оддыг харсанаасаа та юу олов, энэ нь таныг ямар болгов, юу мэдрэхэд хүргэв гэдэгт л байгаа юм. Оддыг харах, эсвэл дотоод ертөнцүүд, дотоод дэлхийнүүдийг харах, эсвэл дотоодын Гэрлийг харж, эсвэл дотоодын Аялгууг сонссоны дараа хүний мэдрэмж, билиг ухаан, амьдралын зам мөр өөрчлөгддөг.

Бид Оддыг харж, Аялгуу сонсох дуртайд бус, харин тэдгээрийг сонсож, харсан нь биднийг аугаа, билиг ухаантай, гэгээнтэнлэг, Будда шиг, Есүс Христ шиг болгодогт л гол нь байгаа хэрэг. Тиймээс бид тэр бүхнийг харах ёстой. Яг л бидний идсэн талх, төмс маань цус, бидний бодол, булчин шөрмөсний хүч болон хувирдагтай адил. Тийм ээ, ийм л юм. Тэр Одод, тэр Аялгуу бол бидний дотоод талх, амьдралын талх, ус юм. Ийм учраас л Есүс хүн дан ганц талхаар амьдрахгүй гэж хэлжээ. Тэрний хэлэх гэсэн санаа нь энэ. Учир нь амьдралын ус болон талх нь бидний дотоодод оршдог.

***Асуулт 33:*** *Яагаад энэ дэлхийд ийм их зовиур шаналал байна вэ?*

**Багш:** Яагаад гэвэл бидэнд ямар ч дэмжлэг алга. Ард маань тэсвэрлэж даах Хүч алга. Тэр Хүчийг бид үл ойшоожээ. Бид зөвхөн сэтгэл, тархиа ашиглаж байснаас биш Бурханы хязгааргүй дэмжлэг туслалцааг ашиглаж байсангүй. Тиймээс энэ дэлхийн дарамт шахалт, зовиурыг тэвчиж чадалгүй бид зовж шаналдаг юм. Хэрвээ бидэнд тэр аугаа эрдэнэс, аугаа дэмжлэг, аугаа хүч чадал байх аваас тийм их зовиур шаналлыг мэдрэхгүй. Тэр зовиур шаналал оршсон хэвээр л байх болно. Гол нь бид түүнийг тэсвэрлэн дааж чадна. Яг л залуу байхдаа, хүүхэд байхдаа бид таван

фунт* савласан будаа өргөхөд их л хүнд санагддаг байсан шиг. Тийм биш гэж үү? Бид бүр алхаж ч чаддаггүй байсан. Харин өсөж том болоод хорин жилийн дараа бол тавин фунт гэдэг бүр юу ч биш санагддаг. Бурханы Хүчний утга санаа иймл юм. Ийм учраас л бид бясалгалыг дадуулах ёстой. Тиймээс л тэр дотоодын хязгааргүй дэмжлэгтэй нэвтрэлцэхийн тулд бид Арьяабалын аргаар бясалгах учиртай юм. Тэгчихвэл бид тийм их сэтгэлийн зовиур, дарамт мэдрэхгүй, харин ч цаашдаа үргэлж л баяр жаргалтай болно. Зовлон шаналал гэгч зүйл байсаар, таныг оролдсоор л байна. Зовлон шаналал алга болчихно гэж би хэлээгүй шүү, харин та түүнийг дааж чаддаг болно. Танд юу ч тийм чухал биш санагддаг болно.

***Асуулт 34:*** *Та хэрхэн би гэх айдсаа дарж, аминч бус бөгөөд би үзэлгүй болсон бэ?*

**Багш:** Би яаж зохицуулдаг байснаа санахгүй байна. Зүгээр л Бурхантай холбогдож, өөрөө Бурхантай нийлэн нэгдэхлээр л тэр аяндаа арилдаг юм. Та зүгээр л аяндаа ямар ч би-гүй болно. Аажим аажмаар л би чинь алга болно. Тэгээд л боллоо. Би түүнийг зохицуулах гэдэггүй. Зохицуулах хэрэгтэй болно гэдэг ярвигтай. Учир нь тэр би маш том учраас үүнийг зохицуулахыг Бурханд л даатгачих. Энэ аргаар бясалгасны дараа та улам бага би-тэй болж, та өөрөө улам л аугаа болно. Хүн өчүүхэн болох тусмаа л төдий чинээ аугаа болж хувирдаг. Энэ бол Бурханы логик зөрчил. Учир нь энэ нь бидэнд ойлгогдохын тулд байгаа юм биш.

***Асуулт 35 :*** *Муу бодлоос хэрхэн ангижрах вэ?*

**Багш:** Энэ хэцүү. Та бас л энэ Хүч, энэ төрөлхийн Хүчийг ашиглах ёстой болно. Та энэ Арьяабалын аргаар бясалгах ёстой, тэгж гэмээнэ аяндаа цэвэр ариун болно. Цаашид зүдэрч тэмцэх хэрэггүй болно. Бид өөрийгөө угааж ариусгахын тулд энэ Гэрэл, Аялгууг өдөр бүхэн хэрэглэдэг юм. Гэхдээ бас нэгэн төрлийн үзлэг хяналт бий, тэр нь бясалгалын өдрийн тэмдэглэл. Хэр их ахиц дэвшил гаргаж, бие, хэл, сэтгэлээрээ хэр цэвэр ариун байгаагаа мэдэх үүднээс өдөр тутамд өөрийгөө хянаж шалгаж байж болно.

***Асуулт 36:*** *Та яаж бясалгадаг вэ?*

**Багш:** Яаж гэнэ ээ! Мэдээж яаж бясалгахыг хүн бүхэн мэднэ. Гол нь буруу зүйл дээр л бясалгаад байдаг. Зарим хүн хөөрхөн бүсгүйчүүд, зарим нь мөнгө, зарим нь ажил бизнесээ бясалгадаг. Нэгэн үзүүрт сэтгэлээр, хамаг сэтгэлээсээ нэг зүйл дээр анхаарлаа маш их төвлөрүүлэх бүр нь бясалгал юм. Тэгвэл би анхаарлаа зөвхөн дотоод Хүч, өршөөл нигүүсэл, хайр энэрэл, Бурханы өршөөнгүй чанар дээр л тавьдаг, энэ л миний бясалгал. Харин үүнийг их ёс журамтай хийхийн тулд бид нэг чимээгүй буланд сууж, өөрөөрөө байх хэрэгтэй, энэ бол бясалгалын үйл явц. Гэхдээ хүн нэг чимээгүй буланд суухлаараа л ямар нэгэн юмтай болчихдог юм биш. Үгүй! Үгүй! Та нар эхлээд тэрхүү дотоодын Хүчтэйгээ нэвтрэлцэх ёстой, тэгээд тэр дотоод хүчээрээ бясалгадаг юм. Угтаа тийм байдаг.

* Фунт- Их Британийн 0,454 кг –тай тэнцэх Хүндийн хэмжүүрийн нэгж

Тиймээс үүнийг мөн чанараа сэрээхүй гэж нэрлэдэг. Та нар дотоод жинхэнэ Би-гээ сэрээж, Түүнийгээ бясалгуулах ёстой, түүнээс биш, та өөрөө, хүний тархи, эгэл ухамсраараа бус, Тэр Хүч л бясалгана. Тэр бясалгаж, Өөрийгөө сэрээнэ, хэрхэн ажиллахаа мэддэг. Энэ мөчид та Түүнийг унтуулчихвал, та бүхнийг тархиараа, тархины тушаалаараа механикаар хийгээд эхэлнэ. Тэгээд та бүр бясалгаж суухдаа хүртэл зүсэн зүйлийн юм бодож, хүсэл шуналаа ч дарж чадахгүй болдог. Харин таны жинхэнэ Би сэрчихвэл, таны дотоодод буй тэрхүү Бурханы Хүч тань бүхнийг хянаж, бас бясалгаж, өөрөө жинхэнэ Би рүүгээ буцаж ирнэ. Энэ бол жинхэнэ бясалгал. Жинхэнэ Их Багшийн дамжуулалт таныг сэрээсний дараа л жинхэнэ бясалгал гэж юу байдгийг та мэднэ. Эс бөгөөс энэ нь ердөө л цагийн гарз, бие сэтгэлтэйгээ ноцолдож буй хэрэг. Зөвхөн бие тань амраад сэтгэл тань харин зүдрээд л, тэмцэлдээд л байдаг. Ингэх нь жинхэнэ бясалгал биш.

***Асуулт 37:*** *Зөв гэж байна уу? Буруу гэж байна уу? Ямар ялгаатай вэ?*

**Багш:** Байхгүй гэж үү? Ялгаа байхгүй гэж үү? Танд надаас үүнийг асуух шаардлага байна уу? Та хэрвээ гадагш гараад хүний эхнэр булаах гэвэл энэ чинь зөв үү? Нөхрөөс нь очоод гуйхад тэр зөвшөөрөхгүй, манай нийгмийн зан төлөв, ёс зүйн дагуу бол энэ буруу зүйл. Юу зөв, юу буруу болохыг бид хууль зүй болон хүн ёсны дагуу ямар ч шалтаггүй дагаж мөрдөх ёстой. Би Бурхантай нэгэн цогц болчихсон, Бурхан алагчилдаггүй шүү дээ гэж бид хэлж болохгүй. Зөв нь буруу, буруу нь зөв. Үгүй. Үгүй, Үгүй. Бид энэ мэт утгагүй шалтаг тоочиж болохгүй.

Тиймээс надтай хамт энэ бясалгалыг дадуулна гэвэл би ариун ёс зүйг онцлон тэмдэглэнэ. Тухайн хүн сахил, ёс суртахууны таван зарчмыг чандлан биелүүлэх сэтгэлтэй байх ёстой. Амь хороож болохгүй, хулгай хийж болохгүй, садар самуун явж болохгүй, худлаа хэлж болохгүй, архи ууж, хар тамхи татаж болохгүй буюу сэтгэлийг самууруулж, бие махбодыг сул дорой болгох зүйлсийг хорьж, хүсэл тачаалыг өдөөх, бидний нам чимээгүй, тайван дөлгөөн мөн чанарт сайнаар нөлөөлөхгүй аливаа кино шийг үзэхгүй байх явдал орно. Кино ший, мөрийтэй тоглоом, архи дарс гэхчлэн энэ бүгд хар тамхинд тооцогдоно. Эд бүгдээрээ хар тамхи. Тиймээс манай энэ бясалгалын бүлэгт нэгдмээр байвал Би танаас энэ таван зарчмыг чандалхыг гуйх болно. Та намайг биечлэн дагах, надад үйлчлэх шаардлага байхгүй, над өргөл барьц өгөх шаардлага байхгүй, харин өөртөө амлалт өгч, өдөр бүр бясалгал хийнэ. Үүнийг болж өгвөл биелүүлэх ёстой. Мөн таван сахил сахихыг Би шаардана. Таны хийх ёстой бүхэн энэ л юм.

***Асуулт 38:*** *Яагаад 65-аас доош насны хүмүүс авшиг хүртдэг вэ?*

**Багш:** Яагаад 65 наснаас доош настай хүмүүс авшиг хүртэх ёстой вэ гэж үү? Асуулт энгийн юм. 60 юмуу 65-аас арай хэтрээд хөгшрөөд ирэхээр хүний тархи бага зэрэг соргог бус болдог. Тийм хүмүүс ихэнхдээ Их Багшийн сургаалыг ойлгодоггүй. Бас ургамал хоолноос болдог. Ийм өндөр насан дээр хүн мах идэж байснаа ногоон хоолтон болох өөрчлөлтийг гэнэт хийхэд танд таагүй хүндрэл гарч магадгүй. Үүнийг та дагаж чадахгүй байж мэднэ.

***Асуулт 39***: *Яагаад Христийн шашны тэргүүнүүд унаад байна вэ? Яагаад сөрөг зүйл, ял шийтгэлийг илүү онцлоод байдаг юм бэ?*

**Багш:** Би та нарт хэлсэн. Мунхагийн харанхуй, гэгээрэл дутмагаас ийм юм болж байгаа юм. Тэд ямар ч бясалгал хийдэггүй. Номлогч та хоёрын хооронд ямар ялгаа байна вэ? Надад хэлээч? Тэд бас мах идэж, архи дарс уудаг, зарим нь эмэгтэй хүнтэй, та нар ч гэсэн адилхан тэгдэг. Тэд бас та нар шиг л өдөр болгон судар номлол уншдаг. Ийм байхад номлогчид, та болон бусад хүмүүсийн хооронд ямар ялгаа байна вэ? Тэд үүнийг ойлгодоггүй. Энэ л тэдний ялгаа. Тиймээс мэдээж, тэд зөвхөн сөрөг зүйл, ял шийтгэлийг л ярьж чадна, яагаад гэвэл тэд Бурханы өршөөнгүй чанар дээр чимээгүй төвлөрч, Түүний хайрын Хүчинд хүрээгүй байна.

Тэд зөвхөн номлоод л, яриад л байдаг. Таныг сүм хийдэд очих бүрт тэд ганцхан Библийг л давтан уншдаг. Би зөвхөн Христийн шашныг хэлж байгаа юм биш. Тэд том ном гаргаж ирээд “Матью Гэгээнтэн ингэж, тэгж хэлж, сургасан байна” гэдэг, тэгээд тэрийг нь та нар хамтдаа чанга уншиж байгаад гэртээ харина. Бурханыг яаж ийм энгийнээр олж чадах юм бэ? Тэгээд тэднийг номлогч, эцэг, эх, эсвэл их багш энэ тэр гэж дууддаг. (Их Багш инээв.) Номлогч, их багш болох тийм амархан юм уу? Та нар бүгдээрээ тэдэн шиг болчихвол яасан юм? Би өөрөөсөө үүнийг асуугаад гайхдаг. Би өөрөө ч гайхширдаг. Шашин дэлгэрүүлэгч болох чинь их амархан байх нь ээ. Тийм биш үү? Бүр гэрлэж ч болно. Протестант шашны номлогч байсан ч бас л гэрлэж болно. Тийм бол та яагаад тэдний нэг болчихдоггүй юм бэ, Би гайхаж байна?

***Асуулт 40:*** *Ургамал ногоог идэх нь нэг төрлийн амь хороолт биш үү, учир нь ургамал ногоо амьтны адил амьтай.*

**Багш:** Тийм ээ, энэ үнэн, гэхдээ ургамал ногоонд амь тун бага. Сүнс нь унтаа байдаг. Бүх зүйл олон элементээс бүтдэгийг та мэднэ. Хүмүүн бид ч гэсэн олон элементээс, үүний дотор сүнс, хий, шороо, төмөр, мод зэрэг олон бодисоос бүтдэг. Гэтэл ургамал уснаас бүтдэг, ерэн хувь нь ус. Ургамалд бусад бодис тун бага, сүнс нь бараг л унтарсан байдаг. Гэсэн хэдий ч бид ургамал ногоо идвэл ялгаагүй амь хороono. Тийм болохоор Будда “Юу ч идсэн, бүр ногоо идсэн ч хүүхдийнхээ махыг идэж байна хэмээн үзэх ёстой” гэж хэлсэн.

Гэвч бид юу ч идэхгүйгээр энэ дэлхийд амьдрах юм бол тэгээд яах болж байна? Бид идэхгүй байж чадна л даа, гэвч ингэх нь бие махбодын маань хэрэгцээнд харш. Бие махбодын материаллаг хэрэгцээнүүдийг давахын тулд биднээс асар их сэтгэлийн тэнхээ шаардагдана. Юу ч иддэггүй хүмүүс бий. Тэд байсаар байна, гэхдээ би та нарт ингэ гэж зөвлөхгүй. Нэгдүгээрт, хүмүүс та нарыг “Зоо-лоо” юмуу, эсвэл нэг хачин жигтэй хүн мэтээр хараад эхэлнэ. Эсвэл зөвхөн юу ч иддэггүй байдалд чинь татагдаад тан руу хүмүүс шавна, ингэснээрээ тэд таны оюун санааны шинж чанарууд, эдгээрээс өмнө тавихыг зорьсон хамгийн дээд зорилгыг тань үл хэрэгсэнэ.

Над руу анхаарлаа хандуулна уу, Чин Хай юу ч идэхгүй байна гээд л, үүнийгээ сонинд "Их Багш Чин Хай юу ч иддэггүй гэнэ" гэж сурталчлаад л. Маш олон хүн энд цугларч, надаас өдөржингөө Яаж? Яагаад? Хэр удаан? Хэдийнээс эхлэв гээд л асууна. Ердөө л энэ. Тэгээд би тэдэнд анхаарлаа Бурхан луу, миний ярьж байгаа луу хандуулахыг ятгах гэж бөөн юм болно. Энэ бол Арьяабалын бясалгалын арга. Энэ бол амин чухал зүйл. Нээрээ шүү. Та нар хоёр цаг гучин минут бясалгаж, ургамал хоолтон байх ёстой гээд л. Энэ бүхнийг тэд хальт ч атугай сонсохгүй байх, учир нь тэдний хамаг анхаарал юу ч иддэггүй дэглэм рүү чиглэчихсэн.

Би энэ талаар бүгдийг мэднэ. Формосад хорин жилийн турш юу ч идээгүй нэг хүн бий. Надаас авахуулаад л хүн бүр тэнд очиж, нэг адил зүйл асуудаг. (Инээв.) Тэгэхээр бид ургамал хоол идсэн ч гэсэн мөн л бага сага үйлийн үр хураана, өөрөөр хэлбэл муу нөлөөлөлд автана. Тийм учраас бид энэ өчүүхэн үйлийн үрийг арилгахын тулд энэ аргаар бясалгах ёстой юм, тэгж байж л бид чөлөөлөгдөж бас ариусна.

***Асуулт 41:*** *Бие махбод, эсвэл оюун санааны талаасаа чөтгөр шуламтай тулгарвал, жишээ нь, хэн нэгэн таныг хөнөөх, хорлохыг оролдох, ямарваа нэг байдлаар хэн нэгэн таныг гэмтээхийг завдвал та өөрийгөө хамгаалахаар эсэргүүцэн тэмцэх үү, эсвэл зүгээр л үхээд өгөх үү?*

**Багш:** Зүгээр л үхэх ээ? Та тоглож байгаа байлгүй! Зүгээр л тэгээд үхнэ ч гэж байхгүй ээ, би зугтана (Инээв). Эсэргүүцэж зодолдохгүй, гэхдээ амьд үлдэхийн тулд зугтана. Хэвтэж байгаад үхээд өгөх тийм тэнэг хүн байдаг л байх, харин би бол тэгэхгүй. Амь нас бол нандин зүйл. Надад хийх юм их байна. Надад энэ бие маань хэрэггүй байлаа ч шавь нарт маань хэрэгтэй. Хэрвээ би тэгээд үхчихвэл энэ нь маш хариуцлагагүй хэрэг болно. Мэдээж амь амьдралаа хамгаалахын тулд хамаг чадлаараа хичээх ёстой, учир нь амь эрхэм. Амьгүй бол бид юунд ч хүрч чадахгүй. Энэхүү хүний амьгүйгээр бид Бурхан луу хүртэл буцаж чадахгүй. Бурханд улам ойртож, хамгийн аугаа хүч чадал, адислах хүчээ ухаарч мэдээд бидний тусламж хэрэгтэй байгаа бусад төрөлтөнд туслахын тулд хүн болж амьдарч буй хором бүр маань хэрэгтэй байдаг. Өөрсдөд маань энэ хүч хэрэггүй байж магадгүй ч бид түүнийг олж авах ёстой. Өөрт маань мөнгө тэгтлээ их хэрэгтэй биш байлаа ч эхнэр хүүхэд, гачигдалтай бусад хүн, ядарсан хүмүүст тусалж, тэдэнд өгөхийн тулд бид мөнгөтэй байх ёстой байдагтай энэ нь адил юм.

***Асуулт 42:*** *Мөн чанараа – ухаарч мэдэхийн тулд яагаад заавал ургамал хоолтон болох ёстой байдаг юм бэ?*

**Багш:** Учир нь бид Бурхан бол хайр болон өршөөл, Будда бол энэрэл нигүүсэл гэдгийг бүгдээрээ л мэддэг. Тэдэн шиг болохын төлөө суралцахгүй юм бол бид яаж Бурхантай нэгэн цогц болж, хэрхэн хайр энэрэл, өршөөл нигүүслэлийн орон болох Диваажинд амьдрах ёстой болж байна? Ямар нэгэн юм сурахыг хүсвэл бид түүн шигээ болох хэрэгтэй биз дээ. Амьтад амьдрахыг хүсдэг, амьдралд хайртай, амьд үлдэхийн төлөө зугтдаг. Тэгж л бид тэднийг амьдрах дуртайг мэддэг, тэд бидний л

адил амьдралыг хайрлаж мэддэгийг нь мэддэг. Бидэнд тэдний амийг булаах эрх байхгүй. Ямар ч бай арга замаар, бүр шууд болон шууд бусаар ч бай бид амь хөнөөх ёсгүй.

***Асуулт 43:*** *Та Бурхан бол бүх юм гэж хэллээ, гэхдээ Та ид шид гэж юу болохыг огт тайлбарласангүй юу?*

**Багш:** Бурхан бол бүх юм. Бурхан бол ер бусын шидтэн биш. Ид шид бол бидний ухамсрын доод түвшин. Ид шидийн бие, шидийн хүч бол Бурханы хүч биш, Хамгийн Дээд Хүч биш, хэдийгээр энэ нь ихэд айж сүрдмээр, маш хүчирхэг харагддаг ч гэсэн. Гэтэл энэ бол бүрэн бүтэн зүйл биш.

***Асуулт 44:*** *Энэ дэлхий болон ертөнцөд хамаардаггүй төөрсөн төрөлтнүүдийг аварч, чин сэтгэлээсээ туслаг хэмээн жинхэнэ Бурхан таныг илгээж, адисласан гэдгийг та үнэхээр мэдэж байгаа юу?*

**Багш:** Тийм ээ! Бүрэн мэдэж байгаа. Би та нарт хэлэхгүй, эс бөгөөс хэрвээ Би худлаа ярьчихвал тамд очихоос эмээж байна. Би Бурханы шийтгэлээс эмээдэг. Түүний шүүлтээс эмээж байна. Буддагийн зэмлэлээс айж байна.

***Асуулт 45:*** *Чөтгөр гэж юу вэ?*

**Багш:** Чөтгөр. Тийм ээ. Тэд бол арай доод төвшний сэтгэхүй, доод төвшний оршихуй, хайр энэрлээр нэлээн бага төрөлтөн. Үүнийг л бид чөтгөр гэж нэрлээд байгаа юм. Гэрэл багатай, хайр багатай тэр зүйл бол чөтгөр.

***Асуулт 46:*** *Хүн яаж бясалгах вэ? Тухайн хүний сэтгэлд юу байх ёстой вэ?*

**Багш:** Юу ч байх ёсгүй. Бясалгагчийн сэтгэлд юу ч болох ёсгүй. Гэвч угтаа тийм биш л дээ. Авшиг хүртээх үед танд бүгдийг хэлж өгөх цаг надад гарах байх. Зүгээр л ингэсхийгээд хариулчих нь сайн биш л дээ, учир нь та үүнийг ойлгохгүй.

***Асуулт 47:*** *1940-өөд онд эрдэмтэд хурмаст тэнгэр (ether) байхгүй гэж баталсан талаар та юу гэж тайлбарлах вэ? Энэ юу юм бэ, хэрхэн ажилладаг вэ?*

**Багш:** Үүнийг шинжлэх ухааныхан өөрөөр нэрлэснээс болсон байж магадгүй. Хурмаст тэнгэр гэдэг нь Хятадуудын “Chi” гэж нэрлэдэг зүйл. Та нар мэднэ дээ, энэ нь бидний нүдэнд үзэгдэлгүй ажилладаг, үүнийг зүгээр л шинжлэх ухаанаар баталчих боломжгүй юм. Би үүнтэй санал нийлэхгүй байна. Эрдэмтэд олон зүйлийг зохиож, олон нээлт хийдэг боловч бас тэдний мэдэхгүй, мэдэж чадахгүй, нээж илрүүлж чадахгүй олон зүйл бий. Үүний энгийн шалтгаан нь хүн бүр оюун ухааныхаа зөвхөн нэг хязгаарлагдмал бичил хэсгийг, үл ялих хэсгийг ашигладаг болохоор тэр. Бид ердөө тавны нэг, эсвэл аравны нэг хувийг ашигладаг хэрнээ бүхнийг мэддэг гэж боддог. Ээ, энэ боломжгүй!

***Асуулт 48:*** *Яагаад хүн бясалгалын үеэр цагаан Гэрэл хардаг юм бэ? Энэ нь ямар учиртай юм?*

**Багш:** Муугүй шүү (Инээв). Гэрэл харна гэдэг чинь ямар ч харанхуй байхгүй гэсэн үг.

***Асуулт 49:*** *Сэтгэл мэдрэлийн эмч нар хүмүүст асуудал бэрхшээлд нь туслах юу хийдэг гэж та боддог вэ?*

**Багш:** Сэтгэл мэдрэлийн эмч нар бий, гэхдээ сэтгэцийн саатлалтай хүмүүсийн асуудал бэрхшээл нь харагдаж буйгаасаа илүү гүнзгий байдаг. Тиймээс заримдаа сэтгэл мэдрэлийн эмч нар асуудал бэрхшээлийг нь шийдвэрлэх гүн гүнзгий мэдлэггүй байдаг, харин ч бүр дордуулж орхидог. Гэтэл энэ нь тэдний буруу биш, харин аливаа нийгмийн бүхэл бүтэн тогтолцооны гажиг юм. Бид бүх хүнийг гэгээрүүлэх хэрэгтэй, тэгвэл тэдний хийсэн бүхэн төгс голдрилдоо орно. Учир нь тэд аливааг энэ хягаарлагдмал тархины таамаглал, буруу мэдээллээр үйлдэх бус, харин билиг ухаан, дотоод мэдрэхүйгээрээ хийнэ. Сэтгэцийн эмч нарын үзүүлдэг туслалцаа нь үнэндээ тэдний өөрийнх нь танин мэдэхүйгээс гарсан байдаггүй, харин бусдын бодол, өөр сэтгэцийн эмч нар, бусдын бодол санааны нөлөөнд автсан байдаг. Харин сүүлд нэгэн өдөр өөрийнх нь арга буруу байгааг ойлголоо гэхэд залруулахад дэндүү оройтсон байдаг. Ихэнхдээ ийм байдаг тул тэдний юу хийх хэрэгтэйг надаас бүү асуу. Тэднийг бүгдийг нь Арьяабалыг бясалгалын аргаар бясалгаж гэгээрээд буцаж ажилдаа ороод улам сайн ажиллаж, илүү сайн эрдэмтэд болж, улам олон өвчтөнд сайн аргаар туслах хэрэгтэй гэж би бодож байна.

***Асуулт 50:*** *Таны аав зөвхөн уламжлалт барууны эм, шинжлэх ухаан гэх мэт физик бодит зүйлд итгэдэг бол та яах вэ? Бүх йогч тэнэг гэж тэр бодож байгааг та мэддэг байлаа гэхэд та юу ч хийхгүй юу? Йогч хүн тийм аугаа юм бол түүнийгээ нисэх, алга болох зэрэг ид шид үзүүлж батлах ёстой гэж тэр бодно. Та энэ тухайд юу хийх вэ?*

**Багш:** Та энэ тал дээр яахыг мэддэггүй юм уу? Чимээгүй байж, бясалгалаа хий. Энэ тал дээр бидний хийж чадах юм байхгүй. Чадах зүйл бол бясалгалын хүч, хэлбэлзлэлээрээ гэр бүлийнхэндээ нөлөөлж л чадна. Тэд аяндаа л Өндөр дээд хүчийг тэр даруй автоматаар хүлээн авамтгай болно, удалгүй тэд ойлгоно. Гэр бүлийн маш хүчтэй эсэргүүцэл байсан ч авшиг хүртсэн олон хүн Формосад бий. Тэд хэсэг хугацааны турш тэвчээртэй, хайр дүүрэн бясалгасны дараа гэр бүлийнхэн нь өөрчлөлтийг нь, бас ач тусыг нь мэдэрчээ. Тэгээд өмнө нь охин, хүүгээ гэлтгүй бүр Их Багшийг хүртэл үгүйсгэж байсан тэр хүмүүс авшиг хүртсэн. Тэд бүр над дээр хүрч ирээд есөн шидийн аргаар сүрдүүлж, үүрэгт ажилд маань янз бүрээр саад болдог байлаа. Харин дараа нь бүх гэр бүлээрээ ирж авшиг хүртсэн билээ.

Тэдний санааг эргүүлэхийн тулд ингэж, бас үзэгдэхгүй алга болох хэрэг над байхгүй. Би бол нүдэнд үзэгддэггүй бөгөөд угаас л байж байдаг тэр Хайрын Хүчийг ашигладаг юм. Бүр ашигладаг ч үгүй юм. Энэ хүч байж л байдаг. Энэ хайрын хүч хорин дөрвөн цагийн турш урсаж л байдаг тул тэд тэртээ тэргүй хүртдэг. Тэд үүнийг хүртээд, үүнийг үнэлж эрхэмлэхээрээ аяндаа л тэр даруй бишрэгч болдог. Тиймээс бидний хийх ёстой зүйл энэ. Өөрийнхөө үнэ цэнийг бид өөртөө л батлах ёстой.

Бидэнд тэгж их маргаж мэтгэлцэх шаардлага байхгүй. Бид хэдий их ярина, төдий ихийг алддаг. Цаг нь болохыг хүлээж байгаад ганц хоёр үг хэлчих, ингэхэд л хангалттай байх. Гэхдээ бид Гэрэл тээгч байх ёстой. Бид хайр, тэвчээр, билиг ухааны үлгэр жишээ болох учиртай. Тэгвэл бусад хүн түүнийг чинь мэдрээд аяндаа л хүрээд ирнэ. Яг л цэцэг шиг. Цэцэг ярихгүй хэрнээ анхилуун үнэр, балаараа зөгийг өөртөө татдаг шүү дээ.

Тэгэхлээр нисэх болон алга болох бодлын хувьд бол та намайг тэгж байхыг харж магадгүй юм. Үнэндээ үүнийг байнга харж ч магад. Гэвч би үүнийг зөвхөн эцгийг чинь итгүүлэх төдийхний төлөө хийхгүй. Аав тань билиг ухаанаараа, чөлөөт хүсэл сонголтоороо итгэснийхээ дараа үүнийг харж магад. Харин түүнийг итгүүлэх гэсэндээ би үүнийг хийнэ гэхгүй. Ингэх нь миний зарчим, Бурханы тушаалтай зөрчилдөнө. Их Багш хичнээн аугаа гэдгээ батлахын төлөө ямар нэгэн ид шидийн хүчийг үзүүлэхгүй л болов уу. Тэр үүнийгээ нотлох тусам төдий чинээ өчүүхэн болдог. Нар юуг ч баталж нотлох гэдэггүй, тэр зүгээр л гийж байдаг. Нүдтэй хүмүүс нь л харна. Сохор хүнтэй маргах хэрэггүй. Тийм биш үү? Тэр сохор шүү дээ, түүнтэй маргах шаардлага юу байна. Гэхдээ тэр нарны илчийг нүүрэндээ мэдэрч, ач тусыг нь хүртэж л байгаа.

Нисэхэд энэ махан биеийн хэрэг байхгүй. Их Багш хэдийд ч, хаашаа ч нисэж чадна. Тэнгэрт дүүлэн бадамлянхуа хөлөглөн нисэж, диваажинд нисэж, там руу ч хүрч, дэлхийг тойрон нисэж чадна. Хүнд хэцүү үед шавь нартаа тусалж, өөртэй нь барилдлагатай хүмүүсийг аврахын төлөө хаа ч оршин байхын тулд тухайн Их Багшийн хэрэглэдэг хүүхдийн мэх, хамгийн энгийн, анхан шатны зэмсэг нь энэ юм. Үзүүлж харуулаад, хэлж яриад байх юм үүнд байхгүй. Энэ бүгд ялихгүй үйлдэл.

Үзэгдэхгүй алга болохыг та бүр одоо ч харж болно; даанч нүд тань дэндүү хаагдчихсан болохоор зөвхөн миний махан биеийг хараад өөр юу ч харахгүй байгаа юм. Танд үнэхээр билгийн мэлмий байгаа бол ярьж байгааг минь хүртэл харахгүй байж магадгүй. Та энд зөвхөн Гэрэл л харна. Өрөө тэр чигтээ Гэрэл, өөр юу ч байхгүй, ямар ч хүн байхгүй. Бүх үзэгч сонсогчид хүртэл энэ Гэрэл дотор үзэгдэхгүй алга болно. Тэгэхээр энэ чинь л жинхэнэ үзэгдэхгүй алга болно гэдэг зүйл. Миний фото зургуудаас харвал та нар намайг олж харахгүй, зөвхөн Гэрэл байгааг харна. Зургийг минь авч байгаа хүмүүс Их Багшийг биш, зөвхөн нэгэн том Гэрэл л үздэг. Хүн нь алга болчихдог, миний ихэнх зураг тийм байдаг. Иймэрхүү төрлийн харагдахгүй алга болох үзэгдлийг баталж нотлох шаардлагагүй. Зургийн аппарат үүнийг нотолчихно. Заримдаа тайзан дээр ямар ч Их Багш байхгүй болчихдог, энэ бол үзэгдэхгүй алга болох гэгч юм. Учир нь үнэн мөн чанартаа ямар ч их багш, хэн нэгэн, хамаг амьтан, оршихуй гэж байдаггүй, зөвхөн Гэрэл болон Хэлбэлзэл, хайр болон хамт оршихуй л гэж байдаг. Одоо энэ болж байна уу? Хүн бүхэн нисэх их дуртай, гэтэл бясалгал дадуулдаггүй. Хэрэв та надтай хамт бясалгал дадуулбал хэсэг хугацааны дараа миний нисэж, бас алга болохыг ядах юмгүй харж чадна гэдгийг би танд амлаж байна. Хэрэв та бясалгахгүй бол би үүнийг хийхгүй. Танд харуулахын төлөө бол тэгэхгүй. Бид ямар циркэд байгаа биш дээ.

***Асуулт 51:*** *Гүйя, намайг өөрөөс минь буюу хэн гэдгээс минь өчүүхэн болгоход хүргэдэг бүхий л хэлбэрээс би зайлсхийж чадаж магад тул Танаар бүрэн дүүрэн адислуулж болох уу.*

**Багш:** Адислалыг хүлээн авах арга зам бол өөрийнхөө дотоод Хүчээрээ өөрийгөө адислах юм. Харин үүнийг яаж хийхийг би мэднэ, танд хэлж өгч чадна. Өөрөөс тань өөр хэн ч таныг адислаж чадахгүй. Бурхан танд зөвхөн тусалж л чадна. Таныг илүү өндөр ухамсрын төвшин рүү дэвшүүлэхийн төлөө Тэр танд Өөрийнхөө туяа, хайр, хүч чадлаасаа хэсэгхэнийг зээлдүүлнэ, гэхдээ бүрэн гүйцэд биш юм. Та адислалын хүчээрээ өөрийгөө дуртайяа адислахыг хүсэхгүй байгаа бол Тэр үүнийг хийж чадна. Тийм биш байсан бол Есүс дэлхийг бүхэлд нь адислачихсан, бид өнөөдрийг хүртэл энд тийчилж хэвтэхгүй л байх байсан биз дээ. Тийм биш байсан бол Будда Энэтхэгийг бүхэлд нь, ядаж л Энэтхэгийг адислаад, тэднийг нирваанд аваачихсан л байх байсан.

Та өөрөө харж байгаачлан Будда хэдийнэ Будда (төгс гэгээрсэн оршихуй) болчихсон байхад Энэтхэгчүүд, тэдний ихэнх нь мунхаг харанхуй хэвээрээ л байна. Тэгэхээр хэн ч хэнийг ч адислаж чадахгүй. Мэдээж нэгэн их багш дэлхий дээр бууж ирэхдээ Бурханы аугаа адислалыг авч ирдэг, тэрхүү адислалын хүчээр түүний амьдарсан, эсвэл ирсэн, явсан газар орон гаднаа ч тэр, ухамсар оюуны хувьд ч тэр өөрчлөгддөг нь эргэлзээгүй. Гэхдээ энэ бол ердөө өчүүхэн хэсэг нь. Хүн бүр өөрийгөө адислах ёстой.

***Асуулт 52:*** *Сумо бөх гэж юу вэ? Сумо бөх нь Будда мөн үү (Төгс гэгээрсэн төрөлтөн) ? Хэрхэн Сумогийн их багш болохыг та мэдэх үү? Өөрөөрөө – бахархах гэж юу вэ? Хүн шашингүйгээр амьдарч болох уу?*

**Багш:** Сумо бөх Будда мөн үү гэнэ ээ? Түүний дотоодод Будда чанар бий, гэхдээ тэр Гэгээнтэн болоход тун ч хол байна, уучлаарай. Үүнд маш их хугацаа орно! Өөрөөрөө-бахархах гэсэн үү? Өөрийгөө хүндлэх талаар асуусан гэж би бодож байна. Өөрийнхөө сайн сайхан чанар хаана буйг танин мэдэж байж л өөрийгөө хүндэлж чаддаг болно. Гэвч жинхэнээсээ өөрийгөө хүндэлдэг болоход их хэцүү. Аугаа байх Хүч өөрийнх нь дотоод байдгийг таньж мэдэхийн тулд хүн баясалгах хэрэгтэй байдаг.

Хүн шашин шүтэхгүй амьдарч болох уу? Болно, бас болохгүй. Болно гэж байгаа нь ихэнх шашин хүмүүст хэрхэн гэгээрэхийг заадаггүй. Тиймээс тэд утга санааг нь ойлгохгүй, үйлдэл болгож хэрэгжүүлэхгүйгээр тэрхүү уйтгартай сургаал номлолыг давтан уншаад л байдаг. Тэгээд л Христийн шашныг сүсэгтнүүд хөршөө хайрла гэж сургадаг хэрнээ Протестант шашинтнуудтай байлдаж байх жишээтэй. Христийн шашинтан бүхэн тийм биш л дээ. Тэд дотоодын хүчээ нөөж чадахгүй, Бурханы жинхэнэ хүчээр дутагдсаны улмаас номлож байгаа зүйлээ үйлдэл болгож чаддаггүй гэж би хэлэх гээд байгаа юм. Тэд хэдий хүссэн ч ингэж чаддаггүй.

Тэгэхээр та шашинтай ч амьдарч болно, шашингүйгээр ч болно, чадахыгаа л хий. Ямар ч шашинд хамаардаг байлаа гэсэн та бүхий л талаар сайн хүн бай, буянтай хүн, шашинлаг бай. Хэрвээ ямарваа шашинд харъяалагддаггүй ч, хэрвээ та сайн хүн бол, хулгай хийдэггүй, худал хэлдэггүй, бусдад хор учруулдаггүй, сайн иргэн байхыг хичээдэг бол энэ нь шашинтай хүн л гэсэн үг.

***Асуулт 53:*** *Хүн Бурханаас яагаад тусгаарлагдсан бэ?*

**Багш:** Тийм ээ, та нарт хэлсэн шүү дээ. Бид дэндүү завгүй байдгаас л болж байгаа юм. Хүн тантай утсаар ярих гээд залгаад байхад та хоол хийгээд, бусадтай яриад завгүй байвал тэр хүн тантай холбогдож чадахгүй, тийм биз. Бурханы хувьд ч яг адилхан, Бурхан тан руу өдөр бүр, минут бүр утасдаад л байдаг, харин танд түүнд гаргах цаг байдаггүй. Та Бурханыг утасны шугаман дээр зүүгдээстэй л байлгаад байдаг. Ингэж л бид Түүнээс тусгаарлагддаг юм. Одоо та түүнтэй дахин нэгдэхийг хүсч байвал цаг гарга. Түүнтэй холбогдохын тулд өдрийн бүх цагийнхаа аравны нэгийг Түүнд гарга. Тэгвэл та ахин тусгаарлагдахгүй болох нь лавтай юм.

***Асуулт 54:*** *Хамгийн анх оршин байсан Үг эсвэл Наам, Будда, Бурхан чанараасаа бид яагаад салж тусгаарлагдчихсан юм бэ?*

**Багш:** Бид хэзээ ч салж тусгаарлагдаагүй гэдгийг би хэлсэн. Бид түүн дотор оршдог. Тэр чинь бидний дотор талд, гадна талд, дотор талд эсвэл тонгорчихоод байж л байгаа. Бид бүгд Бурхан болон Будда чанартай. Ердөө л бид дэндүү завгүй байгаа хэрэг. Бид энэ дэлхийн үүрэг хариуцлага, ажил төрөлдөө сохор хараллган болчихоод Бурхан хаана байгааг мэддэггүй. Жишээлбэл, та нүдний шилээ халаасандаа хийчихээд хайгаад байдаг шүү дээ. Үүний нэгэн адил дэндүү завгүй бид олон зүйлийг мартчихдаг, эсвэл зарим үед бүр хайртай хүмүүс маань хажууд ирэхэд тэднийг ч харах завгүй байдаг. Тийм биш үү? Бас зурагтаа асаачихна, тэгээд л бас завгүй. Өөр хэн нэгний тухай бодоод байгаа болохоор хүний яаж байгааг ч харахгүй, эсвэл дэргэдэх хүнтэйгээ ярьсаар байгаад зурагтаар юун тухай гарч байгааг мэддэггүй. Тэгдэггүй гэж үү? Энэ бол үнэн. Тэгэхээр дотоодод Бурхан байхад түүнд зориулах цаггүй бол түүнийг харахгүй нь эргэлзээгүй. Ийм л юм! Одоо Би таныг энэ Үг буюу Бурхантай дахин нэгтгэж чадна. Тэгэхээр бид яагаад гэж асуух хэрэггүй, харин яаж дахин нэгдэх вэ гэж л асуу.

***Асуулт 55:*** *Таны бүх зааврыг дагаж, одоо авшиг хүртэхгүй гэвэл бидэнд туслах өөр бясалгалын арга байна уу? Бидэнтэй түүнийг хуваалцан тусалж болох уу? Заримдаа би өнгөрсөн зүйлсээ бодоод, өнгөрсөн үйл явдлууд толгойд эргэлдээд байдаг. Одоо авшиг хүртэхгүй тэр хүмүүстэй хуваалцах ямар нэг бясалгалын арга байна уу? Бас* ургамал *хоолтон болж, бие махбодын тогтолцоогоо цэвэрлэж ариусгачихаар агаарын бохирдол, бусад цэвэр бус бодис болон ариун бус хүмүүстэй харилцахад таныг илүү эмзэг мэдрэмтгий болгочихгүй юу? Хөдөө газар амьдрахад дарамтгүй байдаг. Харин хотын амьдрал маш ядаргаатай, дарамттай байдаг. Өөрийгөө хэрхэн ариусгаж, тийм эмзэг мэдрэмтгий болохгүй байх вэ?*

**Багш:** Ийм л дээ. Зарим нэг бясалгалын арга байна л даа. Та боломжийн хэрээр ургамал хоолтон байхыг хичээ, тэгвэл энэ тус болно. Бүр бохир заваан газар хүртэл ургамал хоолтон байх нь таны дархлааг улам сайжруулж өгнө. Үүнийг та мэдэж байх ёстой! Ургамал хоолтон хүмүүс мах иддэг хүмүүсээс маш бага өвддөг. Тэгэхээр ургамал хоол таныг хамгаалж, сэтгэл санааг чинь тайвшруулж, бодолдоо дарагдахыг чинь багасна. Өршөөн нигүүлсэх чанарыг өгөхөөс гадна ургамал хоолтон байх нь танд ийм ач тусыг авчирдаг. Яагаад тэр вэ? Учир нь бид өршөөдөг. Хэн нэгний амийг таслахгүй байвал бидний амь ч бас эрсдэлт байдалд орохгүй. Энэ бол Үйлийн үр, шалтгаан ба үр дагаварын хууль. Хэрвээ бид бусдыг өршөөвөл, тэд ч бас биднийг өршөөнө, тэгээд бидний сэтгэл улам амгалан болно. Бидэнд гэм буруутай юм шиг санагдахгүй. Сэтгэлд гэмшил төрөхгүй тул сэтгэл санаа амар тайван болно. Ургамал хоолтон байхыг тунгаан бодох тун учир зүйтэй арга зам нь энэ юм.

Тэгэхлээр та авшиг хүртэж чадахгүй байгаа бол танд сахихад хэцүү ямар дүрэм байна гэж бодож байгаа юм бэ? Би түүнийг тайлбарлаад өгье, та өөрөө шийдвэрээ гаргана. Хэрвээ та тэдгээрийг бүрэн сахиж чадахгүй гэж байгаа бол, би танд өөр арга зааж болох юм, асуудалгүй. Тэр ямар дүрмийг чандалж чадахгүй гэж байна? Тэр эмэгтэй юу гэж байна? (”Бие хамгаалах урлаг” гэж сонсогчдын нэг нь хариулав.) Тэр чинь энэ дүрэм журамтай ямар хамаатай билээ? Тулалдах уу? Өө, тэр чинь ердөө зугаа шүү дээ. Та хүний амь хөнөөхгүй, тийм биш үү? Та тулаан хийдэг юм уу? Үүгээр хүн хороох юм уу? Тэднийг өвтгөх үү? Пөөх! Үнэхээр гэж үү! Гэтэл та ийм сайхан хүн байх атлаа яаж хүмүүсийг зоддог юм бэ? Та буруу хоббитой болчихсон юм байна гэж би бодож байна. Яагаад та зурах, бүжиглэх, эсвэл дуулахыг сонирхож болдоггүй юм бэ? Ингэх нь таны сайхан царай, ялдам ярианд илүү тохирохсон.

Үүнийг ямар ч асуудалгүй гэж би бодож байна. Сонирхдог зүйлээ л өөрчилж байгаа хэрэг. Гадаа гарч, хүмүүстэй үзэлцдэг байсан бол тэнд суугаад Бурхантай үзэлцэнэ. “Хурдан гараад ир, надад өөрийгөө харуул” гэж Түүнд хэлээд л. Энэ ч бас нэг төрлийн тулаан. Өөртэйгөө тулаан хийнэ гэдэг бусадтай тулалдахаас хамаагүй хэцүү гэж би боддог. Та тэгж боддоггүй гэж үү? Тэгэхлээр би танд шинэ төрлийн бие хамгаалах урлагийг зааж өгнө. Авшиг хүртчих, тэгээд өөртэйгөө байлд. Энэ нь их сонирхолтой болохыг та мэдэх болно. Ингэвэл ямар вэ?

***Асуулт 56:*** *Будда хамаг амьтныг гэтэлгэхийг хүссэн, бас хамаг амьтныг Будда (Төгс гэгээрсэн) болгохыг хүсэж байсан. Харин Есүс Христ зөвхөн Өөрт нь итгэсэн хүмүүс л аврагдана, эс итгэсэн нь тамд унана гэж хэлсэн. Буддагийн судар номыг тайлбарлахдаа та Библи, Бурханы сургаалыг ашигладаг. Энэ нь Будда Бурханаас илүү сайн, хамаагүй аугаа гэсэн үг үү?*

**Багш:** Үгүй. Тэд хоёулаа ижил юм ярьдаг. Ийм юм л даа. Будда хэлэхдээ Би хамаг амьтныг гэтэлгэмээр байна гэжээ, гэвч чадаагүй, Тэр чадсан уу юм уу? Бүх хүн гэтлэгдчихдэг юм биш. Буддатай уулзсан бүх хүн гэтлэгдчихэж болно л доо, гэхдээ зөвхөн Буддаг амьд байхад л тэгж чадна. Гэтлэгдэхийн тулд бид амьд Буддаг (Төгс

гэгээрсэн төрөлтөн) олох ёстой. Есүс мөн иймл зүйл хэлсэн, өөрт нь итгэсэн хэн ч бай диваажинд очно гэж хэлсэн. Түүнийг амьд байх үед бол энэ үнэн үг, гэтэл явсных нь дараа бид өөр Есүсийг олох хэрэгтэй болно.

Тэгэхлээр тэд нэг л ижил зүйл ярьжээ. Хоёулаа л хамаг амьтныг гэтэлгэхийг хүсэж байсан, итгэсэн хүмүүс нь л диваажинд хүрч очиж чадна. Гэвч олон төрөлтөн диваажинд очоогүй хэвээр байна. Тэднийг явсны дараа бусад хүн ирсэн, тийм ч олон хүн Будда болон Есүст үргэлж итгэж байгаагүй. Буддаг ирэх тоолонд ердөө л цөөхөн, гарт тоологдохуйц цөөн хүн Түүнд итгэж байсан. Тэгэхээр тийм л цөөхөн хүн диваажинд очиж чадна. Бусад нь хаачих нь үйлийн үрээс нь шалтгаална.

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт
## АНУ, Калифорни муж, Сан Хосе, Эвэргрийн Олон нийтийн төв
## 1989 оны 5 дугаар сарын 27

***Асуулт 57** Ургамал хоолтон хүмүүс яагаад сармис, бөөрөнхий сонгино, ногоон сонгино идэж болдоггүй вэ?*

**Багш:** "Wu Shing" гэдэг нь таван төрлийн маш хурц содон амт бүхий, тухайлбал, сармис, сонгино, ногоон сонгины зүйл аймаг гэсэн үг юм. Дорны соёлд, жинхэнэ ургамал хоолтон энэ таван зүйлийн сонгины төрлийг идэж болохгүй гэдэг. Сонгино, сармис, ногоон сонгино гэх мэт. Одоо энэ Хятад хүн надаас яагаад гэж асууж байна. Миний бодлоор, энэ нь амьтан хөнөөсөн явдал биш болохоор та идэж болно л доо. Тийм. Гэхдээ Буддын шашин болон эртний дэг жаягийн Хинду судруудад хэрвээ хүн сонгино сармис, үүнтэй ижил зүйл идвэл түүнээс муухай үнэр танар гардаг бөгөөд чөтгөрүүд дурлаж ирээд уруулыг нь долоодог гэж тайлбарласан байдаг. Хинду болон Буддын шашны судар номд ингэж л тайлбарладаг юм байна. Мөн сонгино, сармис хүний хүсэл тачаалыг өдөөж, жирийнээс илүү ихээр сэтгэл хөдөлгөж догдлуулдаг. Тийм учраас Буддын шашны дэг жаягт лам, гэлэнмаа нарыг амар амгалан байлгахын тулд эдгээрийг идэхийг зөвшөөрдөггүй. Шалтгаан нь энэ л юм.

Харин тэгтэл Буддын шашны зарим эгэл хүн эдгээрийг идэхгүй бол тийм ч сэтгэлийн хөдөлгөөнтэй биш болчихно гэж боддог аж. Ногоон сонгино буюу таван төрлийн ногоон сонгиныг идэхгүй байх сахилын утга учир энэ юм. Гэхдээ та нар бол жирийн хүмүүс шүү дээ. Хэрвээ та ургамал хоолтон байхыг хичээж байгаа ч бас эдгээр хүнсийг хэрэглэхгүй байж чадахгүй байгаа бол үүнд хор хөнөөлтэй юм байхгүй гэж би бодож байна. Зүгээр л аажим яв, хэрвээ идэхээ болимоор байвал идэхээ л больчих. Хэрвээ тэдгээрийг хүсэхгүй байвал аажимдаа идэхээ больчих, эсвэл хааяа нэг хэрэглэж байж болно.

Сонгино, сармис идсэн үед бас тун эвгүй үнэртэж, хамт ажиллаж байгаа зарим хүмүүс маань тэвчиж чаддаггүй гэдэг шүү дээ. Тийм биз дээ? Тэгэхээр бид эдгээрийг идээгүй байвал хүн бүр ямартай ч баяртай байх болно. Гэхдээ сонгино, саримсанд анагаах чанар байдаг. Ханиад хүрсэн бол сонгины шүүс ууж, сонгинотой шөл хэрэглэдэг. Мөн хааяа цусаа цэвэрлэхийг хүсвэл сармис идэж болдог. Өвдсөн үед үүнийг хэрэглэхэд буруудах зүйл үгүй.

***Асуулт 58:*** *Ургамал ногоог хөнөөхийг яагаад амь хөнөөх гэдэгт тооцдоггүй юм бол оо? Зугаацаж хөгжилдөх нь Гэгээрэхэд ямар үүрэгтэй вэ?*

**Багш:** Ургамал ногоог хөнөөх нь бас л нэгэн төрлийн амь хөнөөлт мөн, гэхдээ тун өчүүхэн, Арьяабалын бясалгалын аргаар хэдхэн минутын бясалгалаар бас угааж арилгаж болохуйц өчүүхэн бага үйлтэй. Гэгээрэхээрээ бид тэр Гэрэл болон дотоодын Аялгуутай холбогдсон байдаг. Бид маш хүчтэй болдог. Тэгээд бид өдөр бүр түүнтэй ахин дахин холбогдоод байвал ургамлыг хөнөөсөн буюу хүнсний ногоо идсэн үйлийн багахан үр дагаврыг угааж арилгах болно. Ногоо идэхгүй юм бол яаж энд амьдарч, бясалгах болж байна аа? Тэгээд авшиг хүртчихээд л үхээд өгөх юм уу? Бүр хүнсний ногоо ч идэж болохгүй хэрэг үү?

Амьд байхын тулд үүнийг идэхээс өөр аргагүй. Гэхдээ бид хамгийн бага хэмжээнд л хороож байна. Учир нь ургамлын 90% нь ус байдаг, өвдөлт мэдрэх нь тун бага, өчүүхэн, бараг л юу ч мэдэрдэггүй. Амьтадтай харьцуулахад тэр шүү дээ. Амьтад бол амьдрах дуртай, амиа хамгаалахын төлөө тэмцдэг. Үүнд маш том ялгаа бий. Тийм биз? Харин та зөвхөн цагаан хоол л иддэг, харин дотоод Бурханы хүчтэй тань холбож өгдөг Арьяабалын бясалгалын аргаар бясалгадаггүй бол та гэтлэгдэх тань баттай болж чадахгүй, учир нь та сая тайлбарласан шиг ямарваа хэлбэрээр амь хөнөөсөөр л байгаа.

Хоёр дахь асуулт, “ямар үүрэг......, гэгээрэхэд зугаацаж хөгжилдөх нь ямар үүрэгтэй вэ” гэл үү? Англиар зөв үү? Зөв асуулт уу? Гэгээрэхэд зугаацаж хөгжилдөх ямар үүрэгтэй вэ? Гэгээрчихсэн бол зугаацах чаддаг хэвээр байх уу гэж та асуух гээд байна уу? Энэ зөв үү? Ийм утгатай асуулт уу? Асуусан хүн нь босоод надад тайлбарлаад өгөөч. Энэ алдартай асуултын эзэн хэн бэ? Та юу? Надад ойлгуулаад өгөөч. “Гэгээрэхэд зугаацаж хөгжилдөх нь ямар үүрэгтэй вэ?” (Үзэгчдийн дундаас нэг хүн “дотооддоо Хөгжмийг зугаацахын тулд сонсдог бол ухамсарт ямар ч ялгаа гарахгүй” гэж Та түрүүн хэлж байсан) Би тийм утгаар хэлээгүй. Зугаатай учраас л тэрийг сонсдог юм биш гэсэн утгаар хэлсэн. Учир нь гэвэл дотоодын аялгуу бидэнд аугаа боломжийг өгдөг. Зугаацах гэж гаднах жирийн хөгжим сонсдогтой энэ огт адилгүй. Би ямар утгаар хэлсэн гэхлээр, дотоодын Аялгуу бол зугаацахад зориулагдаагүй, харин биднийг гэгээрүүлж, өдөр бүр улам их билиг ухаан өгөхийн төлөө юм. Ийм утгаар л юм. Одоо би таныг ойлгож, та ч бас намайг ойлголоо.

Зугаа цэнгэл болон баяр жаргал хоорондоо ямар ялгаатай вэ? Хоёулаа адилхан гэж би бодож байна. Зугаацаж цэнгэхээрээ бид баяр хөөртэй болдог, магадгүй тийм л байдаг байх. Зугаацах гэдэг нь их нухацтай биш байх. Зарим төрлийн тоглоом, гадны нөлөө нь зугаа цэнгэлийг өдөөдөг байх, харин баяр жаргал бол илүү гүн гүнзгий байх. Илүү гүн гүнзгий сэтгэл ханамжийн мэдрэмж байж магадгүй л дээ. Толь бичгээс харвал ийм л байх, магадгүй, магадлалтай зүйл. Энэ болж байна уу? Танд баярлалаа.

***Асуулт 59:*** *(Их Багш асуултыг уншаад орчуулав.) Энэ хүн аль хэдийн өөр нэг баясалгалаар хичээллэдэг болсон гэнэ ээ, өөр ямар нэгэн арга байх л даа, тэгээд авшиг хүртэж бас болох уу? гэж асуусан байна.*

**Багш:** Мэдээж болно, авшиг хүртэхэд таны сүнслэг хүч бэхжинэ шүү дээ.

***Асуулт 60:*** *Христ мөн чанар луугаа би хэрхэн хүрч эхлэх вэ? Бурханы аялгууг сонсож эхлэхийн тулд миний зүгээс онцгойлон юу хийх ёстой вэ?*

**Багш:** Та маягтыг бөглөөд, авшиг хүртэх хүсэлтээ гарга, дараа нь бид хамтдаа суугаад Би танд түүнийг уламжилна. Дотоодын сонсох мөн чанарыг тань би нээж өгч туслана гэсэн үг. Дотоодын сонсох мөн чанар гэдэг нь бидний жинхэнэ-Би, гаднах сонсох чанар нь хуурмаг Би юм. Хуурмаг-Би нь энэ хуурмаг биеийг заадаг. Энэ махан бие бол хуурмаг-Би, жинхэнэ Би бол дотоодод буй. Би юу гэж байна гэхлээр энэ нь дотор биш, гэхдээ өөр нэг зүйл юм. Тэр бидний дотоодод байж л байдаг. Тэр жинхэнэ нь жинхэнэ чихтэй, жинхэнэ нүдтэй. Одоо бол тэр жинхэнэ нь унтаж байгаа, тиймээс бид жинхэнэ ертөнцийг харахгүй, Бурханы жинхэнэ дуу хоолойг ч сонсохгүй байна. Хэрэв тэр жинхэнэ нь сэрчихвэл, бид үүнийг сэрэхүй, эсвэл гэгээрэхүй гэж нэрлэдэг. Тэгвэл бид нэгэн өөр дэлхий, жинхэнэ дэлхийг харж чадна. Жинхэнэ мэдрэх эрхтнээрээ бид Бурханы орныг харж, Бурханы үгийг сонсож чадна, үүнийг хэрхэн хийхийг аль хэдийн мэддэг болсон төгс төгөлдөр нэгэн хүнээр тэрхүү жинхэнэ мэдрэх эрхтнүүдээ сэрээлгүүлнэ. Энэ нь машин, эсвэл зурагт засч чаддаг хүнтэй л адил. Тэр яаж хийхийг мэддэг шүү дээ.

Тиймээс л авшиг хүртэх үед Их Багш дотоод чихийг тань нээж өгснөөр та түүнийг сонсож чаддаг болно. Эс бөгөөс та чадахгүй. Хэдэн зуун мянган тэрбум жилээр амьдарсан ч та дотоод ертөнцийг хэзээ ч үзэж чадахгүй. Зөвхөн энэ гадаад дэлхий, бие махбодын дэлхий, материаллаг ертөнц, үхэж төрдөг, өөрчлөгддөг, мөнх бус чанарын хорвоо дэлхийг л үзэж туулна. Та жинхэнэ, мөнхийн, үл үзэгдэх дотоод ертөнцийг хэзээ ч үзэж мэдэж чадахгүй. Түүнийг үзэж мэдэхийн тулд бид жинхэнэ-Би, дотоод Би-гээ сэрээсэн байх ёстой.

Энэ нь цэцэг харахын тулд нүд, ярихын тулд ам, сонсоход чих, мэдрэхүйн таашаал эдлэхэд бие хэрэгтэй шиг л, өөр өөр юмыг мэдрэхэд өөр өөр эрхтэн хэрэгтэй байдагтай л адил юм. Одоо харин бидэнд гэгээрч, Бурханыг мэдэхийн тулд өөр эрхтэн байна. Эдгээр өөр эрхтэн нүдэнд харагддаггүй, бид тэднийг сэрээх ёстой. Гэхдээ бид өөрсдөө сэрээж чадахгүй. Тиймээс үүнийг чадах хэн нэгнээс гуйх ёстой юм. Өөрсдөө хийж чадах бол болж байна, сайн хэрэг. Харин чадахгүй бол мэргэшсэн хүнээс нь гуй.

***Асуулт 61:*** *Танаас гэгээрэх аргыг авчихаад гэртээ бясалгаж болох уу? Энд Калифорнид байгаа Та надад яаж туслах юм бэ?*

**Багш:** Та энэ аргаар гэртээ өдөр бүр бясалгаж болно. Гэр тань таны сүм шүү дээ. Бие тань таны сүм. Та хаашаа ч, ямар ч сүм хийд рүү очих шаардлагагүй, бүр надтай

уулзахаар ирэхийн ч хэрэг байхгүй. Та хэрэв хүсэж байгаа бол болно л доо. Учир нь Их Багш бүхэн үргэлж-оршигч, хаа сайгүй оршигч хэмээн нэрлэгдэх үнэ цэнэтэй байдаг. Тэр эмэгтэй, эсвэл эрэгтэй их багш таныг хаана ч хамгаалж чадна. Таныг хамгаалахын тулд үзэгдэж ч чадна. Та яг одоо намайг харж байгаа шиг л тэр хаана ч, хэдийд ч танд харагдаж чадна. Их багшийн махан биед сэтгэл хүлэгдэх шаардлага байхгүй. Би тантай хэдийд ч холбогдож чадна. Өөрт тань буй саад тотгорууд, эсвэл хангалттай өндөр дэс төвшинд хүртэл гэгээрээгүйн улмаас Их Багшийн хувилгаан биеийг хараахан хараагүй байдаг ч бай хамаагүй та бүр захиа бичиж, утсаар ярьж ч болно. Өнөө үед энэ нь ямар ч асуудалгүй болсон шүү дээ. Ингээд дууссан уу? Асуултанд тань бүрэн хариулав уу?

***Асуулт 62**: Мөнхийн амьдрал гэж юу вэ? Үхэхэд ямар байдаг вэ?*

**Багш:** Үхэхэд ямар байдаг вэ? Та үхэхгүй, энэ л гол нь. Гэгээрлийг мэдсэний дараа та үхэхгүй. Нэг өрөөнөөс нөгөө өрөө рүү ордог шиг л та нэг ухамсраа нөгөөгөөр солино. Өнгөрөх, үхэх энэ тэр гэж юм огт байхгүй. Та үүрд амьдарна. Үүнийг л мөнх амьдрал гэж нэрлээд байгаа юм, “Chang Sheng Buh Lao” гэж нэрлэдэг. Та хэзээ ч үхэхгүй. Та үхэхгүй, энэ чинь ердөө л хуурмаг зүйл. Бид зөвхөн хувцсаа л сольдог. Харин бясалгадаггүй хүмүүс бол, үнэхээр үхдэг. Учир нь тэд мөнх амьдрал гэж юу байдгийг мэдэхгүй. Ийм л юм.

***Асуулт 63:** (Их Багш асуултыг уншив.) Энэ Хятадаар юм байна. Энэ хүн ингэж асуужээ, өдөр бүр ямар аргаар, яаж Бурхантай ойрхон байх вэ? гэжээ.*

**Багш:** Арьяабалын бясалгалын аргыг ашигла гэж би хэлсэн. Та өдөр бүр Бурхантай хамт, өдөр бүр түүн дотор, өдөр бүр тэрэнтэй хамт байна, өдөр бүр та өөрөө тэр байх юм шүү дээ.

***Асуулт 64:** Би нэг Гүрү багштай л даа, Таны сайхан сэтгэлд би талархаж байна. Өөрийн гадаад амьдралынхаа талаар би будлиад байх юм. Танд надад өгөх өөр зөвлөгөө байна уу? Би дагахад бэлэн байгаа хэрнээ ухамсар, сэтгэл маань дотоод илгээлтийг хүлээж авахгүй байна.*

**Багш:** Бид бие биентэйгээ дотоодоороо холбогдоогүйгээс л ингэж байгаа юм. Бид холбогдчих юм бол та бүр ч илүү бэлэн болно. Гэхдээ ямар ч байсан бүү яар. Өнөөдөр бэлэн биш байгаа бол өөртөө маргаашийг, эсвэл дараа жилийг, үгүй бол хойд насаа үлдээ. Ирж төрөх олон олон төрөл танд байна, юундаа яарах вэ. Хэрэв энэ төрөлдөө, нэг л төрөлдөө үүнийг гүйцээж цэгцэлмээр байвал та намайг дагаж болно. Хэрэв танд цаг хугацаа байгаа бол энэ талаар олон мянган жилийн турш бодож болно (Инээв). Одоо танд аль хэдийн Гүрү байгаа юм чинь болж байна гэж бодож байна. Танд баяр хүргэе. Харин гадаад амьдралынхаа талаар төөрөлдсөөр байгаа бол энэ нь таны багш өөрт чинь арай л хангалттай биш байна гэсэн үг.

***Асуулт 65:** Гүрү гэж юу вэ?*

**Багш:** Гүрү гэдэг нь Их Багш гэсэн үг. Энэ нь орчин үеийн үг, Самгарди хэлний үг л дээ. Гүрү гэдэг нь харанхуйг зайлуулагч, Гэрэл өгөгч, гэгээрсэн Их Багш гэсэн утгатай. Ийм л үг юм, гэтэл бид бүгд үүнийг ярвигтай болгоод байх юм. Үүнийг янз янзаар нэрлэдэг. Гүрүг та Будда, эсвэл Их Багш гэж дуудаж болно. Гүрү гэдэг ийм л утгатай.

Одоо тэр эмэгтэй Гүрүтэй хэрнээ ихэд будилсаар байна гэдэг чинь тэр Гүрү нь түүнд олигтой тус нэмэргүй байна гэсэн үг, эсвэл тэр өөрөө Гүрү-гээ илтэд, бүрэн дүүрэн дагадаггүй байх. Хэрвээ та сайн Гүрүтэй, бас тэр танд сайн арга зааж өгсөн бол багшийгаа үг дуугүй сайн дага. Бүрэн дүүрэн дагасан хэрнээ л дотоод болон гадаад амьдралдаа сэтгэл хангалуун биш байвал буцаад ир, би танд тусалж болох юм. Гадна талд ямар л төөрөгдөл байна, түүнийгээ тодорхой бичээд ир, би танд хариулж, бас тусалж болох юм.

***Асуулт 66:*** *Хималайд гэгээрсэн тэр амьдралынхаа талаар ярьж өгнө үү?*

**Багш:** Их урт түүх болно. Та зүгээр л ингээд гэгээрнэ. Нэг их яриад байх юм байхгүй ээ, Мөн чанараа үзэж ухаарсан. Мөн чанараараа өөрөө дотоодын баяр баясгалан, сэтгэл ханамжийг олсон. Хэрэв та авшиг хүртэхийг хүсэж байвал, сүүлд үүнийг даруй мэдэж магад. Энэ тухай ярихад дэндүү их цаг үрнэ.

***Асуулт 67:*** *Өмнө нь байсан болон гэгээрсний дараах Та хоёрын хооронд ямар ялгаа байна вэ?*

**Багш:** Маш их ялгаа бий, маш их ялгаатай. Та нарт хэлэх боломжгүй маш олон зүйл бий. Гэгээрсний дараа танд бүх юм тов тодорхой болдог юм. Бүх Библи судар маш тодорхой болно. Өмнө нь библи, судар номуудыг бүр уншаад ч ойлгогддоггүй байсан. Гэгээрсний дараа өдрөөс өдөрт улам ихийг ойлгож, суралцахгүйгээр бүхнийг мэдэж авч, тэр байтугай та улам л аугаа ихээр гэгээрнэ. Тэгснээр та хаа сайгүй оршиж, юуг ч хийж, хайртай дуртай хүмүүсээ аварч чадна. Диваажинд хүрч, бас тамд очин тамын төрөлтнүүдийг аварч чадна. Хүмүүний ухаан санаанд багтамгүй тийм зүйлсийг хийж чаддаг болно. Энэ бол гэгээрсэн болон гэгээрээгүй хоёр хүний ялгаа юм.

Гэгээрээгүй хүн энэ амьдрал, өөрийн хүч чадал, бүхий л гай гамшиг, зовлон гуниг, бүр аливаа бясалгалд хүртэл эргэлзэж тээнэгэлзэж явдаг. Харин гэгээрсэн хүн мөнхийн баяр хөөртэй, үргэлж сэтгэл хангалуун байдаг, ямар ч нөхцөл байдал дор амьдарч чадна. Тэрээр Буддагийн хүрсэн бүхий л зүйлд хүрч, Есүсийн хийсэн бүхнийг чадна. Энэ нь ижил хүч чадал, гэгээрлийн мөн адил төвшин гэсэн үг.

Хэн нэгэн бүрэн төгс гэгээрэхэд, бүр төгс гэгээрэхээсээ ч өмнө, дөнгөж бага зэрэг гэгээрсэн байхдаа ч асар сайхан санагдаж, баяр жаргалтай, нуруун дээрх ачаа нь хөнгөрсөн мэт мэдрэмж төрдөг. Гудамжинд бүжиглэж, агаарт сэлж чадахаар ч юм шиг бодогддог. Энэ бүх гайхам сайхан мэдрэмжийн тухайд би юу хэлэхээ мэдэхгүй байна, учир нь ярих тусам улам төөрнө, энэ аймшигтай. Би уучлал гуйя,

та үүнийг өөрөө үзэж мэдэх ёстой. Ингэх боломжийг би танд олгоё, тэгээд та үүнийг өөрөө мэдэж авна. Надаас асуух шаардлагагүй болно. Гэхдээ танаас энэ талаар асуух хэн нэг хүн байвал та ингэж л хэлнэ, би танд хэлж чадахгүй.

***Асуулт 68:*** *Таныхаар Бурхан гэж юу вэ?*

**Багш:** Бурхан бол энэ. Бурхан бол тэр. Өө, Бурхан минь! Бурхан гэж юу вэ? Та мэдмээр байгаа бол авшиг хүртээх үеэр би танд үүнийг хэдхэн минутын дотор мэдүүлж чадна. Харин надаас энэ тухай асуух юм бол би дахиад л хэлж чадахгүй болчихно. Бурхан бол таны хэзээ ч төсөөлж байгаагүй аугаа их хүч, хэзээ ч амталж байгаагүй аугаа их хайр, хэзээ ч мөрөөдөж байгаагүй тийм их сэтгэл ханамж гэдгийг л би танд хэлж чадах байна. Бурхан буюу ер нь хэн ч гэж нэрлэсэн бай энэ Хүч, Будда чанар бол хамгийн дээдийн дээд хайр, орчлон ертөнц дээрх хамгийн төгс төгөлдөр зүйл. Тэр нь Бурхан юм. Харин та түүнд хүрэхээрээ та ч хамгийн дээд болно. Та бүх зүйл болно. Бүхий л  хэргийг бүтээж чадна. Бурхан гэж энэ л юм.

Гэвч хүмүүс энэ амьдралд хэдийнээ бүх юм өөрт нь байна гэж боддог учраас маш цөөхөн хүн л Бурханыг мэддэг. Бурханы тухай ярина гэдэг тун хийсвэр зүйл, хэн ч үүнийг ойлгохгүй. Бурханыг таньж ухаарсан хүмүүс ч энэ талаар ярина гэдэг тун бэрх. Учир нь өөрөө танин мэдэж, өөрийн туршлагаасаа ухаардаг хүмүүн төрөлтөн бид ийм ядмаг үг хэл, хязгаарлагдмал ойлголтоороо тайлбарлаад л Бурханыг ухамсарлачихаж чадахгүй. Бясалгалын Арьяабалын арга бол Бурханыг нэн даруй, хурдан түргэн мэдэж болдог арга юм. Авшиг хүртсэний дараа та өдөр тутам минут бүрт Түүнийг дахин дахин таниж мэдэх болно. Тэрээр таныг анхааран халамжилна, ингээд та ч Бурхан байдаг гэдгийг мэддэг болно.

***Асуулт 69:*** *Авшиг хүртэхэд яагаад насны хязгаар байдаг вэ?*

**Багш:** Учир нь зарим үед  хүмүүс нас өтөлхөөрөө ухаан санаа нь бага сага самуурч будилдаг. Тэд зааврыудыг ойлгохгүй, эсвэл ургамал хоолтон байж чаддаггүй. Тэгээд л тэр. Сүнс мөнхөд залуугаараа байдаг. Зөвхөн энэ сэтгэлд л бясалгал дадал хэрэгтэй. Учир нь бидний ярьж байгаа зүйлийг сэтгэл барьж авч чадахгүй бол хүлээн зөвшөөрч бас чадахгүй, мөн цааш нь нэвтрүүлэхгүй гэсэн үг. Сэтгэл гэдэг чинь үүдний сахиул. Тэрэнтэй нөхөрсөг л байхгүй бол таныг дотогш оруулахгүй.

***Асуулт 70:*** *Хүн эргэж төрдөг юм бол яагаад дэлхийн хүн ам олшроод байгаа юм бэ?*

**Багш:** Хүмүүс эргэж төрдөг болохоор л тэр! (Инээв.) Учир нь ихэнх хүн гэгээрэхгүй, чөлөөлөгдөхгүй байна. Тиймээс л дэлхийн хүн ам өсөөд байна даа. Тамаас эргэн гарч ирэн хүний төрөл авч дахин төрж байна. Амьтны ертөнцөд байсан төрөлтнүүд амьтан байх үйлийн үрээ төлсний дараа буцаж ирээд хүн болсон байна. Бид хичнээн их үхэр, нугас, тахиа, гахай иднэ, төдий хэрээр дэлхийн хүн ам хэт өснө. Тэр сүнснүүд хариу өс хонзонгоо авах тэр газрыг олох ёстой. Бас энхжингийн орны зарим тэнгэрийн элч, зарим хүн хэдэн зуу, хэдэн мянган жилийн дараа төрөл аван

эргэн төрөхдөө Дэлхийд хүн болж ирдэг. Тийм болохоор дэлхийн хүн ам байнга, цаашид ч хэт олширсон хэвээр байна.

***Асуулт 71:*** *Биднийг Бурханы дүр төрхөөр бүтээдэг юм бол бид яагаад ийм мунхаг байгаа юм бэ? Яагаад Бурхан биднийг гэгээрсэн чигээр нь бүтээж болоогүй юм бэ?*

**Багш:** Бурхан биднийг гэгээрсэн чигээр нь бүтээсэн. Бид л харин Гэрлээр нь явдаггүй, тэрнийг ардаа хийдэг, тэр Гэрлийг нуудаг, хувцасны шүүгээндээ нуучихсан хэрэг. Тэр Гэрлийн хаана байгааг мэдэхийг хүсвэл та авшиг хүртчих, тэгээд л агшин зуур түүнийг харах болно. Бурханыг яагаад ийм хайр энэрэлгүй байгаа юм бэ гэж Бурханаас асуух шаардлага байхгүй. Тэр нэн хайр энэрэлтэй. Бид л тэрийг нь ашигладаггүй болохоос. Яг л бид нүдний шилээ атгачихаад хаа нэг тийш утсаар ярьж дуусаад нүдний шилээ хайгаад явдагтай энэ нь адил. Энд байна гэхэд та тэр даруй харж чадна. Тийм учраас л хөөрхийлөлтэй хүмүүс үүнийгээ хардаггүй. Харин би өдөр бүр гайхшран суудаг. Бурханыг харах ийм амархан байдаг. Энэ бол хүмүүсийн сэтгэлийг хааж тотгорлодог сөрөг хүчний л хийж байгаа ажил.

***Асуулт 72:*** *Дандарын ёсны үүрэг нь юу вэ? Энэ нь йог мөн үү?*

**Багш:** Дандар йог нь ийм юм л даа. Жинхэнэ дандар бол бясалгалын нууц дадуулалт юм. Яагаад нууц байгаа вэ? Эрт дээр үеэс авахуулаад Их Багш нар аюул занал дунд амьдарсаар иржээ. Жишээг нь та өөрөө харсан ч болно. Энэтхэгийн олон гэгээнтэн амьдаараа арьсаа өвчүүлж, Есүс цовдлуулж, Будда бараг л алуулах дөхсөн бөгөөд амьдралынхаа туршид өдөр бүр халдлагад өртөж байсан. Тийм учраас эртний Их Багш нар өөрсдийгөө маш сайн нуудаг байв. Тийм ч учраас Их Багштайгаа уулзъя гэхэд их бэрх байжээ. Тэгээд л үүнийгээ нууц сургаал, бясалгалын нууц арга зам гэдэг болжээ.

Дандар бол үүний нэг хэсэг нь юм. Жинхэнэ дандрууд бол Арьяабалын аргаар бясалгаж байсан тэр хүмүүс, гэгээрлийн энэ арга. Гэвч одоо цагт бүх юм өөрчлөгджээ. Жинхэнэ Их Багш нь өөд болонгуут бүх зүйл өөрчлөгдчихдөг. Ямарваа шашин, урсгал, бясалгалын аргын хувьд ийм байдаг. Ийм шалтгааны улмаас зохистой аргыг засаж залруулах, зөв аргыг нь хүмүүст хэлж өгөхийн төлөө жинхэнэ Их Багш үргэлж ахин дахин төрөхөөс өөр аргагүй болдог юм. Гэвч тэрхүү жинхэнэ Их Багшийг ирэх болгонд хүмүүс - үгүй ээ, би тантраар хичээллэдэг, Буддын шашныг бясалгадаг, би Католик шашныг шүтдэг, энэ л байхад хангалттай гээд хүлээж авдаггүй. Амьд Их Багш маш чухал гэдгийг тэд мэддэггүй.

Өнөө цагийн дандар бол жинхэнэ дандар нь биш. Аливаа ёс жаяг нь дотоодын жинхэнэ ухаарлын бэлгэ тэмдэг төдий зүйл. Жишээ нь, лааны гэрэл, бөмбөр болон харанга цохих чимээ, хонхны дуу гэхчлэн энэ бүхэн нь дотоодын гэрэл, дотоодын бөмбөр, дотоодын хонх, дотоодын харанга, дотоод ухаарлыг илтгэх бэлгэ тэмдгүүд юм. Ийм учраас аливаа зан үйлд хүмүүс олон эвэр бүрээ үлээж, баахан хөгжим тоглож, сүм буюу бясалгалын төвд маш олон лаа асаадаг.

Эдгээр нь дотоодын хүч, ухаарал, гэрэл, аялгууг бэлгэдэж байгаа юм. Гэхдээ тэдэнд ердөө зан үйл нь байгаа болохоос жинхэнэ ухаарал нь байхгүй байна.

***Асуулт 73:*** *Чод Йог буюу би үзлийг устгадаг Түвдийн зан үйл ямар учиртай юм бэ?*

**Багш:** Бараг үхэж, авсанд орох шахдаг хүн үү. Майхан барьж суугаад өдөр бүр өөрийгөө шийтгэж, өөртөө би үзлээ дэвсэж хаяя гэж хэлдэг гэх мэт зүйлс. Энэ чинь тэдний бясалгал нь. Заримдаа энэ бясалгал тэр хүнийг солиотой болгодог. Ихэнхдээ л ийм байдаг ч багш нь үүнийг тоодоггүй. Чод йогт өөрийгөө нэгэнт зориулбал нэг бол та түүнийг олж авах, эсвэл амиа алдаж ч болох эрсдэлтэй гэж багш нь хэлдэг.

Орчин цагт үүнийг дэндүү аюултай гэж би үздэг. Бидэнд “Би”үзлээ дарахын тулд үхээрийн газар очих юмуу, хаа нэгэн буйдхан газар очиж майхан бариад суух цаг зав хаана байна. Би үзлээ үгүй хийнэ гэдэг бол өөрийгөө Бурханд нэгтгэхийг хэлнэ гэж би итгэдэг. Бурхантай нэгэн цогц болсон үедээ би өөрийгөө хаядаг, ийм л энгийн зүйл. Гадны талын шийтгэл, өөрийгөө ховсдох зэргээр тархиа дарамтлах ямар ч хэрэг байхгүй. Тийм, би ингэж л итгэдэг. Баярлалаа.

Энэ бол Чод йог. Түвдэд байдаг юм. Тэд үүнийг сургуулилдаг. Энэ жаахан аюултай. Та их туранхай, тун шаргал, цагаан болно. Их идэж болохгүй. Өдөр бүр өөрийгөө зоддог байх. Заримдаа бүр үнэхээр өвдөтлөө дадлага хийнэ. Та өвдөлт мэдэрнэ, тэгээд өвдөлтийг өөрийгөө гэж өөртөө итгүүлнэ. Бас хэн ч өөрийг нь хороох гээгүй байхад хэн нэгэн намайг хороож байна гэж боддог. Хэн ч өөрийг чинь зодоогүй байхад зодуулж байна, их өвдөж байна гэж итгэнэ. Тэгээд, уучлаарай, та С-О-Л-И-О-Т болно.

***Асуулт 74:*** *Сэтгэл (Mind) гэж юу вэ? Тэр нь биеийн хаана оршдог вэ? “Би бодлоо өөрчиллөө” гэсэн нэр томъёо ямар утга санаа агуулдаг вэ? Гэгээрэх үйл явцад оюун бодлын гүйцэтгэх үүрэг юу вэ?*

**Багш:** Угтаа сэтгэл оршдоггүй. Бид бодох сэтгэх, эсвэл үзэл санаагаа өөрчлөх үедээ л түүнийг танин мэддэг. Тэгж л бид оюун бодолтой гэдгээ, би санаагаа өөрчиллөө гэдгээ мэддэг. Хэрвээ бидэнд сэтгэн бодох, бодол санаа байхгүй үед бидэнд сэтгэл гэх юм байдаггүй. Сэтгэл хаанаас бий болдог юм бэ? Зөвхөн бодохоос, гаднах мэдээллүүдээс цуглуулсан өгөгдлүүдээс л бий болдог. Бидний сэтгэлгээ бол бидний суралцах үйл явц, бусад хүмүүстэй харилцсаны үр дүн. Үүнийг л бид сэтгэл гээд байгаа юм. Харин сэтгэл гэж юм үнэхээр оршдоггүй.

Сэтгэлийг бид шалтгаан, эсвэл бодит туршлага дээр үндэслээгүй урьдчилсан бодол буюу мухар сүжиг гэж хэлж болно. Бид юу л бол юуг хамж түүгээд түүндээ итгэсэн ч, итгээгүй ч, хэсэг хугацааны турш нэмж цуглуулаад цуглуулсан тэр зүйлээ “сэтгэл” гэж нэрлэдэг. Хэрвээ та Буддын шашинд итгэдэг бол хэн нэгэн ирээд Католик шашныг ухуулбал, та тэр номлогчид итгэхгүй бөгөөд Католик шашин сайн

биш, энэ номлогч буруу номтон, эсвэл шүтлэггүй гэх мэтээр хэлдэг. Ингэж байхдаа та өөрт чинь сэтгэл санаа байна гэдгээ мэдэг. Та өөрийгөө мухар сүжигтэй гэж үзэж болно. Ийм л юм. Өөр хэн нэгнээс цуглуулсан бодлууд таныг үнэмшүүлээд дотор тань гүн бат үндсээ суулгана, та энэ үндсийг сугалаад хаяж чаддаггүй. Энийг л "сэтгэл" гэж нэрлээд байгаа юм.

Сэтгэл биеийн аль нэг хэсэгт байрладаггүй. Магадгүй цуглуулсан янз бүрийн мэдээллийг хадгалдаг тархины бор давхаргад хаа нэгтээ нь байдаг байж болох юм. Гэхдээ тархинд мэс засал хийгээд нээж үзвэл олдохгүй. Энэ нь нүдэнд үзэгддэггүй бодлын долгионууд юм. Энэ л сэтгэл юм.

"Би санаагаа өөрчиллөө" гэж хэлэхдээ бид санаа зорилгоо өөрчилдөг. Яг л чихэр идэхийг хүсдэг шиг. Би чихэр идмээр байснаа, болохгүй ээ, чихэр шүд өвтгөнө гэж боддог. Тэгэхлээр би сэтгэлээ өөрчлөөд жимс иддэг. "Би санаагаа өөрчиллөө" гэж үүнийг л хэлээд байгаа юм. Ийм л энгийн. Та яагаад надаас асуух болов? Бид бодол хийгээд ямар нэгэн юмны сонголтоо өөрчилж байгаа нь санаа бодол буюу сэтгэлээ өөрчилж буй үе юм.

Гэгээрэхэд сэтгэл ямар үүрэгтэй вэ? Энэ их чухал. Гэгээрэх үйл явцад сэтгэл маш том үүрэгтэй. Сэтгэл бидэнд тусалж чадна, бас итгэл сүсгийг маань сүйтгэж чадна. Тийм ч учраас Их Багш өөрөө хичнээн өндөр дэстэй байлаа ч сэтгэлтэй найзлахын тулд, сэтгэлд тэрхүү санаануудыг хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө, улмаар танаар явж авшиг хүртээд бясалгаж эхлэх алхмыг хийлгэхийн тулд Их Багш маш олон учир зүй, шалтгааныг ашиглах ёстой болдог. Хэтэрхий их мухар сүжиг, тогтсон үзэл санаа байсны уршгаар сэтгэл бидний яриад буй зүйлийг хүлээж авахгүй байвал тэр хүн асуудалд орж байгаа юм. Яг л хамгийн эхний хүн "би таныг дагамаар байна л даа, гэвч сэтгэл маань тэр илгээлтийг хүлээж авахгүй байна" гэж хэлж байсан шиг. Асуудал үүнд л байна, учир нь тэд тогтсон үзэл бодлыг их хураажээ. Жишээ нь, Будда болохын тулд Очироор огтлогч судрыг мянган удаа уншсан байх ёстой, Будда болохын тулд "*Ум Ма Ни Бад Ми Хум*"-ийг хэдэн зуун удаа унших ёстой гэх мэт. Эсвэл Диваажинд очихын тулд ням гараг бүр сүмд очиж, номлогчийн сургаалыг сонсох учиртай гэх мэт. Тэгээд Формосагаас (Тайвань) ирсэн Их Багш Чин Хай гэгч хүн бидэнд Бурханыг үзүүлж чадна гэж хэлэхэд нь итгэж чаддаггүй. Сэтгэл бидэнд ингэж л тотгорлодог, ингэж л гэгээрлийн замд том үүрэг гүйцэтгэдэг юм. Ихэнх хүн гэгээрч чадахгүй байна. Ихэнх хүн энэ дэлхий дээр дахин дахин төрж байна. Энэ сэтгэлээс болоод тэд дэлхийн хүн амыг хэт өсгөөд байна. Их Багшийн заавар зөвлөгөөг хүлээн авч, гэтлэгдэхийн төлөө тэд энэ сэтгэл гэдэг хаалгыг нэвтэлж чадахгүй байна. Сэтгэл гэдэг ийм л аугаа аж. Бурханы дараа орох аугаа зүйл аж. Сэтгэл энэ дэлхий дээрх бүхнийг захирч удирддаг болохоор бүр Бурханаас ч илүү аугаа байж магадгүй гэж би хэлье. Тогтсон үзэл, мухар сүжиг, хурааж цуглуулсан мэдээ, мэдээлэл бүхнийг удирдаж байна. Тэгээд бидний төрөлх мөн чанарыг мартуулдаг, энэхүү урьдаас тогтсон үзэл санаанууд чинь би биш гэдгийг мартуулж байна. Бид шүүлт ирнэ гэдгийг мартах ёсгүй. Бид төрөлх билиг

ухаанаа олох учиртай, гэтэл сэтгэл үргэлж л хөндөлсдөг. Дэлхийн хүн ам ингээд л хэт өсөөд байгаа юм. Сэтгэлээс л болж байгаа нь тэр.

***Асуулт 75:*** *Яагаад бясалгаж байж л гэгээрэх ёстой юм бэ? Өөр ямар нэгэн үйлдлээр гэгээрэлд хүрэх боломжтой юу?*

**Багш:** Бясалгалаар л гэгээрдэг юм биш. Гэгээрэлд хүрэх ажлын нэгээхэн хэсэг нь л бясалгал юм. Гэвч бясалгахгүйгээр та гэгээрч чадахгүй. Гэвч та тохиолдлоор бясалгаж байгаа үед гэгээрэх амаргүй. Та авшиг хүртэх ёстой, өөрийгөө нээлгэх ёстой. Дотоодын билиг ухаанаа нээх ёстой, тэгвэл л та гэгээрнэ, бясалгалаар биш. Харин билиг ухаанаа нээлгүүлсний дараа та түүнийгээ тэжээж тэтгэх ёстой. Нам чимээгүй сууснаар та өдөр бүр гэгээрнэ. Мөн чанар, билиг ухаанаа ухаарч танихын тулд нам гүм байх учиртай. Бурханы илгээлтийг танин ухаарахын тулд зогсож, сууж, хэвтэхийн алин ч бай үүнийг бясалгал гэж нэрлээд байгаа юм. Тэгэхээр хөлөө ингэж завилж суугаад л гэгээрэлд хүрчихнэ гэж битгий бодоорой. Тийм биш, тийм биш, тийм биш. Та чимээгүй байж, дотоод луугаа нэвтэрч, билиг ухаанаа таних ёстой. Ингэх нь бясалгал юм. За юу. Төрөлх билиг ухаанаа олоогүй бол хичнээн удаан бясалгасан ч нэмэргүй. Ямар ч ялгаа гарахгүй, ашиг тус ч гарахгүй.

***Асуулт 76:*** *(Их Багш асуултыг Хятад хэлнээс орчуулав.) Та нар сонсмоор байна уу, үгүй юу? (Үзэгчид: Тийм ээ, сонсъё гэв.) Энэ хүн ингэж асуужээ. Та жинхэнэ Будда, жинхэнэ дотоод ертөнцийг хуурмаг үзэгдлээс яаж ялгадаг юм бэ? Бясалгаад дотоод ертөнцийг үзэх үедээ энэ нь жинхэнэ, эсвэл хуурмаг гэдгийг яаж мэддэг юм бэ?*

**Багш:** Авшиг хүртэх үед үүнийг би танд хэлж өгнө. Үүнийг хэрхэн ялгаж салгахыг би хэлнэ. Жинхэнэ ба хуурамч хоёрыг ялгадаг нэг арга бий. Бас дээр нь танд Их Багшийн хамгаалалт өгөгдөнө, тэгээд та мэднэ дээ. Гэгээрсний дараа та мэднэ. Жинхэнэ Их Багш танд бүгдийг, бүхий л бүтэлгүйтэл, замд таарах бүхий л нүх саад, чөтгөрийн тавьдаг хуурамч үзэгдэл ба ов мэх бүхнийг зааж өгөх учиртай. Ингэж чадахгүй бол тэр жинхэнэ Их Багш биш байна, учир нь тэр өөрөө ч үүнийг мэдэхгүй байна шүү дээ.

***Асуулт 77:*** *(Их Багш асуултыг Хятад хэлнээс орчуулав.) Та нар бас л сонсмоор байна уу? (Тийм гэв.) Ингэсэн байна. Энэ хүн хятадаар асуужээ. Хэрвээ гэгээрэл бүхэлдээ нэг ижил юм бол, яагаад Буддын шашинд тийм олон урсгал, тийм олон төрлийн бясалгалын арга байдаг юм бэ? Зарим нь цагаан хоолтон бол гэдэг, зарим нууц сургаалынхан, лам нар мах идэж байна, яагаад бясалгалын ийм олон арга байдаг юм бэ?*

**Багш:** Би ингэж л хариулах байна. Гэгээрэл, бас түүнд хүрэх арга нь ганц л байдаг. Тухайн Их Багш өөд болсны дараа бүх юм хөл толгойгоо алдаж, өөрчлөгддөг. Жишээлэхэд, Будда бодь модны дор суун бясалгаад дотооддоо Оддыг үзсэн, дотооддоо Гэрлийг үзсэн, ингэж Тэр гэгээрэлд хүрсэн. Будда ямар нэгэн зураг дүрс, барималд мөргөөгүй, ямар нэгэн бөмбөр цохиогүй, лаа асаагаагүй, ямар ч тосон

бялуу, жигнэмэг санал болгоогүй. Нууц бүлэг, лам нарын бүлгийнхний хийдэг шиг тийм зүйлийг Тэр ер үйлдээгүй. Энэ бүх ёс жаяг, янз бүрийн арга Буддаг нирваан дүр үзүүлсний дараа л бий болсон. Хүмүүс гэгээрлийн залгамжлалыг алдсанаар зүгээр л ямар нэгэн зүйлийг зохиож эхэлжээ.

Үүний дараа Буддын шашин Түвдэд орж ирсэн. Мэдээж энэ нь тухайн үндэстний шашны өнгө төрх, тосон бялуу, янз бүрийн хөрөг дүрс, маш олон янзын дүр дүрслэл, төрөл бүрийн өнгө, далбаа гэх мэтэд тусгалаа олжээ. Эд чинь бүгдээрээ Бон шашин, энэ бол Түвдүүдийн шашин. Харин үүний дараа энэ нь Буддын шашинд нөлөөлж, нийлэн холилдсон аж. Үүн шиг л Буддын шашин Хятадад орж ирэхдээ адилхан л Даоизм болон түүний ёс жаягаас ихээр шингээн нэвтрүүлсэн, тэгээд л тэд маани уншиж, бөмбөр цохиж, лаа асаах гэхчлэн элдвийг хийдэг болжээ. Цэвэр Буддизм гэдэг нь иймэрхүү зүйлс биш. Цэвэр Буддизмд энэ мэт (их чимээтэй)-ийн ямар ч юм байхгүй.

Будда бодь модны дор сууж байхдаа чимээгүй л гэгээрсэн. Түүнд лаа, бялуу, цэцэг жимс, ямар ч гадны гэрэл, зан үйлийн хэрэгцээ гараагүй. Тийм биш гэж үү? Мөн цэвэр цагаан хоол чинь Буддын шашны хоол, учир нь Будда (гэгээрсэн Их Багш) болохыг хүсэж байвал цагаан хоол идэх ёстой гэж Будда бүх судар номдоо айлдсан байгаа. Хүн мах идээд Будда болж чадна гэж зааж буй хэн нэгэн бол чөтгөрийн сургаалыг зааж байгаа нь тэр. Будда судартаа үүнийг маш тодорхой хэлсэн. Олон олон сударт Тэр ингэж айлдсан. Тэгэхээр үүний дараа хэрвээ хэн нэгэн мах иддэг хүн өөрийгөө Буддын шашинтан гэж ярьсан хэвээр байвал, Ай да, Би үүнийг яах ч билээ дээ.

***Асуулт 78:*** *Хойд Калифорнид Түвдийн Буддистуудын барьсан нэгэн хийд байдаг юм. Их алдартай, ариун хөрстэй газар, энэ шалтгаанаар тэд уг хийдийг босгох явцдаа улам их энерги хураахын тулд мах иддэг болсон.*

**Багш:** Тэд мах иддэггүй юм уу?

***Асуулт:*** *Тэд мах иддэг. Хийдээ барьж босгоход нь энэ хэрэгтэй байсан гэсэн.*

**Багш:** Ахиухан эрч хүчтэй болохын тулд уу?

***Асуулт:*** *Тийм ээ, таван жилийн турш, миний мэдэж байгаагаар тэд гэгээрлийн зам мөрөөр явсаар байгаа. Калифорнид байдаггүй өөр нэгэн их багшаас мах идэх нь буг чөтгөрүүдийг холдуулах хүч агуулдаг гэж ярихыг би сонссон юм.*

**Багш:** Тэгвэл, Сурангама судар худлаа ярьсан болж байна уу даа. Шагжамуни Будда надад худал хэлжээ дээ. Сурангама судар бол Буддын шашны сургаал номлолын хамгийн найдвартай эх сурвалж, бас бясалгал дадлын судар гэгддэг.

Хэрэв та тэндээс унших юм бол, мах идсэн хэн ч бай Маяа[*] хаан буюу зөвхөн чөтгөрийн хааны төвшинд л хүрнэ, эсвэл түүний туслах болно гэж эрс хатуугаар заан бичсэн байгаа. Мах иддэг хүмүүс хэзээ ч Бурханы хутагт (Гэгээнтний хутагт) хүрч чадахгүй. Гэртээ хариад түүнийг унш, харин намайг бүү байцаа. Буддагийн хэлснийг би яаж ч чадахгүй.

***Асуулт:*** *Мах идсэний үйлийн үрийг Будда өөрчилж чадахгүй юу?*

**Багш:** Будда "***Юу тарина, түүнийгээ хураана.***" гэж хэлсэн. Будда өөрөө ч материаллаг хуулийг зөрчиж зүрхлээгүй. Жишээ нь, би коммунист оронд очлоо гэж бодъё, би чөлөөт орны иргэн байг л дээ, гэвч би коммунист оронд очсон бол тэдний хуулийг дуртай ч, дургүй ч дагаж мөрдөх ёстой. Магадгүй Бурханы оронд хууль цааз, муу муухай, ад зэтгэр гэж байдаггүй байх л даа, харин энд *бол* ***Юу тарина, түүнийгээ хураана***. Үйлийн үрийн хууль, учир шалтгаан ба үр дагаврын энэ хуулинд хүн бүр захирагдах ёстой.

Тийм учраас Будда бүгдэд хандаж хамаг амьтны махыг ч бүү ид, тэр байтугай таван төрлийн цэвэр махыг ч бас бүү ид хэмээн онцлон тэмдэглэсэн. Тэр үүнийг дараа нь хатуу анхааруулж хэлсэн. ***Би та нарт өнөөдрөөс эхлээд ямарваа мах идэхийг хориглож байна***. Би үүнийг хэлсэн юм биш. Будда хэлсэн. Энэ судруудыг Түвд, Вьетнам, Хятад, Япон гээд бүх хэлээр хөрвүүлсэн байгаа. Миний уншсан бүх хэлээр, бүх судар бүгд яг ижил зүйлийг тэмдэглэсэн байдаг. Тэгэхээр би эдгээрийг яах билээ дээ? Та тэднийг гэгээрсэн гэж бодож байж болох юм, тэд өөрсдийгөө гэгээрсэн гэж итгэдэг байж болох юм. Харин Сурангама сударт заасныг уншаад үзвэл та тэдний хүрсэн гэгээрлийн дэсийг мэдэж болно. Тэд гэгээрсэн, гэхдээ тийм ч их өндөр төвшинд биш.

Учир нь иймюм л даа, амьтдын энерги биднийхээс хүнд байдаг, үйлийн үр нь илүү хүнд. Тиймээс л тэд амьтны төрөл авсан. Хэрэв бид тийм соронзон талбайг өөрийнхөө соронзон талбай руу оруулвал тэгээд л амьтны соронзон талбайтай улам холилдох болно. Ингэхээр бид мэдээж илүү өндөр дээд болж чадахгүй. Хичнээн учир зүйтэй байгааг хараач? Уучлаарай, бүр их гэгээрснийхээ дараа та гэгээрсэн нь хэн бэ гэдгийг харна. Жирийн байр сууринаас үүнийг ялгаж танихад хэцүү. Харин диваажингийн мэлмий тань нээгдсэн үед мах иддэг хэрнээ гэгээрсэн гэгддэг тэр хүмүүсийн соронзон талбай, гэрлэн бие нь хар, бор, кофений толбо холилдсон, тод бус өнгөтэй болохыг харах болно. Үзэсгэлэнтэй сайхан биш, гэрэлгүй байдаг. Харанхуй байдаг. Тэгж л та мэдэх болно. Уучлаарай. Ийм л байна.

[*] **МАЯА** (**МАЙЯ**) - самгарьд: ***Эсэрва тэнгэр (самгарьд:Brahta)-ийн хүч чадал (Хуурмаг дүр төрх, юм үзэгдлийг бүтээгч хүч чадал). Ид шид. Хуурмаг үзэгдэл. Зэрэглээ. Униар манан. Хууран мэхлэлт.*** Эсэрва тэнгэр нь Майяагийн тусламжтайгаар ертөнцийг өөрөөсөө бүтээдэг. Майя өөрөө хуурмаг юм үзэгдэл үүсгэн бүтээдэггүй, тэрээр нэг бол ертөнцийн тухай мэдээллийн нэг хэсгийг нуун дарагдуулж, юм үзэгдлийг хөшиглөн хааж, нөмрөг (аварана)-өөр бүрхдэг, эсвэл мэдээллийг сарниулж, юм үзэгдлийн нэг хэсгийг үл үзэгдүүлж, арилган (викшепа) алга болгодог. Ингэхлээр ертөнц хуурмагаар хуваагдаж, үй олон, аюул түгшүүртэй мэт харагддаг ажээ.

***Асуулт 79:*** *Гэгэээрэхүйн эсрэг талын хүч бий юу? Хамгийн эцсийн үр дүнд ямар зорилго байна вэ?*

**Багш:** Гэгээрэхийн эсрэг талын хүч нь үл гэгээрэхүй юм. Харанхуй мунхагийн хүч юм. Энэ бол тотгорлогч хүч. Энэ хүч бидэнд олон талаар саад болж, мунхаг болгодог бөгөөд биднийг Ариун Орон, Хамгийн Дээд Оронд очиж чадахааргүй болгодог. Хамгийн эцсийн үр дүнд хүрэх зорилго гэвэл та гэтлэгдэнэ, та үхэл амьдралаас айхгүй болно, орчлон ертөнцийн бүх юмыг мэддэг болно. Гэгээрлийн эцсийн үр дүн гэвэл энэ юм. Та хамаг амьтныг аварч чадна.

***Асуулт 80*****:** *Аливаа зүйлд орших эсрэг талын хүч ямар зорилготой вэ?*

**Багш:** Сөрөг хүч ямар зорилготой вэ, энэ хоёрын тэмцлээс эцэстээ ямар үр дүн гаргах вэ гэж та асууж байна уу? Энэ нь биднийг хүчирхэг болгоход орщдог. Яг л бид усгүйгээр сэлж сурахгүйтэй адил. Төвөгтэй хурдны зам, засмал зам, жолооны дүрэмгүйгээр та нийгмийн хэв журмыг сахиж, сайн жолоодож сурахгүй. Тэгэхээр, сөрөг хүчнээс гарч буй тэр бүх урхи бол бид түүнийг даван гарахад зориулагдсан юм, бид тэдгээрийг эсэргүүцэж, улам хүчирхэг болж, илүү сэтгэлийн тэнхээтэй, илүү хүчтэй болох ёстой юм. Ийм л юм.

***Асуулт 81:*** *Их Багш болчихлоор нэг юмыг нөгөөд хувиргах гэх мэт ид шидийн хүчүүдтэй болдог гэж үнэн үү?*

**Багш:** Хүн бүхэн ид шидийн хүчинд дуртай. Нэг зүйлийг өөр болгон хувиргах нь даанч өчүүхэн илбэ. Тийм ээ. Хүүхдийн илбэ гэдэг нь эргэлзээгүй. Та тийм зүйлийг сурмаар байна уу? Ямар ч илбэчин ингэж чадна, үүний төлөө аугаа Их Багш болох шаардлагагүй. Гэхдээ шаардлагатай бол Их Багш ч гэсэн ингэж чадна, харин таныг зугаацуулахын төлөө бол тэгэхгүй!

***Асуулт 82:*** *Дараа төрөл гэж үнэхээр байна уу?*

**Багш:** Байдаг гэж би хэлдэг шүү дээ. Бясалгах юм бол харж чадна, та урьд болон ирээдүйн төрлөө харж чадна. Харин Арьяабалын аргаар бясалгавал бид дараах төрлөө харахгүй, учир нь бид ахин хүн болж төрөх албагүй. Бид Оройн дээд Бурханы оронд очно. Бид Бурхантай хамт амьдрахаар явна.

***Асуулт 83:*** *Их сайхан харагддаг, ариун явдалт хүмүүс яагаад гай гамшиг, хүнд хэцүү нөхцөлд өртсөөр байдаг юм бэ?*

**Багш:** Магадгүй урьд төрөлдөө тийм ч ариун сайн явдлаар амьдраагүй байх. Энэ нь урьд төрлийн зарим үйлийн үр байж болно. Эсвэл харанхуйд, хэн ч харахгүй гэж бодоод ямар нэгэн муу юм хийдэг байх. Бид мэдэхгүй шүү дээ, харин Бурхан мэднэ, Будда нар мэднэ. Бас зарим их муу үйл хийдэг юм шиг хүмүүс урьд төрөлдөө хийсэн сайн үйл, буян, сайн явдлынхаа үрээр энэ төрөлдөө маш их буянтай, жаргалтай амьдрах нь бий.

***Асуулт 84:*** *Энгийн хар хүн чигээрээ бясалгаад байвал дараа төрөлдөө арай дээр амьдрах уу?*

**Багш:** Магадгүй, үгүй ч байж мэднэ, учир нь ирээдүйд бидэнд зориулагдан хуримтлагдсан юу байгааг бид мэдэхгүй, хуримтлагдсан үйл үрийг арилгахгүй бол үүнийг мэдэхгүй. Яагаад гэвэл бидний амьдрал энэ насны төдийгүй, урьд төрлийн үйл үрээс бүрэлддэг. Тиймээс тэдгээрийг бүгдийг нь цэвэрлэхгүй бол бид дараа төрлөө ямар байхыг мэдэхгүй. Иймээс Арьяабалын аргаар бясалгаж, Буддатай, Бурхантай хамт шууд гэртээ харь, тэгвэл бид юунд ч санаа зовох  хэрэггүй болно. Бид жинхэнэ дэлхийд амьдрахаар явна.

***Асуулт 85:*** *Хүүхэд-чанар, оюун ухаан, дотоодод орших илүү дээд Бурхан чанар гэсэн энэ гурван төвшинг нэгтгэх хамгийн сайн ямар арга байна вэ?*

**Багш:** Арьяабалын аргаар бясалгах нь өөрийгөө нэгтгэж, өөрийгөө эвлүүлэх, бүрэн бүтэн болгох хамгийн сайн арга.

***Асуулт 86:*** *Би амьдралдаа их олон удаа аялж үзсэн, гэхдээ байгальд гарч маш хол, хүнд хэцүү замтай газраар аялах болгонд надад бараг өөрийнхөө дотор аялж байгаа юм шиг тийм асар их хүч чадал мэдрэгддэг. Энэ ямар учиртай юм бэ?*

**Багш:** Та ямар нэгэн шинэ юм үзэж мэдэрлээ гэсэн үг. Энэ бол таны өөрийн чинь дотоод хүч, энэ бас л сайн. Гэхдээ болгоомжтой бай, танд их багш буй бол түүнээс хаана, хэр хол байгаагаа асуусан нь илүү дээр.

***Асуулт 87:*** *Би чулуу бас толь цуглуулах хоббитой. Энэ нь гэгээрэлд хүрэх олон арга замын нэг мөн үү?*

**Багш:** Үгүй ээ, Та  чулуу л болно. Та юунд дуртай вэ, түүн шигээ л байна. Та юу иднэ, түүн шигээ л байна. Та юу бодно, тийм л байна. Тийм учраас гэрийн тэжээвэр амьтан асардаг олон хүн тэр амьтантайгаа адилхан байдаг. Та тэгж бодохгүй байна уу? Нохой эзэнтэйгэээ адилхан харагддаг (Багш Инээв). Тэгэхлээр болгоомжтой бай !

***Асуулт 88:*** *Дэлхий маань түргэн болдог гоймон, түргэн босдог байшин гэх мэт зүйлээр  дүүрлээ, гэтэл одоо бас түргэхэн өөрийгөө-баярлуулчих түргэн гэгээрэл гээд гараад ирлээ. Энэ хурдхан-засчих арга чинь бидний тэвчээргүй зангийн тусгал биш үү, мөн иймдээ ч бид Бурханы тэр сүр жавхлантай, үл баригдам зам мөрийг жинхэнээр нь ухаарч мэдэх чадваргүй байдаг юм биш үү?*

**Багш:** Гэнэт гэгээрэх энэ арга чинь эрт дээр үеийн арга. Хятадад үүнийг гэнэтийн гэгээрэл гэж нэрлэдэг байсан юм. “Dueen Wu Fa Men” гэдэг. Энэ бол гэнэтийн гэгээрэл, агшин зуурын буюу түргэн гэгээрэл гэсэн утгатай. Энэ чинь ялгаагүй зүйл. Аль дээр үед ч  бидэнд энэ арга байсан. Будда үүнийг гэнэтийн гэгээрэл гэдэг байсан юм. Гэгээрэлд хүрэх хоёр арга байна, хурдан арга зам, удаан арга  зам. Бидний “Chien Wu” болон “Dueen Wu” гээд буй энэ арга бол алгуур зам болон хурдан түргэн зам гэсэн утгатай. Тэгэхээр энэ арга манай соёл иргэншлийн жишиг хэв

загварын тусгал бус, харин үтэр түргэн гэтлэгдэх эртний арга юм. Хэдий тийм ч, та цөхрөхгүй үргэлжлүүлэх ёстой. Та өдөр бүр бясалгах ёстой. Би танд үтэр түргэн гэгээрчихээд гэртээ харьж, өдөр бүр зурагтаа үз гэж хэлээгүй. Тийм биш, та шаргуу хөдөлмөрлөх ёстой. Би ч өдөр бүр бясалгасаар байдаг, Будда өдөр бүр бясалгасан. Энэ бол түргэн-засах бус, харин гэгээрлийн түргэн гялбаа юм. Энэ бол үүнийг усалж, тордон тэжээх удаан хугацааны үйл явц. Тэгэхээр энэ нь залхуурах зам мөр биш.

***Асуулт 89:*** *Та яагаад үсээ хусаж, хувраг шиг хувцасласан юм бэ? Ингэх ямар зорилго байна?*

**Багш:** Аа, би лам болохоор л ингэсэн юм.

***Асуулт 90:*** *Шар хувцас өмсөж, эргэн тойрондоо ийм их шар өнгө бүрдүүлэх ямар учиртай вэ?*

**Багш:** За яахав. Маргааш би ногооныг өмсөөд ирье. Тэгэх үү? Энэ чинь ердөө л уламжлал. Буддын болон Хиндү шашны хуврагууд шар өмсгөл хэрэглэдэг. Тэгдэггүй гэж үү, энэ нь гэгээрэл гэсэн утгатай, ийм учраас л гэгээрлийн бэлгэ тэмдэг болгож хуврагууд шар хувцас өмсдөг. Ийм л юм. Харин би тоохгүй, янз янзын өнгөтэй хувцас өмсдөг, энэ бүхнийг ойшоодоггүй. Учир нь би энэ хувцсыг бөөний худалдааны дэлгүүрээс авсан юм, тэд үүнийг ширхэглэж биш, харин нэг килограммыг нь таван центээр зардаг. Тиймээс л олон өнгө байгаа хэрэг, би бүгдийг нь хольж янзалж байгаад ингээд л өмсчихдөг юм. Дажгүй харагдаж байгаа биз дээ. Үгүй байна уу? Их хямдхан. Би заримдаа ногоон, цагаан гээд аль тааралдсан өнгөөрөө, хямдхан даавуунуудаар хувцаслачихдаг. Өөрөө оёж, загварыг нь зохиодог болохоор их хямд төсөр, биед эвтэйхэн, бас сэрүүхэн байдаг.

***Асуулт 91:*** *Та яаж гэгээрсэн бэ?*

**Багш:** Энэ аргаар л гэгээрсэн. (Арьяабалын бясалгалын аргаар) Гэгээрлийг чин сэтгэлээсээ хүсэмжилснийхээ үрээр гэгээрсэн.

***Асуулт 92:*** *Та энэ биеэ орхисны дараа хаана байх вэ?*

**Багш:** Би хаана байсан тэндээ л байх болно, хаанаас ирсэн тэр газар луугаа л очно.

***Асуулт 93:*** *Самадид орохын тулд бодлоо зогсоох хамгийн сайн арга юу вэ?*

**Багш:** Арьяабалын бясалгалын арга

***Асуулт 94:*** *Бодлоо хэр удаан зогсоож болох вэ?*

**Багш:** Самадид орох л юм бол, та бодлоо зогсоож чадна.

***Асуулт 95:*** *Хэрэв амьдрал мөнх, хэзээ ч төгсдөггүй, сүнс бас мөнх оршдог, хэзээ ч устаж үгүй болдоггүй юм бол амь таслах, эсвэл амьд явахаас татгалзах нь яагаад буруу гэж?*

**Багш:** Жам ёсны бус учраас буруу. Жишээлбэл, таны нас жар байх ёстой байтал та үүнийг дөчин тав болгох гэж хүчилж байна. Ингэхээр та Бурханы таалал болон эрхийг ээзэрхийлэн авч байна гэсэн үг. Тиймээс энэ буруу. Жам ёсоороо болоогүй бүхэн хүчирхийлэл. Тэгэхлээр амьд явахаас татгалзана гэдэг бас л буруу, учир нь та хулчийж байна. Муу үйл хийчихээд, түүнийхээ үрийг амсахыг хүсэхгүй байна шүү дээ. Үйлийн үрийн төлөөс хүрээд ирэхэд та түүнийг хүлээж авалгүй, өөр бусдад зовлонгоо үүрүүлэх гэж хүсэж байна. Энэ нь та хүнээс мөнгө зээлчихээд мөнгөтэй хэрнээ буцааж төлөхийг хүсэхгүй байгаатай адилхан. Мэдээж энэ чинь буруу. Энэ буруу.

***Асуулт 96:** Та гэрлэчихээд, гэгээрсэн хүний бэлгийн амьдрал ямар байдгийг бидэнд ярьж өгч яагаад болохгүй гэж? Гэгээрсэн хүнд зугаа цэнгэл, хурьцлын их жаргал бий юу?*

**Багш:** Их жаргал цэнгэл гэнэ ээ? Тэр чинь юу ч биш. Зугаа цэнгэлийн мэдрэмж өөрөө их сул, маш хямдхан, их зүдэргээтэй зүйл. Хэрэв та гэгээрч, илүү аугаа баяр цэнгэлийг амсаад үүнтэй харьцуулж үзэх юм бол хурьцал хийхийн баяр цэнгэл яг л хог шиг болохыг олж мэднэ. Тэр мөчид та өдий хүртэл ийм хямдхан орлуулагчаар хэрхэн зугаацаж, ташуурч байснаа төсөөлөхөд хэцүү болно. Яагаад хүн бэлгийн харилцааны жаргалд ташуурдаг юм бэ? Учир нь бид тэрнээс хамаагүй илүү жаргал цэнгэлийг амталж үзээгүй болохоор л тэр. Хэрэв өчнөөн илүү жаргал цэнгэл байдгийг мэдчихвэл бид бэлгийн харилцааг орхино. Тэр талаар бодох ч үгүй.

Энэ нь нялх хүүхэд сүү уухдаа хөхөлт угжаа хаядагтай адил. Үүнтэй яг ижил. Маш их өлсөхөөрөө, хөхөлт биш эхийхээ хөхийг л хүснэ биз дээ, тэр жинхэнэ нь гэж мэдэж байгаа шүү дээ. Хөхөлтөө шидчихнэ. Эсвэл өсөж том болоод хуванцар машинаар тоглохыг хүсэхээ больж, жинхэнэ Мерседес машин жолоодохыг мөрөөднө. Энэ нь бид амьдралд байдаг илүү өндөр үнэ цэнийг ойлгож мэдсэн хэрэг. Төгс гэгээрэлд хүрэхээрээ хурьцал бол хог гэдгийг мэднэ. Гэвч та гэгээрээгүй байгаа болохоор үүнээс алгуур холдож цээрлэж болох юм. Өөрийгөө тийм түргэн хорих шаардлагагүй. Гэвч диваажингийн жаргал цэнгэлийн хажууд бол хурьцлын жаргал юу ч биш.

***Асуулт 97:** “**Би бол Зам мөр, Үнэн, Гэрэл. Надгүйгээр хэн ч Эцэгт хүрч чадахгүй**” гэж Есүс хэлсэн. Будда ингэхэд Христтэй –тэрслэгч үү, эсвэл Есүсийн өөр нэгэн дүр үү? Будда өөрийгөө Христ шиг л Бурханы хүү гэж зарлаж байсан уу? Авралд багтахын тулд хүн дахин төрөх ёстой гэж Христ хэлж байсан. Энэ тал дээр Будда юу гэж хэлсэн бэ?*

**Багш:** Христийн хэлсэн зөв. Хэдийд л Их Багш, амьд Их Багш байна, та түүнийг дага, тэгвэл Эцэгтээ очиж чадна. Тэр Их Багшгүйгээр та Эцэгтээ очиж чадахгүй. Энэ бол амьд Христ байж байхын зайлшгүй хэрэгцээ шаардлага юм. Тийм учраас л Христ ***Энэ дэлхий дээр байгаа цагтаа Би энэ дэлхийн Гэрэл нь*** гэж хэлсэн юм. Тэр би үүрд мөнх байна гэж хэлээгүй. Тэр биднийг үүнийг буруу ойлгочих вий хэмээн эмээсэн учраас, ***“Би энэ дэлхий дээр байгаа цагт, энэ дэлхийн гэрэл нь Би***

***байх болно. Өөрийнхөө дараа би та нар луу өөр тайтгаруулагчийг илгээнэ, надаас өмнө, тэр тэр байсан....*”** гэхчлэн хэлсэн.

Тэгэхээр Будда Христтэй тэрслэгч байгаагүй. Христ бол Будда, учир нь Будда, Христ хоёр адилхан зүйлийг зааж сургадаг. Тэвчээртэй байвал бид ойлгоно. Будда өөрийгөө Бурханы хүү гэж хэлээгүй, гэхдээ тэр, “Би Татагата” умайгаас мэндэлсэн гэж хэлсэн. “Татагата” гэдэг нь ухамсрын тэнгис, хамаг ухамсрын өлгий (умай) гэсэн утгатай. Энэ нь Бурханлаг ухамсар гэсэн үг. Христ Бурханаас ирсэн, эсвэл Бурханы хүүхэд байсан байхад Будда “Татагата”-гаас иржээ, энэ бүхэн адилхан утгатай.

Авргадахын тулд хүн дахин төрөх ёстой гэж үнэн хэлсэн. Энэ үнэн. Энэ үнэн. Хэсэг хугацааны дараа та дахин төрнө, авшиг хүртсэний дараа та нэгэн төрлийн үхлийг үзэж туулаад амьдралд буцан ирдэг. Дахин төрөх гэж бидний нэрлээд байдаг зүйл энэ. Хамгийн сүүлд намайг авшиг хүртээхэд хэдэн хүн үхэл, амьдралын хилийг харсан байсан, бидний олонтоо яриад байдаг тэр хонгилыг би хэлж байна. Зарим хүн үхлийн дараа тэр хонгилыг үзэж, түүгээр өнгөрөн Гэрэл хардаг. Авшиг хүртэх үед та ч мөн үүнийг үзэж магадгүй, эсвэл зарим чинь үзэх байх. Энэ бол үхэх буюу дахин төрөх үйл явц юм. Авшиг гээд байгаа тэр зүйл бол энэ.

***Асуулт 98:*** *Нэгэнт Бурхан бүгдийг бүтээсэн юм чинь чөтгөр ч бас Бурханы хүү гэж хэлж болох уу?*

**Багш:** Тэр мөн, гэхдээ муу хүү. Муу болохоор нь Бурхан түүнд диваажингаас яв гэж хэлсэн юм. Гэхдээ хийсэн нүгэлдээ гэмшихээрээ, хэсэг хугацааны дараа тэр дахин буцаж ирнэ.

***Асуулт 99:*** *Хайраас айдаг, зүрх сэтгэл нь хаалттай хүн авшиг хүртэж болох уу?*

**Багш:** Болно болно. Тэгвэл зүрх сэтгэл чинь нээгдэж, та ахин хайраас айхаа ч болино. Та үүнийг туршаад үзэх ёстой.

***Асуулт 100:*** *Ургамал идэхэд амьтны махтай адилаар хэлбэлзлэл нь бидэнд яагаад нөлөөлдөггүй юм бэ?*

**Багш:** Сайхан асуулт байна. Учир нь ургамлын хэлбэлзлэл амьтных шиг доош татах биш харин ч биднийг тэжээн тэтгэдэг юм. Ойлгож байна уу, бас ургамлын хэлбэлзэл тийм ч хүчтэй биш, доошоо чангаах зүйлгүй байхад амьтад хүчтэй ухамсартай. Тиймээс үзэн ядах сэтгэлтэйгээр үхэх үед нь энэ хэлбэлзлэл, эсвэл уур амьсгал нь тэр газраа үлдэж хоцордог. Энэ үзэн ядалтаас бий болсон хор нь бүр маханд нь хүртэл шингэчихсэн байдаг. Харин ургамлын ухамсар их дорд, тэдэнд тийм хүчтэй мэдрэмж, эсвэл хүсэл шунал байдаггүй. Иймээс ургамал бидэнд тэгж их нөлөөлж чаддаггүй.

***Асуулт 101:*** *Авшиг хэр удаан үргэлжилдэг вэ? Таны өгөөмөр сэтгэлд талархъя.*

**Багш:** Цөөхөн... заримдаа гурав, дөрвөн цаг, заримдаа долоон цаг үргэлжилдэг. Аугаа авшиг бүтэн өдөр ч болно. Тийм нь маш сайн. Харин та их түргэн хөдөлж байна. Та өнөөдөр авшиг авмаар байгаа юм байна. Тиймээс би үүнийг төвлөрөлтэй, хурдан хийхийг хичээе. Бүтэн өдөр үргэлжлэх нь илүү сайн байдаг. Тэгвэл би маш их юмыг тайлбарлан өгч, таны дотоод эргэлзээг тайлж, тээнэгэлзсэн асуултанд чинь хариулж чадна.

***Асуулт 102:*** *Бурхантай холбогдож чаддаг хэвээрээ байхын зэрэгцээ бие махбодын болон оюун ухааны зугаа цэнгэлийг эдэлж болох хамгийн бага төвшин байна уу?*

**Багш:** Та урьдных шигээ үргэлжлүүлж болно. Дотоодын Гэрэл болон Хэлбэлзлэлийн аргаар бясалгаад эхлэхээр аяндаа энэ багасгасны чинь үр нөлөө танд харагдаад эхлэнэ. Тэгэхлээр өөрийгөө хэтэрхий их хянаж, бухимдуулж, түгшээх хэрэг байхгүй. Бясалгаад байвал аяндаа өөрөө багасна. Таны хийх ганц юм бол ердөө л ургамал ногооны хоол идэх, ёс суртахуунтай амьдрах явдал, харин бусад нь аажмаар өөрчлөгдөнө. Өөрийгөө дэндүү дарамтлах гэх хэрэг юу байна. Сэтгэлээ ч бас хэт их дарж болохгүй. Тэгвэл тэр чинь эсэргүүцэл зарлаад танд бэрхшээл үүсгэнэ. Танд маш их баярлалаа!

# Багшийн лекцийн асуулт, хариулт
## АНУ, Калифорни муж, Сан Хосе, Эвэргрийн Олон нийтийн төв
## 1989 оны 5 дугаар сарын 28

***Асуулт 103:*** *Та мах иддэг өөр нэг урсгалын хүнийг бас дутуу хэсэгчлэн гэгээрсэн гэж Та Бямба гарагт дурдаж байсан, ердөө бага сагахан гэгээрсэн гэсэн үг л дээ. Энэ чинь Барууны хүмүүст мах гэхгүйгээр аажимдаа гэгээрэх арга зам болох юм биш үү?*

**Багш:** Та наймаалцах гээ юу даа. Тэгвэл, та тийшээ явж болно. Тийм ээ, тийшээ очоод хэрэв танд олдохоор байвал дутуухан гэгээр л дээ. Бүр хэсэгчлэн гэгээрэхэд ч хэсэгчлэн гэгээрсэн их багшийг олох шаардлага гарна, гэтэл энэ нь харин ч бүр маш ховор (Инээв). Учир нь мах идэж дарс уун хорвоогийн зугаа цэнгэлд толгойгоо алдсан хүмүүс үүнийгээ орхиж бараг л чадахгүй, хэрвээ эдгээрийг орхиж чадахгүй бол та Бурханы оронд очиж чадахгүй. Бурхан сарниж хуваагдаагүй анхаарлыг шаарддаг. Тэрбээр ***Би хартай Бурхан. Хэрвээ та аливаа бусад зүйлийг надаас дээгүүр үзэж шүтвэл, энэ нь болохгүй зүйл!*** гэж хэлсэн. Хэрэв бид мах, хүүхэн, бусад зүйлийг Бурханаас дээгүүр үзэж шүтвэл Бурхан ганцааранг маань үлдээнэ. Бурхан биднээс зөвхөн өөрийг нь л хүсэхийг хүсдэг. Гэхдээ би та нарыг бүгдийг чинь лам бол гэж хэлж байгаа юм биш. Та ядаж л тэгэх албагүй. Эхнэр, нөхөртэй хэвээрээ байж болно. Зүгээр л арай эгэл ариун амьдарч, бэлгийн амьдралаа хянаж, садар самуун явахгүй бай. Ингэх амархан.

Харин одоо махан хоолны талаар яръя. Та өөрөө л махыг орхихгүй бол мах таныг орхино гэж байхгүй. ***Ходоодонд орсон мах, мах идсэн ходоодыг Бурхан хоёуланг нь устгана***. Библид ингэж өгүүлсэн байдгийг та санаж байна уу? Тийм ээ. Намайг зөвхөн Буддын сургаалыг л яриад байна гэж бүү хэлээрэй. Та нарын Библи дээр ингэж хэлсэн байгаа, яг адил зүйлийг хэлжээ. Будда бас бүх буддист бясалгагч нарт мах идэхийг хорьсон. Хэрэв та хэсэгчлэн гэгээрмээр байгаа бол тийм ээ, би ч танд зааж өгч болох л доо, эсвэл та тэр хэсэгчлэн гэгээрсэн их багшаа хайж олж болно. Гэхдээ энэ хэцүү. Тийм ээ? Тэгтэл хэрвээ би танд ийм арга байдлаар заачихвал, надад энэ нь хариуцлагагүй л санагдана.

Яагаад хариуцлагагүй санагдана гэж? Учир нь би таныг замын талд орхичихсон мэт санагдах болно. Хэрвээ та их багшгүйгээр, мах идээд гэртээ

бясалгавал танд хэцүү асуудал олонтаа тулгарна. Та махаа орхиж чадахгүй байгаа болохоор би тэр хүнд хэцүү байдлаас гарахад чинь бүрэн тусалж чадахгүй. Таныг өндөр дээд ухамсрын төвшин рүү ахих үед мах маш их самуурал үүсгэнэ; зөрчил тэмцэл үүсгэнэ. Та ухамсрын өндөр төвшинд хүрмээргүй байгаа бол хамаагүй. Гэхдээ бид энэ тухай бүр яаж бодож чаддаг юм? Аан, аймшигтай юм аа! Мах идэхэд сайн юм юу байна вэ? Надад хэлээч. Аан? Энэ нь танд маш их цус гэж санагддаггүй гэж үү? Бодоод үз дээ. "Веган хооллолтын ач тус" –ын тухай номыг минь уншаарай, тэгээд дахин бодож үз. Магадгүй дараа жил, эсвэл хойд насанд чинь би эргэж ирээд хоёул энэ талаар хэлэлцэж магадгүй л юм (Инээв).

***Асуулт 104:*** *Есүс ном дэлгэрүүлэгч нартаа мах идэхэд зүгээр гэж хэлсэн, Бурханы бүтээсэн бүх юм сайн, амаараа бие рүүгээ юу хийх чинь огт хамаагүй, харин сүнс рүүгээ юу хийх чинь л хамаатай гэж хэлсэн. Тэгвэл яагаад гэгээрэхийн тулд цагаан хоолтон байх шаардлагатай байдаг юм бэ?*

**Багш:** Утгагүй юм.

***Асуулт*** *Ногоо идэх нь зан үйл шиг юм биш үү?*

**Багш:** Үгүй ээ. Есүс хүүхэд байхаасаа ургамал хоолтон байсан. Тэр Ессэни хэмээх гэр бүлд төрсөн. Яг л Хинду шашны ариун явдалт гэр бүлд төрсөн хүүхэд байхаасаа цагаан хоолтон болдогтой адил. Мөн жинхэнэ Сикх* гэр бүлд төрсөн бол бас л бүр багаасаа цагаан хоол иддэгтэй ижил. Бас жинхэнэ Буддын шашинтай гэр бүлд төрвөл та хүүхэд байхаасаа цагаан хоол иддэгтэй энэ нь ижил.

Ариун сударт Есүс ***Та мах идэж болохгүй*** гэжээ. Библи сударт хүртэл Бурхан хэлсэн байна. Юу билээ? Санаж байна уу? ***Хэн та нарыг энэ эр үхэр, эм ямааг алаад надад тахил өргө гэсэн юм бэ? Намайг залбирлыг чинь сонсоосой гэж байгаа бол гэмгүй амьтдын цуснаас өөрийгөө цэвэрлэ, тэгэхгүй бол би та нараас нүүр буруулна, яагаад гэвэл та нарын гар нэл цус болсон байна!*** гэж хэлсэн. Бурханд тахил өргөхийн тулд ямаа, ухна хороохыг Тэр бидэнд зөвшөөрөөгүй байтлаа тэднийг идэхийг бидэнд яаж зөвшөөрнө гэж? Тэд бол гэмгүй амьтад, ***Гэм нүглээ наманчил, тэгвэл Би таныг өршөөнө*** гэж Тэр хэлсэн. Тэр Библид ингэж хэлээгүй гэж үү? Та энэ хэсгийг уншсан уу? Үгүй юу? Буцаж очоод Библийг унш. Өө, би таны өмнөөс ичиж байна (Инээв). Та нар зөвхөн уншихыг хүссэн хэсгээ л уншдаг! (Инээв) Тэгээд л бүгдийг нь гуйвуулчихдаг.

Буддын шашинтнууд ч адил. Буддистуудын библид ямар ч амьтны махыг огт идэж болохгүй гэж олон газар, дахин дахин дурдсан байгаа. Тийм байтал ихэнх Буддистууд "Би Буддын шашинтай" гэж хэлдэг атлаа бас мах идээд байдаг, лам нар нь хүртэл. Ийм байхад бид юу хэлэх юм бэ? Тиймээс та юуг хайр энэрлийн зам гэж боддог вэ, түүнийгээ дага. Бурханыг юу таатай байдаг гэж бодно, тэрийгээ дага. Бурхан бүтээдэг. Тэр алж хороодоггүй. Бүх юм өөрийн жам ёсоор үхэж үрэгддэг.

*Сикх – Сикхизмын шашны дагалдагч. Энэ нь самгарьд хэлний шишья – шавь, сурагч гэдэг үгээс үүдэлтэй.

Тэгэхлээр, бид амьтны амийг гэнэт хүчээр эцэслэх юм бол энэ нь бид Бурханаас эрхийг нь булааж байгаа хэрэг болно.

Зөвхөн Бурханд л алж хороох эрх бий. Бид юуг ч бүтээх чадалгүй байж яаж алж болдог юм бэ? Биднийг мах идэх хэрэгтэй гэж Есүс хэлээгүй. Есүс, ***"Идэх өмсөхийн араас тэгтлээ бүү санаа зов. Бурхан чамайг халамжилна. Бурхан чамайг харгалзана."*** гэж хэлсэн. Тэр энэ санааг л хэлсэн. Миний шавь нар материаллаг тав тухын төлөө тэгтлээ их санаа зовох ёсгүй, харин Бурханд дуулгавартай бай, Бурхан тэднийг зохицуулна гэсэн санааг Тэр хэлсэн байна.

Тиймээс ***Эхлээд Бурханы Хаант улсыг эрж хай, бусад бүх зүйл танд нэмж өгөгдөнө"*** гэж бас хэлжээ. Тэр чинь энэ. Есүс биднийг мах ид гэж хэзээ ч хэлж байгаагүй. Тэр хүүхэд байхаасаа л цагаан хоол идсэн. Түүнээс гадна Тэр Энэтхэгт очиж, олон жил байсан тухай судалгаа байдаг. Тэр Энэтхэгт байхдаа Хиндүчүүд, Энэтхэгийн Йогчид, Буддын лам нартай хамт сурч байсан, тэр хүмүүс бүгдээрээ төрөлхийн цагаан хоолтон байсан. Та нар мэдэх ёстой! Хэдий Есүс мах иддэг байсан байлаа ч энэ хүмүүсийг арав гаран жил дагасны дараа буцаад мах иднэ гэж хэзээ ч байхгүй. Уучлаарай, та үүнийг буруу тооцоолсон байна. Бас та маш бага уншсан байна, энэ чинь асуудал. Та зөвхөн махны тухай мөрүүдийг сонгож уншаад, цагаан хоолны тухайг нь мартжээ. (Инээв)

***Асуулт 105:*** *Есүс, бидэнд нэг Тайвшруулагч, Ариун сүнсийг явуулна гэж хэлсэн. Тэр бидэнд олон Тайвшруулагч хүнийг илгээнэ гэж хэлээгүй. (Их Багш: "тэр нэгийг л гэж хэлээгүй.") Тэгвэл яагаад Будда болон бусад Их Багшийг Есүсийн илгээсэн Христ буюу Тайтгаруулагчид гэж хэлдэг вэ?*

**Багш:** Үгүй. Есүс Буддагаас хожим төрсөн. Тэгэхээр хэн илгээгдсэн тухай бид ярих юм бол Будда Есүсийг илгээсэн гэж хэлэх юм байна. (Бүгд инээв) Есүс Буддагаас залуу. Уучлаарай, та үнэхээр эндүүрчээ.

Ямартаа ч, тэд бүгд ялгаагүй. Энэ тал дээр бүү марга. Бурхан зөвхөн Есүс ч биш, олон тайтгаруулагч илгээсэн. Есүсээс өмнө Илия* (Elijah) гэж байсан, Баптист Жон бас байсан, олон гэгээнтэн байсан. Тиймээс нэгэн хүн Есүсээс түүнийг Илия гэх мэт урьдны их багш нарын хойд дүр мөн эсэхийг нь асуухад Тэр үгүйсгэсэн үг хэлж байгаагүй. Тэр чимээгүй байснаараа хүлээн зөвшөөрсөн.

Тэгэхлээр, Есүсээс өмнө Их Багш нар байжээ, мөн Есүсийн дараа ч их багш нар байх болно; Буддагаас өмнө Будда нар байсан, Буддагийн дараа ч Будда нар байх болно. Бурхан Буддаг илгээсэн, Есүсийг ч илгээсэн. Есүс Буддаг илгээсэн юм биш.

---

* *Илия - (Илия, Элайжа)* – эш үзүүлэгч, бошиглогч, Яхве шүтлэгийн номлогч, иудын шашин дахь Ваал**-ыг шүтэхийг эсэргүүцэгч, Бурхан түүнийг амьдаар нь тэнгэрт дэвшүүлсэн гэдэг. **Ваал \Баал\ - (Палестин, Сири дэх бурхан; амьтад, тэр ч байтугай хүмүүсээр Баалд тахил өргөдөг; мөргөлийн үеэр тахилч нар түүний анхаарлыг татахын тулд өөрийгөө жад, эсвэл хутгаар хатгаж, хашгирах дуугаараа түүнийг дууддаг байжээ; Хуучин Гэрээнд Баалыг шүтэхтэй тэмцэх нь эш үзүүлэгч, бошиглогчдын хамгийн чухал үүрэг даалгавар гэсэн байдаг аж.)

***Асуулт 106:*** *Бүх нярай хүүхэд дахин төрсөн сүнснүүд үү?*

**Багш:** Та тэднийг юу гэж бодоо вэ? Дахин төрсөн сүнснүүд биш юм бол тэд тэгээд юу юм бэ? Дахин төрөл авсан чулуунууд юм уу? (Инээв.)

***Асуулт 107:*** *Дахин төрөл авах үйл явц яаж болдог вэ? Дахин төрөл авахыг хүсч буй сүнс эмэгтэй хүнийг хөл хүнтэй болохыг хүлээж байдаг уу?*

**Багш:** Ийм юм л даа. Тухайн сүнсний буян гүйцээд хүний жишигт хүрээд ирэхээр тэр сүнс дахин төрөл авч чадна. Хүн болж төрөхийн тулд та урьд төрөлдөө тун их буянтай амьдарсан байх ёстой, эсвэл урьд хийсэн хамаг нүглээ төлж барагдуулсан байх учиртай.

Мөн хүн төрөл авахын тулд амь хороохгүй байх, садар самуун явахгүй байх, хулгай хийж, худал ярихгүй, мөрийтэй тоглохгүй, хар тамхи хэрэглэхгүй байх зэрэг хүнд байх ёстой шинжүүдийг урьд төрөлдөө өөртөө эзэмшсэн байх учиртай. Тэгж байж л та шууд буцаж ирж чадна. Тэгж л та дахин хүн болж төрнө. Та урьд төрөлдөө энэ таван сахилыг чандалж чадалгүй ямарваа нэг гэм нүгэл хийсэн бол хүний төрөл аван төрж чадахгүй.

Хүүхэд болж төрөхийнхөө өмнө сүнс аль нэг завсрын газар амарч байдаг. Тэгээд шалтгаан нөхцөл нь бүрдэж, мөн эр, эм хоёр тухайн сүнстэй ямарваа нэг барилдлагатай байвал тэр төрөл авч чадна, ингэхээс өмнө бол чадахгүй. Бүх нөхцөл зөв зүйтэй бүрэлдсэн байх ёстой. Түүнээс биш зүгээр л хүрч ирээд хэн нэгний хүү, эсвэл нялх үр нь болчих боломжгүй. Гэр бүлийн тань бүх гишүүн учир шалтгаан, үр дагаварын хуулиар холбогдсон, олон олон төрөлдөө ингэж нөхцөлдсөн байдаг. Буддын шашинд ингэж үздэг. Надад итгэх албагүй.

***Асуулт 108:*** *Тухайн сүнс дахин төрөхийг хүссэн учраас эмэгтэй хүн жирэмсэн болдог уу?*

**Багш:** Миний түрүүн хэлснээр бүх учир шалтгаан болон нөхцөл байдал нь зөв цуглан бүрэлдсэн байх ёстой. Үүнийг юу шийддэг юм бэ? Тэр үйлийн үр буюу урьд төрлүүдийн учир шалтгаан болон нөхцөл байдал гэгдэх зүйл л шийднэ. Амьдрал, үйлийн үрийн тэр номыг бид гэгээрлийн тодорхой төвшинд очиж, тодорхой ертөнц, магадгүй Хоёрдугаар ертөнцөд хүрэхээрээ уншиж чаддаг болно. Тэнд тийм нэгэн номын сан байдаг бөгөөд бид хүн бүрийн амьдралыг бичсэн номыг авч үзэж болно, тухайн хүн хаанаас ирсэн, хэнтэй барилдлагатай, ирээдүйн амьдрал нь ямар байх зэргийг мэдэж болно.

Харин миний танд зааж өгч болох гэгээрэлд хүрэх арга, Арьяабалын бясалгалын аргаар бясалгах хүн хүсэл сонирхлоороо, эсвэл бусдад туслах зарим нэг зорилгоор дахин төрье гэж хүсэхийг эс тооцвол тэр хүн дахин төрөл авахгүй.

***Асуулт 109:*** *Та хэдэн настай вэ? (Инээв) Өдөр бүр хоёр цаг гучин минут бясалгах зайлшгүй шаардлагатай юу, яагаад?*

**Багш:** Зайлшгүй шаардлагатай. Хэдэн настайг минь та тааж чадахгүй. Та хэл дээ? (Асуулт тавьсан хүн таав.) Өө, их залуу юу? Арван наймтай юу? (Бүгд инээв.) Жаран наймтай юу? Тийм ч хөгшин биш ээ. Гучин наймтай юу? Тийм ээ, нэг тэр хавьцаа. Энэ тийм чухал биш. Энэ чинь ердөө л энэ физик биеийн нас төдий. Би энэ дэлхий шиг хөгшин, бас огт төрж байгаагүй шиг залуу.

Та хоёр цаг хагас бясалгах ёстой. Учир нь сүнсээ, бохирдсон хэсгээ аагтай хандаар угааж ариусгах нь зайлшгүй хийх ёстой зүйл. Та өдөржин ажиллаад гэртээ хир тоостой харьсан бол хоёр галлоноос (7.5 литр) багагүй ус хэрэгтэй болдог. (Инээв) Бид өдөр бүр энэ дэлхийд хутгалдан бусдаас халдвар авч, эргэн тойрны хүмүүс болон өөрийн зайлах аргагүй буруу үйлдлийнхээ нөлөөнд өртдөг. Жишээ нь, амьсгалах үедээ бид нүдэнд үл үзэгдэх маш олон амийг хөнөөж байдаг, ногоо идэхдээ ургамлын амийг тасалдаг. Эсвэл өт хорхойн дээр гишгэж, шумуул руу хор цацдаг, бас гараа угааж – халдваргүйжүүлэхдээ үл үзэгдэх олон амийг тасалдаг.

Тэгэхээр энэ хоёр цаг гучин минут бол бид сүнсээ угаах хоёр галлон ус гэсэн үг. Хэрвээ та нэг галлон хагас усаар угаачихвал бас л дажгүй, гэхдээ бүрэн цэвэрхэн болсон гэсэн үг биш. Тэгээд маргааш нь дахиад хэсэг хир буртаг нэмчихнэ, түүнийгээ ердөө ганц галлон усаар угаана. Ингэж өдөр бүр дутуу цэвэрлэсээр байгаад нэг л өдөр танаас үнэр танар гарч магад. (Инээв)

***Асуулт 110:** Ганцхан Бурханд л амь хөнөөх эрх бий гэж та дурьдсан. Та үүнийг дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч?*

**Багш:** За тийм ээ! Учир нь Бурхан бүгдийг бүтээдэг, тухайн сүнс хэзээ хувцсаа солихийг Бурхан л мэдэхээс биш бид мэдэхгүй. Энэ нь та нэг компанид ажиллаж байлаа гэхэд эзэн чинь л аль машин нь сайн, аль нь бүрэн, алийг нь сайн үнээр зарж болох, аль нь гажиг согогтой, алийг нь эвдэлбэл зохих, түүнийг дахин өөр хэлбэртэй болгох зэргийг мэддэгтэй адил юм. Та бол тэгж чадахгүй. Та өөрөө хийх гэвэл тэр машиныг бүрэн бүтэн биш байна гэж бодоод буруу хийчихнэ. Тэгээд л алдаа гаргаж байгаа юм. Эзэн чинь таныг хөөж гаргана, эсвэл ажлаас хална, үгүй бол төлбөр тулгана.

***Асуулт 111:** Сэтгэл ханамжгүй, мөн их багш юмуу замчийг мэддэг болохыг мөрөөсөж буй надад тусалж, сэтгэлийн хоосролыг минь арилгаж чадах хэн нэгнийг би яаж олж уулзах вэ? Мөн тийм хүнтэй тааралдахаас өмнө би заавал бүрмөсөн цөхөрсөн байх ёстой юу?*

**Багш:** Тэр чинь хэдийнээ тохиолдчихжээ. Та бэлэн болсон цагт Их Багш гарч ирдэг. Үргэлж тийм байдаг, үүнээс өмнө биш. Харин та итгэл сул байгаа бол гэртээ хариад "Гуйя, дагавал зохих тэр хүнд намайг итгэлтэй байлгаж өгөөч. Би хэнийг дагах вэ?" гэж Бурханд залбир. Гэхдээ би танд Их Багшийг таних аргыг хэдийнээ хэлээд өгчихсөн. Их Багш хүн өөрийнхөө амь амьжиргаанд зориулж танаас юу ч авахгүй. Тэр танд бүхнийг үнэ төлбөргүй өгнө: зөвхөн үйлчилнэ, юу ч шаардахгүй. Тэгэхээр танд бүр эхнээсээ л алдах юм юу ч байхгүй. Ямартаа ч та юунаас ч айж эмээлтгүй.

Их багшийг таних хоёр дахь шинж тэмдэг нь тэр танд Библи болоод бусад судар номд дурдсан гэгээрлийн ахуй ойлголтуудыг өгч чадна. Гэгээрсэн хүн диваажингийн Гэрэл, галын дөл үзэж, тэнгэрийн дуу мэтээр Бурханы дуу хоолойг сонсож чаддаг бол таны Их Багш наанадаж л энэ мэт үндсэн ахуй ойлголтуудыг танд өгч чаддаг байх хэрэгтэй, тэгэх ч ёстой. Тэгж л та түүнийг жинхэнэ Их Багш юм байна гэж мэднэ. Тийм биш бол та яаж таних болж байна вэ? Хүн бүр энд “би их багш” гэж бичиж чадна. Танд ямар ч мөнгө харуулахгүйгээр хүн бүр өөрийгөө саятан гэж хэлж чадна. Жинхэнэ их багш өөрөө гэгээрсэн байх ёстой төдийгүй танд гэгээрлийн ахуй ойлголтыг нэг хоёрхон минутын дотор үзүүлж чаддаг байх ёстой. Энэ бол төгс Их Багшийн шинж.

***Асуулт 112:*** *Би цагаан хоолтон, гэвч миний хань биш. Бид хоёрын хувьд хоол хийх тал дээр ямар ухаалаг сайн арга зам юу байна вэ? Бид тийм ч ёсорхог хүмүүс биш, заримдаа хоолоо тусдаа хийж, тусдаа иддэг.*

**Багш:** Та хоёр аль хэдийн тусдаа хооллодог болсон юм уу?

*Хөтлөгч*: *Заримдаа тэгдэг.*

**Багш:** Заримдаа л уу? Бусад үед та мах идчихдэг юм уу, эсвэл? Тусдаа л ид. Хоолоо тусдаа хий. Та түүнд махан хоол хийж өгөөд өөртөө ургамал веган хоол хий; тус бүр өөр өөрийнхөө хоолыг хий.

Бид хэн нэгнийг хүсээгүй, бэлэн болоогүй байхад нь ургамал хоолтон болгох гэж хүчлэх хэрэггүй. Та өөрөө ургамал хоолтон юм бол ханьтайгаа амар тайван амьдарч болно. Яагаад болохгүй гэж? Ханьдаа цагаан хоол ид гэж хэлбэл та хоёрт хоёуланд чинь л сайн. Тэр аяндаа л иддэг болно. Та сайн үлгэр жишээ болж, өсч хөгжин, сайн хэлбэлзлэлтэй байж, бясалгаж, хайр цацруулаад байвал түүнд нөлөөлнө.

***Асуулт 113:*** *Хэрэв би Тантай хамт суралцвал өмнөх багштайгаа уулзах цаггүй болох байх. Багш маань надад энэ аргыг заагаагүй ч гэсэн номлогч шиг л зарим ариун сайхан зүйлийг сургадаг. Би өмнөх багшийнхаа заасан ач тустай зүйлийг эргэж санахгүй болчихвол урвагч шиг болчих болов уу?*

**Багш:** Үгүй. Та оюун санаа болон эрхэм ариун явдлаар өөрийгөө сайжруулан багшийнхаа сайхан сэтгэлийг хариулж байна. Тэгээд та гэгээрэхээрээ, улам их гэгээрэхээрээ бүр их хайр, Гэрлийг цацруулж, бусад олон хүнийг, бас өөрийгөө аварна. Энэ чинь багшийнхаа сайхан сэтгэлийг хариулж буй хэрэг. Үргэлж тэр багшаа эргүүлдээд мунхаг хэвээрээ байх хэрэг байхгүй. Ингэх чинь түүний сайхан сэтгэлийг хариулах арга биш.

***Асуулт 114:*** *Та Христийн Гэлэнмаа биш, харин Буддын шашны Хандмаа болсны учир юу вэ?*

**Багш:** Өчигдөр би хэлсэн шүү дээ, дахиад хэлье. За яахав! Хамаагүй. Би бас тийм Гэлэнмаа болмоор байна. Ямар ч бай, энэ нь ердөө л амьдралын арга хэлбэр, өөр хувцас төдий. Харин би Буддын шашны ёс заншилтай орчинд төрсөнд л асуудал байгаа юм. Бас Буддын сүм хийдэд би ургамал хоол олж идэж чадна, харин Христийн сүмд бол үгүй. Тиймээс би тэгж аз туршиж зүрхлэхгүй. Хэрэв Христийн сүмд очоод би цагаан хоолтон юм аа гэж хэлбэл, намайг тэнд үлдээнэ гэж бодож байна уу? Энэ хэцүү. Тэгээд л би Буддын Хандмаа болсон юм.

Бас зарим нэг барилдлагаас болсон. Таны хэн байх, юу болохыг чинь Оройн Дээд зааж шийддэг юм. Та эхнэрийн дүрд тоглох ёстой учраас л эхнэр болсон хэрэг; Ерөнхийлөгчийн үүрэг зорилгыг гүйцэлдүүлэх ёстой учраас л та ерөнхийлөгч болсон. Хэрэв та Буддын шашны Хандмаа, эсвэл Католик гэлэнмаа болсон бол энэ нь таны л төөрөг. Та гэгээрсэн байлаа ч хувь төөргөө л дагана.

Жишээлбэл, Будда гэгээрснийхээ дараа буцаад хар хүн болж болох л байсан. Тэр хувцсаа сольж чадахаас биш гэгээрлээ солихгүй шүү дээ. Гэхдээ тэр өөрчилж солиогүй, зүгээр л тэр чигээрээ үлдсэн. Тэгэхээр одоо энгийн хувцастай байгаа та гэгээрснийхээ дараа, Арьяабалын бясалгалын аргаар гэе, та авшиг хүртээд гэгээрснийхээ хойно жийнсээ богино банзлаар солих шаардлагатай юу, үгүй юу? Эсвэл өөр хувцас өмсөх үү, үгүй юу? Та гэгээрсэн л бол гэгээрсэн, таны ямар хувцастай байх нь хамаагүй. Та Сикх хувцас өмсөж болно, Хиндү хувцас өмсөж болно, Буддист, эсвэл Христийн шашны хувцас өмсөж болно. Ингэлээ гээд ямар ч ялгаа гарахгүй. Та юуг ч өөрчлөх гэх шаардлагагүй. Тэгвэл би яагаад ямар нэгэн юмыг өөрчлөх ёстой гэж? Би энэ байдлаараа дажгүй байна. Их сайхан харагдахгүй байна уу? (Инээв. Алга ташив.) Тэгэхээр энэ маань танд таалагдаж байвал надад өөрчлөх шаардлага алга.

***Асуулт 115:*** *Бид яагаад архи, дарс ууж болдоггүй юм бэ? Үүнд эмчилгээний сайн тал бий.*

**Багш:** Архи уух нь бидний сэтгэл санаанд нөлөөлж, түүнийг бүрхэг, харанхуй, будлиу болгодог, бас мэдрэлийг зарим талаар хөшүүн, мэдээгүй болгоно. Үүнийг бүгд мэднэ. Тэгэхээр энэ нь таны гадна талд ямар сайн нөлөө үзүүлэхийг би тоохгүй, архи ууруаг тархи болон бодох тогтолцоог гэмтээдэг. Гэгээрэхийн тулд бид бодож сэтгэх тогтолцоондоо найдах учиртай. Мэдрэл их суларвал бид төдий их будилж, зөв сэтгэж чадахгүй болно. Тийм учраас бид архи дарс уух хэрэггүй.

***Асуулт 116:*** *"Учир шалтгаан ба үр дагавар" гэж юу вэ?*

**Багш:** Библид ***"Та юу тарина, түүнийгээ хураана."*** гэж хэлсэн байдаг. Нимбэгний үр таривал, нимбэг л хураана. Муу үйл хийвэл, муу үр дагавар л эдэлнэ. Сайн үйл хийвэл, сайн үйлийг л хураана. Гэгээнтнүүд (Буддагийн зам мөрийг дагавал, та Гэгээнтэн) Будда л болно. Хорвоогийн эгэл зам мөрөөр явбал, эгэл хорвоогийн нэг төрөлтөн л болно.

***Асуулт 117:*** *"Учир шалтгаан ба холбоо хамаарал" гэж юу вэ?*

**Багш:** Учир шалтгаан ба холбоо хамаарал гэдэг ийм л дээ. Хэрэв урьд төрөлдөө хэсэг хугацааны турш энэ эрэгтэй нэгэн эмэгтэйд эд материалын тав тух эдлүүлж байсан, харин тэр эмэгтэй энэ насандаа хариуг нь эд материалаар барьж чадаагүй бол тэр эмэгтэй дахин буцаж төрнө. Тэрээр ажиллаж, мөнгө олж, өрөө төлөхийн тулд нөгөө эрийн эхнэр юмуу, охин нь болж магад. Үүнийг л учир шалтгаан ба холбоо хамаарал гэж хэлээд байгаа юм.

Тэгэхээр буцаж төрмөөргүй байгаа бол та бүх өрөө төлж барагдуулсан эсэхээ сайн нягтлаарай. Тийм болохоор надтай хамт суралцана гэдэг нь ёс суртахуунтай амьдарна гэсэн үг. Хулгай хийхгүй, тийм юм чинь та буцаж төрөх шаардлагагүй. Бүх үйлдлээ шулуун шударга, үнэнчээр хийнэ, тэгж байж л буцаж ирэх шаардлагагүй болно.

***Асуулт 118:*** *Мах иддэг Тайландын лам нар яах бол? Тэд диваажинд төрөхгүй юу?*

**Багш:** Та тэднээс асуу. Буддын судард бичсэнээр бол тэд диваажинд төрөхгүй. Тэд хичээнгүйлэн бясалгаж, “хулгай хийхгүй”, бэлгийн дур хүсэлгүй байх, худал ярихгүй байх, архи дарс уухгүй байх гэсэн бусад сахилыг чанд сахивал гэгээрлийн тодорхой нэг төвшинд хүрч магадгүй. Гэхдээ Бурханы хутагт (Гэгээнтний хутагт) хүрч чадахгүй. Магадгүй диваажинд очих байх.

Хэрвээ та хамгийн эхний диваажинд очвол тэднийг бүгдийг нь харах байх. Та тэдгээр мах иддэг хэрнээ сайн, ариун явдалт лам, гэлэнмаа нарыг тэнд бүгдийг нь харна.

***Асуулт 119:*** *Би авшгийг их сонирхож байна, гэхдээ надад садар самуун явахгүй, гэрлэхийн өмнөх бэлгийн харилцааны тал дээр асуудал бэрхшээл байна. Энэ асуудал дээр Та юу гэж зөвлөхсөн бол?*

**Багш:** Та хамтрагчаа солих гээгүй, гэрлэх санаатай л байгаа бол гэрлэхийн өмнөх бэлгийн харилцаа нь садар самуун явдал биш юм. Одоо цагт энэ чинь гэрлэлттэй төстэй болжээ. Тийм үү? Хамтран амьдарч, ингэснээрээ бие биенээ эхлээд таньж мэднэ, энэ чинь зүгээр шүү дээ. Ердөө л өөр бусадтай бүү яв, хосоо тийм хурдан бүү соль. (Их Багш болон бүгд инээв.)

Гэрлээгүй хэрнээ бие биеэ тэвчиж чадахгүй, бас бүхий л хүнд сорилт, зовлон зүдгүүрийн дараа яриа хөөрөө, тайван арга зам хэрэглээд ч таарч тохирохгүй хэвээр байвал хоёулаа салах талаар шийдвэр гарга, эсвэл ирээдүйд өөр нэгэн хүнтэй санаандгүй таарах ч юм бил үү, тэгвэл та өөртөө үнэнч байх хэрэгтэй гэж би бодож байна. Тэгэхэд л хангалттай.

Орчин үеийн энэ цагт бид хэтэрхий хатуу чанга байж болохгүй. Садар самуун явах гэж би юуг хэлээд байна вэ гэхээр аль хэдийн хань ижилтэй болсон, тэр өөрт чинь сайн, таарамжтай байхад хүсэл тачаалаасаа болж ийш тийш сээтгэнэн ханиа гомдоохыг хэлж байгаа юм. Харин энэ аргаар хэсэг бясалгаад ирэхээр та аяндаа ийш

тийш сээтэгнэх хүсэлгүй болно. Та аяндаа л цэвэр ариун болно, учир нь Бурханы хүч таныг ариусгана.

***Асуулт 120:*** *Хаанаас хий юм үзэгдэж сонсогдоод байдгийг мэдмээр байна? Энэ нь зүүдтэй адил эх сурвалжаас бий болдог уу?*

**Багш:** Буруу бодол, буруу хоолноос болж хий юм үзэгдэж, бас сонсогддог юм. Тийм болохоор л Будда хэлэхдээ та мах идэж, дарс ууж, бэлгийн зугаа цэнгэл, эсвэл хорвоогийн жаргалд ташуурвал ердөө л чөтгөрийн хааны суудалд л хүрнэ, хэзээ ч Буддагийн байр сууринд хүрэхгүй гэсэн аж. Чөтгөрийн хаан гэдэг нь хий юм үзэж сонсох, хуурамч байр байдал гэсэн үг болохоос биш, жинхэнэ бөгөөд хамгийн дээд байр суурь биш юм. Бидний бие, хэл, сэтгэл ариун бус байхад бясалгахыг хичээх, эсвэл төгс сайн багшгүйгээр ганцаараа бясалгах үед хий юм үзэж, сонсох нь амархан эхэлдэг. Харин хамгийн дээдэд хүрэхийг хүсч байгаа бол танд ёс суртахуунлаг амьдрал, бие, хэл, сэтгэлийн цэвэр ариун байдал маргаангүй нэн чухал болно. Эс бөгөөс та диваажин болон хий юм үзэж сонсох хоёрын завсарт л очих болов уу.

Бас хүчилтөрөгч дутагдах үед бясалгаагүй ч гэсэн хий юм үзэж харах тохиолдол байж болно. Тиймээс заримдаа хүн ухаан алдаж унахаараа диваажингийн зарим хэсгээс харсан мэт болдог, гэтэл хүчилтөрөгч дутагдсан л байдаг. Эсвэл хэт их өвдөж шаналах, зовлон зүдгүүр туулахаараа ухаан алдаж унаад бас тийм юм хардаг. Эсвэл хэт их ядарч туйлдаад үгүй бол хар тамхи хэрэглэсэн үед хий юм үзэж сонсох нь бий. Энэ байдал маш олон эх сурвалжаас үүсдэг.

Энэ нь зүүдтэй төстэй, гэхдээ дандаа зүүд байдаггүй. Зүүд нь арай жинхэнэ талдаа юм. Унтахаараа хүн зүүдэлдэг. Харин миний түрүүн хэлсэн шиг хэт их өвдөх, хүчилтөрөгч дутагдах, ядрах, хар тамхи хэрэглэх зэрэг гадны дарамт шахалтын улмаас хий юм үзэх сонсох явдал заримдаа гардаг. Тэгэхээр энэ нь жаахан ялгаатай.

***Асуулт 121:*** *Би амьтны гаралтай уураг, тахианы мах зэрэг хоол тэжээл хэрэглэх шаардлагатай эмчилгээний нөхцөлд байдаг юм аа. Яах вэ?*

**Багш:** Яагаад өдий насны хүмүүс дэлхий дээр амьтны уургаас өөр уураг байдаггүй гэж буруу ойлгоод байдгийг би мэдэхгүй юм. Эмч, эрдэмтэд бүгдээрээ ургамлын уураг нь үнэхээр хангалттай, бүр махан хоолноос илүү хүний эрүүл мэндэд ашиг тустай гэдгийг баталчихсан.

Формоса (Тайвань)-д Христийн шашинд итгэгчдийн барьж байгуулсан хоёр эмнэлэг бий. Эмнэлэг дотор бүх эмч, сувилагч, өвчтнийг цагаан хоол идэхийг шаарддаг. Та тэнд байя гэвэл цагаан хоолтон байх ёстой. Тэд маш хурдан эдгэрдэг, шим тэжээлийн хомсдолоос болж эндсэн нэг ч хүн байгаагүй. Тэгэхээр веган хоол бол эргэлзээгүй хамгийн сайн гэж бодож байна.

Судалгаагаар америкчууд маш их мах иддэг, танай орон хорт хавдрын хувиараа дэлхийд хамгийн эхэнд явдаг гэдэг нь тогтоогдсон. Энэ тэгээд баяр хүргэх шалтгаан мөн үү? (Инээв) Орос улс болон Эх газрын Хятад улсад мах байдаггүй,

учир нь тэд ядуу орон, гэтэл хорт хавдрын тоо нь хамгийн бага байна. Үүнийг харьцуулж үзвэл зугаатай байна уу?

***Асуулт 122:*** *Одоо 79 настай нэгэн эмэгтэй өнөөдрөөс эхлэн ургамал хоолтон болохоо амлаж, авшиг хүртэхийг гуйж байна.*

**Багш:** Их сэтгэл хөдөлмөөр юм, гэхдээ тэр дэндүү өндөр настай байна. Тиймээс би түүнд өөр нэг юм зааяа. Тэр ургамал хоолтон болж болно, гэхдээ жаахан оройтжээ. Тэгэхээр дэндүү хожимдохоосоо өмнө арай залуу байгаа дээрээ хурдлаарай.

***Асуулт 123:*** *Гэгээрэхээсээ өмнө нас барчихдаг хүүхдэд юу тохиолддог вэ?*

**Багш:** Энэ сүртэй юм биш. Ихэнх хүн гэгээрэхээсээ өмнө үхдэг. (Инээв) Тэгээд ямар нэгэн өөр юм болоод л буцаад ирнэ. Гэгээрэхээсээ өмнө нас барж буй хүүхэд бидэн шиг хөгширчихөөд гэгээрэлгүй үхэж байгаатай адил тийм харамсалтай биш. Их Багш болон арга замаа эрж хайхгүйгээр бид маш удаан амьдарсан. Хүүхэд бол энэ тал дээр яаж ч чадахгүй, гэтэл бид бол чадна. Бидэнд өөрчлөгдөх хугацаа байна. Гуч, дөч, тавь насалсан бидэнд цаг байж л байна. Тиймээс үүнийг хий.

***Асуулт 124:*** *Гэрлэсэн хосын бэлгийн амьдралын талаар?*

**Багш:** Зүгээр ээ. Хурдан ахиц гаргахын төлөө чадах хэмжээндээ энэ харилцаагаа багасга. Аяндаа л багасга, тэгэхгүй бол сэтгэл эсэргүүцэнэ. Аажмаар түүнийгээ орхи, их бясалгаад байвал тэр чинь улам хэвийн бага болно, улмаар хэрэгтэй зүйл биш гэдгийг бүрэн мэдэрнэ. Хэрвээ та тэрийг хийсээр байгаа бол бас л зүгээр; тийм биш нь ч бас зүгээр. Танд ямар ч хүндрэл бэрхшээлгүйгээр лам, гэлэнмаа мэт санагдана.

Хурьцал үнэхээр зайлшгүй чухал биш, энэ бол ердөө л дадал. Одоо бодоод үз. Заримдаа олон сарын турш эмэгтэй хүнтэй уулзаагүй бол таны сэтгэл тэгж их хөдлөхгүй. Харин уулзаад харчихвал нэг юм загатнах шиг санагдана. (Инээв) Эхнэрээсээ удаан хол байх, эсвэл их ажилд дарагдах үед танд хурьцлын цэнгэл шаардлагатай мэт санагддаггүй гэж л би хэлэх гээд байна. Тийм биш гэж үү? Хэсэг хугацаанд ингээд туршаад үз, тэгвэл миний санааг ойлгоно.

Гэтэл амьтад цаг нь иртэл хэзээ ч юу ч хүсдэггүй. Тэдэнд цаг улирал гэж бий. Тийм биш үү? Сэтгэл санаа нь Бурханых гэдгийг эс тооцвол хүн бол амьтны аймагт харъяалагдана; эрэгтэй хүн бас л амьтан. Үнэндээ хүмүүс энэ зүйлийг хэтрүүлдэг. Хүмүүс физикийн хуулийг дагаж, үүнийг ердөө л улирлын чанартай хиймээр юм уу. (Инээв.) Таашаал авах гэж биш нөхөн үржихийн үүднээс гэж би хэлэх гэсэн юм. Тэгээд ч Библид **“*Өөрийгөө бүү өөгшүүл.*”** гэж хэлсэн байдаг. Хэрэв тэрийг хэт их үйлдээд байвал дадал зуршил болж, яваандаа залхана. Тэгээд ч энэ нь юу ч биш зүйл шүү дээ.

***Асуулт 125:*** *Эрт цагийн оюун санааны Их Багш нарын ихэнх нь цөөн хэдэн шавиа л гэгээрүүлж чадсан байдаг. Та яагаад ийм олон хүнд гэгээрлийг өгч байгаа юм бэ?*

**Багш:** Тэр олон хүн чинь хэн бэ? Тэр бүх хүн над дээр ирж, гэгээрнэ гэж та бодож байна уу? Үгүй. Зарим нь ирнэ, зарим нь ирэхгүй. Эрт цагийн ихэнх Их Багш цөөхөн хүмүүст гэгээрлийг өгсөн нь мэдээж шүү дээ, цөөхөн хүн ирсэн учраас. Тэдний ихэнх нь нуугдаад ил гарч ирж зүрхэлдэггүй байв. Ил гараад ирэх л юм бол алуулж мэднэ.

Есүст юу тохиолдсоныг та ойлгодоггүй юм уу? Хүмүүс түүнд гурван жил хагас л амьдрах боломж өгсөн. Сикхийн Тав дахь Гүрү, зургаа дахь, арав дахь Гүрү нэг хотоос нөгөө рүү хөөгдөж, амьдаараа арьсаа өвчүүлж, халуун наранд түлэгдэж, халуун пийшин дээр суухад хүрсэн. Сикх шашны тав дахь, зургаа дахь Гүрүг тэд халуун наранд дүрэлзэж буй гал дээр халуун хайруулын тавганд суулгасан. Бүхнийг Чадагч Хүчийг өөртөө агуулсан Тэр үүнийг эсэргүүцээгүй. Тэр хулчгар учраас бус, харин шавь нарынхаа өмнөөс ийм шийтгэлийг үүрсэн юм.

Яг л Есүс шиг. Тэр үзэгдэхгүй алга болж, эсвэл диваажин руу нисч, эсвэл зарим ид шидээр мэхэлж чадах байсан. Гэвч Тэр чөтгөрүүдийг эсэргүүцээгүй бөгөөд тэдэнд Өөрийг нь цовдлох боломж өгсөн. Тэр зугтаж чадахгүйдээ тэгсэн юм биш. Тэр зугтаж чадах байсан, хүссэнээрээ алга болж чадна. Түүнд маш их ид шидийн хүч байсан. Библид тэмдэглэснээр бол Тэр олон удаа харагдахгүй алга болж байжээ. Йогийн олон ов мэхийг сурсан байсан. Тэрээр үзэгдэхгүй алга болох, хувилж харагдах, өвчтэй хүнийг эдгээх, сохор хүнд хараа оруулах, усан дээгүүр явах зэргийг чаддаг байжээ. Гэвч энэ бүхнээ хэрэглээгүй. Яагаад? Учир нь Тэр тухайн цагийн шавь нарынхаа нүглийг угаах ёстой байсан.

Гэгээрлийг хүсэмжлэн өлмийд нь сөгдсөн хэний ч нүглийг Их Багш бүр үүрэх ёстой байдаг, учир нь нэгэн хүн төрөлтний үйл түйтгэр тоо тоймшгүй олон төрлийн турш цугларч хуримтлагдсан байдаг. Хэр том болохыг нь төсөөлөхийн аргагүй. Будда ***"Нэг хүний нүгэл хилэнцийг хардагсан бол тэр нь орчлон ертөнцийг бүхэлд нь дүүргэнэ."*** гэжээ. Ганцхан хүний гэм нүгэл бүх ертөнцийг хэдийнээ дүүргэж байна! Библид бас ***"Төрсөн л бол бид хэдийнээ нүгэл хураасан байдаг."*** гэж хэлжээ. Бид нүгэл хилэнцийг цусандаа өвлөж авсан байдаг байтлаа түүнийг яаж энэ хязгаарлагдмал билиг ухаан, тамир тэнхээгээрээ угаан арилгаж чадах билээ? Үүнийг хэрхэн угааж арилгах арга замыг мэддэг Бурханы Хүү, Аврагч, эсвэл Их Багш бидэнд хэрэгтэй.

***Асуулт 126:*** *Хамгийн Дээд Хүч цор ганц л байдаг уу? Туршлага, хүч тэнхээ, итгэл найдвараа бүлгийнхэнтэйгээ хуваалцдаг зарим талаар гэгээрсэн хүмүүсийн хамтын нөхөрлөлийг та ашиглаж болохгүй юу?*

**Багш:** Хамгийн Дээд Хүч ердөө цор ганц л байдаг уу гэсэн үү? Тийм ээ. Хамгийн Дээд Хүч гэж бий. Дээшлэх тусам л тэр хүч улам л илүү өндөр илүү хүчтэй болдог; хэдий чинээ доошилж, энэ дэлхийд ойр бууж ирнэ, энэ хүч төдий чинээ багасна. Ийм учраас л гэгээрэлд дэс түвшингүүд байдаг юм. Та хэдий дээшээ дээшээ мацна, төдий их гэгээрч, улам их хүчийг өөртөө эзэмшинэ. Бурхантай нэгэн цогц болтлоо тэгнэ, ингэвэл та Үнэмлэхгүй Хүчтэй болно. Тэр мөчид та Нирваанд, Гэгээнтний хутагт хүрэх буюу Бурхантай нэгэн цогц болж, Бурханыг ухааран таньсан байна.

Гэгээрсэн Их Багш нар бүгд хамтрах хэрэгтэй юу? Та ингэж асуусан уу? Тийм үү? Энэ боломжтой зүйл. Гэхдээ гэгээрсэн Их Багш тийм олон байддаггүй. Байсан ч тэд завгүй. Энэ дэлхий дээр гэгээрээгүй хүн ийм олон байгаа учраас гэгээрсэн багш нар цугтаа байгаад байх биш, харин ийш тийш явж хүмүүст туслах ёстой байдаг юм. Сүнсээрээ хэдийнээ хамтдаа болсон болохоор биеэрээ хамт байх шаардлагагүй. Гэхдээ авшгийн дараа бид номын ах, эгч нартайгаа хамт бясалгаж, туршлагаа, баяр баясал, хамтын хүчээ хуваалцаж болдог. Харин Гүрү нар хаа холоос тухайн бүлэг хүмүүсийг бүхэлд нь хамгаалж, тусалж, адислаж чаддаг. Тэгэхээр хамтын бясалгал маш их ач тустай. Ийм учраас л Есүс ***“Миний нэрийн дор хоёр хүн сууж байхад Би тэдэнтэй хамт.”*** гэж хэлсэн юм. Энэ нь хамтын бясалгал маш их Бурханы адислалтай гэсэн үг.

***Асуулт 127:*** *“Дао” гэж та юуг хэлээд байна вэ?*

**Багш:** Дао гэдэг нь “Зам мөр” гэсэн үг. Дао гэж гэтлэхүй буюу орчлон ертөнц дээрх хамгийн дээд билгүүн ухаан, бүтээгч хүчинд хүрэх зам гэсэн Хятад үг юм. Дао гэж энэ юм.

***Асуулт 128:*** *“Эгэл жирийн сэтгэл бол Дао” гэж Та юуг хэлсэн бэ? Энэ үгийг би ойлгоогүй.*

**Багш:** Тэрийг Дао гэж байгаа юм. Эгэл жирийн сэтгэл гэдэг нь бидний сэтгэл амар амгалан, тайван дөлгөөн, аливаа нөхцөл байдал болон төрөлтнүүдтэй эв зохиролд байхыг хэлж байгаа юм. Үүнийг л энгийн сэтгэл гэж нэрлээд байгаа юм. Угтаа “Ping Chang Hsin” (Хятад хэлээр) нь энгийн сэтгэл гэсэн үг биш л дээ. Зүгээр л үүнийг Англи хэл рүү орчуулахад үгс дутагдсан хэрэг. Тэгэхээр “Ping Chang Hsin” гэдэг нь энгийн сэтгэл гэсэн л утгатай, гэхдээ “энгийн” мэдрэмж гэдгээр биш юм. Энэ бол амар амгалан, аль хэдийн гэгээрсэн, маш ээ эвтэй сэтгэл юм. Энэ л “Ping Chang Hsin” юм.

***Асуулт 129:*** *Таны энэ зам бидний зам мөр мөн эсэхийг лавтай мэдэхгүй байгаа тохиолдолд эвгүй сэтгэгдэл юмуу, үйлийн үр хураахгүйгээр авшиг хүртэж үзчихээд өөрийн замаа хөөгөөд орхиод явж болох уу?*

**Багш:** Тиймээ, болох л юм. Би таныг хорихгүй. Ямар ч нөхцөл болзол байхгүй шүү дээ. Гэхдээ та орхиж явахыг хүсэхгүй л байх гэж би эмээж байна.

***Асуулт 130****: Авшиг хүртсэний дараа бид бүдэрч, амлалтаа биелүүлэхгүй, гурав дөрвөн алхам урагшлах бүртээ хоёр алхам хойш ухраад байвал яах вэ? Өөр замаар явахаар шийдэж болох уу? Та биднийг авшиг хүртэхгүй байсан нь дээр гэж үзэж байна уу? Бурханы Хүч хүрдүүдтэй ямар хамаатай вэ?*

**Багш:** Та манай энэ замаар яваад үз. Харин долоон хүрдэнд хамаатай ямар нэг зүйл Бурханы Хүчинд бий. Гэхдээ та хүрд гэж хэлэхдээ дээшээ энэ хүртэлх биеийн хүрдүүдийг л хэлж байгаа бол энэ нь Бурханы хүчинд хамааралгүй. Би эдгээр хүрднээс дээш байгаа зүйлийг ярьж байна. Ихэнх йогчид биеийн доторх хүрдээр бясалгал дадлага хийдэг бөгөөд дотоод дулааны хөдөлгүүрээ л ажиллуулдаг.

Бидэнд хоёр хөдөлгүүр бий, биенд хоёр урсгал байдаг; нэг нь Аялгууны урсгал, нөгөөх нь Дулааны урсгал. Дулааны урсгал нь бие дэх аливаа хөдөлгөөнийг зохицуулна – хоол боловсруулалт, хөлрөлт, цус, цусны эргэлт гэх мэт; нөгөө урсгал нь биднийг дээшээ, Бурханы орон луу буцааж аваачдаг. Йогчид бясалгахаараа бэлгийн хүрд, хошногоны хүрд, хэвлийн хүрд, наран сүлжээ, зүрхний хүрд, хоолойн хүрд зэрэгтэй ажилладаг. Манай бясалгалд эдгээрийг ярьдаггүй юм гэх гэсэн юм. Би эдгээр биеийн хүрднээс дээш яриад байна. Та миний "Билгийн мэлмийн нууц" гэсэн лекцийг миний хамгийн анхны Англи номоос уншаарай. Тэнд би янз бүрийн хүрд болон манай бясалгал тэдгээрээс юугаараа ялгаатай тухай ярьсан байгаа.

Одоо авшиг хүртэхийг хүсч буй бол та тууштай бай, гуйя. Бурханыг бүхнээс илүү хүсэж буйгаа та мэдэх ёстой. Бурхантай бүү наймаалц. Би таны юу хийхийг тоохгүй. Бурхан л тооно. Бурханыг элэглэх ёсгүй юм. Түүний урдуур хэнийг ч оруулж шүтэх хэрэггүй.

***Асуулт 131:*** *Идэхээсээ өмнө хоолоо адислуулахаар гуйх нь ач тустай юу?*

**Багш:** Тийм ээ, тустай. Идэхээсээ өмнө та хоолоо Бурхан, эсвэл Есүс, Будда, хамгийн их итгэдэг хүндээ, эсхүл өөрийн Гүрү Нанакдаа өргөх хэрэгтэй, тэгээд ид. Хоол чинь адислагдаж, амархан шингэнэ.

***Асуулт 132:*** *Гэгээрэлд хүрэх хичнээн зам мөр байдаг вэ? Тэд ямар вэ?*

**Багш:** Цорын ганц л зам байдаг. Тэр бол ***Аялгууны Урсгалын Арга*** гэж Будда хэлсэн. Дотоодод маань байгаа Гэрэл болон Аялгуу биднийг гэгээрэлд хөтөлнө. Есүс бас "***Би бол энэ дэлхийн Гэрэл. Намайг дагасан хүмүүс харанхуйд алхахгүй.***" гэжээ. Тэгэхээр тэр Гэрлийг өгч чадаж буй хэн ч бай Христийн даалгаврыг биелүүлж яваа хүн. Тэр хүн бидэнд Гэрэл өгч байна гэдэг чинь тэр хүн биднийг Гэрэл рүү хөтөлж байна, бид харанхуйд алхахгүй гэсэн үг. Гэгээрэл гэдэг нь "Гэрэл" гэсэн утгыг агуулж байна, тэгэхээр тэр Гэрлийг танд хэн ч өгсөн бай та лавтайяа "гэгээрсэн" хэрэг.

***Асуулт 133:*** *Мах идэх нь ёс суртахуунгүй явдал юм бол бүс тэлээ, гутал хийх зэрэг бусад зорилгоор амьтан хөнөөх нь бас ёс суртахуунгүй явдал уу?*

**Багш:** Тийм ээ, мөн. Ямар ч зорилгоор бай, ***Амь хөнөөж болохгүй***. Нүдийг нүдээр, шүдийг шүдээр гэсэн эртний үг бий. Тиймээс шууд болон шууд бус алин ч бай аливаа аллагыг цээрлэх нь хамаагүй дээр. Амьтны гаралтай хоол хүнс хэрэглэхгүй байвал хэн ч амьтан алахгүй, учир нь энэ нь ямар ч ашиггүй. Тэгэхээр мах идэх нь шууд бус аллага болно.

***Асуулт 134:*** *(Их Багш асуултыг уншиж орчуулав.) "Би ахин дахин эргэж төрмөөргүй байна, тиймээс гэгээрч, энэ төрөлдөө гэтэлмээр байна" гэж энэ эмэгтэй хэлжээ. Вьетнам хүн юм байна, тэр "та намайг би үзэлдээ хүлүүлсэн байна гэж хэлэх байх, гэвч би энд байгаа Вьетнам лам нарт яагаад ч мөргөж чадахгүй юм. Тэд ажил хэргээ л хийгээд дэндүү завгүй байдаг" гэжээ.*

**Багш:** Тэгвэл битгий мөргө. Тэгвэл битгий мөргө. Амархан, сайхан санагдахгүй байхад заавал ингэх шаардлага байхгүй. Та зүгээр л үнэнч байна. Тэгээд л боллоо. Би таны үнэнчийг бишрч байна. Хэрвээ Та гэгээрээгүй бол зөвхөн ажил бизнесээ л хийнэ. Энэ нь хаана ч адилхан. Харин та гэгээрчихвэл чулуунд ч мөргөж чадна. Та тоохгүй. Тэд өөрсдийнхөө юмыг хийг, та өөрийнхөө юмыг хийнэ. Та тэр хүнийг нь бус, харин гэгээрлийн бэлгэ тэмдгийг л шүтэж байгаа хэрэг. Тиймээс та тэдэнд мэхийн мөргөж болно.

Надад ч гэсэн ямар ч нөхцөлд хэзээ ч битгий мөргө. Надад бүү мөргө, учир нь энэ бол ердөө л нэг махан бие. Би энэ биш. Энэ бие ердөө л миний хувцас. Тэгэхээр над дээр ирэхдээ мөргөх хэрэггүй. Энэ талаар бүү айж эмээ. Шавь нарын маань хэн нь ч надад мөргөдөггүй. Тэд мунхаг бөгөөд мэдэхгүй учраас мөргөхийг эс тооцвол хэн ч мөргөхгүй, мөргөвөл би зугтдаг. Тэгээд тэд хоосон сандалд мөргөнө. Эсвэл би тэднийг загнадаг.

***Асуулт 135:*** *"Quan Âm" энэ дэлхийд оршдог юм уу? Олон сүм дуганд маани мэгзэм, залбирал уншсаар байна. Ингэх нь гэгээрэлд хүргэх арга мөн үү?*

**Багш:** "Quan Âm" гэдэг нь Арьяабал* Бодьсадва гэсэн үг. Вьетнамд "Quan Âm" гэдэг нь Гуан Инь Бодьсадва гэсэн утгатай. Энэ хүн буюу гэгээнтэн нь Бурханы, Буддагийн энэрэн нигүүлсэгч чанарыг илэрхийлдэг. Тийм! Гуан Инь Бодьсадва оршдог! Заримдаа Тэр энэ дэлхий дээр төрөл авч төрөөд мунхаг харанхуй хүмүүст туслахын тулд энэ махан биеэр хувцасладаг. Тэр оршдог юм шүү! Тэр Хятадад олон удаа заларсан. Дахин дахин, олон удаа ирж төрөөд буй Гуан Инь хувилгаан хэн байсныг бид мэднэ. Тэр заримдаа бас Түвдэд төрсөн.

Хоёр дахь нь "олон сүм дуганд маани мэгзэм, залбирал уншиж байна. Ингэх нь гэгээрэлд хүрэх арга мөн үү?" гэжээ. Биш! Үгүй! Энэ бол ердөө хэсэг нь төдий. Залбирал болон маани унших нь бидний чин сэтгэлийг бадрааж, чин сэтгэлийн бөгөөд цэвэр ариун уур амьсгал бүрдүүлэхэд туслахад зайлшгүй хэрэгтэй зүйл. Гэвч чимээгүй Бурхантайгаа харилцахын тулд бид чимээгүй байх ёстой. Бурхан чимээ шуугиан таригч биш. Харин бид л бие, хэл, сэтгэлээ өдөржин завгүй байлгадаг. Бид сүмд очихдоо ч бас л завгүй, маани тоолж, юм яриад л, Бурханд юу хийхийг нь зааж хэлээд байдаг. Тэгэхээр Бурхан бидэнд хэзээ цаг гаргах болж байна, эсвэл бид Бурханд цаг гаргах юм уу? Бид чимээгүй суух ёстой. Бүр зогсохдоо, хэвтэхдээ ч чимээгүй байж л Бурханыг хаанаас олохыг мэднэ. Бид сүм хийдэд залбирах, маани мэгзэм уншихаас гадна үүнийг хийх ёстой.

***Асуулт 136:*** *Хүнд тусалж байхдаа тэдний үйлийн үрд, эсвэл хичээл сургамжинд хөндлөнгөөс оролцоогүй гэдгээ яаж мэддэг вэ? Хүний гутлын үдээсийг байнга үдэж өгөөд байвал тэр хүн үүнийг хэзээ ч өөрөө хийж сурахгүй. Хэдийд туслах болон туслахгүй байхаа яаж мэдэх вэ? Тухайн хүн тусламж гуйх хүртэл хүлээх ёстой юу?*

---

* Самгарьд: Avalokiteshvara- хят. Гуан Инь, монг. Хоншим, Арьяабал, яп. Каннон. Их хөлгөн болон очирт хөлгөний домогт Арьяабал бодьсадва нь энэрэл нигүүслэлийн илэрхийлэл болдог.

**Багш:** Тухайн хүн өөрөө чадах бол та түүний гутлыг үдэж өгөх шаардлагагүй. Өвчтэй учраас чадахгүй байвал та тусалж болно. Хөндлөнгөөс оролцох, эсвэл оролцохгүй байхыг бид аргалах аргагүй. Заримдаа бид хөндлөнгөөс оролцохыг хүсээгүй хэрнээ аяндаа л оролцчихдог. Тэгэхээр хамгийн сайн арга бол Бурханы хүчтэй холбогдох, Бурханлиг билиг ухаантай болох юм. Тэгвэл Бурхан таны юу хийхийг чиглүүлээд өгнө. Тэгж та ачаа, үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөнө. Өөрөөр бол танд үүнийг хийж чадах ямар ч арга байхгүй. Зөвхөн Бурхан л мэднэ. Бид билиг ухаантайгаа холбогдчихвол, тэр билиг ухаан биднийг өдөр тутмын ажил хэрэг бүр дээр залж чиглүүлнэ! Ингэж л бид итгэлтэй болно. Хийж буй зүйл маань яг зөв гэдэг нь бидэнд тодорхой байх болно. Хэрхэн зөв замаар хийхийг та нарт үзүүлэх арга зам нь надад байна! Гэхдээ авшгийн дараа үүнд жаахан цаг орно.

***Асуулт 137:*** *Эрт үеийн дурсамжаасаа Та хувь төөргөө мэдсэн үү? Таны Их Багш хэн бэ? Их Багш тань Хималайд байгаа юу?*

**Багш:** Хималайд. Тэр явчихсан, Гэртээ харьчихсан. Эрт үеийн дурсамжаасаа Та хувь төөргөө мэдсэн үү? гэсэн үү. Тийм ээ, та мэдэж болно. Ганц Би ч биш, та ч бас мэдэж болно. Би зөвхөн өөрийнхийгөө биш, таныхыг ч бас мэднэ. Би энэ орчлон ертөнц дээрх төрөлтөн бүрийг мэднэ.

***Асуулт 138:*** *Хэн нэгэн танд туславал та өөр хэн нэгэнд бас заавал буцааж туслах ёстой юу? Өөр хүнд сайн үйл хийснээрээ тухайн өрийг арилгаж болох уу?*

**Багш:** Чадвал тэр хүндээ л буцааж тус хүргэ. Чадахгүй бол орчлонгийн хамаг амьтны сайн сайхны төлөө бусдад эргүүлж тусал. Өөрт тань тусламж хэрэгтэй байгаа бол гуй, тэгээд дараа цаг нь ирэхээр буцааж тусал. Тус дэм хэрэгтэй үе хүн бүрт тохиолддог.

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт

## Коста Рика, Сан Хосе, Архитекторуудын Нийгэмлэг
## 1989 оны 6 дугаар сарын 8

***Асуулт 139:*** *Энэ лекцийн дараа өнөөх энгийн амьдралдаа буцаж ороход Та бидэнд юу гэж зөвлөх вэ? Хамгийн түрүүнд хийх хэрэгтэй зүйл юу вэ?*

**Багш:** Гадаа буй мэдээллийн ширээн дээр очоод Гэгээрэлд хүрэхийн тулд авшиг хүртмээр буйгаа хэлээд нэрээ бичүүлнэ үү. Таны хийх ёстой хамгийн эхний зүйл бол энэ. Хоёрт, тэр шаардлагуудыг унш, гуравт, та гэгээрлийг хүрт. Ийм хялбархан! Тэгээд зааврын дагуу өдөр бүр бясалга.

***Асуулт 140:*** *Тантай хувиараа уулзах боломж бий юу? Та энд амьдардаг уу, эсвэл урт, богино хугацаагаар зааж сургахаар түр байгаа юмуу, удахгүй явах гэж байгаа юу?*

**Багш:** Би 11-нд Бразил, Аргентин улс  руу явна, учир нь би дэлхийг тойрох аялал хийж байгаа юм. Үнэхээр яаралтай зүйл бол надтай уулзаж болно, энэ лекцийн дараа хувиараа уулзахыг надаас дахиж гуйгаарай, тийм биш бол хожим уулзаж болно. Үнэхээр тийм яаралтай бол надад биечлэн хэлэх хэрэгтэй, дуртайяа уулзана.

***Асуулт 141:*** *Яаж зовохыг зогсоох вэ?*

**Багш:** Жаргалтай болж л зогсооно. Аз жаргалын аугаа эх булаг нь гэгээрсний дараа, гэгээрлийг өдөр бүр давтаснаар Бурханаас ирэх тайтгарал юм. Аз жаргалыг тун тунгаар авахад зовлон багасаад л байх болно. Яг л эмч танд эм өгөхөөр өвчин тань өдрөөс өдөрт илааршиж, улам тэнхээ ордог шиг юм.

***Асуулт 142:*** *Авшиг гэж яг юу вэ? Энэ яг ядаг арга вэ?*

**Багш:** Авшиг бол үл үзэгдэх үйл явц. Үүнийг бүр үгээр илэрхийлж ч болдоггүй. Хэдийгээр би олон цагийн турш ярьж байгаа ч авшгийг уламжлах үед бид ярьдаггүй. Миний ярьж өгөх зүйлс гэвэл таны яаж суух, яаж төвлөрөх, Бурханы адислалыг хэрхэн авах, өдөр тутам яаж ариун гэгээн байх, урхи зангыг хэрхэн тойрох, итгэл сүжгээ хэрхэн арвижуулах, хэрхэн улам сайжрах, өдөр бүр Бурханд хэрхэн ойр байх, өдөр тутмын амьдралд яаж бясалгах, өдөр тутмын амьдралдаа Бурханы адислалыг хэрхэн авчрах тухай. Би ийм юмс л ярина, харин энэ арга өөрөө чив чимээгүй. Би тэр аргыг дээд зэргийн аниргүйд уламжилна, тэгээд та гэгээрлийг хүртэнэ. Та юу ч авахгүй юм биш, та  гэгээрлийг хүртэнэ, гэхдээ анир чимээгүйд. Би ч үүнийг мөн

чимээгүй дамжуулна, тиймээс таны агшин зуур гэгээрэхийг эс тооцвол яриад байх юм юу ч үгүй.

Та Бурхантай холбоо барьж, зарим ахуй ойлголт үзнэ. Таны итгэл сүжиг, өдөр тутмын зориуллыг тань өдөөх ямар нэгэн зүйлийг би яриад байна. Хэрэв та Бурханыг зэрвэс харж, түүний гайхамшигт Аялгуунуудыг сонсоогүй бол Түүнийг мэдэж чадахгүй, Түүнийг үнэхээр байдагт итгэлтэй болохгүй. Тиймээс Түүний зэрвэсхэн гялбааг ч болов харах хэрэгтэй. Дараа нь та өдөр бүр адислалыг нь хүртээрэй. Та Бурхан үнэхээр байдаг, Бурхан таныг үнэхээр хайрладаг, үнэхээр адисладаг гэдгийг лавтайяа мэддэг болно. Энэ арга нь тайлбарлаж ярьж болдог зүйл биш. Би танд төвлөрөл, адислалыг хэрхэн авах, яаж өдөр тутам бясалгах талаар л ярих болно. Харин энэ арга чимээгүй дамждаг. Та гэгээрлийг бас л чимээгүйд хүлээж авна, гэхдээ та гэгээрлийг хүртэнэ.

***Асуулт 143:*** *Хайр гэж юу вэ?*

**Багш:** Хайр бол энэ. (Их Багш үнсэлтээ үлээв.) Хэн нэгэнтэй тун ойр дотно байх, хэн нэгэнтэй маш нөхөрсөг байх, хэн нэгэнтэй хамт байхыг машид хүсэхийг л хайр гэнэ. Нэгэн хүн таны дутагдалтай тал, бүтэлгүйтэл, би үзэл зэргийг үл тоон таныг хамгаалж, чиглүүлж, хайрлаж, тусалж, адислаж байвал тэр бол хайр мөн. Үнэнч найзын хайр, ханийн хайр, эцэг эхээ гэх үр хүүхдийн, үрээ гэх эцэг эхийн хайр, энэ бүхэн бол Бурханы сансрын хайрын нэгээхэн хэсэг л юм.

Харин Бурханы хайр бол бидний энэ мөнх бус хайраас хэдэн мянга, сая дахин илүү, хязгааргүй их. Би танд түүний хайрыг сэнхрүүлж чадахгүй ч Түүний хайр луу хөтөлж чадна, ингэснээр та тэр хайрыг өөрөө үзэж, түүнд умбаж, жаргаж, эрхэлж чадах юм. Тэгвэл та энэ дэлхий дээр үүнтэй харьцуулж болох юм гэж байдаггүйг ойлгоно. Энэ амьдралдаа үзсэн хамгийн жаргалтай мөчийг ч Бурханы хайранд гүн гүнзгий умбасан тэр үеийн өчүүхэн хэсэгтэй жишиж харьцуулахын аргагүй.

***Асуулт 144:*** *Та хүсэл шуналдаа маш хүчтэй автах үедээ түүнээс өөрийгөө яаж чөлөөлдөг вэ?*

**Багш:** Маш сайн асуулт байна. Бид хүсэл шуналаа дардаггүй. Тэгж бараг л чадахгүй, гагцхүү Бурхан л чадна. Авшиг хүртээд Бурхантай хамт байх, эсвэл Бурхантай холбогдоход энэ дэлхий дээрх юуг ч улам л бага хүсдэг болчихдог. Бид баясч цэнгэх боловч шунаж улайрахгүй. Дотоод хүнээ л бүрэн дүүрэн болгочихвол юу ч хэрэггүй юм шиг санагддаг, тэгсэн хэрнээ бидэнд бүх юм байх болно. Би хором бүрт жаргалтай байдаг. Амьдралынхаа мөч бүрт би сэтгэл хангалуун, элбэг дүүрэн байдаг. Учир нь Бурхан миний дотоод хүнийг надад хэрэгтэй бүхнээр хангасан.

Та намайг маш том, сайхан дуганд амьдардаг болохоор жаргалтай байдаг гэж боддог биз. Үгүй! Би ойд, майханд амьдардаг. Гэр орноо орхиж ирсэн шавь нар маань ч майханд амьдардаг. Намайг маш их мөнгөний өргөл барьц авдаг болохоор жаргалтай байдаг гэж та бодож байгаа байх. Үгүй! Би өргөл барьц авдаггүй.

Хүмүүсийг над дээр ирээд газарт сунаж мөргөдөг, тэгэхээр нь би их бардамнаж, жаргалтай болдог байх гэж та бодож магадгүй. Үгүй! Би надад мөргөхийг хэнд ч зөвшөөрдөггүй. Би тэдэнд "Дотоодод буй өөрийнхөө Бурханд мөргө. Будда таны дотор бий. Бурхан дотоодод чинь байгаа. Түүнийгээ өөрөө хөгжүүл, өөрийгөө шүт, учир нь та маш аугаа." гэж хэлдэг.

Өөрийнхөө аугааг мэдэх, өөрөөрөө бардамнах хоёр чинь ялгаатай зүйл. Өөрийнхөө хичнээн аугаа болохыг мэдэхээрээ бид маш даруу болдог. Энэ дэлхийн аливаа дүрс хэлбэрт байгаагаараа бардамнах нь нэг төрлийн сул дорой мэдрэмж. Дутуу дулимагийн мэдрэмжийн нэг хэлбэр юм. Учир нь та хичнээн аугаа гэдгээ мэддэггүй, та ердөө тиймхэн л аугаа гэж боддог. Та өөрийгөө эмч гэж бодоод бардам байдаг. Өөрийгөө профессор гэж бодоод бардам байдаг. Үгүй ээ, та бол Бурхан. Профессор гэдгээрээ бахархаж байгаа бол та өөрийгөө доош нь хийж байна. Бурханы ертөнц дэх өөрийн байр сууриа дутуу үнэлж байна. Тиймээс би үүнийг бас л нэг дутуу дулимагийн шинж гэж л хэлнэ.

***Асуулт 145:*** *Гэгээрлийг үзэж мэдэрсэн л бол энэ нь Бурхан луу явах замаа дуусгачихлаа гэсэн үг үү?*

**Багш:** Та нэг л удаа гэгээрсэн ч дуусах хараахан болоогүй. Дөнгөж л эхэлж байна, Гэртээ харих замдаа алхаж эхэлж байна. Та өдөр бүр явах ёстой. Гэгээрэл гэдэг нь энэ бол Гэртээ харих зам мөн байна гэдгийг одоо мэдлээ гэсэн үг. Бид өдөр бүр замаасаа хазайхгүй, өөрснийгөө хаягдаж орхигдсон гэх мэдрэмжгүйгээр цааш үргэлжлэн алхана. Тийм учраас бид Бурхантай холбогдсон энэ холбоосоо өдөр болгон бэхжүүлэх ёстой. Үүнийг бас яаж хийхийг би хэлж өгнө.

Авшиг бол ердөө эхлэл. Үүний дараа Их Багш тэр эрэлхийлэгчийг бүрэн хөгжих хүртэл нь сонирхлоо үргэлжлүүлэх үйл явцыг нь халамжлах ёстой. Үүний дараа л Их Багшийн ажил дуусна. Энэ нь таныг коллежид элсэн ороход профессор таныг докторын зэрэг авах хүртэл зааж сургах ёстой байдагтай л адил. Үүнээс цааш та өөрөө бас профессор болж магадгүй; багштайгаа ижил түвшинд хүрнэ.

***Асуулт 146:*** *Эцэг дээр хүрч очих цор ганц зам бол зөвхөн Надаар дамжих зам юм гэж Есүс хэлсэн. Энэ ямар учиртай юм бэ?*

**Багш:** ***Надаар дамжихгүйгээр хэн ч Эцэгт хүрч чадахгүй.***

***Асуулт:*** *Энэ мэдэгдлийн талаар Та ямар байр суурьтай байдаг вэ?*

**Багш:** Би Түүнтэй санал бүрэн нийлж байна. Тэр амьд байхдаа Зам мөр байсан, энэ дэлхийн Гэрэл нь байсан гэсэн санааг Тэр хэлсэн. Түүнээс гадна тэр бас **"*Энэ дэлхий дээр байгаа цагтаа Би энэ дэлхийн Гэрэл нь.*"** гэж хэлсэн.**"*Энэ дэлхий дээр байгаа цагт.*"** гэж хэлсэн шүү. Амьд их багш оршиж байгаа цагт та түүнээс ирэх Гэрлийг дагаж, гэртээ харих хэрэгтэй гэсэн санаа юм. Хэрэв тухайн Их Багш явчихсан бол, түүний залгамжлагч өөр нэгнийг дага. Ийм учраас л Есүс Бурханы

орон луу буцсаныхаа дараа Петерт тэр түлхүүрийг өгсөн. Петерийн түлхүүр энд байна. Одоо надад байна.

***Асуулт 147:*** *Энд Коста Рикагаас бид Таны сургаалыг яаж дагах вэ?*

**Багш:** Ямар ч ялгаа байхгүй. Миний заадаг зүйл Есүсийнхээс ялгаагүй. Та аль хэдийн Арван сахил нэрээр зарим хэсгийг нь дагадаг болсон. Би зөвхөн гэгээрэл, Есүстэй, Бурхантай холбогдохуйг нэмсэн. Ингээд та Есүс, эсвэл Бурхантай шууд холбогдож, Тэдэнд өөрөө асуултаа тавина. Манай бясалгал, манай дамжуулалтаар та Есүсийг харж магадгүй. Итгэл бишрэл тань хүчтэй бол та Түүнийг бүр авшгийн үед, суусан эхний хоромдоо ч харж магадгүй. Зарим шавь нар маань Түүнийг аль хэдийн харчихсан. Тэд авшиг хүртээд хэдхэн хоножбайгаа ч харсан.

Гэхдээ та бас Арван сахилыг мэдэх ёстой. Хамгийн эхний сахил нь ***"Амь бүү хөнөө"***. Одоо цагт ихэнх маань зөвхөн хүний амь хөнөөхгүй байвал болчихно гэж ойлгодог, гэвч Бурханы хэлэх гэсэн санаа энэ биш. Бид амьтай бүхнийг, үүнд бусад ахан дүүс гэгдэх амьтдыг ч хороох ёсгүй юм. Тиймээс та бүхнийг амь хөнөөхгүйн гүн гүнзгий утгыг ойлгоосой гэж би хүсч байна. Энэ бол машид хайр энэрлээр амьдарч, юунд ч гэм хор хүргэхгүй байх гэсэн үг. Яг л Библид ингэж хэлсэн байдаг шиг юм: ***Ахыгаа бүдэрч унагахад хүргэх зүйлсийг бүү ид.*** Санаж байна уу? Бас ингэж хэлсэн: ***Мах идэж, архи уугсдын дунд бүү бай***. Тэгэхээр энэ чинь л амь хөнөөхгүй байх гэдгийг жинхэнэ утга учир. Амьтныг бүү ал, тэднийг бүү ид. Бид махыг нь идээд байгаа учраас л бусад маань амьтан алахаас өөр аргагүй болоод байгаа юм. Тиймээс мах идэх нь бас шууд бус аллага юм.

Та нарын анхаарлыг хандуулахыг хүсээд буй цорын ганц зүйл маань Библийн Арван сахилын энэхүү гүн ухаарал ойлголт юм. Өөр шинээр заах зүйл надад байхгүй. Би зөвхөн таны дотоод "Би"-г сэрээнэ, би шинэ юм юу ч заагаагүй. Библи бидэнд цагаан хоол ид гэж заагаагүй гэж та хэлэх байх. Мах идэж, архи ууж болохгүй тухай Библид байдаг олон хэсэг ишлэлийг танд дахин сануулмаар байна. ***Ходоодонд орсон мах, мах идсэн ходоод, Бурхан хоёуланг нь устгана. Мах идэж, архи уугсдын дунд бүү бай***. Тэгвэл энэ ямар утгатай юм бэ? Библид бас "Бурхан ууртай" гэж бичсэн байдаг. Нэгэн удаа нэг хүн Түүнээс бидэнд мах өг гэж шаардахад Бурхан хүчээ ашиглан илбэ шидийн хувиргалт хийж, тэдэн дээр махаар бороо оруулсан. Харин үүнийхээ дараа Тэр тэднийг бүгдийг нь живүүлсэн. Библид бас өөр нэгэн хэсэг байдаг: ***Надад өргөл барих гэж үхэр, ямааг бүү хороо. Гэмгүй амьтны цуснаас өөрийгөө цэвэрлэ, тэгвэл би нүглийг чинь өршөөж магад. Гэмээ наманчил. Эс бөгөөс би залбиралд чинь хариулахгүй, яагаад гэвэл гар чинь гэм зэмгүй амьтдын цусаар хучигдсан байна.*** Өөрт нь өргөл болгохын тулд амьтны амь таслахыг бидэнд зөвшөөрөхгүй атлаа Бурхан биднийг өөртөө өгөхөөр амь хөнөөхийг яаж зөвшөөрөх билээ? Бид Бурханаас илүү аугаа юм уу? Хангалттай ярилаа. Зарим чинь хэдийнээ сонсох хүсэлгүй болж байгаа гэж би бодож байна. Та дуртай ч, дургүй ч үнэнийг хэлэхийг надад зөвшөөрөх ёстой. Бурханы таалллыг гүйцэлдүүлэх эрхийг надад өгөх ёстой. Гэхдээ танд үүнийг

эсэргүүцэх, эсвэл хүлээж авах эрх бий л дээ. Ийм байдлаар бид бие биенийхээ эрхийг хүлээн зөвшөөрнө. Танд баярлалаа.

***Асуулт 148:*** *Би шашингүй үзэлтэн биш л дээ, гэхдээ шүтлэггүй хүн Бурханд итгэхээс нааш амар амгаланг олохгүй юм байна гэж таны энэ лекцээс ойлголоо.*

**Багш:** Бурханд итгэдэггүйн тань төлөө би таныг буруутгахгүй ээ. Үзээгүй хараагүй, бас холбоо бариагүй зүйлдээ бид итгэж чадахгүй. Та шүтлэггүй хүн биш ээ, та зүгээр л үнэнч хүн байна. Тиймээс Бурханыг таньж мэдсэнийхээ дараа л та Түүнд итгэх үгүйгээ шийд. Харин би танд Түүнийг мэдэхэд туслах уу? Тэгвэл та Түүнд итгэдэг үгүйгээ хэлж чадна. Та Бурханд итгэдэггүй ч юм биш. Итгэж чадахгүй байгаа юм, та ийм зүйлээр өөрийгөө мэхэлж чадахгүй байгаа юм. Энэ нь хэн нэг хүн “Хөөх, тэр хөршийнх үзэсгэлэнтэй охин, эсвэл хөөрхөн хүүтэй” гэж ярихыг та сонсохтой адил. Тэгсэн хэрнээ та тэр үзэсгэлэнтэй хүнийг зэрвэс ч болов хараагүй. Бүгд л тэр үзэсгэлэнт охины тухай ярих атлаа өөрсдөө ч барааг нь хараагүй. Тийм охин байдаг гэдэгт өөрсдөө хүчээр итгэсэн, таныг итгүүлэх гэж бас хүчилсэн, харин та итгэдэггүй. Энэ таны буруу биш. Энэ бол мэдээлэл, бодит байдал, жинхэнэ харилцаа холбоо дутагдсаных. Бурханыг харчих юм бол бүх хүн Түүнд итгэнэ. Тэр аугаа зүйлийг нэг үзээд мэдэрчих юм бол Бурханы хайр хийгээд оршихуйг үгүйсгэх хүн нэг ч үгүй болно.

***Асуулт 149:*** *Хайрын хүч болон хурьцлын энергийн талаар Та юу гэж үздэг вэ?*

**Багш:** Эхнэр, нөхрийн хоорондох хайр сэтгэл бол энэ бэрх амьдралд зориулагдсан том тайтгарал юм. Заримдаа бид хурьцлыг энэ хайр сэтгэлийн илэрхийлэл болгон ашигладаг. Тэр үнэн хайрыг илэрхийлж л байвал энэ тийм хортой зүйл биш гэж би боддог. Харин бэлгийн дур хүслээ урвуулан ашиглах, өөгшүүлэх нь л хор хөнөөлтэй. Тийм үү, үгүй юу? За. Үгүй бол дахиад асууна уу.

***Асуулт 150:*** *Хойд төрөл авах урт удаан үйл явц байдаг гэдэгт та итгэдэг бол энэ амьдралдаа хэрхэн эрх чөлөөнд хүрч чадах вэ?*

**Багш:** Учир нь бид хойд төрлийн дараалсан үйл явцыг аль хэдийн туулсан байна. Одоо бид энэ цагт хүрээд иржээ, энэ хүмүүс үхэж төрөхийн хүрдийг төгсгөн нэгэн насандаа гэгээрэлд хүрэхэд бэлэн болжээ. Ийм хүмүүс сэтгэлдээ энэ дэлхийгээс холбоогоо таслах асар хүчтэй тэмүүллийг тээж явдаг бөгөөд Бурханы хайрыг мэдэхийг хүсэмжилж буйгаа мэдэрдэг. Тэд энэ зовлонгоос уйдаж ядарсан байдаг. Энэ хүмүүс бол миний дамжуулсан илгээлтийг хүлээн авахад бэлэн гэсэн үг. Бидэнд бас чөлөөт хүсэл гэж бий, битгий мартаарай! Бид үргэлжлүүлж ч болно, эсвэл больж ч болно. Үргэлжлүүлэх зам байгаа бол зогсоох арга зам ч байж л таарна. Энэ нь маш учир зүйтэй байна. Үгүй гэж үү? Та үргэлжлүүлмээр байвал, болно шүү дээ! Зогсоомоор байвал бас л болно!

***Асуулт 151:*** *Будда, Христ, Мухаммед, Кришна тэргүүтэн бүгд хүн төрөлхтөнд адилхан илгээлт өгч байсан гэж Та бодож байна уу?*

**Багш:** Тийм. Би Тэднийг бүгдийг нь мэднэ. Тийшээ аялахдаа бид хамт ажилладаг юм.

***Асуулт 152:*** *Бид аливаа амьд амьтныг хороож болохгүй гэж Та хэлсэн, тэгвэл ялаа, бөөс, эсвэл бидэнд үнэхээр өвчин халдаадаг ямарваа шавжийг алж болох уу?*

**Багш:** Тийм ээ болно, гэхдээ үүнийгээ заавал буцааж төлөх ёстой.

***А.153:*** *Бид хэрхэн Бурхантай аминчлан холбогдож харилцах вэ?*

**Багш:** Учир нь Бурхан бидний дотоодод бий. ***Та бие цогц биш, та бол Бурханы сүм, Ариун сүнс дотоодод чинь бий гэдгийг мэд.*** Бурхан бидэнтэй тун дотно. Тэр бидэнтэй биечлэн холбоотой байдаг. Хэрэв Тэр бидний дотор байдаг юм бол, бид Түүнийг биечлэн олж чадна.

***Асуулт 154:*** *Аугаа Цагаан ахан дүүсийн барилдлагатай Та ямар холбоотой вэ?*

**Багш:** Цагаан ахан дүүсийн барилдлага, ахан дүүгийн барилдлага, цагаан ахан дүүс үү? Би хэн нь цагаан, хэн нь харыг мэдэхгүй, бүгд л миний ах дүү. Хар, цагаан алин байхыг би тоохгүй. Бүгд миний ах дүү. Тэр цагааныг ойлгож байна. Би ямар нэг ялгаа гаргахгүй. Цагаан ахан дүүгийн барилдлага бол оюун санааны удам судар. Би ямарваа сайн сайхан бөгөөд хүмүүсийг гэтлэхүйд хүргэх зүйлстэй холбоотой.

***Асуулт 155:*** *Үхэх үедээ бид хаашаа явах вэ? Там байдаг гэдэгт Та итгэдэг үү?*

**Багш:** Одоогийн хийсэн үйлдэл болон хураасан үйлийн үрийн эрхээр бидний хаана очих тавилан зурагдсан байдаг. Тэр газар луугаа л явдаг. Авшиг хүртэж, Бурханы оршихуй, Бурханы хайранд орсон тэр хүмүүс харин Бурханы орон, Бурханы хаант улсад очно. Тийм ээ. Би тамд итгэдэг. Там байдаг. Заримдаа би хэцүүхэн шавь нараа болон зарим шавийнхаа төрөл төрөгсдийг аврахын тулд там руу явах ёстой болдог. Тамыг Бурхан бүтээгээгүй. Хүмүүс өөрийн хар, сөрөг, хайр үгүй хэлбэлзлэлээрээ үүнийг бүтээдэг. Там маш бодитой, энэ дэлхийн эмнэлэг шиг бодитой. Там бол сэтгэцийн өвчтэй хүмүүст зориулагдсан эмнэлэг. Бид хайр энэрэл, буян хишгээр дутагдаж байгаа нь сэтгэцийн өвчтэй байгаа хэрэг, тэгээд л эдгэрэхийн тулд тамд унах ёстой болдог юм.

***Асуулт 156:*** *Яаж гэгээрлийг олох вэ? Зайлшгүй алхмууд гэж бий юу?*

**Багш:** Гэгээрэлд хэрхэн хүрдэг вэ гэж үү? Нээлттэй зүрх сэтгэл, Бурханы хайр ивээлээр л хүрнэ. Бурханы ивээл адислал үргэлжид урсаж байдаг, харин бид түүнийг хүлээж авахын тулд сэтгэл зүрхээ нээлттэй байлгах учиртай. Бурханы адислал яг гэрэл цахилгаан шиг л хүний судсаар дамжин бидэнд ирдэг. Энэ дамжуулагч утсанд далд ороод бидэнд Гэрлийн хэлбэрээр, эсвэл өөр багажаар ирдэг.

Харин үүнд ямар нөхцөл эсвэл шаардлага тавигддаг вэ? гэвэл та гадаа буй авшгийн хуудсан дээрээс уншиж болно. Мөн цорын ганц үнэхээр хүнд шаардлага нь амь – хороогоогүй хоол хүнс хэрэглэх гэж байгаа, өөр юм үнэндээ байхгүй. Жишээ нь, садар самуун явж болохгүй. Үүнийг бүгд угаасаа мэднэ. Ганцхан эхнэр, ганц нөхөртэй байхад ч асуудал бэрхшээл хангалттайг бид мэдсээр байж өөр, дахиад хоёр дахин их зовлонг юунд хүсэх билээ. Арван сахил (Ten commandments) байдаг шиг л бүү амь тасал, бүү хулгай хий, бүү худал ярь, бүү садар самуун яв гэдэг. Бид үүнийг товчлоод ердөө таван сахил болгосон байгаа. Амь бүү хөнөө гэдэгт амь хороогоогүй хүнс хэрэглэх орно, энэ нь амьтнаас биш, харин ургамлын гаралтай бүхий л уурагтай хоол, сүү, бяслагийг өдөр тутмын хүнсэндээ хэрэглэнэ гэсэн үг. Тэгэхээр амь хороохгүй, мөн худал хэлэхгүй, хулгай хийхгүй, садар самуун явахгүй, архи, хар тамхи хэрэглэхгүй. Эдгээр нь таны л сайн сайхны төлөөх шаардлага болохоос биш, үнэндээ шаардлага сахил гэхээр юм биш. Тэд бол жинхэнэ сахил биш. Зөвхөн таны ариусалд туслах л зүйлс.

***Асуулт 157:*** *Бурхан бүгдтэй адилхан уу, эсвэл Өөрийгөө янз янзаар хувилгадаг аргатай юмуу, аль нь жинхэнэ Бурхан бэ гэдгийг бид яаж мэдэх вэ? Би энэ тухай дандаа бодож явдаг юм.*

**Багш:** Бурхан гэж хэлж байгаа нь бид Бурханы мөн чанар, Бурханы ариун сүнсийг ярьж буй юм. Тэр манай дэлхий дээр олон янзын хэлбэрээр бууж ирдэг. Буддагийн дүрээр, Есүс, Мухаммед, Кришна, Сократ, Платоны дүрээр ирсэн. Хэрвээ бид Бурханаас ирсэн жинхэнэ төлөөлөгч нь хэн болохыг лавтай мэдэхгүй байвал Бурханд залбирч болох юм. Эндхийн хамгийн ариун хийдийн нэр юу билээ? Тийшээ очоод Ариун Марияд мөргөж, дотоод хариултыг ав, эсвэл Есүст залбир. Мөн үү, биш үү гэдгийг түүнээс асуу. Та түүнтэй хамт зөв хариуг олж болно, Ариун Мариятай зөвлөлд.

***Асуулт 158:*** *Бид мөнхийн амьдралыг олох гэж энэ амьдралд ирсэн үү, эсвэл мөнхийн амьдралын ийм боломж олддоггүй бусад төрөлтөн байдаг юм уу? Мөнхийн амьдралд хүрэх эрхгүй төрөлтөн байдаг уу?*

**Багш:** Байхгүй. Бүгд мөнхийн амьдралд хүрэх эрхтэй. Харин энэ төрөлдөө юу, эсвэл дараа төрөл, дараа дараачийн төрлүүддээ юу гэдэг л байна. Энэ бол цаг хугацаа, бэлэн байдалтай холбоотой асуулт юм. Бид угаасаа мөнхийн амьдралд байгаа. Үүнийг бид мэдэх ёстой. Бид ердөө л хэлбэрээ өөрчилдөг. Бурханы оронд тухайн хэлбэр ер өөрчлөгддөггүй, тэгээд л тэр. Жишээлбэл, бид энэ дэлхийд хүн болж төрснөөрөө жаргалтай байна, харин үхэхлээр энэ хэлбэр маань шувуу, эсвэл тугал болсон байж магад. Тэгээд тэрэндээ бид баяртай байхгүй, эсвэл там гэгдэх газар очсон байж ч магад. Харин мөнхийн жаргалд хүрэх тэр мөчид бид Бурханы оронд үргэлж тэр хэвээрээ үлдэнэ. Бид өөрчлөгдөхгүй, дахин хэзээ ч зовохгүй. Мөнхийн өөрчлөлт энд бий, харин мөнхийн жаргал тэнд бий. Энэ л цорын ганц ялгаа.

***Асуулт 159:*** *Бурхан бидний дотор л байдаг юм уу?*

**Багш:** Бурхан бидний дотор л байдаг юм уу гэсэн үү? Тэр дотор ч байдаг, гадна ч байдаг. Тэр бидний ч дотор байна, бусад бүх зүйлд ч байна. Гэхдээ Есүс **"*Бурханы орон таны дотор оршдог.*"** гэж хэлсэн. Энэ нь Тэр үүнийг бидэнд хандаж хэлснээс болжээ. Тэр цэцэгт хандаж хэлвэл бас л ижилхэн хэлнэ - Бурханы Орон таны дотор бий гэж хэлнэ. Гахайд хандаж хэлбэл бас л адилхан зүйл хэлнэ. Харин тэр амьтад Түүнийг ойлгох хэмжээний хөгжилд хүрээгүй байхад тэдэнд юу гэж ингэж хэлэх билээ? Тиймээс л тэр үүнийг дурджээ, Тэр бидэнд хандаж л хэлсэн байна.

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт

## Коста Рика, Сан Хосе, Архитекторуудын Нийгэмлэг 1989 оны 6 дугаар сарын 9

***Асуулт 160:*** *Хүндэт Их Багш аа, дахиад олон төрөл авахгүйгээр зөвхөн энэ төрөлдөө биднийг гэгээрэлд хүрч чадна гэж Та бодож байна уу? Яаж тэр вэ?*

**Багш:** Тийм ээ. Та манай бүлэгт авшиг хүртсэн бол Би үүнийг амлаж чадна. Харин манай бүлгийнх биш бол Би хэлж мэдэхгүй байна. Би над дээр ирсэн хүмүүсээ л хариуцдаг. Над дээр ирээгүй байна гэдэг нь тэд бэлэн биш байна гэсэн үг.

***Асуулт 161:*** *Амьтны амь таслахгүй, тэднийг идэхгүй байх талаар би асуух гэсэн юм. Есүсийн үед Тэр далай тэнгист загасчилахад тусалдаг байжээ, миний бодлоор тэд ийм амьтдыг иддэг байсан. Бид далайн амьтдыг идэж болох уу?*

**Багш:** Энэ бол Библийн буруу тайлбар гэж бодож байна. Тийм ээ. Өчигдөр энэ талаар асуулт асуусан. Би энэ товхимолд бүрэн хариулчихсан байгаа. Сүүлд гарч очоод нэгийг аваарай. Би танд хурдхан хэлэхэд Есүс бол Эссений гэр бүлд төрсөн бөгөөд Эссений зан заншилд хүмүүс нь цагаан хоол иддэг. Та Есүсийн жинхэнэ амьдралын талаарх номыг олж унших хэрэгтэй; Библиэс биш шүү, Библиэс өөр номноос. Энэ ном Англи хэлээр гарсан, Испани хэлээр бас байдаг шиг санагдаж байна.

***Асуулт 162:*** *Түвдийн лам нар болон Таны хооронд тодорхой ялгаа бий юу?*

**Багш:** Тийм ээ, асар их ялгаа бий. Нэгдүгээрт, Би лам биш. Би загас, мах иддэггүй, мөн дарс уудаггүй. Бид тэдний бясалгадаггүй аргаар бясалгадаг. Тэд бол дүрслэл төсөөллийг бясалгадаг, маани мэгзэм болон нууц тарни уншдаг. Би ийм зүйл хийдэггүй. Би Бурхантай шууд холбоотой байдаг. Надад ямар ч маани хэрэггүй. Тэд бас хэнгэрэг, хонх, хөгжмийн зэмсэг мэтийн гадна талын дуу чимээ гаргадаг. Би бол дотоод дахь хөгжмийн зэмсгээ тоглодог. Асар их ялгаа нь энд л байна. Гэхдээ тэд над аятай сайхан санагддаг. Тэд сайн хүмүүс. Та нар над сайн хандсаар ирсэн шиг, тэд ч бас надад сайн хандсаар ирсэн.

***Асуулт 163:*** *Та Бурханы элч юм бол яагаад Библиэс зааж сургадаггүй юм бэ?*

**Багш:** Би Библийг хэрэглээгүй бил үү? Тэгсэн үү? Тийм ээ! Тэгэх ёстой юу, Би ингэх албатай юу? (Их Багш нэгэн ном барив.) Үгүй ээ, би үүнийг аль хэдийн цээжээрээ мэднэ. Би бол тэр Библи. Зүрх сэтгэл дотор минь Библи байж байдаг юм. Хэдэн

өдрийн өмнөөс, дөрвөн өдрийн өмнөөс л туж л Библиэс иш татлаа шүү дээ. Би Библиэс өөр юу ч ярьсангүй шүү дээ. Та номлогч яадгийг харсан биз дээ. Номлогч Библийн нэг хуудсыг уншаад, ахиад нэг хуудас эргүүлээд л уншдаг, тэгээд дахиад л ингэдэг биз дээ. За за. Би тэгж чадна шүү. Дараагийн удаа би Библийг аваад ирье. (Инээв) Тэгвэл бүр төгс болно биз. (Алга ташив.) Та өхөөрдөм юм.

***Асуулт 164:*** *Есүс идэх гэж далайгаас загас барьж байсан. Та түүнийг цагаан хоолтон байсан гэж хэлж яаж чадаж байна аа.*

**Багш:** Есүс идэх гэж далайгаас загас барьж байсан гэнэ ээ. Та тэгж бодоод байгаа юм уу? За, энэ бол буруу тайлбар гэдгийг би хэдийнээ хэлсэн. Нэгдүгээрт, Есүс хүүхэд байхаасаа цагаан хоолтон байсан. Хоёрдугаарт, Тэр арван есөн жилийн турш Энэтхэг, Түвд, Хималайн уулс болон Түвдийн хил рүү яваад алга болсон. Түүний уулзсан хүмүүс, йогчид, буддын шашны лам нар цөм Энэтхэгийн цагаан хоолтон. Хэрэв тэр хүүхэд байхаасаа цагаан хоолтон байгаагүй, тэр цагаан хоолтон байгаагүй байсан бол, арван найман жилийн турш цагаан хоолтнуудтай хамт амьдарсны дараа яаж... тэгсэн байж таарах вэ? Түүнийг хүүхэд байхаасаа цагаан хоолтон байсан гэж хэлсэнд маань та итгэх албагүй. Харин арван есөн жилийн турш цагаан хоолтон байсныхаа дараа та яаж буцаад мах идэж чадах юм бэ? Энэ чинь дадал болчихдог юм шүү дээ, тийм биз! Тийм ээ.

Хүмүүс аль хэдийн буруу хэвлээд гаргачихсан зүйлийг баталж, нотолно гэдэг их хэцүү. Тэд бүр миний номыг хүртэл буруу хэвлэчихдэг. Тийм! Сонин шүү, хүмүүс яахаараа бүр буруу сонсдог байна аа. Миний шавь, гэрээс гарсан шавь нарын нэг нь шавилаад хэдхэн долоо хоножь байсан юм, тэгсэн тэр хүмүүсээс яагаад Их Багш бэлгийн харилцааг сайн гэж хэлдэг юм болоо гэж асуугаад л байсан гэсэн. Би хэзээ ч тэгж хэлээгүй. Тэгтэл ийм асуулт, ийм хариулт мянгаараа л байна, энэ ердөө л нэг хэсэг нь (Их Багш баахан асуулт, хариултыг үзүүлэв), эдгээрийг бид шивэх боломжгүй тул гараар бичсэн. Би цээжээр хэлэхдээ нэг юм хэлдэг, тэд орчуулахдаа өөр болгочихдог, тэгээд цааш нь хуулж бичихдээ бүр өөр болгочихдог. Тиймээс өнөөдрийг хүртэл би тэр бүх асуулт, хариултыг өөрчилсөөр байгаад арай чүү амьд мэнд байна. Тийм байтал хоёр мянган жилийн өмнөх Есүсийг хэлэх юун. Есүсийн тухай хүмүүс ямраар сонсмоор байгаагаа л ярьдаг. Есүс бол амаа нээж чадахгүй болчихсон шүү дээ.

Бид хүмүүсийн хэлж ярьснаар бус учир зүйтэй байгаад нь л итгэх ёстой. Билиг ухаанаа ашигла. Жишээлбэл, би шулуухан хэлье, Библид ***Амь хорооj болохгүй***, Бурханд өргөл барихын төлөө амьтныг алж болохгүй гэж Бурхан хэлсэн байгаа. Тэгвэл одоо Есүс өөрөө Бурханы өгсөн сахилыг зөрчсөн хэрэг үү? Тэр ингэнэ гэж үү? Амь хороох байсан уу? Энэ чинь учир зүйгүй байгаа биз дээ. Гэхдээ би таныг буруутгахгүй, учир нь зарим Бурханы шашинтнууд бас Буддаг мах иддэг байсан гэж итгэдэг юм. Тийм шүү. Есүст бол бид итгэх л ёстой гэх байх даа, харин Будда бол Бярман байсан. Энэтхэгийн Бярманууд хэзээ ч мах иддэггүй. Бярман хувраг нар огт мах иддэггүй. Тэд энэ мэдээллийг хаанаас олж авсныг би мэдэхгүй юм. Гэвч тэд Будда мах иддэг байсан гэж ярьдаг.

Гэхдээ та миний номыг уншаарай. Би энэ буруу ойлголтыг нэг бүрчлэн тайлбарласан байгаа. Би таныг эсэргүүцэж байгаа юм биш. Би тэр буруу ойлголтыг л эсэргүүцэж, Есүсийн сүр жавхланг хамгаалах гэсэн юм. Тэр бол тэр чигтээ л хайр, энэрэл билээ. Тэр бас Бурханы сахил санваарuудыг ёсчлон биелүүлдэг байсан. Тэр иймэрхүү зүйл үйлдэж байгаагүй. Яагаад зарим Бурханы шашинтан надад дургүй байдгийг та одоо ойлголоо. Учир нь би үргэлж Есүсийг өмөөрдөг юм. Хүмүүс Есүсийг мах идэж байснаар хараад цаашаа эргэн бусдад Есүс сайн биш шүү гэж хэлэх дуртай. Харин Би түүнийг үргэлж өмөөрч өмгөөлдөг, тийм болохоор л тэд надад дургүй байдаг юм. (Инээв) Есүсийг сайн биш гэж хэлэх ямар ч шалтаг тэдэнд олддоггүй л дээ.

***Асуулт 165:*** *Арьяабалын бясалгалд хэлбэлзлэл нь гурав дахь нүд, боргоцой булчирхай, эсвэл өнчин тархины булчирхайг идэвхжүүлж, химийн ашигтай өөрчлөлтүүдийг өдөөдөг үү?*

**Багш:** Юуг бий болгодог гэнэ ээ? (Химийн өөрчлөлт. Энэ залуу химийг сонирхоод байгаа юм байна.) (Их Багш инээв.) Өө, Бурхан минь, та эрдэмтэн юм уу. Юу гэхээр тэр булчирхайнуудыг идэвхжүүлээд байдаг юм биш. Бид өөрсдийнхөө билиг ухаанаа сэргээж идэвхжүүлдэг юм. Энэрэл нигүүлсэл, хайраа нэмж тэтгэдэг юм. Дотоодын хүнээ идэвхжүүлдэг юм, машин дотор унтаж буй тэр жолооч нөхрийг сэрээдэг юм.

***Асуулт 166:*** *Ургамал хоолтон болоход энэрэн нигүүлсэхээс гадна өөр химийн шалтгаан байна уу?*

**Багш:** Ургамал хоол идэхэд энэрэн нигүүлсэхээс гадна өөр шалтгаан бий. Амьтанд амьтны ухамсар байдаг бөгөөд хэдийгээр тэр нь хүний ухамсрыг гүйцэхээр өндөр биш ч тэд хэрхэн амиа хайрлахыг мэддэг. Амьтад үзэн ядах, хайрлах, уурлах, айж эмээх зэргийг мэддэг. Тийм болохоор амьтны мах идэхдээ бид маханд болон амьтны махыг бүрхсэн хэлбэлзлэлд нэвчсэн айдас, уур, цөхрөл, үзэн ядалт зэргийг өөр лүүгээ авахаас өөр аргагүй болдог. Энэ нь биднийг амгалан тайван биш болгож, гэм буруугийн мэдрэмж төрүүлж байдаг. Заримдаа энэ нь бидний сэтгэцэд нөлөөлж, өвчлүүлж, эсвэл ядрааж, үлбэгэр болгодог. Ийм тогтворгүй, тайван бус байдалд гэгээрэлд хүрнэ гэдэг хэцүү.

Гэхдээ та нар амьтан өөрөө маш олон өвчнийг тээж явдгийг бүгд мэднэ шүү дээ. Ихэнх эмнэлэг ургамал хоолтнуудыг бус, мах идэгчдийг л асраад байж байдаг. Америк бол дэлхий дээрх хамгийн их мах иддэг улс орон бөгөөд хорт хавдрын түвшингээр дэлхийд тэргүүлж байна. Тиймээс бид бас эрүүл мэндээ бодоод ургамал хоолтон байх хэрэгтэй болж байгаа юм. Орос болон Хятадууд мах тэгтлээ их иддэггүй, учир нь амьжиргааны түвшин өндөр биш. Тэдний хувьд хорт хавдрын түвшин маш бага, хамгийн бага нь байдаг.

Бас танай оронд хүмүүс мах тун бага иддэг гэж би сонслоо. Танай оронд ирээд би их амар амгалан, жаргалтай байна. Тэгээд онгоцны буудал дээр хэзээ ч уулзаж байгаагүй хүмүүстэйгээ гар барьж, чихэр тараасан. Урьд орой бас л та нарын

заримыг тэвэрч, гар барьж, гарыг нь атгаж, их ойр дотно ярилцсан. Урьд нь хэзээ ч ингэж байгаагүй, Би Формоса (Тайвань)-д таван жил байсан, үүнийгээ та нарт хэлж болох уу? Эсвэл Америкт ч юмуу хаа нэгтээ. Энэ тус болдог юм аа! (Алга ташив.) Тайваньд байдаг шавь нар, зөвхөн шавь нар маань л төрсөн өдөр юмуу, ховорхон тохиолдолд л миний гарт хүрч болдог гэж би хэлэх гэсэн юм л даа. Гэхдээ цөөхөн хэд нь л тэгнэ, тэд бүгдээрээ надад гараа хүргэх боломжгүй. Гэтэл саяны байдал маш олон хүнийг гайхшруулчихлаа шүү дээ. Учир нь би урьд өмнө хэзээ ч ингэж байгаагүй, тэд миний биед хэзээ ч хүрч байсангүй. Тэгэхээр танай ард иргэд махыг тэгж их иддэггүй тул улс орон чинь сайхан хэлбэлзэлтэй байгаад баярлаарай. (Алга ташив.)

Би үнэн хэлж байна. Урьд нь би Формоса (Тайвань)-д хэзээ ч шавь нараа тэвэрч байгаагүй. Би Формоса (Тайвань)-д таван жил их алдартай байсаар ирсэн, бүр хувраг шавь маань хүртэл зөвхөн Есүсийн мэндэлсэн өдөр, Зул сарын баяраар л хөлд минь гараа хүргэдэг байлаа. Намайг өчнөөн олон жил дагасан шавь маань, гэрээс гарсан шавь нар надаас юу гуйдгийг мэдэх үү? Тэд миний хөлийг үнсэж, хэсэгхэн зуур барьж болох уу гэж гуйдаг. Тэдэнд надад гараа хүргэх боломж гарч байгаагүй.

Тэгэхлээр буурай хөгжилтэй, тэгж их мах иддэггүй байгаадаа баяртай байгаарай. Сайхан хэлбэлзлэлийнхээ үрээр та нар надад тун дотно санагдлаа. Болж байна. Баяр хүргэе. Танай оронд би гудамжинд болон энд бараг бүх хүнээс уян зөөлөн байдлыг мэдэрлээ. Мөн лекцийн үед та нартай байх их ойр дотно санагдсан, их тухтай байсан гэж би хэлмээр байна, та нар их амархан, хурдан ойлгож байгааг би мэдэрсэн. Формоса юмуу, зарим оронд би олон өдөр ярьсны дараа ч тэд ойлгодоггүй! Тайваньчууд мах их иддэг, мөнгөтэй улс.

***Асуулт 167:*** *Та яагаад шавь нараасаа зай барьдаг юм бэ?*

**Багш:** Учир нь би тэдэнд хүрэх дургүй байсан. (Инээв) Юу гэхээр, би ирээдүйд тэдэнд улам нээлттэй болно. Гэхдээ гол нь өчигдөр болсон явдлыг та нар хэвийн зүйл гэж бодсон байх, гэтэл та нарын сайн хэлбэлзлэлээс болоод энэ үнэхээр онцгой зүйл байсан. Тиймээс л би энэ түүхийг та нартай хуваалцсан юм. Ийм байдал Формоса (Тайвань)-д ердийн санагддаггүй байсан. Энд бол ердийн л байна. Энэ бол танай хүмүүсийн хэлбэлзлэлээс болж байгаа юм. Хэдий та нар авшиг хүртээгүй ч гэлээ надад тун дотно санагдаж байна. Үүнд баярлах хэрэгтэй гэж би хэлэх гэсэн юм. Түүнчлэн Формоса (Тайвань)-д ёс заншил нь өөр, хүмүүс нь ч ондоо. Энэ та нарт хамаагүй л дээ. Бурханд холбоогүй зүйл. За, үүнийг мартъя.

***Асуулт 168:*** *Би Формоса (Тайвань)-д тань дээр зочлоход юу хэрэгтэй вэ? Би Тантай цөөн хэдэн өдөр байж болох уу? Өнөөдөр би авшиг хүртмээр байна.*

**Багш:** Бололгүй яахав. Визний хугацаа чинь таарч л байгаа бол та миний амьдардаг ууланд хүссэн үедээ очиж, хүссэн хугацаагаараа байж болно, тэнд бүгд үнэ хөлсгүй, бас хайр үнэгүй шүү. Бидэнд байшин байхгүй тул та майхнаа аваад ирээрэй. Жижигхэн майхантай ирээрэй. Хэрэв танд байхгүй бол бид хангая, асуудалгүй.

Аяны хөнжлөө авч ирээрэй. Бидэнд урьдчилж мэдэгдээрэй, хэрэв гэртээ байж таарвал бид таныг очиж авна. Тэгвэл та замдаа төөрөхгүй, ЗА! Ийм л шаардлага тавина. Та миний хаягийг мэднэ.

***Асуулт 169:*** *Таны арга гэгээрэлд хүргэх цорын ганц арга мөн үү?*

**Багш:** Миний л мэдэж байгаагаар энэ бол ямар ч байсан хамгийн хурдан нь, хамгийн дээдэд нь хүргэдэг арга.

***Асуулт 170:*** *Заавал ургамал хоолтон болох шаардлагатай юу? Би ургамал ногоон хоолтон болоход бэлэн болоогүй байгаа ч Бурханд ойртохыг хичээсээр байж болох уу?*

**Багш:** Тийм ээ. Бурхантай ойртохын тулд та үргэлжлүүлэн залбирсаар байх ёстой. Лекцээс өмнө миний заасан тэр аргыг хэрэглэ,...тэгвэл зүгээр залбирах төдий биш, Бурханд илүү ойртох байх. Бурхан дотоодод байдаг юм шүү.

***Асуулт 171:*** *Яагаад энэ дэлхий дээр ийм их зовлон байна вэ, хувь хүн бид үүнд яаж хандах ёстой вэ?*

**Багш:** Энэ дэлхийн зовлонгийн өмнө бид бүгдээрээ хариуцлага хүлээдэг. Энэ бол бидний урьд хийсэн буруу үйлдэл, одоо хийж байгаа буруу үйлдэл, бас заримдаа энэ дэлхийд сөрөг уур амьсгалыг үүсгэгч сөрөг хэлбэлзэлээс бий болдог юм. Энэ нь цаашлаад бидэнд төдийгүй хүн төрөлхтөнд бүхэлд нь нөлөөлдөг. Их, бага ямар нэгэн хэмжээгээр хүн бүр үүнд хариуцлага үүрнэ. Тиймээс л Есүс бидэнд дахин төрөх, гэмгүй цэвэр ариун хүүхэд байх ёстой гэж хэлсэн. Тэгснээр бид Бурханы оронд нэвтэрч болно.

***Асуулт 172:*** *Авшиг хүртсэний дараа би яаж үргэлжлүүлэн өсөж дэвших вэ?*

**Багш:** Авшгийн үед би чамд хэлж өгнө. Ийм л учраас авшгийн үйл ажиллагаа удаан, олон цагаар үргэлжилдэг юм. Түүнээс биш гэгээрэл тун хурдан ирдэг.

***Асуулт 173:*** *Хувь төөрөг гэж байна уу? Энэ нь оршдог юм уу? Миний амьдрал аль хэдийн зурагдчихсан уу?*

**Багш:** Тийм ээ. Хувь төөрөг гэж бий. Бидний амьдрал аль хэдийн зурагдчихсан. Бид энэ амьдралаа тэгж их өөрчилж чадахгүй ч ирээдүйн амьдралаа өөрчлөхийг хүсдэг. Яагаад бидний амьдрал зурагдчихсан байдаг юм бэ? Энэ нь бидний урд төрөлдөө хийсэн үйлдлүүд, үйлдлүүдийн үр дүнгээс болсон хэрэг. Гэхдээ ирээдүй нээлттэй хэвээрээ байгаа. Тиймээс Арьяабалын бясалгалын арга нь танд ирээдүйтэй үүсгэсэн холбоосыг хэрхэн үгүй хийхийг заадаг юм. Тэгснээр та эрх чөлөөтэй болж, Бурханы орон дахь Гэртээ буцна. Тийм ээ, би танд үйлийн үр болон ирээдүйн муу үр нөлөөнөөс зайлсхийж, үйл үрийг хэрхэн таслах, ирээдүйд боловсрох үйлийн үр тарилгүйгээр амьдрахыг заана. Түүнээс гадна Арьяабалын арга болон Их Багшийн хүч таныг ирээдүйд дахин буцаж ирэхгүй болгохын тулд энэ төрөлдөө гаргах алдааг чинь угааж цэвэрлэх болно.

***Асуулт 174:** Бясалгаж байхдаа хэрхэн Бурханаас бусад зүйл рүү сэтгэлээ хандуулахгүй байх вэ? Бясалгалын турш хэрхэн сэтгэлдээ бусад юмыг биш, зөвхөн Бурханы тухай л боддог болох вэ?*

**Багш:** Би үүнийг мөн л авшгийн үеэр тайлбарлана. Би танд хэрэгтэй бүх зүйлийг зохицуулна. Би танд зөвхөн Бурханы хүчийг дамжуулаад зогсохгүй, бас танд хэрэгтэй материаллаг мэдээллийг өгнө. Бусад хүн ч бас чадахын хэрээр Бурхан дээр төвлөрөхийг хичээ. Бурханыг мартах бүртээ өөртөө Түүнийг дахин сануулж, хурдхан буцаж бай.

***Асуулт 175:** Таны энэ аргын тухай бичсэн номыг уншсанаараа би авшиг хүртчихсэн байж болох уу? Ердөө энэ ном зохиолоор л болох уу?*

**Багш:** Захидал харилцаагаар уу? Болохгүй ээ. Бид хараахан захидлаар харилцдаг болоогүй байна. (Инээв) Гэхдээ захидал харилцаа гэж байхаар та яагаад өнөө орой авшиг хүртэж болдоггүй юм бэ? Энэ аргыг хүний хэлээр ярьдаг юм биш. Үүнийг танд дамжуулахад бид хоёр хоёулаа чимээгүй байдаг. Хүний хэлээр бус, Бурханы ивээлээр, Их багшийн хүчээр үүнийг хүртдэг юм. Хүний хэлийг би зөвхөн үүнийг танилцуулахад л хэрэглэдэг. Яг л би чихрийн тухай ярьж байгаатай адил. Миний яриа чихэр биш шүү дээ. Би чихэр зураад түүнийгээ та нарт чихэр гэж хэлбэл энэ нь зөв үү? Цаасан дээрээс чихэр амтагдах уу? Үгүй, энэ бол ердөө л чихрийн зураг шүү дээ.

***Асуулт 176:** Гэгээрсэнээ яаж мэдэх вэ? Бид яаж мэдэх вэ?*

**Багш:** Бид мэднэ ээ. Гэгээрсэн гэдэг бол та Гэрэл харна гэсэн үг. Гэгээрсэн гэдэг чинь та өөрөө Гэрэл дотор байна гэсэн үг. Таны дотоодын Гэрэл гэрэлтэж, тэгснээрээ та тэр Гэрлийг харна. Библид ингэж хэлсэн байдаг, ***Эхэндээ үг байсан, үг нь өөрөө Бурхан.*** Тэгэхээр та дотоодын үгээ сонсож байгаа бол энэ нь та Бурхантай холбогдожээ гэсэн үг. Гэгээрэхээрээ та Бурханы үгийг сонсоно.

***Асуулт 177:** Есүс үхэх үедээ яагаад махан биеэ тэгж тамлуулахыг зөвшөөрсөн юм бэ?*

**Багш:** Бурханы таалал байсан учраас тэр. Бурхан түүнд шавь нарынхаа нүглийг угаахын тулд ингэж зов гэж тушаасан, тухайн үед түүнд аврал одуулж байсан тэр шавь нар нь ингэж байж л жинхэнэ нүгэл хилэнцээсээ салж, Гэрээ зорин Бурханы оронд очиж болох байжээ. Ганцхан Есүс ч биш, Бурханы илгээсэн аль ч Их Багш шавиа болгосон хүн бүрийн нүгэл хилэнцийн төлөө зовох ёстой байдаг. Хэрвээ та олон Гэгээнтэн, Их багшийн амьдралын түүхийг уншаад үзвэл тэд бүгдээрээ аймшигтай үхэж, эсвэл амьдралынхаа туршид ихэд мөрдөж мөшгүүлэн зовсон байдаг. Зовдоггүй Гэгээнтэн гэж нэг ч байхгүй.

Тийм ч болохоор заримдаа бид зовлон биднийг Бурхантай ойртуулдаг гэдэгт итгэхэд хүрдэг. Гэвч хэдийнээ Бурханы дотор байх, түүнтэй холбогдсон байхыг эс тооцвол зовлон дан ганцаараа биднийг Бурханд ойр болгодоггүй. Бурхан биднийг

бусдын төлөө, өөрсдийн маань төлөө зовоодог. Хэрэв зовлон Бурханд ойр аваачдаг байсан бол тамд байгаа бүхэн аль хэдийн Гэртээ харьчихсан, Бурхантай хамт байж байх байсан. Тамд байгаа хүмүүс биднээс илүү зовж байгаа юм чинь нүд ирмэхийн зуур Бурхан дээр оччихмоор доо. Харин энэ зовлон бол Бурханы тааллаар болсон зовлон, ялгаа нь энэ юм. За! Есүсээс өмнө ч, хойно ч олон хүн загалмайд цовдлуулж байсан. Гэвч ийм замаар тэд Бурханд хүрэхгүй. Бид Бурхантай холбогдчих үед зовлон бүхэн, бас жаргал бүхэн Бурханы таалаар болдог. Тэгээд бүх зүйл биднийг Бурхан луу аваачдаг, бүр аз жаргал ч гэсэн.

***Асуулт 178:*** *Та сая зөвхөн Есүсийн үхлийн тухай ярьлаа. Та Түүнийг дахин амилаад диваажинд очиж, тэгээд диваажингаасаа биднийг хамгаалж чадаж байсан гэдэгт итгэдэг үү?*

**Багш:** Тийм ээ, би итгэдэг. Тэр загалмай дээр үхээгүй. Тэр Энэтхэгт зуун хорин настай байхдаа нас барсан.  Кашмир гэдэг газар Есүсийн болон түүний хамгийн дотны шавь нарын нэгний булш байсаар байгаа. Та тэнд зочилж болно. Гадаа нь түүний нэрийг Араб хэлээр “Jesustaphus”, мөн амьдралынх нь түүхийг бичсэн байдаг юм.  Тэр Энэтхэг рүү зугтаж очоод зуун хорин нас хүртлээ Кашмирын хүмүүст зааж сургасан. Есүс хүссэн үедээ үхэж, хүссэн үедээ амилж, мөн махан биеийн ямар ч өвчнийг мэдрэхгүй байх зэрэг йогийн олон аргад суралцсан. Тэгэхлээр Тэр үхсэн, тэр нь зүгээр л худлаа үхэл байдаг. Тэр бас йогийн хүчээрээ дахин амилсан. Бас нисэж сурсан. Түвдийн Мял богд бас нисч чаддаг байсан. Өнөө үед ч зарим хүн бас нисэж чадна. (Алга ташив.) Баярлалаа. Би Есүсийн булшин дээр очиж, Түүний булшинд мөргөж, өргөлийн хайрцагт нь жаахан мөнгө хийсэн. Тэгээд Түүнийг дурсаж, Түүнтэй хамт бясалгасан. Дэндүү орой болж, хүмүүс намайг хөөж гаргах хүртэл суусан, тэд хаалгаа барихыг хүссэн юм.

***Асуулт 179:*** *Есүс Израильд нас барсан атал яагаад Израильчууд бүгдээрээ Түүнд итгээгүй юм бэ? Итгэдэг хүмүүс нь Түүний шавь нар л байсан.*

**Багш:** Тийм ээ, үүнд шалтгаан бий. Учир нь Еврейчүүдийн Библид их олон мянган жилийн дараа л Аврагч (Messiah) ирнэ гэж буруу орчуулсан байдаг юм. Тэгээд Еврейчүүд тэр Аврагч нь ирнэ гэж хүлээсээр байгаа юм. Хичнээн олон Аврагч ирж буцчихаад байна вэ, би Бурханы элчүүдийг хэлж байна? Хичнээн олон сүнс Бурханы орон луугаа буцаж явчихаад байгаа билээ. Гэтэл Жүүдүүд тэр Аврагчаа хүлээсэн хэвээр л байна. Хүн төрөлхтний энэ мунхаглалыг тэгээд бид яах вэ? Яаж ч чадахгүй гэж би таамаглаж байна.

Ийм бардам, мунхаг болохоор бид яг л өөртэй минь адилхан, нэг хамартай, хоёр нүдтэй, хоёр чихтэй хүн Гэгээнтэн болчихсон байгаад итгэнэ гэдэг бидэнд хэцүү байдаг. Яаж итгэх юм? Тэр эмэгтэй яг л над шиг харагддаг! Тэр иддэг, бас унтдаг байж яагаад Гэгээнтэн болчихов оо? Би итгэж чадахгүй юм байна. Тийм ээ, энэ л бидний мунхаглал, бардамнал. Хүний хэлбэрт байгаа Бурханыг шүтнэ гэдэг хэцүү. Тэрхүү хүний хэлбэр нь дотооддоо Бурханы хүчийг агуулж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх нь бидэнд бэрх байна. Гэтэл Бурхан хэлэхдээ та нарт Бурханы орон бий, та нар бол Бурханы сүм, Бурхан та нарын дотор амьдардаг гэээд байдаг!

Бид үүнийг хичнээн олон удаа уншсан атлаа, бас хичнээн олон удаа ойлгохгүй байна вэ?

Лекц эхлэхийн өмнө би энд анх ирээд та бүгдийг харахад нулимс минь бөмбөрөх гээд л байлаа. Яагаад гэдгийг мэдэх үү? Би энд маш олон Бурханыг харсан юм. Би зүгээр л та нараас барьж, хөлд чинь мөргөж, хайрлахыг хүссэн юм. Учир нь та нар бол Бурхан. (Алга ташив.) Бурхантай уулзаж буйдаа би тун ч их баярласан. Гэвч хэдхэн хормын дараа надад гуниг төрсөн. Яагаад өөрийнхөө дотор байгаа Бурханыг хардаггүй юм бэ гэж бодсон! Яагаад миний мэдэж байгаа шиг та нар өөрсдийгөө Бурхан гэж мэддэггүй юм бэ гэж бодоод гунигласан.

Ердөө л мунхаглал, ариун бус амьдрал, зүй ёсны бус амьдрал, буруу сэтгэлгээгээ орхичих, тэгээд л та бид Бурханыг харна. Ийм л энгийн. Яг л би нүүрээ нэг юмаар бүтээчихээд та нарыг харахгүй байгаатай адил. Харин түүнийгээ хуулаад авчих юм бол харна. Их амархан. Бид юмаар хучуулчихсан. Мунхаг харанхуй, нүгэл хилэнц, буруу бодлын гивлүүрээр бид Бурханаа хучиж далдалсан байна. Тэр гивлүүрийг л угаачихвал, хуулаад хаячихвал л бид Бурханыг харна. Авшгийн үед тэр гивлүүрийг хуулж хаяхад би тусална. Тэгээд л та Бурханыг харж, Бурханыг сонсож болно. Энэ их энгийн. Өөр асуулт байна уу?

***Асуулт 180:*** *Сэтгэл мэдрэлийн асуудалтай, жишээлбэл маш гүн гүнзгий гутралд орсон хүнд үүнийг зөвлөж болох уу? Ийм хүмүүст бясалгалыг зөвлөж болдог уу?*

**Багш:** Тиймээ, болно. Бясалгал таныг баяр хөөртэй, аз жаргалтай болгоно. Бурханыг харахгүй, Түүний хайраас тусгаарлагдсан учраас та гутарч байгаа хэрэг. Түүнтэй нэгэнт холбогдож, оршин байгааг нь, бас хайрыг нь мэдэрсэн цагт гуньж гутрахаа болино. Бид бүгд л сэтгэл гутардаг. Зарим нь арай их, зарим нь арай бага. Бид Бурханаас тусгаарлагдаж, Түүнтэй уулзахыг хүсэн мөрөөддөг учраас тэр шүү дээ. Тиймээс бид хичнээн их мөнгөтэй, сайхан эхнэртэй, сайхан нөхөртэй байлаа ч энэ дэлхийд яагаад ч юм үргэлж жаргалтай байж хэзээ ч чаддаггүй. Ямар нэгэн байдлаар үргэлж л нэг юм болж өгөхгүй, ямар нэгэн юм дутагдаад байх шиг санагддаг. Бас заримдаа ямар нэг юмыг буруу хийчихдэг нь мөн л ингэчихвэл жаргалтай болох болов уу гэсэн горьдлогоос болдог. Гэтэл энэ нь Бидэнд Бурханы хайр дутагдаж байгаагаас болдог. Авшиг хүртээд Бурхантай холбогддог болсон цагаас эхлэн бид дахиж буруу юм хийдэггүй. Сахил, зарчмуудыг ч дагаж мөрдөхөд улам хялбар болдог. Бурханы дэмжлэгийг шууд авч байдаг тул бидэнд дайснаа хайрлах ч хамаагүй хялбар болдог.

Танд баярлалаа! Бурханыг дурсан санаарай.

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт

## Бразил улс, Сан-Паулу хот, Японы Соёлын Нийгэмлэг
## 1989 оны 6 дугаар сарын 15

***Асуулт 181:*** *Тэнгэрлэг Гэрэл болон Аялгуу хоорондоо ямар харилцаатай вэ?*

**Багш:** Гэрэл нь бидэнд Бурханы орон луу буцаж явах замыг үзүүлдэг, Аялгуу нь таныг дээш татдаг. Энэ нь машины гэрэлтүүлэг болон хөдөлгүүр хоёртой адил; гэрэл нь танд замыг үзүүлдэг, хөдөлгүүр нь таныг замаар явуулдаг. Энэ асуултыг тавьсан хүн энэ талаар аль хэдийн ямарваа дотоод ахуй ойлголт авсан хүн байна даа. Та Гэрэл болон Аялгуугаар бясалгадаг уу? Аан? Их Багш тань хэн бэ? Та хэлмээр байна уу? Энэтхэг их багш уу? Нэрийг нь мэдэхгүй юу?

***Асуулт 182:*** *Маш олон шашны зүгээс зарлаж мэдэгдээд байгаа дэлхийн төгсгөлийн талаар Та юу гэж боддог вэ?*

**Багш:** Би юу ч гэж боддоггүй!

***Асуулт:*** *Энэ үнэн үү? Төгсгөл бидэн рүү ойртоод байгаа юм биш үү?*

**Багш:** Дэлхийн төгсгөл гэнэ ээ? Тийм ээ, тун ойрхон байгаа. Та хэр ойрхон байгааг мэдмээр байна уу? Таван минутын дараа, эсвэл маргааш ч байж болох юм. Таны энэ дэлхийг орхих, амьдралаа эцэслэх тэр мөч бол дэлхийн төгсгөл. Та өөрийнхөө дэлхийг төгсгөчихсөн байхад энэ дэлхий оршоод ямар нэмэр байна? Тэгэхээр дэлхийн төгсгөл гэж миний нэрлэдэг зүйл бол энэ. Бид үүнд л санаа тавих хэрэгтэй. Би танд дэлхийг хэрхэн төгсгөхгүй байх талаар хэлж болох юм. Би дэлхийн төгсгөлд санаа зовохгүй байна. Надад дэлхийг төгсгөхгүй байх арга бий. Би үүнийг тийм их ноцтой бус, харин хөгжилтэй хошин болгохыг хичээнэ. Ойлгож байна уу, учир нь бидний хүн бүр л нэг их удалгүй өөрийнхөө дэлхийг төгсгөхөөс хойш бидэнд юуны ялгаа байна гэж. Манай дэлхий сөнөсөн ч, сөнөөгүй ч, эсвэл хичнээн олон дэлхий сөнөх байлаа ч бидэнд ямар ч ялгаагүй. Дотоод дахь Бурханы орноо сэрээснээр бид үүрд мөнхийнөөр амьдрах болно, Бурханы оронд амьдрах болно.

***Асуулт 183:*** *Дараа жил, эсвэл магадгүй ирэх арван жилд дэлхийд энх тайван ирнэ гэж та итгэдэг үү? Танд баярлалаа!*

**Багш:** Тийм ээ, бид бүгдээрээ өөрийн амар амгаланг олчихвол, дэлхий бас амар амгалан болно гэж би итгэдэг. Тэр нь биднээс эхлэг! Амар амгаланг олох арга нь дотооддоо амар амгаланг дадуулах, Арьяабалын аргаар бясалгах буюу

диваажингийн Гэрэл, диваажингийн Хэлбэлзэл дээр төвлөрөн дадуулах, мөн өдөр тутамдаа амь үл хөнөөх, хулгай хийхгүй байх, худал ярихгүй байх, садар самуун явахгүй байх, согтууруулах ундаа уухгүй байх, хар тамхи хэрэглэхгүй байх зэрэг үйлдлээрээ асрал хайрыг дадуулах юм. Эдгээр нь дэлхийн энх тайванд хувь нэмрээ оруулна. Амь хөнөөхгүй байна гэдэг нь та бас ургамал хоол идэх ёстой гэсэн үг. Учир нь Бурхан Арван зарлигтаа ***Хүний амийг бүү хороо*** гэж биш, харин ***Амь бүү хороо*** гэж л айлдсан. Хороох буюу алах гэдэг нь амийг нь тасална гэсэн үг. Тэгэхээр амьтай юу ч бай, түүний амийг нь тасалбал аллага болно.

Өнөөдөр машин дотор Амазончуудын тухай нэгэн сонирхолтой түүх сонслоо. Амазонд хүн алж иддэг зарим нэг овог байсаар байгаа гэж нэг хүн надад хэллээ. Юу гэж хэлмээр юм бэ дээ, адал явдал хайгч олон хүн тийшээ очоод хэзээ ч буцаж ирээгүй. Зарим бултаж зугтан ирсэн нэг нь энэ түүхийг ярьсан. Би айсандаа хөшчихсөн. Юу гэхээр тэр мөчид алуулж байсан хүмүүсийн айдас надад мэдрэгдсэн. Тэгээд би хамт байсан хүндээ “өдрийн хоол болохоор алуулах гэж буйгаа мэднэ гэдэг аймшгийн мэдрэмж байдаг байх даа” гэж хэлсэн. Харин тэр, “Тэгэлгүй яахав, тийм! Аймшигтай байж таарна. Тэгж алуулах чинь шууд буудуулахтай адил хурдан байхгүй, харин ч бүр удаан байх. Хэрчүүлээд л!” гэсэн. Тэндхийн хүмүүс хохирогчоо мэдэрдэггүй болохоор алуулж байгаа хүнд ямар байдгийг бодож үзэх дадал огт байдаггүй. Алж идэх нь тэдний зуршил. Зөвхөн хохирогч нь л үхтлээ айдаг байж таарна, аймшигтай байж таарна!

Тэгэхээр нь би “Энэ нь хүмүүс амьтныг алж иддэгтэй яг адилхан” гэж хэлсэн. Амьтан юу мэдрэхийг хүмүүс бодолцож үзэхээ больсон. Бидний хэлээр ярьж чадахгүй, өөрийгөө өмөөрч чадахгүй тэдгээр амьтанд бас л аймшигтай байж таараа шүү дээ. Хэрвээ бид байраа сольчихвол амьтанд ямар байдгийг мэдэрч болно. Өөрийгөө оронд нь тавиад үз, тэр Амазон явсан тэр адал явдал хайгчдын оронд тавиад үз. Тэр овгийн хүмүүст баригдаад хэдэн хэсэг хэрчүүлэх чинь айдас хүйдэстэй явдал болно.

Тийм болохоор Библид ***Амь бүү хөнөө*** гэж хэлсэн юм. Будда бас ***Амь бүү хөнөө*** гэж онцолж хэлсэн. Аливаа шашны хамгийн эхний сахил нь ***Амь бүү хороо*** юм. Гэвч бид амь хороох нь шууд ба шууд бус гэсэн хоёр талтай гэдгийг харахаа мартчихсан аж. Хэрвээ бид амьтдыг идэхгүй бол хэн ч тэднийг алж, зарахгүй. Тэгэхээр амь хороохгүй байна гэдэг нь бас ургамал хоолтон байх гэсэн үг. Бид бүгдээрээ ургамлын хоол идвэл энх тайвны талаар ярих шаардлагагүйгээр дэлхий маань амар амгалан болно. Дэлхий амар амгалан болно, энхжин болно. Учир нь амар амгалан нь хүн төрөлтөн төдийгүй, бас амьтдын төлөө байх учиртай. Хүн амьтан хоёул энэ дэлхий дээр ижил тэгш эрхтэй оршин суугчид. Хүн бий болмогц амьтан бий болсон. Тэгэхлээр хүн, амьтан бид чинь хөршүүд. Амар амгалан ирэх л ёстой юм бол тэрхүү амар амгалан нь дан ганц хүмүүст биш, бүгдэд зориулагдсан байх ёстой. Учир нь амьтад ч бас өдөр бүр амар амгаланг хүсэн уйлж байна. Хэрэв бидэнд Бурханы дотоод чих байдаг бол тэдний уйлж буйг сонсож, хэл яриаг нь ойлгохсон. Яриа минь бүр хадуурчихлаа.

***Асуулт 184:*** *Ургамал ногоо ч гэсэн амьтай. Тэгвэл идүүлэх нь тэдэнд ямар байдаг бол?*

**Багш:** Тэд бас амьтай, гэхдээ ухамсар нь тун доогуур. Тэд арай чүү л мэдэрдэг. Тэгэхээр үнэндээ бол ургамал ногоог идэхэд бид бас “үйлийн үр” гэгдэх зүйлийг хураана. “Үйлийн үр” гэдэг нь ***Юу тарина, түүнийгээ хураана*** гэсэн үг. Та амь хороосон бол өөрөө хороолгоно гэсэн үг. Хэн нэгнийг зодсон бол дараа нь өөрөө зодуулна гэсэн үг. Үүнийг “үйлийн үр” гэдэг юм.

Ургамал идэхэд бас л үйлийн үр хураана. Гэхдээ энэ нь тун бага “үйлийн үр”, маш бага. Өдөр бүр хоёроос гурван цаг бясалгаад байвал бид үүнийгээ угаачихна. Хэрэв Бурханыг бясалгахгүй бол энэ өчүүхэн үйлийн үрээ ч угаахад хэцүү болно. Тийм ч учраас Бурханы Диваажинг, дотоодын Бурханы Оронг бясалгах нь зайлшгүй чухал. Учир нь бид ургамал ногоог идэхээсээ ч өмнө хэдийнээ амь хороочихсон байдаг. Бид амьсгалж, явж, гараа угааж байдаг нь бүгд л аллага юм.

Тэгэхээр ургамал ногооны хоол идвэл нүгэл хилэнцээс чөлөөлөгдөнө гэсэн үг биш ээ. Бүр юу ч идэхгүй байхдаа ч бид нүгэл үйлддэг. Бид урд төрлийн үйлийн үрээсээ нүгэлтнүүд. Үүнийг Библид “Төрөлхийн нүгэл” гэдэг. Бид амьсгал авахдаа ч нүгэл хийдэг, нүдэнд үзэгдэхгүй олон шавжийг хөнөөдөг. Бид биеэ, хувцсаа угааж, халдваргүйжүүлэхдээ нүгэл хураах байдаг, газар дээр, өвс ногоон дээр алхаж явлаа гээд хаана ч явсан олон шавж хорхойг, маш олон үл үзэгдэх шавж хорхойг хөнөөдөг. Иймээс дотоод дахь хамгийн аугаа хүчийг ашиглан бүгдийг угааж ариусгахгүй л юм бол бидэнд зугтах ямар ч арга байхгүй. Үүнийг л бид Бурханы ивээл гээд байгаа юм. Өдөр болгон байшингаа цэвэрлэхээрээ бид Бурханы ивээлийг авч болдог. Үүнгүйгээр Бурханы орон луугаа буцаж очих боломж бараг л байхгүй. Та нартай хуваалцахыг хүссэн зүйл маань энэ юм. Зайлж зугтах аргагүй тэр нүглүүдээс өөрийгөө өдөр бүр цэвэрлэх тэр аргыг хуваалцах гээд байгаа юм.

***Асуулт 185:*** *Оюун санааны мөнх амьдрал оршдогийг би яаж мэдрэх вэ? Өөр амьдралууд байдаг болон байх болно гэдэгт би яаж итгэх вэ?*

**Багш:** Бидэнд мэдрэх шаардлага байхгүй. Бид өөрөө амсаж үзэх ёстой. Хэрхэн ийм туршлагыг амсаж үзэхийг та нарт үзүүлэх арга нь над байна; миний хэлсэнд, мөн Будда болон Есүсийн хэлсэнд итгэх шаардлагагүй. Бид үүнийг өөрөө мэдэх, үзэх, дотооддоо ухаарах ёстой юм. Тийм ч учраас маш олон Диваажин, там, бүхий л буян, нүглийг дүрсэлсэн шашны олон судар ном байдаг юм. Гэвч хүмүүс тэр судруудад өгүүлсэн зүйлд итгэдэггүй, бас там, диваажингийн тухай өөрийн туршлага олоогүй учраас муу үйл хийсээр л байдаг. Тийм учраас энэ нь сэтгэлд нь ч гүн гүнзгий тусдаггүй. Тиймээс тэдэнд зовлон бэрхшээл тарих, буруу үйл хийхээс зайлж зугтаахад бэрх байдаг юм.

***Асуулт 186:*** *Африкийн өлсгөлөнг та юу гэж тайлбарлах вэ? Та тэндэхийн улаан загалмайд ажиллаж байсан уу? Ийм асуудлуудыг та хэрхэн тайлбарлах вэ?*

**Багш:** Үгүй ээ. Би Африкт ажиллаж байгаагүй. Африкт өлсгөлөн байнга нүүрлэж байна. Африкийн хаа нэгтээ, зарим алслагдсан бүсэд жийп машин ч хүрч чаддаггүй, тэдний байгаа байршлыг тогтоох ч бэрхшээлтэй. Заримдаа тэр нутаг шавартай, намаг балчигаар дүүрсэн байдаг. Тийшээ алхаж орох ч боломжгүй. Түүнийг гатлах гэвэл шавар намагт шигдэж үхнэ. Тиймээс хүмүүс ихэнхдээ нисдэг тэрэг хэрэглэдэг. Гэвч нисдэг тэргээр тун бага хүнс аваачиж чадах тул хүмүүс нь өлбөрч, гаднаас хангамжийн зүйл дотогш нь хүргэж чаддаггүй. Тийм учраас тэнд өлбөрч буй хүмүүст улаан загалмай, эсвэл өөр ямар ч загалмай бай, туслахад хэцүү байдаг юм. Африк бол аварга том тив, нэн буурай хөгжилтэй, зам тээвэр хангалттай бус. Би Улаан загалмайд ажиллаж байсан, гэхдээ Германд. Би дүрвэгсдийн хөтөлбөрт орчуулагчаар ажилладаг байсан юм. Мэдээж энэ тал дээр маш олон бэрхшээл байдаг.

***Асуулт 187:*** *Бид үйлийн үрээ солилцож болдог уу? Хүнд үйлийн үртэй төрсөн хүн хөнгөн үйлийн үртэй хүнтэй түүнийгээ солилцож болдог уу?*

**Багш:** Бололгүй яахав. Та тэрийг бүгдийг нь цэвэрлэж болно. Гэвч хөнгөн үйлийн үртэй байлаа ч та эрх чөлөөгүй хэвээрээ. Тэгэхээр та бүгдийг нь цэвэрлэвэл илүү дээр. Би тэгж чадна. Энэ бол миний ажил. Гэхдээ та зарим зааварчилгааг дагах ёстой бөгөөд бид хамтран ажиллах ёстой. Та хог новшиндоо шигдээд байлгүй байшинг чинь цэвэрлэх боломжийг надад өгөх ёстой.

***Асуулт 188:*** *Үхэх үед бидний сүнс энэ гарагийн агаар мандалд үлддэг үү эсвэл өөр гараг руу явдаг уу?*

**Багш:** Тэр нь та энэ төрөлдөө юу хийснээс хамаарна. Хэрвээ та буянтай амьдарсан бол өөрөөр хэлбэл та хайрын сэтгэл, эд баялаг, ажил үйлсээрээ чадахын дээдээр бусдад өглөг өгч, үйлчилж байсан бол нас барахаараа Диваажинд очно, гэхдээ том биш, жижигхэн диваажин. Хамгийн аугаа, эцсийн, хамгийн дээд Диваажинд буцаж очихын тулд бид Бурханы байгааг мэдэж, өөрийн дотоодод Гэрэл, Аялгууг бясалгах ёстой. Харин ёс суртахуунгүй, бусдыг зовоож, сэтгэл муутай, хайрладаггүй байсан бол бид үхэхээрээ тамд очно. Хэрвээ адгуус амьтан лугаа адил зан авиртай байсан бол дараа төрөлдөө бүр амьтны хувцас өмсөхөөс аргагүй болно; хүний зан авир, сайхан сэтгэлийг мэдэхийн тулд амьтны амьдралыг амсаж үзэх хэрэгтэй болно гэсэн үг.

***Асуулт 189:*** *Их Багшийн зааварчилгаагүйгээр, өөрөөр хэлбэл дотоод ертөнцөд ажиллахгүйгээр гэгээрэлд хүрэх боломжтой юу?*

**Багш:** Байж болох л юм! Гэхдээ тун бага хэмжээнд боломжтой, хамгийн дээдэд нь хүрэхгүй, мөн бие болон сэтгэцийн олон аюулд байнга өртөнө гэсэн үг. Тийм ч учраас ганцаараа бясалгасан хүн сул дорой, эсвэл сэтгэцийн өвчтэй, үгүй бол муу сүнсэнд эзлэгддэг юм. Иймэрхүү юмыг бид сонсож байсан. Хэрвээ Их Багштай байвал ийм зүйл тохиолдохгүй. Гэхдээ тэр Их Багш нь төгс төгөлдөр, жинхэнэ, чадвар төгс, хамгийн дээд зорилгод хүрсэн, хаа сайгүй оршигч, өөрөөр хэлбэл нэг,

бас өөр олон газар, нэгэн зэрэг бүхий л орчлон даяар оршин байж чаддаг, асуухгүйгээр асуудал зовлонг мэддэг, таныг мэдэхээс урьтаад тусалж чаддаг нэгэн байх ёстой. Тэгвэл та аюулгүй байдалд байгаа хэрэг.

***Асуулт 190:*** *Үнэндээ Бурхан гэж хэн юм бэ? Бурханы биологийн бүтэц ямар вэ?*

**Багш:** Бурхан гэж хэн бэ гэнэ ээ? Та! Та! Бидний мөн чанар хоёр талтай, нэг нь физик, нөгөө нь супер физик. Би үүнд тохирох үгийг олж чадахгүй байна. Гэхдээ би үүнийг супер физик, сүнс гэж хэлэх хэрэгтэй; нэг нь физикийн, нөгөө нь сүнс. Сүнс гэдэг нь таны бие дотор унтаж байгаа Бурхан юм. Тэр унтаж буй сүнсийг сэрээвэл та Бурхан болно. ***Би Эцэгтэйгээ нэгэн цогц*** гэж Есүсийн хэлсэнтэй адил. Тэгээд бид бүхий л орчлон ертөнцтэй нэг болно. Тэгж бид Луузын дүрсэлсэн “Wan Wuh Tong I Ti” буюу “Бүх ертөнц нэгэн эх сурвалжтай, энэ орчлонгийн бүх юм нэгэн цогц” гэдэг нь болно. Ингэж бид Диваажин дахь Бурхан, Диваажин дахь Эцэг шигээ төгс төгөлдөр болно. Тэр цагт бид хэлэхдээ, хүмүүс хэлэхдээ өөрийгөө Будда, эсвэл Бурхан гэх болно.

Ийм үе шатанд хүрэх нь биднээс хичээнгүй, тогтмол бясалгал шаардана. Энэ нь яг л нялх хүүхэд шиг. Тэр өдөр бүр бага багаар хооллох ёстой, гэхдээ өдөр бүр хооллох ёстой; тэгж л хүүхэд өсөж торнисоор насанд хүрнэ. Тэрээр бүгдийг нэг дор идээд нэг шөнийн дотор том хүн болж чадахгүй. Ингэвэл тэр үхэж мэднэ, тэгэхээр бага багаар, өдөр болгон идэх ёстой. Есүс болон Будда шиг бүрэн гэгээрч, аугаа болохын тулд бид өдөр бүр Бурханы хоолыг идэх ёстой. Тэгж байж дотоодын маань хүн, дотоодын Бурхан маань гүйцэд сэрж, бүрэн өсч том болох юм. Тэгээд бид Бурхан болдог. Бид энэ дэлхий дээр алхаж, идэж, унтаж бусдыг хайрлаж, хүмүүстэй харилцдаг Бурхан болно. Гаднаасаа бол бид өөрчлөгдөхгүй. Бид зөвхөн ухамсар, билиг ухаан, амьдрах арга байдал болон амьдралыг үзэх үзлээ өөрчилнө.

***Асуулт 191:*** *Яагаад бид эв түнжингүй байдал, зовлон бэрхшээлээр дүүрсэн цаг үед амьдарч байгаа юм бэ? Хүн төрөлхтний ирээдүй ямар байх вэ?*

**Багш:** Яагаад ийм цаг үед амьдарч байгаа юм бэ гэж үү? Учир нь бид энэ цагт амьдрахыг сонгосон, урьд төрөлдөө амьдрах арга замаа засаж залруулаагүй. Гэхдээ бид өнөөдрөөс эхлээд засч болно, ингэснээр ийм эв түнжингүй дэлхий дээр цаашид амьдрах шаардлагагүй болно. Оройтоогүй байна, дэлхий хараахан сөнөчихөөгүй байна. Хэрвээ та дэлхийн төгсгөл ирнэ гэж итгэдэг бол өнөөдрөөс эхлэн яаравчлан зас, үүнээс зугт. Над арга зам нь байна. Би танд үзүүлнэ. Авшгийн үед яаж зугтахыг би танд харуулна. Бид Бурханы Хаант Улс руу зугтах болно. Бидэнд энэ байшин, бие цогцоо нүүлгэх шаардлага байхгүй. Бид метафизик аргаар зовлонг орхин нүүнэ, ингэх нь илүү аюулгүй, хурдан. Аль ч агшинд бид нүүж болно. Би танд харуулна!

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт
## Бразил улс, Сан-Паулу хот, Японы Соёлын Нийгэмлэг
## 1989 оны 6 дугаар сарын 16

***Асуулт 192:*** *Хамгийн эхэнд ургамал үүсээд дараа нь амьтан бий болсон. Тэд тус тусдаа үржиж томорчээ. Ирээдүйд нэгэн өдөр бид буцаад ургамал, амьтантай нэгэн цогц болно гэдэгт та итгэдэг үү?*

**Багш:** Үгүй,үгүй! Бид анх ирсэн газар болох Бурханы орон луугаа буцахаар дээшээ явах нь бидний чиг хандлага юм. Тийм ээ, бид дээшээ явдаг ч заримдаа буцаад уначихдаг. Магадгүй ахиад нэг, хоёр, гурав, дөрвөн төрөлдөө амьтан болж төрөх гэж тэгдэг байх. Гэвч хэсэг хугацааны дараа бид буцаад л дээшээ явна. Ургамлын амьдралтай дахин нэгдэнэ гэх юм байхгүй. Яахав, ахархан хугацаагаар л гэхээс тэр үе шат руу үүрд мөнх буцаж орно гэх юм байхгүй. Энэ нь яг л толгод өөд мацаж байгаад заримдаа хөл алдаад, хэсэг зуур доошоо өнхрөхтэй адил. Гэлээ ч дахиад л дээшээ авирдаг, учир нь бид оргилд нь хүрэхийг хүсдэг юм.

***Асуулт 193:*** *Бясалгаж, мөн ургамал хоолтон байхаас гадна өөр ямар таван зарчим сахих ёстойг би мэдмээр байна.*

**Багш:** Сахил уу, энэ амархан. Ердөө л Арван гэрээс шиг л юм, гэхдээ арай товчхон, хураангуй. Хамгийн түрүүнд та амь тасалж болохгүй, тийм учраас ургамал хоол иддэг. Бид ургамал ногооны хоол идэх учраас бусад хэн ч амь таслахгүй. Хоёрдугаарт, худлаа ярьж болохгүй. Гуравдугаарт, хулгай хийж болохгүй, харин өг. Энэ нь юу гэсэн үг вэ? Амь таслахгүй, харин амьдрахад нь тусална. Худлаа ярихгүй, харин үргэлж үнэн өгүүлнэ, бусдад Үнэн ёсыг номлоно. Тийм. Хулгай хийхгүй, харин өглөг буян түгээнэ. Тийм. Садар самуун явахгүй, харин нэг эхнэр, эсвэл нэг нөхөртэй байна. Эсвэл гэлэнмаа юмуу гэлэн болно. (Их Багш инээв.) Түүнд энэ ч таалагдахгүй л дээ. Үүнийг мартацгаая. Нэг эхнэр хангалттай. Нэг эр, эсвэл нэг эхнэр, энэ л сайн. Тавдугаарт, архи уухгүй, мөрийтэй тоглохгүй, хар тамхи хэрэглэхгүй, хөөрхийлөлтэй эмэгтэйчүүдийн төрлийн кино үзэхгүй байх. Хөөрхийлөлтэй эмэгтэй гэдэг нь хувцас өмсөөгүй гэсэн үг, тэд худалдаж авах чадалгүй. Таван сахил гэдэг энэ л юм. Болж байна уу? Бид орчуулгыг нь сонсох ёстой болохоор инээх хэцүү. Тийм шүү, тийм бишсэн бол бид чанга хөхрөлдөнө л дөө.

***Асуулт 194:*** *Португали хэлээр Таны нэр юу гэсэн утгатай вэ?*

**Багш:** Португалиар миний нэрийг “Чин Хай” гэдэг. Та хэлж чадах нь уу? Чин Хай гэдэг нь ариун далай гэсэн үг. Ариун далай, тунгалаг далай тэнгис. Тэгэхээр Португалиар үүнийг юу гэдэг вэ? Би мэдмээр байна. (Хөтлөгч: “Мар Пуро”) Мар Пуро, миний нэр Мар Пуро. (Их Багш инээв.)

***Асуулт 195:*** *Сэтгэл доторх аминч үзлээсээ яаж салах вэ?*

**Багш:** Бага багаар, Арьяабалын аргаар бясалгаж сална. Арьяабалын аргаар бясалгал дадуулах гэдэг нь бид Бурханы хүчтэй холбогдоно гэсэн үг. Зөвхөн Бурханы хүч л бидэнд аль ч тал дээр тусалж чадна. Бурханы хүч бидэнд тэсвэр тэвчээр, аминч бус үзэл, билиг ухаан, хайр энэрэл гээд хэрэгтэй бүхнийг маань өгнө. Бидэнд хангалттай их хайр байхгүйн улмаас амиа бодоод байгаа юм. Бид хайрыг маш их хүсэмжилж байдаг. Хэн ч намайг хайрлахгүй байна, энэ хангалтгүй байна гэж бидэнд санагддаг, тэгээд л бид сандарч, өөрийгөө илүү хайрлахыг оролддог. Бид ийм маягаар өөрийгөө хайрласнаар дутагдсан хайраа нөхөхийг хичээдэг.

Энэ аргаар бясалгаад эхлэнгүүт бид Бурхантай хамт болдог. Бидэнд Их Багшаараа, номын ах эгч нараараа, Бурханаар хайрлуулж байгаа нь мэдрэгддэг. Тэгээд л бид амиа бодохоо больдог. Энэ нь таныг аяндаа л орхино. Авшиг хүртсэний дараа бид Бурханы хүчтэй нэвтрэлцсэн байдаг, ингээд Бурханаар хайрлуулж буйгаа мэдэрдэг. Дотоодод сэтгэл маань хангалуун, бүрэн дүүрэн болдог. Бас Их Багшийн хайрыг ч мэдэрнэ. Бид бясалгагч ах, эгч нарынхаа эв нэгдлийг мэдрээд ирэхээрээ маш аюулгүй болсноо мэдэрч, цаашид амиа бодох шаардлагагүй болно. Аминч зан биднийг өөрөө, аяндаа л орхидог. Тийм ээ. Нэг хоногийн дотор биш ч гэлээ тун удалгүй ингэнэ.

Аминч зан бол хайрын нэг хэлбэр. Өөрийгөө хайрлаж буй хэрэг. Бусад нь биш юм гэхэд та өөрийгөө хайрлаж байна. Та үүнээсээ суралцах ёстой. Өөрийгөө хайрлаж мэддэг хүн л бусдыг хайрлаж мэддэг юм. Өөрийгөө хэрхэн халамжилж мэдэхгүй, хэрхэн тав тухтай байх, тав тухаа хангахыг сураагүй хүн бусдыг мөн тийм байлгаж хэрхэн чадах билээ. Тэгэхээр энэ бол хожим буюу хайрыг өөрөөсөө өрөөл бусад руу тэлэх үед их ач тустай байх нэгэн төрлийн хичээл сургамж юм.

***Асуулт 196:*** *Нохойд Их Багшийн хайр байж болох уу?*

**Багш:** Тэгэлгүй яахав. Яагаад байхгүй гэж? Нохой заримдаа хүнээс ч илүү хайрын сэтгэлтэй байдаг. Заримдаа нохойг хайрлах нь хүнийг хайрлахаас илүү амар байдаг.

***Асуулт 197:*** *Яаж марихуан, тамхи татахаа болих вэ?*

**Багш:** Эхлээд түүнийг орхих хүчтэй шийдвэр гаргах хэрэгтэй. Хүсэл тэмүүлэл байвал арга зам нь байдаг. Таныг чин сэтгэлтэй байвал Их Багш тусална. Марихуан чинь гашишийн нэг төрөл үү? Гашиш, яг зөөлөн гашиш шиг. L.S.D шиг хүчтэй биш, тийм үү? (Хөтлөгч: “хүч багатай. Өвс юм. Түүнийг татахаар солиордог.) Хөөрхийлөлтэй юм аа. Та түүнийг хаяхад суралцах ёстой. Бохь зажлах, чихэр,

шоколад идэх зэрэг өөр төрлийн орлуулга хэрэглэ. Хүссэн зүйлээрээ өөртөө тусал, хар тамхиар л биш шүү. Танд тусална гэж итгэсэн тэр хүндээ залбир. Хүчтэй, чин сэтгэлээсээ залбир, тэгвэл тусыг нь хүртэнэ.

***Асуулт 198:*** *Библи дээрх Бурханы үгийг судалж, мөн тэдгээрийг хэрхэн зөв тайлан тайлбарлахыг мэдсэнээр Их Багш болох боломж бий юу?*

**Багш:** Библийг судалснаар Их Багш болж болох уу гэсэн утгаар тэр асуугаад байна уу? Уучлаарай. Үгүй! Есүсийг төрөхөөс өмнө ямар ч Библи байгаагүй ч Тэр Их Багш болсон. Буддаг төрөхөөс өмнө ямар ч Буддын судар ном байгаагүй, гэтэл Тэр бас Их Багш болсон. Гэтэл одоо бидэнд үнэгүй тарааж байгаа өчнөөн олон Буддын судар бичгүүд байна, их том юм. Католик шашны Библийг үнэгүй тарааж байна. Гэтэл хэн ч Их Багш болохгүй л байна шүү дээ. Ном биднийг гэгээрсэн Их Багш болгож чадахгүй. Бид Гэгээрсэн Их Багштай хамт суралцвал л Их Багш болж чадна.

Эмч болохыг хүсч байгаа бол та эмч нараас суралц. Ном унших нь тустай боловч тэнд ямар ч практик дадлага байхгүй. Харин ур чадвар нь батлагдсан туршлагатай докторуудын зааварчилгаан дор дадлага хийж байж л тариа хийж сурах ёстой. Анагаахын эмч доктор. Туршлагатай эмчийн удирдлагаар л маш олон удаа хийж байж судас барьж сурах ёстой. Та хүний ходоодыг хэр урт, хэр гүн тайрахыг сурах ёстой. Туршлагатай мэс засалчийн хянамгай хараан доор үүнийг хийх ёстой. Номоос уншаад л үүнийг хийчихэж чадахгүй. Хэрэв тэгвэл та өвчтөнөө үхүүлж, өөрөө шоронд ороход хүрнэ.

***Асуулт 199:*** *Бясалгал гэж юу вэ?*

**Багш:** Бясалгал олон янз байдаг. Зарим бясалгал эрүүл мэндэд сайн, зарим нь сэтгэл санаанд сайн, зарим нь оюун ухаанд сайн, зарим нь мөнгө олоход тустай, та гайхаж байна уу? Зарим нь мөнгө олоход тустай. Ажил дээрээ төвлөрвөл бизнес чинь сайн явах учраас тэр. Эрчимтэй төвлөрөл бол бясалгал юм. Тэгэхээр бид бүгдээрээ өдөр бүр бясалгадаг. Зарим нь эхнэрийнхээ тухай бодож бясалгана, зарим сайхан бүсгүйг бясалгана, зарим нь мөнгө бясалгана, зарим нь бизнесээ бясалгана. Манайхан бол Бурханыг бясалгана. Түүнийг бясалгахаас өмнө би танд Бурханыг үзүүлнэ. Энэ нь хөөрхөн охиныг, эсвэл эхнэрээ бясалгахаасаа өмнө та түүнийгээ харсан байх ёстойтой адилхан. Тэгэхээр надаас ямар бясалгалыг нь сурмаар байна вэ? Мөнгөнийхийг нь үү, тийм үү? Тийм ээ тийм, бүх хүн л тийм гэж хэлнэ. (Их Багш инээв.) Бизнесийнхийг үү? За тийм, Эрүүл мэндийн үү? Бурханы юу? (Их Багш ба хүмүүс инээлдэв.) Та надад юу хүсч байгаагаа хэл. Би зааж өгч болох юм.

***Асуулт 200:*** *Ад чөтгөр, Сатана байдаг гэдэгт та итгэдэг үү? Та үүнийг яаж тайлбарлах вэ?*

**Багш:** Би итгэдэг. Сатана, чөтгөрүүд байдаг гэдэгт би итгэдэг. Чөтгөртэй болох амархан. Бидний муу бодол, муу үйл, муу хариу үйлдэл, амьдралын сөрөг арга маяг нь чөтгөрүүдийг бий болгодог. Гадаа хэн нэгэн нь хүн алж харагдвал, та чөтгөрийг

харж байгаа юм. Хэн нэгэн бусдын эд хөрөнгө, эсвэл эхнэр юмуу, аль нэг зүйлийг завшихаар хуурч мэхэлж буй бол тэр чөтгөр. Тэгэхээр энэ дэлхийн аливаа зовлон, чөтгөрдүү, аймшигтай бүх зүйл угтаа хүний хариу үйлдэл, буруу бодлоос үүдэлтэй. Энэ нь нэгэн төрлийн уур амьсгал болтлоо нягтран хатуурч, цааш үргэлжилдэг, үйлдэл болон хариу үйлдэл нь энэ уур амьсгал арчигдаж, эсвэл эрч чадлаа алдах хүртэл үргэлжилдэг. Тэр цагт л чөтгөр үгүй болдог.

Гэтэл хүн төрөлхтөн ийм уур амьсгалыг бүтээсээр байгаа учраас чөтгөр биднээс огт салахгүй байгаа юм. Сайн хүч гарч ирэн нэг газрыг цэвэрлэтэл, тэр нөгөө газар нь эхэлдэг. Өнөөдөр нэг чөтгөрийн уур амьсгалыг цэвэрлэж арилгатал маргааш өөр нэг нь эхэлчихдэг. Бурханы хүч буюу асрал хайр, тэвчээр, амьдрах болон амьдруулах хүч, энх тайвны хүч л Чөтгөрийг сөрж чадна. Тийм учраас бид энэ дэлхийд ямагт үүсч байдаг чөтгөрийн хүчийг дарахын тулд сайн сайхан хийгээд Бурхан дээр бясалгах ёстой юм. Сайн хүч огт байхгүй байвал дэлхийд зөвхөн чөтгөрийн хүч л оршино. Тэгвэл энэ дэлхий там болно. Там бол сайн хүч оршихгүй байгаа тэр газар. Цэвэрлэх үйл явц байхгүй газар юм. Зөвхөн чөтгөр, чөтгөр, чөтгөр, цаг үргэлж чөтгөр.

***Асуулт 201:*** *Гэгээрэхээрээ бид гэнэтийн өөрчлөлт болон энэ мэт хүнд зүйл зэрэг жинхэнэ асуудлуудыг шийдэхдээ илүү сайн болж чаддаг болох уу?*

**Багш:** Тэгэлгүй яахав. Тийм ээ, гэгээрэл тодорхой үр нөлөө өгнө. Бид илүү сайн, амар тайван амьдарч чаддаг болно. Бидний бодол санаа улам саруул тунгалаг болдог тул асуудал бэрхшээлийг улам сайн шийдвэрлэдэг болно.

***Асуулт 202:*** *Авшиг гэж юу вэ?*

**Багш:** Таныг өөрийн тань Бурханы хүчтэй дахин холбохыг авшиг гэнэ. Дотоодод тань буй Бурханы хүчтэй холбож, буцааж холбох буюу Бурхан чанарт тань (дотоод Мөн чанар) буцаан аваачина. Ингэж хэлж болно. Яг л цахилгаанчин шиг. Гэрлийн утас, чийдэн нь байвч ямар ч гэрэл байхгүй тэр үед цахилгаанчин хооронд нь холбоход гэрэл гаргадаг шиг л юм. Тэрээр гэрлийг цахилгаан үүсгүүртэй холбосон учраас гэрэл гарч байгаа юм.

***Асуулт 203:*** *Авшгийг  хэрхэн хүртэх вэ?*

**Багш:** Католик шашинд үүнийг баптизм гэж нэрлэдэг, харин Буддын шашинд аврал одуулах гэж ярьдаг. Бурханы авралд орох, Бурханд итгэж түших гэсэн үг. Библид Есүсийг Баптист Жон усаар адислахад тэр Диваажингийн Гэрлийг харсан гэж бичсэн байдаг. Диваажингийн цагаан Гэрэл шувуу адил доош бууж ирсэн гэдэг. Энэ бол нэгэн төрлийн авшиг. Энэ бол авшиг. Та Гэрэл харвал гэгээрч байгаа юм; энэ чинь авшиг. Уснаас болоод ингэж байгаа юм биш. Баптист Жоны хүчээр ийм зүйл болжээ. Тийм бишсэн бол бид өдөр болгон л усанд ордог ч гэгээрдэггүй биз дээ.

Харин Их Багшид үргэлж ус хэрэглээд байх шаардлага үгүй.Тэр цэцэг, лаа, гал ашиглаж чадна, эсвэл бүр юу ч ашиглахгүй байсан ч болно. Үүнд зөвхөн Ариун

сүнс л хэрэгтэй. Тийм ч учраас Баптист Жон, ***Намайг усаар адислах үед бүү эргэлз, миний дараа ирэх надаас хүчтэй тэр нэгэн харин Ариун Сүнсээр адислах болно*** гэжээ. Тэр Ариун Сүнс нь нүдэнд үзэгдэхгүй. Та түүнийг барьж чадахгүй, атгаж чадахгүй, гагцхүү түүнтэй байж л чадна. Авшгийн үед анир чимээгүйд та түүнийг хүлээн авна. Их Багш ярихгүй, тантай гар барихгүй, иймэрхүү зүйл хийх хэрэг байхгүй. (Их Багш тэргүүндээ гараа хүргэв.) Ингэх нь тустай л даа, гэхдээ зайлшгүй шаардлагатай биш, учир нь Их Багш танд гараа хүргэх үед урсгал нь илүү хүчтэй байх нь эргэлзээгүй. Гэхдээ танд авшиг хүртээж, Баптист Жоны өгч байсан шиг Бурханы Гэрлийг өгөхийн тулд Их Багшид ингэх хэрэг огт байхгүй.

***Асуулт 204:*** *Яагаад бид эрэгтэй, эмэгтэй хүн болж төрдөг юм бэ?*

**Багш:** Яагаад бид эрэгтэй, эмэгтэй хүн болж төрдөг вэ гэж үү? Учир нь бид ийм байх дуртай. Эрчүүд бүгд л эмэгтэйчүүдэд дуртай. Бас эмэгтэйчүүд бүгд л эрчүүдэд дуртай. Ийм л учраас эрэгтэй, эмэгтэй хүмүүс байгаа юм. Энэ нь бидний хүслийг хангахын төлөө юм. Та эрэгтэй, эмэгтэй хүнийг цаашид хүсэхээ больсон цагт л эрэгтэй, эмэгтэй хүний ялгаа байдаггүй тийм газар төрөх болно. Бурханы Оронд эрэгтэй, эмэгтэй хүн байдаггүй. Буддын шашны судар номд Баруун зүгийн диваажинд Амитава Буддад (гэгээрсэн оршихуй) ямар ч эрэгтэй, эмэгтэй хүн байдаггүй гэж бичсэн байдаг. Харин бид энэ байдалдаа баяртай байдаг.

Энэ төвшинд бид үүнийг төсөөлж чадахгүй л дээ. Ямар ч эрэгтэй, эмэгтэй хүн байхгүй гэдэг чинь уйтгартай байна байх. Үгүй ээ, тийм биш ээ. Би та нарт энэ тухай хэлддэггүй л байж. Үгүй юу? Та нарт тийшээ явах хүсэл төрөхөө больчихож магадгүй. Гэр лүүгээ буцахыг хүссэн хэвээрээ байна уу? Ямар ч эрэгтэй, эмэгтэй хүн байхгүй, зүгээр үү? Бидэнд өөр төрлийн аз жаргал байгаа. Өөр төрлийн аз жаргалыг мэдэхгүй байгаа учраас л бид эрэгтэй, эмэгтэй хоёр хүн хамтдаа л аз жаргалтай байна гэж боддог юм. Тийм биш ээ, үүнээс чинь хэдэн мянга дахин илүү аз жаргал бий.

Энэ нь нярай хүүхэд сүүнээс дээр юм байдаг гэж бодож чаддаггүйтэй ижил. Харин өсч том болохоороо бид илүү сайхан, амттай өөр юмстай болдог. Бид юмыг өөрөөр харж, амьдралыг өөр янзаар мэдэрч жаргадаг. Тэгэхээр гэгээрнэ гэдэг нь сүнслэгээр өснө гэсэн үг. Бид илүү томоор, илүү холын зайг харж чадна. Илүү олон зүйлийг ч мэднэ. Огт өөр төрлийн аз жаргалд умбана.

***Асуулт 205:*** *ДОХ өвчний талаар та юу гэж боддог вэ?*

**Багш:** Би энэ талаар юу бодох хэрэгтэй вэ? Би энэ талаар ер боддоггүй, гэвч та нэгэнт надаас асууснаас хойш би бодож үзэх хэрэгтэй боллоо. Энэ өвчин бидэнд болон залуу үед маань муу гэж би бодож байна. Энэ бол биднийг эрхэм ариун амьдрал руугаа буцаж ор гэсэн Бурханы анхааруулга юм. Бид сахилуудыг хүндлэх ёстой. Бид гэгээрэх ёстой. Бид энэ махан бие болон материаллаг эд баялгийн зугаа цэнгэлд живэхийн оронд Бурханы адис хүчинд итгэх ёстой. Та санал нийлж байна уу, тийм үү?

***Асуулт 206:*** *Дэлхийд таван тэрбум хүн байна. Бид бүгдээрээ Гэртээ харьж, нэгэн өдөр аврагдах болов уу?*

**Багш:** Гэртээ харьж, нэг л өдөр аврагдах болов уу гэсэн үү? Маш их цаг хугацаа орно, урт хугацаа хэрэгтэй. Бурханы элчийг хэн ч сонсохгүй байна. Маш цөөхөн хүн л сонсож байна гэх гэсэн юм л даа. Тун цөөн хүн Гэртээ харихыг хүсдэг. Хүмүүс энэ материаллаг дэлхий болон энэ хий хуурмагийн аз жаргалд сэтгэл хүлэгджээ. Үүнээс өөр юм байдаг гэдэгт хүмүүс итгэдэггүй.

***Асуулт 207:*** *Хүн төрөлхтөнд ямар найдвар байна вэ?*

**Багш:** Гэгээрэл, энэ Арга. Бурхан луу буцаж очих, дахин нэгдэх, энэ л бидний ганц найдвар. Бидэнд байгаа цорын ганц найдвар энэ л юм.

***Асуулт 208:*** *Есүс гэгээрсэн хэрнээ загас идэж байсан. Их багш болохын тулд заавал мах идэхгүй байх ёстой юу?*

**Багш:** Зайлшгүй шаардлагатай. Есүс хэзээ ч загас идэж байгаагүй. Олон хүн Библийг буруу ойлгодог. Есүс төрсөн цагаасаа эхлээд цагаан хоолтон байсан, Тэр бүр эхийн хэвлийд байсан шүү дээ. Та Есүсийн амьдралыг илүү сайн судлах хэрэгтэй; Библиэс биш, өөр ондоо номоос. Есүсийн гаргаж ирээд хүмүүст өгсөн загас нь ногоогоор хийсэн загас байсан. Формоса (Тайвань)-д маш олон төрлийн веган буюу ногоогоор хийсэн мах байдаг. Бид ногоогоор тахиа хийдэг, веган тахиа. Түүнийгээ “Чун су ши” гэдэг. Бас ногоогоор хиам, веган үхрийн мах, веган загас хийж байна. Тэр веган загас нь жинхэнэ загастай их төстэй харагддаг бөгөөд амт нь ч төстэй. Бидэнд бүх төрлийн “Нию”, “Көү Нию” бий. “Көү Нию” нь борцолж хатаасан үхрийн мах гэсэн утгатай. Тэгээд намайг шавь нартаа борцолж хатаасан мах өгч байхыг үхрийн мах гэж битгий бодоорой. Хатаасан үхрийн мах шиг веган үхрийн мах юм шүү. Энэ бол ургамал ногооны хоолны нэр шүү.

Есүс цагаан хоолтны гэр бүлд төрсөн. Цагаан хоолтны уламжлалтай Эссэйн гэр бүлд төрсөн. Тэд Есүсийг төрөхөөс ч өмнө хэдэн мянган жил цагаан хоолтон байсан. Та нар Есүсийн амьдралыг номоос судалж болно. Яг л та нар Энэтхэгийн брахман гэр бүлд төрсөн бол хар аяндаа л цагаан хоолтон болно. Тэд Буддаг төрөхөөс ч өмнө хэдэн мянган жил цагаан хоолтон байсан. Гэхдээ энэ юу ч биш. Буддистууд хүртэл Буддаг мах иддэг байсан гэж боддог. Түүний иддэг байсан мөөгийг энэтхэг хэлээр гахайн шийр гэдэг. Тэгээд хүмүүс Будда гахайн шийр идээд үхсэн гэж ярьдаг.

Мөн Энэтхэгт маш олон төрлийн чихэрлэг бөмбөлөг байдаг. Том жижиг чихэрлэг бөмбөлөгүүд. Тэд үүнийгээ чихэрлэг мах гэж нэрлэдэг. Тэгэхээр та нар намайг Энэтхэгт очоод өдөр болгон мах идсэн гэж бодож байна уу? Тийм ээ, би чихэрлэг мах идсэн. Чихэртэй мах гэдэг нь чихэр юм. Чихэрлэг зүйл байдаг. Энэтхэгт мах иднэ гэж үүнийг л хэлдэг. Цаг үргэлж л маш их буруу ойлголтууд байсаар байх юм даа. Ялангуяа Их Багш махан биеэ орхин өөд болсны дараа буруу ойлголт бүр ч их болдог.

***Асуулт 209:*** *Хар тамхи хүн төрөлхтний сүнслэг талыг устгадаг байх боломжтой юу?*

**Багш:** Тийм ээ. Та үргэлжлүүлээд хэрэглээд байвал тэгнэ. Одоо л зогсоохгүй бол тэгнэ. Залуу үеийнхэн маань энэхүү хор хөнөөлтэй хар тамхийг амтлаад эхэлчихсэн, уруудаж доройтоод эхэлчихсэн байна. Бид оюун ухаанаа сөнөөж байна. Сүнсний хөгжилд оюун ухаан зайлшгүй чухал. Сүнсний хөгжилд нэн чухал үүрэг гүйцэтгэх тархины мэдрэмтгий эд эсээ бид үгүй хийж байна.

***Асуулт:*** *Ийм тохиолдолд гэгээрэхэд илүү хэцүү юу?*

**Багш:** Тийм ээ, гэхдээ оройтсон ч огт оролдоогүйгээс л дээр. Өнөөдрөөс эхэл. Өмнө хар тамхи хэрэглэдэг байсан хэдэн хүнд би авшиг хүртээсэн. Нэг эрэгтэй надад хар тамхиа хаяна гэж амласан. Гэвч авшиг хүртээх үед түүний гэгээрэл бусдынхтай адил аугаа байгаагүй, тэр зовж байсан.

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт

## Бразил улс, Сан-Паулу хот, Японы Соёлын нийгэмлэг
## 1989 оны 6 дугаар сарын 17

***Асуулт 210:*** *Их Багш аа, Та дотоодын Хүчний тухай дурьдаж байсан. Энэ тухай дэлгэрэнгүй ярьж өгөхсөн болов уу. Дотоод хүчээ хөгжүүлэхийн тулд зайлшгүй хэрэгтэй ямар төрлийн бясалгал байдаг вэ?*

**Багш:** Миний дурдаж байсан тэр арга бол Арьяабалын арга. Энэ бол дотоодын тэр хүч, Бурханы хүч, Христийн хүчийг хөгжүүлэх хамгийн сайн, хамгийн аюулгүй арга юм. Гуан Инь гэдэг нь Бурханы аялгуу буюу Бурханы үгэн дээр бясалгах гэсэн үг юм. Бурханы аялгуу буюу Бурханы үг гэдэг нь Бурхан өөрөө юм. Тиймээс Бурханы энэ Үгтэй холбогдох үедээ бид Бурхантай холбогдож байдаг. Энэ нь дотоодын Хэлбэлзэл, дотоодын Хөгжим болохоос биш, гадна талд байдаг зүйл биш. Үүнийг Библид "Үг" гэж нэрлэдэг. ***Анх эхлээд л Үг байсан, энэ Үг нь Бурхантай хамт байсан, энэ Үг нь Бурхан байсан.***

Хэрэв бид энэ Үгийг мэдэж авч, энэ Үгтэй холбогдчихвол, бид Бурхантай хамт байдаг, бас Бурхан бидний төлөө бүгдийг зохицуулах болно. Өөрөө хэлбэл, бид Бурханы хүчтэй болж, бүгдийг илүү сайнаар хайрлаж харгалзаж чаддаг болно. Учир нь бид "Би"-г, Би-үзлээ хаяж, хязгааргүй бурханлаг байдалд хүрч, тэрхүү Бурханлагаар бялхаж, бид Бурханаар бялхаж, бид Бурхан болно. Бидэнд дотоодын Хүч байгаа мөчид бид юу хүссэнээ хийж чаддаг, хаа дуртай газраа байж чаддаг, аврахыг хүссэн хэнийг ч болов аварч чаддаг.

***Асуулт 211:*** *Их Багш аа, шалиг завхай явах гэдэг юу гэсэн үг вэ?*

**Багш:** Та яагаад надаас асууна вэ? Энэ юу болохыг та мэдэж л байгаа. Хэрэв та ийм юм хийдэг бол зүгээр л алдаагаа засаад гэрлэ, тэгээд л боллоо. (Инээв.) Санаа зовох юм юу ч байхгүй. Гэхдээ танд гэж хэлэхэд энэ харилцаа хайр сэтгэлийнх бол ямар ч нүгэл хилэнцгүй гэсэн үг. Хэрэв та гэрлэсэн атлаа хором бүр нэг нэгнээ үзэн яддаг бол гэрлэсний ач тус гэж юу байх вэ? Тэрхүү хайр цэвэр ариун бол л Бурхан хүлээж авна. Энэ нь танд хайр байгаа үгүй эсэхээс л хамаарна. Би хайр сэтгэлийг гэрлэлтийн гэрчилгээ биш, гэрлэсэн хүмүүсийн харилцаа холбоо гэж үздэг. Би зүрх сэтгэлийн амлалтыг чинь шүүгчийн гарын үсэг биш, гэрлэлтийн тангараг гэж үздэг.

***Асуулт 212:*** *Ямар түвшинд бодол самадид ороход саад болдог вэ?*

**Багш:** Та бодож л байгаа бол самади байхгүй гэсэн үг. Самади бол ямар ч бодолгүй.

***Асуулт 213:*** *Их Багшгүйгээр саторид хүрч болох уу? Энэ боломжтой юу?*

**Багш:** Тийм ээ, гэхдээ олон төрлийн төвшин байдаг. Ургамал ногооны сатори, чулуун сатори, хуурай сатори, чийгтэй сатори, билиг ухааны сатори, будда сатори гэж байна. Заримдаа та нар өөртөө сатори байна гэж боддог, гэтэл та ердөө л хуурай мод, эсвэл чулуу шиг л байдаг, тэгээд таны саторигаас юу ч гаргахгүй. Та зүгээр л суугаад л, жаргаад л, юу ч мэдрэхгүй, хөдлөхгүй, амьдралгүй байдаг.

Харин хамгийн дээд самадид Их Багшаар дамжин Их Багшаас суралцсанаар хүрдэг. Хэрвээ бид үүнийг ганцаараа чадах бол Бурхан бидэн лүү Есүс, Буддаг илгээх шаардлагагүй. Яагаад бид үүнийг ганцаараа чаддаггүй вэ? Энэ нь бидэнд маш их үйлийн үрийн ачаа, тогтсон үзэл бодол, мухар сүжиг байдгаас болжээ. Бидний тархи хогоор дүүрчээ. Бид хэдэн сая жилийн турш асар их хогоор тархиа угаалгасаар ирсэн. Үүнийг давж, бүгдийг нь угааж арилгахад хэцүү, тийм учраас л үүнд Бурханы хүч шаардагддаг юм. Дөнгөж эхэлж байгаа бидэнд өөрсдөөс маань илүү ихээр билиг ухаанаа хөгжүүлсэн, илүү хүчирхэг хүн хэрэгтэй.

***Асуулт 214:*** *Хойд төрөл байдгийг би яаж мэдэх вэ?*

**Багш:** Билиг ухааны тодорхой нэг төвшинд хүрэхэд бид үүнийг мэдэж болно. Жишээлбэл, ахлах сургуулийн 2-р ангийг төгсөхдөө бид физикийн олон хуулийг мэддэг. Бид өөрсдөө лабораторид тэдгээрийг туршилт хийж үзэж болдог. Хэрэв та Арьяабалын арга, эсвэл өөр нэг төрлийн аргаар бясалгавал 2 дугаар төвшин лүү очиж чадна. Ухамсрын 2 дугаар төвшинг би хэлж байна. Маш олон төвшин байдаг. 2-р төвшин бол хамгийн сайн нь биш, энэ бол хамгийн муу төвшнүүдийн нэг нь юм. Арьяабалын аргын гурав дахь, дөрөв дэх, тав дахь гэх мэт төвшин байна. Илүү өндөр байх тусмаа илүү их билиг ухаантай болдог, тэгэхээр та хамгийн дээдэд нь хүрнэ.

Харин хоёрдугаар төвшинд очвол та өөрийнхөө болоод өөр олон хүний өнгөрсөн амьдралыг мэдэх нь лавтай. Ингэж л та эргэн төрөхүй үнэхээр байдаг юм байна гэдгийг мэднэ. Би үүнийг танд баталж чадахгүй. Таны нүд зуун метрээс цаашихыг харж чадахгүй. Харин би танд диваажингийн нүдээ хөгжүүлэхэд чинь тусалж чадна, тэгвэл та бүр цаашихыг, өмнөх болон хойдох олон цаг үеийг мэдэх болно. Тэгж л та өөрөө өөртөө үүнийг нотолж чадна. Гэхдээ танд гэж хэлэхэд энэ бол бясалгах сайн сэдэл биш, учир нь урд төрлөө мэдэх нь өөрт тань тийм ч сайн байдаггүй. Жишээ нь, эхнэр чинь урд төрөлдөө бар байсныг мэдчихвэл та шөнөдөө хар дарж магадгүй. Тийм биз дээ? (Инээв.) “Ээ, Бурхан минь, энэ эмэгтэй дахиад бар болчихвол яана аа, (Их Багш болон бүгд инээв.) эсвэл гэнэт буцаад бар болоод хувирчихвал яана аа” гэж та бодох байх аа. Ингэх нь сайн биш. Бурхан ивээсэндээ бидний одоогийн болон урд насны амьдралын хооронд хөшиг татдаг, учир нь бидэнд энэ төрөлдөө зохицуулах зүйл хангалттай их байна.

***Асуулт 215:*** *Есүсийг буцаж ирнэ гэдэгт би итгэдэг. Хэрэв энэ үнэн бол би хэрхэн аяглавал зохих вэ?*

**Багш:** Би таны асуултанд хариулахгүй ээ. Та надад итгэхгүй.

***Асуулт 216:*** *Нүглийн тухай ярьж өгөөч.*

**Багш:** Нүгэл гэнэ ээ? Та нар бүгдээрээ үүнийг мэддэг шүү дээ. Та надаас илүү сайн мэдэж байгаа. (Инээв.) Би буяны тухай ярья. Та нар бие биендээ хайрын сэтгэлээр хандах хэрэгтэй; ядуу зүдүү хүмүүст тусал, учир нь тэдний дотоодод Бурхан байдаг юм; нэг нэгнийхээ дутагдалд тэвчээртэй хандах хэрэгтэй; эцэг, эхээ хайрлаж хүндэл, эхнэрээ халамжил, нөхрөө хүндэл; хүүхдүүдээ халамжилж хүмүүжүүл; улсынхаа сайн иргэн нь бай. Бидний ярих ёстой зүйл бол энэ. Хэрвээ та нар энэ бүгдийг биелүүлдэг бол нүглийн тухай ярих шаардлага байхгүй. Бид эерэг байгаа цагтаа сөрөг байх боломжгүй.

***Асуулт 217:*** *Яаж дотоодын аз жаргалд хүрэхийг мэдмээр байна. Мөн тэрхүү аз жаргалаа ойр тойрныхондоо хэрхэн дамжуулах вэ?*

**Багш:** Би танд үзүүлнэ. Маргааш ирээд авшиг аваарай. Би үр дүнг нь агшин зуур батлаад өгнө. Авшгийн дараа та тэр аз жаргалыг мэдэрнэ. Эргэн тойрны чинь хүмүүс ч үүнийг чинь гадарлана. Тэд ямар нэгэн юмны үнэр авна. Тэгээд танаас "чи юу хийчихээ вэ? Чи өөрчлөгдчихсөн байна. Чи надад маш их таалагдаж байна. Тэр нууцаа надад үзүүлвэл яасан юм бэ?" гэж асуух болно. Ингэхэд би та нарт таалагдаж байна уу? Тийм үү? Надтай хамт байхад тухтай байна уу? Надад нэгэн нууц байгаа болохоор тэр. (Их Багш болон бүгд инээв.) Би та нарт энэ нууцыг өгч болно. Бид хамтдаа хуваалцаж болно. Сайхан асуулт тавилаа.

***Асуулт 218:*** *Яагаад Христийн сүмүүд хойд төрөл авах тухай яриаг хүлээн зөвшөөрдөггүй юм бэ?*

**Багш:** Учир нь тэд Библийг буруу ойлгодог юм. За юу? Дээр нь Библийг хэдэн зуун удаа хасаад засварлачихсан. Танд нэг жишээ хэлье. ***Та урьд цагийн тэр тэр гэгээнтний хувилгаан мөн үү?*** гэж Есүсээс асуухад Тэр "үгүй "гэж хэлээгүй. Гэгээнтэн Паул мөн ***Би амьдардаг; гэхдээ "би" биш, Христ миний дотор амьдардаг юм*** гэж хэлсэн. Хэрвээ та дахин төрнө гэдэг зүйлд итгэдэггүй юм бол яагаад Есүсийн хоёр дахь ирэлтийг хүлээгээд байгаа юм бэ, аан? (Инээв.) Та сүмээсээ асуу, за юу? Тэгээд танд юу гэж хариулахыг хараарай.

***Асуулт 219:*** *Хүн төрөлхтөн сүйрэл рүүгээ явж байна уу? Хүн төрөлхтнийг сөнөөх болов уу?*

**Багш:** Тийм ээ, гэхдээ бид үүнийг болиулж чадна. Бид ариун амьдралаар замнаж, өөрийн шүтдэг шашныхаа сахил, зарчмуудыг чандлах хэрэгтэй. Шашин бүр сахилтай. Сайн шашнаас гарсан бүх сахил сайн. Сахилаа чанд сахиж, дэлхийгээ авар. Авшиг хүртчих, хамтдаа дэлхийгээ аваръя. Би үүнийг ганцаараа хийж чадахгүй, тиймээс надад та нар хэрэгтэй. Мөнгө төгрөг, магтаал сайшаал, үнсэлт тэврэлт бус, харин энэ л миний та нараас хүсч байгаа өргөл барьц. Зүгээр л үүнийг хийчих!

***Асуулт 220:*** *Махан биеэсээ гарч аялах тухай та ярьж өгөөч.*

**Багш:** Астрал биеэрээ явж байгаа бол энэ нь сүртэй юм биш ээ. Та нар унтаж байхдаа байнга биенээсээ гарч, байнга Астрал аялал хийдэг, тиймээс маш их зүүдэлж, янз янзын газраар явдаг. Зарим нэг аргаар төвлөрөхөд таны астрал бие махан биеэ орхин хаа нэг тийшээ явдаг. Магадгүй, та энд сууж байхдаа ариун цэврийн өрөө орохыг хүсч байгаад чадахгүй байлаа гэж бодьё. Хэрэв төвлөрөлд орвол та астрал биеэрээ өрөөнөөс гарч, тэнд буй ариун цэврийн өрөөг яг өөрөө биеэрээ гарч очин нүдээрээ харж байгаа шиг л харна. Их багшгүйгээр, сайн үйлгүйгээр, буянгүйгээр нас эцэслэх үедээ та бас астрал биеэрээ явж одно. Унтаж байхдаа заримдаа дээшээ хөөрч, эсвэл доошоо унаж байгаагаа мэдэрдэг. Тийм биш гэж үү. Танд тийм мэдрэмж байдаг биз дээ? Тэр бол та астрал аялал хийж буйн шинж.

***Асуулт 221:*** *Их Багш аа сүнсний хөгжлийн төвшин нь хувь хүнийх байдаг юм бол яагаад эцэг, эх, гэр бүлийнхэн нь ямар нэгэн зүйл золиослохгүйгээр аврагддаг юм бэ?*

**Багш:** Тэд аврагддаг, гэхдээ их багш болохын тулд биш. Бурханы адислал хязгааргүй их учраас л тэд аврагддаг. Та нар бүгдээрээ гэр бүл болон төрөл садан байдлаар холбогдсон байдаг гэдгийг би хэлсэн шүү дээ. Нэг нь л эрх чөлөөтэй болж, сүр жавхлангаа бадруулахад бусад бүх төрөл төрөгсөд нь ач тус хүртдэг. Жишээлбэл, та их үзэсгэлэнтэй охин байж, нэгэн улсын хаан тантай гэрлэхийг машид их хүсч байна гэж бодъё. Хаан тантай гэрлэчихвэл таны төрөл садан, найз нөхөд бүгдээрээ сүр жавхлантай болохгүй гэж үү, аан? Тэдэнд ордонд очиж хаантай уулзан тэр бүх тансаг зүйлийг эдлэх боломж олдохгүй гэж үү?

***Асуулт 222:*** *Эмчилгээгүй гэж ягиргддаг өвчнийг хэрхэн эдгээх вэ?*

**Багш:** Та үүнийг "эерэг анагаалт"-аар хийж болно. Та өдөр бүр Бурхан дээр бясалгахыг хичээ, тэгвэл Бурхан таныг бас илааршуулан анагаах болно. Хэрэв танд хангалттай итгэл сүжиг байх юм бол та даруй эдгэнэ. Тэгээд ч өвчин бол урьдын болон одоогийн буруу үйлдлийн үр дүн гэдгийг та мэдэж байх ёстой. Таныг эрхэм ариун явдлаар амьдрах цаг чинь болжээ гэдгийг сануулсан Бурханы анхааруулга юм. Бид өөрийнхөө мэдэх, мэдэхгүй буруу үйлдэлдээ чин сэтгэлээсээ гэмшиж, Бурханы сахилуудыг чандлан сахиж, ургамал хоолтны амьдралаар явахыг хичээх хэрэгтэй.

Ихэнх өвчин мах, загас зэрэг аливаа төрлийн амьтны бүтээгдэхүүнээс үүссэн байдаг. Америк бол хамгийн их мах иддэг улс, тиймдээ ч хорт хавдрынхаа хэмжээгээр хамгийн эхэнд ордог. Орос, Хятад хүмүүс бол мах идэхээргүй доогуур амьжиргааны төвшинтэй учир хорт хавдрын хэмжээ хамгийн бага байдаг. Бид яагаад цагаан хоолтон байх ёстой, яагаад бид эрхэм ариун байх ёстой, яагаад амьтны мах идэхгүй, энэрэл нигүүлслэлийг өөртөө дадуулах ёстой вэ? гэдэгт дээрх нотолгоо хариулж байна. Бусдыг хайрлана гэдэг нь өөрийгөө хайрлахыг хэлж буй

учраас тэр юм. Бусдын амийг аварвал бидний амь ч бас аврагдана. Энэ бол учир шалтгаан, үр дагаварын хууль. Библид үүнийг ***Юу тарина, түүнийгээ хураана*** гэж хэлсэн байдаг. Ижилхэн л юм хэлсэн байна.

***Асуулт 223:*** *Их Багш аа, өөр тийшээ явсан юмуу, үхсэн хүмүүс нь зурвас илгээж, эсвэл амьд үлдсэн хүмүүсээрээ дамжуулан эмчилж эдгээж чадна гэдэгт Та итгэдэг үү?*

**Багш:** Тийм ээ, гэхдээ тун ховор. Учир нь тэдгээр завсрын сүнсний ихэнхэд хангалттай хүч байдаггүй. Диваажингийн хүмүүс энэ заваан дэлхийтэй холбогдохыг хүсдэггүй. Диваажинд очихоороо тэд манай дэлхийг маш бохир заваан болохыг хараад буцаж ирэхийг боддоггүй. Бид энгийн хүмүүс тул диваажинд байгаа тэдэнд хүрч чаддаггүй. Харин тамд байгаа хүмүүс ч бидэнд бас хүрч чадахгүй, учир нь тамын хүмүүс хүлүүлчихсэн байдаг. Тийм учраас жинхэнэ зурвас юмуу дохиог хүлээж авна гэдэг хэцүү. Тийм зүйл болдог л доо гэхдээ тун ховор, найдвартай байх нь ховор.

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт
## Бразил улс, Сан-Паулу хот, Японы Соёлын Нийгэмлэг
## 1989 оны 6 дугаар сарын 18

***Асуулт 224:*** *Их Багшийн хувилгаан бие ямар учиртай вэ?*

**Багш:** Их Багшийн хувилгаан бие ямар учиртай болохыг та мэдэх үү? Гэрлэн биеийг. Гэрлэн бие. Зөв орчуулагдсан эсэхийг би сая тэднээс асуусан юм. Тэр эмэгтэй үүнийг хэлсэнгүй. Тэр Их Багш шөнө ирж зүүдэнд нь үзэгдээд энийг тэрийг хий гэж хэлдэг гэсэн. Үгүй тийм биш. Тэр чинь Их Багшийн Гэрлэн бие биш. Их Багшийн гэрлэн бие зөвхөн зүүдэнд нь гэлтгүй, хаана ч, хэдийд ч харагддаг юм. Заримдаа та нар яг одоо намайг харж байгаа шигээ л нүдээ нээлттэйгээр түүнийг харж болно; магадгүй галт тэрэгний буудалд, галт тэрэг, нисэх онгоцон дотор, магадгүй та ажлаа хийж байхдаа, ариун цэврийн өрөөгөө цэвэрлэж байхдаа гээд хаана ч харж болно. Их Багшийг харах шаардлага танд байвал Их Багш танд харагдана.

Үүнийг л бид хувилгаан бие буюу Гэрлэн бие гэж нэрлэдэг юм, учир нь энэ бие бүхэлдээ гэрэл. Энэ нь жинхэнэ бие цогц шиг харагдах боловч мах цуснаас бүрдээгүй. Та тэр биеийг хэсэгхэн зуур бариад авч ч магадгүй, гэвч удалгүй Их Багш агаарт замхарчихна. Заримдаа Их Багш цонхоор нисээд ороод ирнэ, гэвч энэ нь махан бие нисэж байгаа хэрэг биш. Энэ бол Их Багшийн самади хүчээр үүссэн хувилгаан бие юм. Тиймээс Буддын шашинтнууд "хэдэн арван мянган бие, хэдэн арван мянган хувилгаан бие" гэж ярьдаг юм. Христ болон Хинду шашны нэр томъёонд үүнийг "хаа сайгүй оршигч" хэмээн нэрлэдэг нь "Их Багш хаана ч үгүй, бас Их Багш хаа сайгүй байж байдаг" гэсэн үг.

Хаана ч, хэдийд ч шавь нартаа туслахын тулд жинхэнэ Их Багш арав, зуу, мянган хувилгаан биед, хэдэн сая биед хувилах чадвартай байдаг. Хэрэв Их Багш тийм олон биед хувилж чадахгүй байх аваас тийм олон шавиа харгалзан халамжлах боломжгүй болно. Тухайн Их Багш олон мянган хувилгаан биеийг бүтээж чадахгүй байх аваас тэр жинхэнэ Их Багш биш гэсэн үг.

***Асуулт 225:*** *Мах идэхээ больсны дараа ургамал хоол бэлдэж идэх боломж нөхцөл надад байхгүй байвал бие маань сульдахгүй юу?*

**Багш:** Үгүй ээ, гэхдээ та дутагдаж буй амьтны гаралтай уургийг нөхөхийн тулд уургаар баялаг хоол хүнсийг сонгох ёстой. Англи хэлээрх Үлгэр дэвтэрт би ямар хоол идэж болох, аль нь уургаар хангалттай тухай хэлсэн байгаа. Бид үүнийг дараа

Португали хэл рүү орчуулахыг хичээнэ ээ. Гэхдээ та гэртээ харьж, англи хэлтэй найзаа олоод орчуулаад өг гэж гуйгаарай. Англи хэл олон улсын хэл учраас танд орчуулаад өгөх хүн хаанаас ч олдоно.

Мах угаасаа сайн биш, бид үүнийг бүгд мэдэж байгаа. Эмнэлгүүд мах иддэг хүмүүсээр дүүрэн л байгаа биз дээ; ургамал хоолтой хүмүүс эмнэлэгт бараг л очдоггүй. Соёл иргэншил хөгжих тусам л бид төдий чинээ их мах идэж, өчнөөн олон эмнэлэг барьж байна. Ургамал хоолонд хангалттай их уураг байдаггүй гэж та боддог бол заан, морь, үхрийг хар л даа; заанаас хүчтэй амьтан байна уу? Тэр юу иддэг билээ? Заан тэр байтугай уургийн тухай огт боддог ч үгүй.

Өөрийгөө бүү хуур. Ногоон хоол бол маш эрүүл. Бүр боксчин Мухаммед Али хүртэл ургамал ногоон хоолтон. Тийм болохоор надад үлгэр ярих хэрэггүй. Та мах идмээр байгаа бол ид; хэн ч, юу ч хэлэхгүй. Зүгээр битгий шалтаг тооч. Мах сайн биш ээ, маш өмхий, есөн шидийн нян, хор, мал, амьтан нядлуулах үеийн бүхий л төрлийн үзэн ядалт, айдас, аймшигтай мэдрэмж зэрэг нь махны соронзон талбайд хадгалагдан үлддэг. Тэгээд тэр махыг нь идэхдээ та дотор нь буй энэ бүх "энергийг" бас идэж байдаг юм. Энэ бол маш хүнд энерги, тийм учраас та буцаад дээшээ "Гэр" лүүгээ авирч чаддагүй юм.

***Асуулт 226:*** *Самадид орох болон кундалин энергиэ сэргээх хоёр хоорондоо ямар ялгаатай вэ?*

**Багш:** Кундалиныг сэрээхэд та самадид орж ч магадгүй, орохгүй ч байж магадгүй. Мөн самадид орох үед чинь кундалин сэрж ч магадгүй, сэрэхгүй ч байж магадгүй. Юу гэхээр, кундалин бол далд энергийн нэгэн төрөл. Энэ энерги нь бие махбодыг халамжилдаг. Энэ нь Хятадын "Чи" энергитэй адил. Энэ "Чи" энергийг сэргээхэд хүний биед амин хүч чадал орж, бие махбод хүчтэй, сэтгэл санаа хүчтэй байдаг, харин Самади бол хүнд билиг ухааныг өгдөг. Таны бие сул дорой, өвчин хуучтай байх боловч та Самадид байхдаа билиг ухаантай болно. Самади болон кундалини хоёрын ялгаа нь энэ юм.

***Асуулт 227:*** *Ойр хавьд жинхэнэ Их Багш байхгүй байгаа тохиолдолд шууд ахуй ойлголтоор гэгээрэлд хүрэх боломж хүнд байдаг уу?*

**Багш:** Тийм ээ, их багшгүйгээр гэгээрч болно, ингэх олон шалтгаан бий. Тухайн хүн өмнө нь, урьдын олон төрөлдөө бясалгаж байсан, тэрхүү ой санамж нь одоо хэр байж байх нь нэг шалтгаан юм. Төрөлхийн гэх хүмүүс байдаг шүү дээ..."Суут ухаантан" гэгддэг олон хүн байдаг даа. Тэд хүүхэд наснаасаа л маш олон зүйлийг хийж чаддаг. Энэ бол түүний урьд төрлийн бясалгалаас үлдсэн үлдэгдэл хүчний илрэл. Бас төрсөн цагаасаа ийм, эсвэл жаахан хүүхэд хэрнээ бясалгахыг, ургамал хоол идэж, сүмд очихыг хүсдэг зарим хүн байна.

Өөр нэг тохиолдол нь та Их Багш гэж мэдэлгүйгээр л зарим нэг Их Багштай уулзсаны дараа гэгээрэлд хүрдэг. Тийм хүмүүс тухайн үедээ түүнийг Их Багш гэж таньдаггүй, Их Багш ч гэж итгэдэггүй, тэгсэн ч хайр адислалыг нь авдаг. Та Их

Багшийн нүд рүү ердөө ганц л харсан. Зарим тохиолдолд энэ нь танд гэгээрэл өгөхөд хангалттай байдаг, та тэр ивээл дор бүр гэтлэгдэж ч чадаж магадгүй. Гэхдээ энэ нь таныг энэ төрөлдөө Их Багш юмуу Будда болгох боломжгүй. Ялгаа нь үүнд л байна. Учир нь ийм гэгээрэл бол бүрэн гүйцэд биш, ердөө л гэгээрлийн нэг хэсэг юм.

Дахиад бас нэг тохиолдол нь нэгэн аугаа Их Багшийн нэг юмуу, нэлээд олон шавьтай уулзах, тэдэнтэй харилцах, тэдэнд туслах, эсвэл сайн харилцаатай байх үед тухайн шавь нар Их Багшийнхаа тухай дурьдаж, эсвэл гэрэл зургийг нь өгдөг, эдгээрээр тэр хүн бас адислагддаг. Тэд эсвэл их багшийнхаа тараасан адистай хүнсийг бусадтай хуваалцдаг. Та жаахныг идээд л, юу болоод байгааг ч мэдэлгүйгээр Гэрэл хардаг, гэгээрдэг. Та үүнийг өөрөө л хийчихлээ гэж боддог. Гэтэл энэ нь угтаа шавь нар болон адистай хүнсээр дамжин тухайн Их Багшаас ирж байгаа нүдэнд үл үзэгдэх адислал байдаг. Адистай хүнс гэдэг нь тухайн Их Багшаар адислагдсан, Их Багшийн сүнслэг хүчээр цэнэглэгдсэн зүйлийг хэлнэ. Энэтхэгт үүнийг “Прашад” гэдэг.

Тэгэхлээр эдгээр нь гэгээрлийн олон янзын тохиолдол юм. Заримдаа гэгээрсэн Их Багшийн авшиг хүртсэн шавьтай төрөл садангийн холбоотой байвал та тэр шавиас нь бас л өгөөж хүртдэг. Тэгэхлээр олон тохиолдол байна. Шавь нарын маань зарим нь хоёр, гурав, дөрвөн настай хүүхдүүдтэй; мэдээж шөнө тэднийг бясалгахад ард нь хүүхэд нь сууж байдаг. Тэгтэл нэг өдөр хүүхэд нь “Ээж ээ, ээж ээ, би Их Багш энд ирсэн байхыг харлаа!”, “Би Есүсийг харлаа”, эсвэл “Би Буддаг харлаа, би Гэрэл харж, Аялгуу сонслоо” гэдэг. Дөрвөн настай хүүхэд хэдийнээ гэгээрчихэж байна. Гурван настай, дөрвөн настай хүүхэд шүү дээ. Үүний учир нь Их Багш ээжээр нь дамжуулан тэднийг адислан цэнэглэсэн байна. Энэ тохиолдолд тэр хүнийг Их Багшгүйгээр гэгээрсэн гэж бид хэлдэг юм.

***Асуулт 228:*** *Хүүхэдтэй байх нь гэтлэхүйд хүрэх замд саад болох уу?*

**Багш:** Үгүй ээ, огтхон ч үгүй. Танд бүр өөр нэгэн сүнсийг Гэрт нь хүргэж өгөх боломж олдож байна гэсэн үг. Гэгээрсэн эцэг, эхээс сүнслэг орчинд төрсөн хүүхдүүд бол адислагдсан хүүхдүүд. Тэд үнэхээр адист ерөөлтэй. Хүүхэдтэй байх сайн. Хүн болгон хүүхэдтэй байхаа больчихвол тэр бүх Будда хаанаас ирэх болж байна?, Есүст дахин төрөх боломж олдохгүй болчихно. Би буцаж ирнэ гэж Тэр амлаа биз дээ. Хүүхдүүдийн чинь нэг нь Есүс байх ч юм бил үү. Бид найдвар тээх хэрэгтэй.

***Асуулт 229:*** *Үйл үр биднийг хүүхэдтэй байхаас өөр аргагүйд хүргэдэг юмуу, эсвэл үйлийн үрээс болоод бид хүүхэдтэй болдог юм уу?*

**Багш:** Тийм, ямар нэгэн шижмээр бид урд төрөлдөө хүүхэдтэйгээ холбогдсон байдаг, тэр нь заримдаа муу үйл үр, заримдаа сайн үйл үр байдаг. Тэгэхлээр үйлийн үр дандаа муу байх албагүй. Магадгүй урд төрөлдөө та нэгэн хүнд тусалсан, энэ төрөлдөө та гэгээрсэн, тэгээд өөрөө мэдэлгүй тэр хүнийг гэгээрэхэд нь тусалхыг хүссэн байж болно; тэгвэл тэр таны гэрт хүүхэд чинь болон төрнө. Энэ тохиолдолд энэ маш сайн. Зарим тохиолдолд эцэг, эх нь тэр хүүхдэд туслахыг хүссэн хүслээс нь тэр хүүхэд төрдөг, яагаад гэвэл тэр хүүхэд урд төрөлдөө хаа нэгтээ эцэг, эхдээ

тусалсан ч юм билүү; харин одоо эцэг, эх нь гэгээрсэн байгаа тул түүний сайхан сэтгэлийг хариулахыг хүсэж л дээ. Далд ухамсартаа тэд түүнийг гэгээрээсэй, гэтлэгдээсэй гэж хүссэн. Тийм учраас тэр хүн нь гэр бүлд нь хүүхэд болж төрсөн хэрэг. Энэ тохиолдолд энэ сайн. Энэ бол муу үйлийн үр биш, харин сайн нь юм.

***Асуулт 230:*** *Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн эрх тэгш гэгээрэх зам байдаг уу?*

**Багш:** Тийм ээ, байлгүй яахав. Дотоодод эмэгтэй, эрэгтэй хүн гэж байдаггүй. Зөвхөн өмссөн хувцасны л ялгаатай байдаг. Энэ хувцаснууд үргэлж солигдож байдаг; та энэ төрөлдөө эрэгтэй хүн, дараа төрөлдөө эмэгтэй хүн болдог. Би үргэлж эмэгтэй Их Багш байгаагүй; эмэгтэй хүн ч бас гэгээрч, Их Багш болж болдог юм байна гэдгийг та нарт мэдүүлэхийн тулд энэ удаа би зориуд эмэгтэй болж төрсөн юм. Энэ ямар байна? (Их Багш инээв.) Эрэгтэй хүний илт давуу байдлын тухай буруу үзэл ойлголтыг чинь үгүй хийж, эмэгтэй хүнийг зоригжуулан алдаршуулж, яг одоо эрэгтэй хүнд нэн хэрэгтэй байгаа эгэл даруу байхын хичээл сургамжийг эрчүүдэд заах гэж ингэсэн юм.

Та нар олон зууны турш би үзлээрээ онгирч, эмэгтэйчүүдийг дорд үзэж ирсэн. Эмэгтэй хүн бол бүх Будда (Гэгээнтэн) нарын, Есүсийн ээж нь шүү дээ, тэд сайн байр суурийг хүртүүштэй. Эмэгтэй хүн үгүй бол нэг ч хүн оршихгүй. Гэвч олон сая жилийн турш хүмүүс дэлхий дээрх эхчүүдэд талархалгүй байсаар иржээ. Тиймээс Бурхан энэ удаад эмэгтэй хүнийг Их Багш байлгахаар сонгожээ. Дотоодод эмэгтэй, эрэгтэй хүн гэж байдаггүй юм. Зөвхөн билиг ухаан, зөвхөн тэнгэрлэг чанар, зөвхөн хайр, адис ивээл гэж л байдаг. Эмэгтэй хүний сүр жавхлан, эрэгтэй хүний сүр жавхлан, эр хүний хайр, эмэгтэй хүний хайр, эмэгтэй хүний билиг ухаан, эрэгтэй хүний билиг ухаан гэдэг юм огт байдаггүй.

***Асуулт 231:*** *Тухайн хүнийг Ch'an мастер, Дао Чи мастер зэрэг урьд цагийн аугаа Их Багш нарын үр сад мөн эсэхийг хэрхэн мэдэх вэ?*

**Багш:** Энэ амархан. Дао Чи Чан буюу Дао Чи гэж юу болохыг та мэднэ. Амьд байх үедээ аугаа Их Багш байхын тулд Тэр ямар ямар чанартай байсныг нь та мэднэ. Тэр чанаруудаас нь танд байгаа, эсвэл таны их багшид тэр чанарууд байгаа бол та болон таны их багш тэрхүү их багштай холбоотой; эргэлзэх зүйл алга. Учир нь та нар бүгдээрээ нийтлэг шинж чанартай байна. Дао Чи амьд байхдаа гэгээрсэн байсан гэдэгт эргэлзэх зүйл байхгүй. Түүнд энэрэл нигүүлсэл, өршөөл хайр, хамаг амьтныг гэтэлгэх хүч байсан; Түүнд Гэрэл байсан. Тэгвэл одоо таны их багшид чинь эдгээр шинж буй бол тэр ямар ч эргэлзээгүй энэхүү удмын үр сад юм. Эдгээр шинж чанараас танд жаахан ч гэсэн өгөгдсөн байгаа бол түүнийгээ улам хөгжүүл, тэгвэл та ч бас тэр их багшийн үр удам юм. Та холбогдсон гэсэн үг.

***Асуулт 232:*** *Сүнснүүд төрдөг юмуу, эсвэл тоог нь аль хэдийн урьдаас тогтоочихсон байдаг юмуу гэдгийг мэдэхийг хүсэж байна. Эд бүгд угаасаа оршдог юм уу?*

**Багш:** Хөгшин сүнснүүд байна, бас зарим шинэ сүнс ч байна; ихэнхдээ л хөгшин сүнс. Хөгшин сүнснүүд нь хүн болж төрдөг нь юм. Тэд муу үйл огт хийдэггүй, ахин дахин хүн болж төрсөөр байдаг юм. Шинэ сүнснүүд нь рашаан эрдэс, цэцэг, амьтны хаант улсаас ирж төрдөг. Тэд хөгжин хувьссаар хүн болдог. Эдний тухайд бол сүнс нь молхидуу, хариу үйлдэл нь удаан, эсвэл бүр аймхай байх нь ч бий. Тухайн сүнс чулуу байснаа одоо хүн болж төрсөн бол яг л чулуу шиг, хүйтэн хөндий, тэнэг зөрүүд байдаг. Урд төрөлдөө мод байж байгаад хүн болсон бол сэрүүхэн, аятайхан байх хэдий ч бас л молхидуу, бүрэг, удаан, оюун ухаан муутай байдаг. Төгс төгөлдөрт суралцахын тулд тэд маш олон удаа төрөл авах шаардлагатай. Зарим сүнс Диваажингаас ирж төрдөг, гэхдээ Бурханы орноос биш, жишээ нь, сахиулсан тэнгэрс, дагинас, тэнгэрлиг сүнснүүд шиг. Төгс төгөлдөрийг дадуулахыг хүссэн учраас тэд дэлхий дээр хүн болж төрдөг. Тэд Их Багшийг хайж олоод, үхэж төрөхийн хүрднээс гэтлэгдэхийг хүссэн байдаг. Тэд өөрсдөө Их Багш болохыг хүссэн. Ийм учраас шинэ болон хуучин гэх мэт янз янзын сүнс байдаг.

***Асуулт 233:*** *Хос хоёрын үйл үрийг хэрхэн ойлгох вэ?*

**Багш:** Тухайн хос эв түнжинтэй байдаг бол сайн үйлийн үртэйн шинж; харин өдөр бүр хоорондоо үзэлцдэг бол энэ ямар үйлийн үр гэдгийг та мэдэж байгаа. Ойлгоход амархан биш байна уу? Эвтэй хос бол түүндээ баярла; харин эв түнжингүй бол дараа төрөлдөө дахин ирээд тун хүсмээргүй үйлийн үртэй хос болчихгүйн тулд таарч тохирохыг хичээн тэвчээртэй байгаарай.

Толстой тун аймаар эхнэртэй байсан. Та Толстойг мэдэх үү? “Дайн ба Энх” номыг зохиосон хүн. Тэр их аймаар эхнэртэй байсан гэж ярьдаг юм. Эхнэр нь өдөр бүр түүнийг харааж загнаж, заримдаа бүр зодож хөөдөг байжээ. Нэгэн удаа найз нь бүр тэвчихээ байгаад “Чи яагаад энэ чөтгөрийг хөөгөөд явуулчихдаггүй юм бэ? тэгвэл бид амар тайван байхсан?” гэж хэлжээ. Толстой “Чшш, битгий чанга ярь. Өмнөх төрөлдөө би тэгдгээ тэгчихсэн, тэгээд энэ удаа бүр дордчихоод байгаа юм. Одоо тэгж зүрхлэхгүй” гэжээ. Тэрсэлдэх тусам л нөхцөл байдал улам дорддог. Тэгэхээр ямар ч юмыг Бурханаас өгсөнөөр нь л хүлээж ав, тэгээд түүнийг давж туулахыг хичээ, өөрийгөө тэвчээр, хүлцэл, “дайснаа” хайрлахад сурга. Толстой шиг ухаантай хүн хүртэл аймшигтай эхнэрээ зохицуулж дөнгөхгүй байхад бидэн шиг жирийн төрөлтөн чимээгүй байсан нь өлзийтэй. (Их Багш болон бүгд инээв.)

***Асуулт 234:*** *Өөрийгөө уучилж, Таны тусламжийг дахин хүртэх боломж бий юу?*

**Багш:** Тийм боломж бий. Та ямар нэгэн буруу юм хийсэн бол чин сэтгэлээсээ гэмш. Нөгөө талдаа гэмээ цайруулж чадахаар бол даруйхан хий. Чадахааргүй бол наанадаж л “уучлаарай” гэж хэл, эсвэл чадах зүйлээ хий; уучлаарай гэж хэлж чадахгүй бол Бурханд гэмшиж буйгаа хэлж, дараа дахиж хэзээ ч ингэхгүй гэдгээ амлаад үүнийгээ март. Хүн бүр л хааяа алдаа гаргадаг. Юу чухал вэ гэхлээр үүндээ гэмших, илүү сайн байхаар өөрчлөгдөх явдал юм. Та амьдралынхаа турш өөрийгөө буруутгавал энэ нь хэнд ч ач тусгүй .

***Асуулт 235:*** *Яаж шунал, нэр төрд дурлах байдлаасаа салах вэ?*

**Багш:** Энэ амаргүй ээ. Зөвхөн Бурханы орны гоо үзэсгэлэн, сүр жавхланг харсан цагтаа л та энэ дэлхийн ололт амжилтанд дурлах сэтгэлээ мартана. Тийм учраас л би та нарт Арьяабалын бясалгалын аргыг өгдөг юм, тэгвэл та диваажин болон Бурханы сүр жавхланг харах магадлалтай, ингэвэл эд хөрөнгийн олз ашиг болон нэр төрд шунах сэтгэлээ орхино. Яг л нялх хүүхдэд сүүг нь өгвөл хөхөлт угжаа хөхөхөө больдогтой ижил юм.

***Асуулт 236:*** *Биеэ тоох буюу өөрийгөө чухалчидаг зангаасаа яаж салах вэ?*

**Багш:** Өөрийгөө чухалчлах зантай гэдгээ мэдэх чинь их сайн хэрэг. Өвчний чинь хагас эдгэчихжээ. Энэ бардамналыг дарах их сайн нэг арга бий. Энэ ертөнцийн аугаа сайхныг, орчлонд оршдог ч чиний ойлгож ухаарч чадахгүй байгаа бүхнийг, орчлонгийн талаар чи юу ч мэддэггүй гэдгээ, бас Бурханы Хуулийн тухай бодоод үз дээ, тэгвэл та өөрийгөө нэн өчүүхэн гэж мэдэрнэ. Энэ дэлхийн тухай бидний олж авсан ямар ч мэдлэг их өчүүхэн. Хичнээн чухал ажил хэрэг байлаа ч мөнх бус. Тэгээд үхэх цагт бид гар хоосон.

Тиймээс та гэгээрсэн нь илүү дээр. Хэдий их гэгээрнэ, төдий чинээ эгэл даруу болно, учир нь орчлон өчнөөн аугаа байхад та маш өчүүхэн мэдлэгтэй гэдгээ мэдсэн байдаг. Ингэж та хамгийн эгэл даруу нэгэн болтлоо улам л даруу болсоор байдаг. Тэгсээр та юу ч мэддэггүй гэдгээ зөвшөөрнө, тэгсэн хэрнээ та бүхнийг мэддэг болно. Тийм учраас л Лууз "***Мэргэн хүн хэлгүй мэт.***" гэж хэлсэн. Ийм учраас л Есүс "***Би ажилладаг, гэхдээ Би биш; дотоодод минь оршигч Эцэг минь ажилладаг юм.***" гэжээ. Тэр хичнээн аугаа нэгэн билээ, гэтэл Эцэггүйгээр юу ч хийж чадахгүй гэдгээ Тэр мэдсэн аж. Өөрөө юу ч хийж чадахгүйгээ мэддэг учраас л Тэр бүхнийг хийж чаддаг. Энэ ойлгоход хялбар байна уу?

***Асуулт 237:*** *Улбар шар өнгө оюун санааны талтай ямар хамааралтай вэ?*

**Багш:** Үгүй, ямар ч хамаагүй. Өчигдөр би цагааныг өмссөн, заримдаа хөхийг өмсдөг. Гэхдээ улбар шар өнгө бол лам нарын уламжлалт өнгө юм. Энэтхэгт гүргэм их байсан, энэ бол өнгөт үндэс. Та үүнийг улбар шараар, гүргэмийн өнгөөр будаж болно. Та үүнийгээ шараар, улбар шараар будаж болно, тэд огоорох сэтгэлийн бэлгэ тэмдэг, хайрын өнгө хэмээн үзэж, хувцсаа улбар шараар буддаг юм. Лам нар хамаг амьтныг хайрлаж, гэгээрнэ хэмээн амладаг. Бас улбар шар өнгө нь газар шорооны өнгөтэй адилхан тул хиртэх нь амархан мэдэгддэггүй. Учир нь энэтхэгийн лам нар усгүй, мөн усанд орохгүйгээр олон бээр алхах хэрэг гардаг байжээ. Мөн энэ өнгө нь лам нарт өөрийгөө газар шорооноос бүтсэн шүү, удахгүй буцаад шороо болно, тиймээс сэтгэл хүлэгдэх юм юу ч үгүй гэж бодоход нь тусалдаг юм. Гэхдээ хувцсаа биш, зүрх сэтгэлээ будах нь илүү дээр. Та хувцсаа будах шаардлагагүй, зүгээр л зүрх сэтгэлээ буд; зүрх сэтгэлээ хайрын өнгөөр будчих. Өөрийгөө Бурханы сүр жавхлангаар хувцасла, тэгээд л та Бурхан, хайр болно.

Миний өнгөнүүд бүгд өөр байгааг та харж байгаа биз дээ. Би улбар шар өнгийн хувцсыг нэг их өмсдөггүй. Би дуртай юмаа л өмсдөг. Энэ хувцас тухтай байсан учраас би өмсчихсөн юм, ямар ч асуудалгүй, би хаана ч суусан болно.

Хүмүүсийн орхиж үлдээсэн хувцас даавуу шуувуухныг сонгоод л хооронд эвлүүлчихдэг. Би хувцасныхаа загварыг өөрөө зохиодог. Тийм болохоор надад олон өнгийн хувцас бий; өнөөдөр улбар шар, маргааш ногоон, дараа нь цагаан гээд л. Сонгож авсан юмаараа л хувцас хийчихдэг юм. Түүнийгээ улбар шар өнгөөр будаж болно л доо, гэхдээ л нэг их тоодоггүй, би чинь тун завгүй хүн шүү дээ. Түүнээс гадна даавуу будахад хуруунууд чинь улбар шар болчихно, угаах болгонд улбар шар, улбар шар ус гарч ирээд бүх юмыг завааруулж орхино шүү дээ. Тиймээс ямар өнгө байна, тэрийг л би өмсчихдөг; харин өнөөдөр би улбар шар өнгийн хувцас өмсч таарлаа, өчигдөр би цагаан хувцастай байсан, тэрний урд өдөр хөх хувцастай байсан, би тоодоггүй. Энэ бол юу ч биш.

***Асуулт 238:*** *Авшиг хүртээд сул дорой болж, буцаад мах идчих болов уу гэж би айж байна. Их Багш аа, хэдий тийм байлаа ч би авшиг хүртэх хэрэгтэй юу?*

**Багш:** Та их үнэнч хүн юм, надад таатай санагдаж байна. Ирээдүйг бид мэдэхгүй шүү дээ. Одоо цагаа л анхааръя. Та хэзээ ч тэгэхгүй ч юм билүү, хэн мэдлээ? Та чин сэтгэлтэй байх хэрэгтэй бөгөөд Их Багшид залбирах ёстой, тэгвэл энэ нь тусална. Чин сэтгэлтэй байх юм бол Их Багш танд унах боломж гаргахгүй.

***Асуулт 239:*** *Ер бусын ахуй ойлголтоо бусдад ярьж болохгүй гэж та хэлсэн, ярьчихвал тэр нь алга болчихно. Гэхдээ найз нөхөд, бусад хүний тухайд ямар вэ, бидний ахуй ойлголтууд тэдэнд тус нэмэр болж чадахгүй гэж үү?*

**Багш:** Тийм ээ, сонсож байгаа хүндээ бол тустай, харин ярьж байгаа хүндээ ашиггүй. Дөнгөж сая бидний найз хүүгийнхээ ахуй ойлголтыг ярилаа. Их Багшийн адислал ганцхан тань дээр буудаггүй юм, тиймээс ахуй ойлголтоо бусадтай хуваалцах хэрэггүй. Ярьчихвал Их Багш тэрийг чинь хаачихдаг. Үүнээс болоод л энэ дэлхий дээр Их Багш байх нь хэцүү байдаг. Энд илбэ үзүүлээд л бүх хүний сэтгэлийг татаад явбал надад амар л байна, гэвч надад ингэхийг зөвшөөрдөггүй юм. Хэрвээ би ийм зүйл хийхийг хүсээд байвал хүмүүсийг гэрт нь хүргэж өгч чаддаггүй төрлийн л Их Багш болчихно.

Жинхэнэ сүнслэг бясалгагч хүн хэзээ ч өөрийн ахуй ойлголт болон хүчээ гайхуулж онгирч болдоггүй юм. Их Багш нь хичнээн хүчтэйг шавь нь авшгийн үед болоод авшгийн дараа мэддэг. Тухайн шавь хэр их баясалгана, Их Багшийнхаа ямар аугаа вэ? гэдгийг төдий сайн мэдэж авдаг. Учир нь тэр өдөр бүр адислалыг нь хүлээн авч байдаг юм. Гайхамшиг өдөр бүр тохиолддог, зөвхөн түүнийг нийтийн өмнө үзүүлэхийг Их Багшид зөвшөөрдөггүй юм. Түүнээс гадна Их Багш маш даруухан хүн учраас хэзээ ч иймэрхүү юмаар онгирдоггүй, дагалдагч нарынхаа сэтгэлийг татах гэж ид шидийг ашигладаггүй. Ингэх нь өөрөө өөрийгөө өргөмжилж, сурталчилж буй хэрэг бөгөөд ийм зүйл Их Багшийн арга барилд нийцэхгүй. Энэ Их Багшаас суралцаж эхэлснээсээ хойш та Их Багш болоход өөрөө суралцдаг. Их Багш байх хамгийн эхний шинж бол хүлцэнгүй даруу байдал, тэгэхлээр шавилж байгаа цагтаа та эгэл даруу байж сурна гэсэн үг. Гэгээрлийн дэвшлийнхээ талаар ярихгүй, чимээгүй байж эхлэх ёстой, тэгэхгүй бол Бурхан түүнийгээ буцаагаад авчихна.

## Их Багшийн лекцийн асуулт, хариулт

### Малайз улс, Пенан, Хятад хорооллын өргөө 1989 оны 10 дугаар сарын 1

***Асуулт 240:*** *Хималайд байсан үеийнхээ оюун санааны ахуй ойлголтоосоо ярьж өгнө үү.*

**Багш:** Оюун санааны ахуй ойлголттой болохын тулд бид заавал Хималай явах шаардлагагүй. Тэгээд ч миний оюун санааны ахуй ойлголт Хималайгаас эхлээгүй, бас тэнд төгсчихөөгүй. Амьдралын маань минут, секунд тутамд надад сүнслэг ахуй ойлголт ирдэг. Би бүгдийг нь та нарт хэлж чадахгүй нь. Дэндүү их урт, маш их зүйл бий. Мөн энэ нь та нарын төсөөлөл, таамаглалаас хэтэрсэн зүйл. Би таныг бидэнтэй нэгдэж, бидэнтэй адил зүйл хийж, дараа нь өөрийгөө мэдээсэй гэж урьж байна, ингэх нь хамгийн сайн. Чихрийн тухай үргэлж ярих ямар хэрэг байна. Тэр чихрийг идсэн хүн нь би. Та тэрийг идээгүй, тиймээс би их хэлж ярих тусам л таны арааны шүлс их асгарна. (Их Багш инээв.) Гэхдээ би та нарт бүхий л судар номлолд “хамгийн дээд ахуй ойлголт” гэж нэрлэсэн зүйлийг үзэж мэдэрсэн гэж л хэлье. Тэгэхлээр өдөр болгон бүр улам их хөгжинө. Та нэг төвшиндөө л зогсчихдоггүй. Та өдөр болгон улам улам ихийг үзэж мэдэрнэ. Гэхдээ хамгийн дээд ахуй ойлголтыг би авсан. Үүнийг л би та нарт хэлж чадах байна.

***Асуулт 241:*** *Зохих заавар зөвлөгөөгүйгээр бясалгал хийх юм бол галзуурах юм уу, чөтгөрийн нөлөөнд ордог гэж үнэн үү?*

**Багш:** Тийм ээ, энэ үнэн шүү, үнэн. Тиймээс миний заасан юуг ч та нар бусдад зааж болохгүй. Тийм учраас ахуй ойлголт болон бясалгалын аргаа бусдад ярихыг би шавь нартаа зөвшөөрдөггүй. Бид хайр энэрэлгүй, эсвэл ямар нэгэн нууцыг хадгалахыг хүсээд тэгдэг юм биш! Шавь нар гэгдэх тэднийгээ хамгаалах хангалттай их хүч шавь нарт байдаггүй учраас л тэгдэг юм.

Тийм болохоор би ялгалгүй заадаг юм. Та нар над дээр ирэх шаардлага байхгүй. Ингэхэд л хангалттай. Би мэдчихнэ.

***Асуулт 242:*** *Өөр бясалгал хийж байгаа хүмүүс тэрнийгээ зөв нь гэж яаж мэдэх вэ? Таны энэ аргыг оролдоод үз гэж тэдэнд зөвлөх хэрэгтэй юу?*

**Багш:** Ийм юм л даа. Хүн болгон өөр, тийм учраас та өөртөө хамгийн сайн гэж санагдсан бясалгалаа л сонго. Арьяабалын арга бол хамгийн аюулгүй, хамгийн

хурдан, хамгийн сайн гэж би хэчнээн хэлэх нь үүнд хамаагүй. Та үүнийг хүлээн авахгүй байж магадгүй гэдгийг би ойлгож байна. Тиймээс танд өөрт чинь хамгийн сайн, аюулгүй гэж бодогдсон тэр зүйлээ л хий. Бясалгал тань танд амар амгалан, анир чимээгүй, билиг ухаан, хайрын сэтгэлийг улам л их өгч байвал тэр чинь зөв нь байна. Танд хор болохгүй.

Харин бясалгаад байхад хаа ч хүрэхгүй, ямар ч хайрын сэтгэл үүсэхгүй, билиг ухаан байхгүй, сэтгэл ханамжгүй, сэтгэл чинь амгалан биш байвал өөр бясалгалын аргыг хайж олох хэрэгтэй. Миний танд санал болгож байгаа арга бол үнэ төлбөргүй, ямар ч үүрэг, болзол тавихгүй, мөн энэ нь хамгийн сайн бөгөөд аюулгүй нь юм. Таныг Будда (гэгээрсэн Их Багш) болох хүртэл чинь хамгаална гэж би биечлэн баталгаа өгнө. Бусад аргыг та өөрөө турших үз. Би баталгаа өгч чадахгүй, бас тэрийг чинь хамгийн сайн нь гэж хэлж чадахгүй.

***Асуулт 243:*** *Гэгээрэхэд төрдөг тэр мэдрэмжийг дүрслэн хэлж өгнө үү?*

**Багш:** Дүрслэгдэх боломжгүй зүйлийг би яаж дүрслэн хэлж чадах юм бэ? Та ер нь дурлаж үзсэн үү? Тийм үү? Үзсэн үү, эсвэл үгүй юу? Үзсэн байна! Дурлахад тань төрсөн тэр мэдрэмжээ та бусдад дүрслэн ярьж өгч чадах уу? Мэдээж чадахгүй. Иймэрхүү зүйлийг бид яг өөрийн биеэр л үзэж, мэдрэх ёстой. Тэгэхлээр хамгийн сайн арга зам бол таныг бидэнтэй нэгдээч гэж урих л юм. Гэгээрэхэд юу мэдэрдгийг та маш хурдан мэдчихнэ. Авшиг хүртэх үед л та үүнийг агшин зуур мэдчихнэ. Энэ бол тун гойд сайн гэж л би танд хэлж чадна.

***Асуулт 244:*** *Хүндэт Их Багш аа, Хималайгаас бууж ирсний хувьд Та зарим төрөлтөнд яагаад билгийн мэлмий байдаг болон тийм хүмүүст яагаад тийм хүчний давуу тал өгөгддөг юм бэ гэдгийг тайлбарлаж өгнөүү?*

**Багш:** Бид бүгд л билгийн мэлмийтэй. Ердөө л заримынх нь хагас нээгдсэн, заримынх нь бүрэн нээгдсэн, зарим нь таг сохор байдаг юм. Яагаад ийм байдаг вэ? Шалтгаан ба үр дагаврын хуулиас болоод л тэр. Зарим хүн урд төрөлдөө, эсвэл энэ насандаа сайн үйл хийсэн байдаг. Зарим хүн гэгээрсэн Их Багштай тохиолдлоор тааралдаж, санамсаргүй адислуулчихдаг, ингэснээр билгийн мэлмий нь гэнэт нээгддэг.

Тэд мөн олон төрөлдөө бясалгасан болон гэгээрлийн зарим дэст хүрсэн хүмүүс ч байна. Тийм хүмүүс энэ төрөлдөө үргэлжлүүлэн ахиухан бясалгадаг. Эсвэл хэрвээ билгийн мэлмийгээ нээлгэхийг хүсч байвал, та явж эрж сураад, билгийн мэлмий нь аль хэдийн нээгдсэн бөгөөд бусдын билгийн мэлмийг нээхэд тусалж мэддэг тийм гэгээрсэн Их Багшийг олж болно. Тэгвэл та билгийн мэлмийтэй болно. Хүн болгонд билгийн мэлмий заяасан байдаг.

***Асуулт 245:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, шумуулыг яах вэ? Шумуулыг бас алж болохгүй юу?*

**Багш:** Болохгүй, бид алах ёсгүй!

**Асуулт:** *Гэхдээ шумуул биднийг хазаж, өвчин тараадаг. Шумуулыг хороогоод өөрсдийгөө хамгаалж болохгүй юу?*

**Багш:** Шумуул өөрийн үүрэгтэй. Шумуул та нарыг босгож, бясалгуулахын тулд тэгснээр шөнө сэрээдэг юм. (Үзэгчид инээлдэж, алга ташив.) Бид дандаа өөдрөг байх хэрэгтэй. Бид үргэлж амьдралын гэрэл гэгээтэй талыг харах ёстой.

Шумуулнаас салахын тулд та нарын хийж болох олон зүйл бий. Та тор хэрэглэж болно. Шумуулны тор өлгөөд гэрээ цэвэрхэн байлгаж болно гэх мэт. Гэхдээ Арьяабалын арга бүр шумуулыг ч та нараас хол байлгаж чадна гэж та нарт хэлэх байна. Арьяабалын бясалгалын аргаар авшиг хүртсэнийх нь дараа манай олон шавь нарын гэрээс шумуулнууд гэнэт баяртай ч гэж хэлэлгүй яваад өгсөн. (Үзэгчид инээв.) Тэд баяртай гэж хэлээд явахгүй байвал та шумуулны тор, эм, мөн ариун явдалт амьдралаараа өөрийгөө шумуулнаас хамгаалж болно.

Хэрвээ та “Rau Ming” буюу хэн нэгний амийг уучилж, амьдрал дахин бэлэглэх юм бол Бурхан танд хамгаалалт өгнө. Ийм учраас л би та нарт амьтны биеийг битгий ид, тэгвэл амьтад та бүхэнд нөхөрсөг хандана гэж хэлдэг юм. Шумуулны амийг тасалж, өөрийгөө хамгаална гэдэг тийм ч тустай зүйл биш. Бид магадгүй өт хорхойн өвчин тусч, эсвэл өөр нэгэн төрлийн өр төлөөсөнд унах байх.

Тэгэхлээр Бурханы хайр, Буддагийн энэрэл нигүүлсэлд бууж өгөх нь өөрийгөө хамгаалах хамгийн сайн арга болно. Хамгаалалт, тусламж, замчлалыг хүсэн өдөр бүр чин сэтгэлээсээ залбир, өдөр болгон хамгийн багадаа хагас цаг бясалга, хамаг амьтныг энэрч өршөөхийг хичээ. Энэрэл хайрын илэрхийлэл болгож ургамал хоолыг чадахын хирээр хэрэглэ, тэгвэл амьдрал тань хэрхэн дээрдэн өөрчлөгдөхийг харах болно. Бид гай гамшгаас үргэлж зугтааж чадахгүй. Бид өөрсдийгөө буян хариулал, Бурханы хамгаалалтаар л хамгаалах ёстой. (Гэвч арга бүхэн бүтэлгүйтэж, шавж хорхой бидний эрүүл мэндэд дэндүү халдвал нөхцөл байдалдаа зохицуулан арга хэмжээ авах ёстой. Гэхдээ энэ үйлийн үрээ угаахын тулд ахиухан бясалга.)

**Асуулт 246:** *Зөв бясалгал хийж байна гэдгээ хүн яаж мэдэх вэ? Илүү ахисан төвшний бясалгал гэдгийг хэрхэн мэдэх вэ?*

**Багш:** Би танд түрүүхэн хэлсэн. Аливаа бясалгал танд хайр энэрэл, билиг ухаан, сэтгэл ханамж, амар амгаланг өгч байвал энэ нь ямарваа байдлаар наанадаж л зөв. Танд хор болохгүй. Танд ашиг тусаа өгч л байвал тэр зөв бясалгал юм.

Үүний адил нэгэн шалгуур нь та хэдий их хайр, амар амгалан, билиг ухаантай болно, та төдий чинээ ахисан байна гэсэн үг. Ингэж л бид бясалгалаа хэмжинэ. Өдөрт өчнөөн олон цагаар бясалгадаг ч бусдыг хайрлахгүй, хүлцэмж тэвчээр байхгүй, сэтгэл нь амгалан биш, билиг ухаанаа нэмэхгүй, оюун ухаанаа ахиулахгүй байгаад байвал тэр бясалгал үр жимсээ өгөхгүй байна.

Арьяабалын бясалгал бол хамгийн шилдэг нь. Яагаад тэр вэ? Та өөр дээрээ маш түргэн өөрчлөлтийг мэдэрнэ. Та бүрмөсөн өөрчлөгдөнө. Өмнө нь та уурладаг,

тэнэг, юманд удаан байсан бол одоо огт өөр болж, илүү их хайрын сэтгэлтэй, амар амгалан, тэвчээртэй, мэргэн ухаантай болдог. Урд нь та судар ном, Библи уншаад юу яриад байгааг нь ойлгодоггүй байсан. Арьяабалын аргаар авшиг хүртэж, бясалгасны дараа судар номд бичсэн бүх зүйлийг маш хурдан ойлгодог болно. Та хэнээр ч тайлбарлуулалтгүй болно. Энэ бол Арьяабалын аргаар бясалгасан бидний туршлага. Ийм учраас л бид Арьяабалын арга бол зөв, сайн гэдгийг мэдээд байгаа юм.

***Асуулт 247:*** *Бид аль нэг шашныг дөвийлгөх гээд байна. Эхнэр маань Христийн шашин луу, харин би Буддын шашин луу хэлбийгээд байдаг юм. Би яавал таарах вэ?*

**Багш:** Тэгвэл та өөрөө Бурханы шашны хийд рүү яваад харин эхнэрээ сүм рүү илгээчих. (Үзэгчид алга ташив.) Тэгээд орой нь буцаж ирээд тус тусын очсон газраасаа юу олж авснаа хэлэлц. Ингэвэл амьдрал чинь улам баян болно. Та хоёр салангид тусдаа зүйлээс суралцаад гэртээ ирэхээрээ нэг нэгэндээ зааж сурга! Энэ сайн зүйл биш гэж үү? Их сайн шийдэл! (Алга ташив.) Баярлалаа.

***Асуулт 248:*** *Дахин төрөхийг та юу гэж үздэг вэ?*

**Багш:** Би дахин төрөл авахад итгэдэг. Үнэндээ бид үүнийг өөрсдийнхөө хувьд харж болно. Арьяабалын аргаар бясалгахад маш олон өөр өөр дэс төвшин байдаг. Хамгийн Нэгдүгээр төвшинд та Гэрэл, Аялгуу, сайхан үзэгдэл, гоё хүмүүсийг үзэж сонсоно, тэгээд өөр өөр ертөнцөөр явна, янз янзын ид шидийн хүчтэй болно. Энэ бол Нэгдүгээр төвшин. Хоёрдугаар төвшинд та өөрийн болоод бусад хүний өмнөх төрлүүдийг харна. Тэр үед та дахин төрөх үйл явц лавтайяа, бүр жинхэнээсээ байдаг гэдэгт итгэнэ. Бусдаас цуу яриа сонсох шаардлага байхгүй, түүнийг өөрөө л мэдчихнэ. Гуравдугаар төвшинд та янз бүрийн зүйлийг үзэж мэдэрнэ. Дөрөв, тав дугаар төвшин байна. Дахин төрөхүй гэж байдгийг би ингэж л мэдсэн. Дахин төрөхүй байдгийг шавь нар маань ч ингэж л мэдсэн. Бид бусдын ярихыг сонсож, эсвэл Библи болон бусад судраас үүнийг уншсандаа ингэж байгаа юм биш. Бид үүнийг өөрсдөө үзэж мэдсэн юм,.

***Асуулт 249:*** *Бясалгалын үед ямар ч бодолгүй төвшинд хүрэхэд, үүнийгээ мэдрэхийн тулд ямар чадварыг ашиглах вэ?*

**Багш:** Бид ямар нэгэн чадварыг ашигладаггүй. Тийм үед бидэнд ямар ч сэтгэл, хэл, чих, нүд, бие, мэдрэмж, бодол байдаггүй. Бид зүгээр л үүнийг мэддэг. Зүгээр л үүнийгээ мэдэж, мэдэрч, үүндээ бүрэн итгэлтэй байдаг. Юмсыг харахын тулд бид нүд хэрэглэдэггүй, сонсохын тулд чих хэрэглэдэггүй. Тэрхүү ахуй ойлголтыг тооцоолж, анализ хийхэд тархиа хэрэглэдэггүй. Бид зүгээр л мэдчихнэ! Яг л юу гэдгийг нь би мэдэхгүй байгаатай адил. Та өөрөө ч хэлж чадахгүй байгаа юмыг хүмүүс яаж хэлж чадах юм бэ. Үүнийг тайлбарлахад хэцүү. Би энэ эгэл жишээг л авч хэрэглэх байх. Жишээлбэл, та хүнд дурлаад, тэр хүн чинь бас танд дурласан бол та хоёр хоёулаа мэднэ! Ямар чадварыг ашиглаж байгаагаа ч та хоёр мэдэхгүй, та хоёр

зүгээр л түүнийгээ мэдэрч, жаргалтай байх болно. Гэхдээ энэ бол их ядмаг жишээ. Би үүнээс дээр жишээ олж чадахгүй байна, тиймээс бүгдээрээ үүнтэй эвлэрчихье.

***Асуулт 250:*** *Гэгээрлийн утга учир юу вэ?*

**Багш:** Гэгээрнэ гэдэг нь мунхаг харанхуйн эсрэг зүйл нь. Жишээлбэл, өмнө нь бид хайрын талаар мэддэггүй, орчлон ертөнц, бие махбод, Бурхан, Буддагийн ажилладаг учир начрыг мэддэггүй байсан. Мөн хэн гэдгээ, хаанаас ирснээ, нас барсны дараа хаашаа явахаа мэддэггүй, энэ бол мунхагийн харанхуй юм. Тэгвэл гэгээрэл гэдэг нь энэ бүгдийг мэднэ гэсэн үг. Үүнээс илүү дээшээ, та хэдий их гэгээрнэ, төдий их хүчирхэг болно. Энэ хүч бол бяр чадлын хүч биш. Энэ нь хүн бүхэнд таныг хайрлах боломж өгдөг тун их хайрлагч хүч юм, энэ хайрын хүчээрээ хүн бүхнийг аврах боломжийг танд өгнө.

Жишээлбэл, бидэнтэй хамт Арьяабалын аргаар бясалган гэгээрэх юм бол таны дотоод дахь хайрын энэ хүч нээгдчих учраас таны аль хэдийн өөд болсон таван үеийн ах дүүс чинь аврагдах болно. Хэрэв тэд тамд байвал тамаасаа Диваажинд очно, амьтан болж төрсөн байвал хүний ертөнц рүү очно. Тэгээд тэд гэтлэгдэнэ. Гэгээрэл гэж нэг иймэрхүү юмыг л хэлнэ. Гэвч ийм богино хугацаанд үгээр илэрхийлэхэд хэцүү өөр олон зүйлийг холбож хэлэхэд над амаргүй байна. Тиймээс та Арьяабалын аргаар бидэнтэй бясалгаж, өөрөө гэгээрэлд хүрэх нь хамгийн сайн. Удаж төдөлгүй та мэдэхийг хүссэн бүхнээ мэдчихнэ.

***Асуулт 251:*** *Будда Бурхан хоёр ижил үү? Бурханд итгэх нь дээр үү, эсвэл Буддад итгэх нь дээр үү?*

**Багш:** Бурханы хүч болон Будда чанар хоёр адилхан гэж би хариулна. Гэхдээ Будда гэдэг нь ялгаатай. Бидэнд зааж сургахын тулд Бурханы хүч болон Буддагийн хүчнээс төрсөн Будда нар (бүрэн гэгээрсэн оршихуй) Их Багш нар энэ дэлхийд төрдөг. Бидэнтэй ойр холбоотой байхын тулд нэгэн Будда энэ дэлхийд төрөхдөө тэрхүү Бурханы хүчийг Өөртөө агуулж байдаг. Тэр өөртөө Буддагийн хүчийг агуулсан байдаг. Би ялгаварлаж үздэггүй. Эмэгтэй хүн ч бас Будда (гэгээрсэн Их Багш) болж чадна. Гэхдээ тэрхүү Хүч бол угтаа хүн биш. Тэр бол нэгэн оршихуй, Тэр бол Хүч, гайхамшигтай хайр. Үүнийг бид үгээр дүрслэн хэлж чадахгүй. Гэхдээ энэ хүч төсөөлөхийн аргагүй аугаа бөгөөд хайр энэрэлтэй. Энэ нь хамаг зүйлийг бүтээж, мөн түүнийгээ хайрлан халамжилж байдаг. Харин заримдаа тэрхүү бүтээлүүд нь нөгөө хамгийн аугаа Хүчнийхээ заавар зөвлөгөөг сонсдоггүй. Тийм учраас тэр аугаа хүч хүний биед хувилж буудаг юм. Бидний дотоодод байгаа аугаа Хүчинд хэрхэн итгэхийг бүх оршихуйд заахын тулд энэ эгэл хорвоогийн дүр төрхтэй махан биеийг ашигладаг юм. Ийм болохоор л Христийн шашинтнууд; ***Та бол Бурханы сүм гэдгээ тань, Бурхан дотор чинь оршин буй*** гэж ярьдаг. Бурхан таны дотор амьдардаг гэсэн байна. Будда бас ***Хамаг амьтан дотооддоо Бурхан чанартай*** гэж хэлдэг. Үүний утга нь тэр.

Одоо бол Буддагийн хүч, Бурханы хүч, Будда нар, элч мэргэд бүгд өөр. Элч мэргэд энэ дэлхий дээр илгээлт, Бурханы хайр, Буддагийн хүчийг авчирдаг. Буддагийн хүч буюу Бурханы хүч нь хамаг амьтны дотоодод амар амгалан, хайр энэрлийг агуулаад байж л байдаг. Гэхдээ энэ хүч өөрт чинь би энд байна шүү гэдгээ мэдэгддэггүй. Хэрэв мэдүүлэхийг хүсвэл нэгэн биед хувилна, тэгээд танд хэрхэн аяглах, дотоодод байгаа аугаа чанараа, Бүтээгчийн аугаа чанарыг, Буддагийн аугаа Хүчийг хэрхэн танихыг сануулж хэлж өгөхийн тулд хүмүүн биеэ машин болгон ашиглана.

Будда бол зөнч мэргэн (the Prophet) хүн. Англи хэлээр бол Будда гэдэг нь зөнч мэргэн хүн буюу хамгийн дээд Хүчний илгээлтийг бидэнд авчирч байгаа гэгээрсэн Их Багш юм. Будда болон Бурханы хүч буюу Бурханы хооронд багахан ялгаа энэ л юм. Гэвч үнэн хэрэгтээ тийм их ялгаа байхгүй. Яагаад тэр вэ?. Учир нь Будда буюу зөнч мэргэн тэр хүн аль хэдийн Бурхантай нэг болчихсон. Луузын хэлснээр **хамаг амьтан нэгэн цогц** бөлгөө. Мөн Есүсийн хэлснээр **Би Эцэгтэйгээ нэг**, үүний утга нь Тэр ба Бурхан хоёр нэгдмэл гэсэн үг. Будда хэлэхдээ ***Би Будда болчихлоо, Би болон хамаг амьтан одоо хоорондоо ялгаварлагдахгүй*** гэсэн. Ингэж хэлэх хэцүү.

Угтаа хамгийн төгс дээдийн үүднээс ярьвал Будда нь хамгийн дээд Бурханаас өөр биш, Будда гэдэг нь зөнч мэргэн гэсэн үг. Гэтэл энэ хорвоогийн үүднээс ярьвал Тэр ялгаатай. Яагаад? Учир нь Бурхан бол Бурхан, Будда буюу Зөнч мэргэн нь бас Бурхан, тэгсэн хэрнээ бас хүн төрөлтөн. Тэрбээр хүний амьдралд амьдарч хүн шиг харагддаг. Түүнд бас хүнд байдаг сул талууд бий. Хооллох, бие засах, унтах, ярих, хувцас өмсөх, өвдөх ёстой болдог гэх мэт хүний биед байдаг зайлшгүй хэрэгцээ Түүнд бий. Энэ үүднээс харахад тэр бүрэн төгс Бурхан биш, гэхдээ Тэр өөр дотроо бүрэн төгс Бурханы хүчийг агуулдаг, ийм бол Бурхан бол хэзээ ч өвдөхгүй. Бурхан хэзээ ч бие засахгүй, хэзээ ч зоогийн газарт орохгүй гэх мэт. Тэгэхээр бидний билиг ухаангүй нүдээр бол тэдний хооронд ялгаа байна. Гэхдээ уг нь бол ялгаа байх учиргүй, учир нь энэ махан бие бол тэр аугаа нэгний ердөө машин нь л юм. Энэ хэцүү л дээ гэхдээ ойлгохыг хичээнэ үү.

Тиймээс та Бурханд итгэдэг бол энэ чинь сайн. Өөрийнхөө зөнч мэргэнд итгэдэг бол энэ чинь бас л сайн. Зөнч мэргэн хүнээрээ дамжуулан Бурханд итгэ, Буддагаар дамжуулж Бурханд итгэнэ, энэ бас л дажгүй хэрэг. Есүс: ***Надаар дамжихгүйгээр хэн ч Эцэг рүү очиж чадахгүй*** **гэж хэлсэн байдаг. Будда ингэж хэлжээ:** ***Та Буддатай уулзаагүй, Буддаг хараагүй бол гэтлэгдэж чадахгүй. Та хамгийн дээд төвшний гэгээрэлд хүрч чадахгүй***. Эдгээр нь төстэй. Янз янзаар хэлсэн болохоос л биш, ижилхэн утга агуулсан байна.

***Асуулт 252:*** *Зарим хүн трансцендентал* [*] *бясалгал (transcendental) болон* Арьяабалын *аргын тухай асууж байна. Ямар ялгаа байна вэ?*

---

[*] *Трансцендентал (хэтийдсэн, чанагуухид хүрэх) бясалгал (амар амгалан, бүтээлч байдал болон оюун санааны сайн сайханд хүрэхийн тулд тарни уншдаг бясалгалын арга)*

**Багш:** Үүнд маш том ялгаа бий. Яг л эрэгтэй, эмэгтэй хүн шиг ялгаатай. Маш том ялгаа бna. Арга нь адилгүй, сахил санваар нь ч яг ижил биш. Жишээлбэл, трансцендентал бясалгалд суралцвал тэд танд яагаад ургамал хоолтон байх, яагаад сахил санваараа чандлах ёстойг нарийн тайлбарлаж өгөхгүй. Амь хороож болохгүй, хулгай хийж болохгүй, худал хэлж болохгүй, садар самуун явж болохгүй, хар тамхи хэрэглэж болохгүй, мөрийтэй тоглож болохгүй гэх зэрэг Удирдамж зарчмыг, таван Сахилыг та яагаад тодорхой сайн чандлан баримтлах ёстойг хэлж өгөхгүй. Тэд үүнийг онцлож үздэггүй. Мөн тэд танд өдөрт хорин минут бясалгахыг заана, илүү хийж болохгүй. Гэтэл манай бясалгал түүнээс илүү хатуу чанга. Та ургамал хоолтон байх ёстой. Өдөрт 2 цаг 30 минут тогтмол бясалгах ёстой. Бас Сахилаа сайн сахих ёстой. Маш их ялгаатай жижиг сажиг зүйл олон бий. Бас бясалгалын техник нь ондоо. Эдгээр нь адилгүй.

***Асуулт 253:*** *Очироор огтлогч сударт Будда хэрэв ямар нэгэн хэлбэр загвар, дуу чимээнд хүлэгдвэл Будда чанараа олж чадахгүй гэж хэлсэн байдаг. Та хүмүүст Бурханы гэрэл, Буддаг, Үг болон Буддагийн Аялгууг үзүүлэхийн төлөө Арьяабалын аргыг зааж байгаа нь хэлбэр дүрс, дуу чимээнд хүлэгдэж байгаа хэрэг биш үү?*

**Багш:** Би “Үгүй!” гэж хэлнэ. Энэ бол тэр дуу чимээ, тэр хэлбэр дүрс биш. Учир нь түүнийг харахад нүдийг, сонсоход чихийг ашигладаг юм биш. Тэр бол амар амгалан зүйл. Буддагийн хэлээд байгаа хэлбэр дүрс, дуу чимээ нь жишээлбэл, дүрст бэлгэдлүүд, Буддагийн баримал хөшөө зэрэг гадны дуу чимээ, хэлбэр дүрс юм. Бид ийм зүйлд сэтгэл хүлэгдэх ёсгүй. Судар номын үг хэлтэй ч зууралдах хэрэггүй, Буддагийн хэлэх гэсэн дуу чимээ, хэлбэр дүрс нь энэ юм! Учир нь бид үүнийг чихээр сонсож, нүдээр харж чадна. Будда үүнийг л дуу чимээ болон хэлбэр дүрс гэж нэрлэсэн. Түүнээс биш бид дуу аялгуу, хэлбэр дүрс гэж хэлж чадахгүй шүү дээ. Арьяабалын аргын дуу чимээгүй Аялгуу, хэлбэр дүрсгүй Хэлбэр бол Буддагийн хэлсэн тэр зүйл биш. Тийм байсан бол, Будда баруун зүгийн Диваажин, “Pa Kung Tei Shui”, найман буянт рашаан ус, Буддагийн хэлбэр дүрс, Буддагийн орон гэх зэргийг дурдаж хэлэхгүй байх байсан.

***Асуулт 254:*** *Авшиг гэж юу вэ? Арьяабалын бясалгалын арга гэж юу вэ? Гэгээрэхэд хэр их хугацаа орох вэ?*

**Багш:** Гэгээрэхэд тань туслахын тулд авшиг байгаа юм, та гэгээрлийг агшин зуур олно. Харин хэрхэн авахыг тайлбарлаж өгөхөд цөөн хэдэн цаг орно. Авшгийн дараа хэрхэн бясалгах вэ? гэх мэтчилэн. Авшиг болон гэгээрэл гэж энийг л хэлж байгаа юм. Үүнд маш бага хугацаа ордог, тун хурдан. Тайлбарлахад л их цаг ордгийг эс тооцвол гэгээрэл өөрөө их хурдан. (Их Багш хуруугаа инчдэв.)

***Асуулт 255:*** *Зовлонгийн шалтгаан юу вэ?*

**Багш:** Өө! Өмнө нь та бусдад зовлон тарьж байсан учраас тэр. Тэгэхээр нэмж зовохыг хүсэхгүй байгаа бол бид зовлонгийн шалтгааныг таслан зогсоох хэрэгтэй.

Бусдад сайн үйл хийх хэрэгтэй. Бид тэдэнд зовж зүдэрч, гуньж гутарсан, санхүүгийн бэрхшээлтэй үед нь туслах хэрэгтэй. Тэгвэл хариуд нь танд амар амгалан ирнэ.

***Асуулт 256:*** *Хүн төрөлхтөнд шунал хүсэл, атаа жөтөө, үзэн ядалт, хүсэл тачаал гэсэн дөрвөн том саад тотгор байдаг. Тэгвэл бид энэ дэлхийд энэ дөрвөн муу зүйлийг аль болох бага үйлдэх гэж төрдөг гэж Та боддог уу?*

**Багш***:* Аль болох бага үйлдэх ээ? Та ингэж хэлсэн үү? Тийм ээ, бид эдгээр хүсэл шуналаа багасгахыг хичээх хэрэгтэй, гэхдээ зөвхөн бясалгал болон ариун явдалт амьдралаар л ингэж чадна.

***Асуулт 257:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, бүх юм мөнх бус гэж Будда хэлсэн. Будда чанар, Бурхан, ер нь аливаа бүхэн бас л мөнх бус уу?*

**Багш:** Үгүй ээ. Бүх юм гэдэг нь материаллаг зүйлсийг хэлж байгаа юм. Бидний харж, барьж, сонсож байгаа дуу чимээ, хэлбэр дүрс юм. Эдгээр зүйл мөнх бус. Харин Будда Чанар, Бурхан л мөнх, үүрдийн.

***Асуулт 258:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, хүн төрөлтөн хаанаас ирсэн юм бэ?*

**Багш:** Хаанаас ирсэн юм бэ гэж үү? Гэгээрлийн өндөр зэрэгт хүрснийхээ дараа л та үүнийг мэднэ.

***Асуулт 259:*** *Ургамал хоолтон байх нь амьтны амийг шууд бусаар хороож байгаа хэрэг биш үү? Жишээлбэл, хөдөлдөггүй л болохоос ургамал чинь амьтай.*

**Багш:** Энэ үнэн. Тэгээд та өлсөж үхмээр байгаа юм уу? Та мах идэж чадахгүй, дээр нь ургамал хоол идэх хүсэлгүй байгаа бол баяртай л гэх байх даа. Мэдээж, ургамал хоол идэж байгаа нь бас л амь хороож байгаа хэрэг, гэхдээ ургамлын амь тийм бодитой биш, мэдрэмж нь хүчтэй биш, үйлийн үр нь тийм ч хүнд биш. Өдөр бүр бясалгаад байвал бид тэр өрөө арилгаж дийлнэ. Харин амьтан идвэл, ингэсэн үйлийн үрээ угааж арилгахад амар бус.

***Асуулт 260:*** *Эрхэм Их Багш аа, Оройн Дээд Бурхан, Бурхан Будда зарим хүнд үзэсгэлэнтэй царай, амьдралын сайхан орчин нөхцөл, амьдралдаа баясч цэнгэх сайхан цэцэг бүхий гоё орчныг өгдөг гэж Та хэлсэн. Тийм биз! Тэгвэл би ингэж асуух гэсэн юм, яагаад оройн Дээд Бурхан, эсвэл Бурхан Будда Африк гэх мэт олон мянган хүн нь өлсөж үхэж байгаа тийм орны зовсон хүмүүст ийм тэгш бус, нинжин бус ханддаг юм бэ? Ау Лак (Вьетнам) гэх мэт зарим газар нь хүмүүс бие биенээ хөнөөж байна. Яагаад?*

**Багш:** Энэ нь Бурханы таалал биш, Буддагийн шийдвэр ч биш. Энэ бол бидний өөрсдийн маань л хийж байгаа ажил. Бурхан хэзээ ч бидэнд ал гэж хэлээгүй, тийм биш гэж үү? Бурхан тэгж хэлж байхыг та ер нь сонссон уу? Гараад нэг нэгнийхээ амийг хөнөө гэж Будда сургаж байхыг та дуулсан уу? Тийм юм байхгүй! Тэгэхлээр энэ бол бидний хийсэн зүйл, өөрсдийн маань хариуцлага. Ийм учраас л би та нар

дээр ирж, дахиж ингэж болохгүй гэдгийг сануулж байгаа юм. Бид бие биенийгээ хайрлаж, амар амгалан амьдрах ёстой. Бүр амьтдад хүртэл ингэж хандах хэрэгтэй, тиймээс би та нарт ургамал хоол ид гэж сануулаад байгаа юм. Өөрийгөө хамгаалж чадахгүй амьтад шиг тийм жижиг, даруу, сул дорой төрөлтнийг хамгаал. Тэгэхээр дээрх зүйл бол Бурханы хийсэн хэрэг биш. Үүнд Бурхан, Буддаг бүү буруутга. Бурхан бидэнд зөвхөн хайр өгч, хамгаалдаг. Бидний хүлээн зөвшөөрч, ойлгож ухаарч дийлээгүй хэвээр буй хүчийг ч бас өгсөн. Харин бид үргэлжлүүлэн буруу зүйл хийсээр л байна. Бид Бурханы тааллын яг эсрэг зүйлийг хийдэг тул хариуд нь зовдог.

***Асуулт 261:*** *Та чухам хэний заавар зөвлөгөөн дээр бясалгадаг вэ? Таны шашныг бид юу гэж нэрлэх вэ?*

**Багш:** Надад шашин байхгүй гэж би та нарт хэлсэн. Шашин бүхэн миний шашин гэж л би хэлэх гэсэн юм. Би бүх шашныг хүндэлдэг. Учир нь шашин болгон хүмүүст сайн үйл хийх, бие биендээ сайн сайхнаар хандах, хамаг амьтныг энэрэх тухай заадаг. Аливаа шашны ямар ч хүн яг үүний эсрэг зүйлийг хийх юм бол энэ нь тэр хүний л хариуцлага болохоос биш, тэр шашин нь, эсвэл шашныг үндэслэгч нь хариуцах зүйл биш. Тэгэхээр ямар ч шашныг бид муу гэж хэлж болохгүй. Харин тэр шашныг дагаж байгаа зарим хүн тухайн шашнаа ойлгохгүй, эсрэг зүйлс хийж байна даа гэж л хэлж болно.

Тиймээс та нарын аль ч шашин миний шашин. Би өөрийн чинь шашны сайн сайхныг сануулж хэлдэг, таныг итгэж биширдэг Бурхан, Будда, Дао-даа улам их итгэ гэж л хэлдэг. Гэхдээ та итгэж бишрч буй зүйлээ танин мэдсэн байх ёстой. Та итгэж биширдэг тэрхүү Хүчтэйгээ холбогдсон байх ёстой. Хэрвээ та тэр хүч, Христийн Хүч, Бурханы Хүч, Буддагийн Хүчтэй нэвтрэлцээгүй байгаа бол би танд туслая, энэ л юм. Хэрэв та Арьяабалын аргаар бясалгавал Есүс, Мухаммед, Будда, Аллах гээд итгэдэг бүхэнтэйгээ холбогдож чадна, учир нь энэ бол хаа л бол хаана хүрдэг арга зам нь юм. Яг л та төв замд орчихвол маш хурдан явж чаддагтай адил. Энэ төв замаасаа та өөр өөр тийш эргэж болох байх, гэхдээ энэ бол хамгийн хурдан зам нь юм.

***Асуулт 262:*** *Өнөөдөр ярьсан дүрэм журмын үндэс, сахил санваар, итгэл бишрэлийнхээ тухай бидэнд хэлж өгөөч?*

**Багш:** Бурхан минь, хоёр цагийн турш ярьсны дараа та ийм зүйл асууж байгаа юм уу? Энэ чинь та унтчихсан байсан гэсэн үг! Миний хэлснээс та юу ч сонсоогүй байна. (Инээв.) Тэгээгүй юм бол юу гэж ийм зүйл асуух вэ дээ? Тийм биз! Магадгүй та самадид орчихсон байсан байх. За за. Миний зурвасыг авч чадаагүй бол гараад номуудаас маань ав, тэгээд чөлөөт цагаараа аажуу уужуу уншаад миний юу хэлэх гээд байгааг, ямар шашинд итгэдэгийг маань ойлгох болно. Үнэн Ёсыг түгээн дэлгэрүүлдэг гэдгээ би хэлсэн. Хамгийн Дээд бол миний итгэдэг нэгэн. Би бүх шашинд итгэдэг. Гэгээрснийхээ дараа та бас л ижил зүйлийг л харах болно. Та надтай адилхан үзэл бодолтой болно. Та үүнээс өөр үзэл бодолтой болох боломжгүй.

***Асуулт 263:*** *Энэ дэлхийд амьдрахдаа бид олон сөрөг нөлөөнд автаж, оюун санааны өндөр дээд төвшинд хүрч чадалгүй, эдгээр нөлөөллийн хохирогч нь болдог. Үүнийг хэрхэн давах вэ?*

**Багш:** Тийм ээ! Та Бурханы хүч, Буддагийн хүчинд найдах ёстой. Энэ Хүчийг хэрхэн авахыг мэдэхгүй байвал би танд тусалж болно. Түүнийг хаанаас авдгийг би мэднэ. Та авшиг хүртчих, тэгээд л мэднэ.

***Асуулт 264:*** *Энэ орчлонгийн хамаг амьтны төлөө залбирвал тэд үүнээс тус хүртэх үү?*

**Багш:** Тэгнэ, тэд хүртэнэ. Хүн болгон чин сэтгэлээсээ ингэж залбирдаг бол дэлхий маань хичнээн сайхан болж өөрчлөгдөхийг та төсөөлж байна уу. Бүгд бие биенээ хайрлаж халамжилна. Уур амьсгал амар амгалан, хайр энэрэлтэй болно. Тэд мэдээж ач тус хүртэнэ шүү дээ.

***Асуулт 265:*** *Дөнгөж сая та лус савдгийн тухай дурьдлаа. Тэр чинь юу юм бэ? Дэлхий дээр тийм олон бурхан байдаг гэдэгт би эргэлздэг. Тайлбарлаж өгнөүү?*

**Багш:** Хүмүүс модны сүнсийг шүтэх, нар, сарны бурханыг шүтэх, “Tu Ti Kung”-ийн бурханыг шүтэх нь лус савдаг юм. (Их Багш Хятадаар ярив. Tu Ti Kung гэдэг нь газрын бурхан.) Тухайн нутгийнхаа эзэн нь. Tu Ti Kung гэдгийг Англиар юу гэхийг би мэдэхгүй байна. Энэ бол Бурханы нэг төрлийн хязгаарлагдмал хүч юм. Олон янзын онгод (spirits) байдаг. Онгод савдгуудын хүч нь хязгаарлагдмал учир бидэнд учиргүй их тусалж чадахгүй. Бидний лус савдаг гэж нэрлээд байгаа зүйл бол тэр юм, нутгийн савдаг, онгод юм. За юу? Бурхан бол хамгийн дээд Бурхан. Хамгийн дээд Бурханыг л бид шүтэх ёстой. Нутгийн жижиг бурхадыг биш, хамгийн аугаа Будда Хүчийг л бид шүтэх ёстой.

***Асуулт 266:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, та өөрийгөө том гэгээрэлд хүрсэн гэж хэллээ. Үүгээрээ Та ямар санааг хэлж байгаа вэ? Та өөрийгөө Буддатай адил хамгийн төгс гэгээрэлд хүрчихсэн гэж хэлж байгаа юм уу?*

**Багш:** Тийм ээ! Би тийм л утгаар хэлсэн. Буддагийн хүрсэн бүх зүйлд би хүрсэн. Буддад байсан бүх юм над байна.

***Асуулт 267:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, бясалгалын Арьяабалын арга болон Випашяна, эсвэл оюунаа* ухаарах (mind awareness meditation) *бясалгал нь трансцендентал бясалгалын адил самадийн бясалгал мөн үү?*

**Багш:** Үгүй! Арьяабалын арга эдгээрийн аль нь ч биш. Арьяабалын арга бол Бурханы заавартай холбогдох, Буддагийн Аялгуутай, Буддагийн сургаалтай дотооддоо холбогдох арга юм. Бидэнд зааж сургахын тулд Будда нар өөр өөр хэлийг ашигладаг. Энэ нь бид хүн төрөлхтөн учраас хоорондоо харилцаж, бие биеэ сургаж, сураг ажиг авалцахдаа хүний хэлийг ашигладагтай л адилхан юм. Будда нар буюу Бурхан бидэнд заахын тулд өөр хэлийг хэрэглэдэг; Түүний Дуу хоолой, дотоод

Дуу хоолой, дотоод Хэлбэлзэл бидэнд маш олон зүйлийг зааж сургана; Арьяабалын арга гэж энэ юм. Энэхүү Буддагийн Дуу хоолой буюу Бурханы Дуу хоолойтой холбогдсоноор та одоо мэдэж байгаа зүйлээсээ хавьгүй ихийг мэдэх болно. Энэ бол Арьяабалын арга юм, харин трансцендентал бясалгал биш. Энэ бол өөр.

***Асуулт 268:*** *Та үүнийг яагаад Арьяабалын бясалгал гэж нэрлэдэг юм бэ? Энэ чинь Арьяабал өөрөө юм уу?*

**Багш:** Үгүй! Үгүй, бас тийм. Учир нь Арьяабал бодьсадва энэ аргаар бясалгасан юм. Мөн бид "Инь" гэгдэх Аялгуун дээр бясалгадаг болохоор үүнийг Гуан Инь гэж нэрлэдэг юм. Гуан, "Гуан Ча" (Их Багш хятадаар ярив. Энэ нь ажиглах гэсэн утгатай) гэдэг нь Аялгууг ажих гэсэн үг. Тиймээс л үүнийг Гуан Инь гэж нэрлэсэн.

***Асуулт 269:*** *Бид бусдыг үймүүлэхгүй амьдрахыг хичээж байна, гэвч хэн нэгэн хүн биднийг үймүүлэх гээд байгаа үед яавал таарах вэ?*

**Багш:** Тэвчээртэй байж, тэр хүндээ илүү их хайр илгээхийг оролд. Тэр хүндээ улам бүр эелдэг хандаж, түүнд юу хэрэгтэй байгааг анзаар. Түүнд таны хайр, анхаарал хэрэгтэй ч байгаа юм билүү. Заримдаа хүүхдүүд анхаарлыг чинь татах гэхээрээ хөлөөрөө газар дэвсэж, чимээ шуугиан тарьдаг. Таны хайр анхаарлыг хүссэндээ л ингэж байгаа юм. Заримдаа хөршүүд маань бас ингэдэг. Магадгүй тэр хүнд бидний өрөвч сэтгэл, энэрэл, хайр, тусламжийн гар, өрөвчхөн чих хэрэгтэй болсон байж магадгүй. Түүний асуудлыг сонсож, ажил хийхэд нь тусал. Түүнд юу хэрэгтэй байгаа, юугаар тусалж болохыг асуу. Магадгүй таны чин сэтгэл, хайрын уур амьсгал түүнд нөлөөлж, сэтгэлийнх нь гүнд хүрэх байх. Тэгвэл таныг үймүүлэхээ болино. Үймээн самууныг шийдэх хамгийн сайн арга бол энэ юм.

***Асуулт 270:*** *Бясалгал, ховсдуулж ухаан алдах хоёр хоорондоо ямар ялгаатай вэ?*

**Багш:** Пээ, ёстой том асуулт байна. Бясалгал, ховсдуулах хоёр ялгаатай. Энэ нь та ямар төрлийн бясалгал хийдгээс хамаарна. Зарим хүн ухаан алдахаараа бие нь татвалзаж, ухамсраа алддаг, тэгээд буцаж сэрснийхээ дараа хийсэн юмаа мэддэггүй. Үүнийг ховс гэж нэрлээд байгаа юм. Энэ нь бясалгах үед самадид ордогтой адилгүй. Бясалгалын самадид орох үед та бүрэн ухамсарлаж байдаг, бас уймарч самуурах, үйл хөдлөл болон билиг ухаанаа мэдэрч ухамсарлахаа болих явдал гарахгүй. Ялгаа нь энэ.

***Асуулт 271:*** *Зохих зааварчилгаагүйгээр хүн өөрийнхөөрөө бясалгаж болох уу?*

**Багш:** Бясалгаагүй нь дээр ээ.

***Асуулт 272:*** *Эрхэм хүндэт Их Багш минь надад туслаач. Бурхан Будда судар номдоо цагаан хоолны тухай онцлон хэлж байсныг би санахгүй байна. Харин эсрэгээр нь Будда цагаан хоолны тухай сануулан хэлж байгаагүй шиг санагдаж байна. Будда Махакасяапа гэхэд л Буддагийн (Гэгээнтэн) хутагт хүрснийхээ дараа үүний нөлөөнд автаж, бярман гэр бүлийнхээ цагаан хоол идсэн өнө удаан*

*жилийн уламжлалыг эвдсэн. Гэвч би буруу мэдээлэл авсан юм болов уу гэж өөрийгөө хардаж байна. Хэрэв тийм бол намайг залруулж өгөөч.*

**Багш:** Та жижиг товхимлоос харна уу, танд байна уу, үгүй юу. Та гадагшаа гараад туслагч нараас маань тэр номыг асуу. Тэр номд би ургамал хоолтон байх олон шалтгааныг бичсэн байгаа. Би тэр өгүүлэлд Будда цагаан хоолыг онцлон хэлж байсныг тусгасан бүх судар номын эшлэлийг бичсэн байгаа. Жишээлэхэд “Neih Pan Ching” буюу Нирвааны судартнэгэн хувраг Буддагаас өглөгийн хоолон дотор мах орсон байвал яах вэ гэж асуужээ. Будда хариуд нь “***эхлээд махыг нь авч хаяад үлдсэн хоолыг сайтар угаасны дараа идвэл зохино.***” гэж хэлжээ. Будда цагаан хоолыг тоодоггүй байсан бол ингэж хэлнэ гэж үү? Мөн Сурангама судартБудда “***Мах идсэн хэн ч бай миний шавь биш. Ямар ч нөхцөлд, ямар ч төрлийн мах идэхийг би хатуу хориглож байна.”*** гэжээ. Гэртээ хариад үүнийг дахин унш. Ядаж л энэ хоёр судрыг унш. Энд дуусашгүй их эшлэл байгаа.  Харин одоо надад тэрнийг ярих цаг алга. Миний ном дахь “Ургамал хоолны Ач тус” гэдгийг та лавлаж үзээрэй, бас та мэдээлэл олж авна. Танд баярлалаа!

***Асуулт 273:*** *Бүтээл ямар утга учиртай вэ? Бурханы шашны зам мөрд үүнийг огт заагаагүй юу?*

**Багш:** Будда энэ талаар тодорхой хэлсэн, хэлээгүй бүтээл орших ёстой. Тийм биш байсан бол Тэр Өөрөө яаж оршиж чадах вэ? Бидний эргэн тойрон дахь бусад юм яаж орших болж байна? Бүтээл угаасаа оршдог. Энэ талаар ярих шаардлага байхгүй. Бүх юм байна. Энэ бүх зүйлийг бүтээдэг Аугаа хүч байна. Бид тэрхүү Хүчийг Бурхан, эсвэл Будда Чанар (дотоод Мөн чанар), эсвэл өөрийн сэтгэл гэж нэрлээд байгаа юм. Бүх юм сэтгэлээр бүтээгдсэн. Бүтээх хүчийг агуулж байдаг зүйл чинь энэ. Энэ чинь л бүтээл хэмээгддэг.

***Асуулт 274:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, цорын ганц, Бүхнийг Чадагч, хамгийн төгс дээд Бурхан гэж ганц л байдаг юм бол яагаад толгой эргүүлсэн ийм олон дээдийн ном сургаал байдаг юм бэ?*

**Багш:** Тийм олон янзын ариун сургаал гэж байдаггүй. Түүнд өгсөн олон янзын өөр өөр нэр л байдаг. Будда амь хороож болохгүй, худлаа ярьж болохгүй, хөршөө хайрла, садар самуун явж болохгүй, хар тамхи, архи, мах хэрэглэж болохгүй гэж адилхан л зүйл сургадаг. Библи бидэнд мөн л ижил зүйлийг сургадаг; амь хороож болохгүй, хөршөө хайрла, бурханаа хайрла, бусдыг уучил гэдэг. Ямар ялгаа байна вэ? Ердөө л өөр өөр нэртэй байна, тэгэхэд л хүмүүс түүнийг салгаж тусгаарлаад танд бусдыг нь судалхыг хориглодог юм. Жишээлбэл, та Буддын шашинтан бол Христийн шашны Библийг судалж болохгүй гэнэ. Мусульман шашинтан бол Буддын шашны судар номыг харж болохгүй гэнэ. Тэгээд л бид бие биенийхээ шашин, судар номын талаар мунхаг харанхуй байдаг. Бид юмыг мэдэхгүй байхынхаа хэрээр л их эргэлздэг. Бидэнд хэдий их асуудал бэрхшээл байна, төдий чинээ зайгаа барьдаг.

Бид этгээд хачин юмстай байнга шөргөөцөлддөг. Түүн доторх сайн сайхныг нь биеэрээ үзэж мэдрээгүй учраас бид гадаадын юмс, гадаадын сургаалын эсрэг байдаг. Бид тэдний алинаас нь ч суралцдаггүй. Тиймээс юу нь адилхан болохыг бид мэддэггүй. Цаг зав, тэвчээр, хайраа зориулаад бүх шашныг судлах юм бол тэд бүгдээрээ адилхан байгаа. Та Арьяабалын аргаар бясалгавал аль ч шашинд итгэж биширдэг бай, хамгийн оройд нь хүрнэ. Энэ бол очихыг хүссэн бүх газар луу тань хүрдэг хурдны төв зам юм. Бурхан бол Бүхнийг чадагч, харин бидний сэтгэл биш. Бурханы Аугаа байдлыг бид ойлгодоггүй. Бурхан биднийг төөрөлдүүлэхийг хүсдэг ч юм биш.

# Их Багшийн лекцийн асуулт, хариулт
## Малайз улс, Пенан, Хятад хорооллын өргөө
## 1989 оны 10 дугаар сарын 2

***Асуулт 275:*** *Гуан Шин Инь Пуса (Гуан Инь (Арьяабал)бодьсадва) болон Шагжамуни Будда хоёрт хоёуланд нь бид маш итгэдэг байна гэж төсөөлье.* (Их Багш тайлбарлав: энэ бол Буддын шашны нэр томъёонууд байна. Будда болон Гуан Шин Инь хоёр нь Буддын шашны хамгийн хүндэт гэгээнтнүүд юм.) *Тэгвэл бясалгаж байхдаа энэ хоёрын алийг нь сэтгэлдээ дуудвал хамгийн сайн бэ? (Инээв)* (Их Багш: Алийг нь сонгохоо мэдэхгүй энэ хүн асуудалтай тулгарчээ.) *Намайг болон биднийг мэргэн хариултаараа гэгээрүүлж хайрла.*

**Багш:** Энэ их амархан. Нэгийг нь өнөөдөр, нөгөөг нь маргааш дууд. (Их Багш болон бүгд инээв.) Гэхдээ ингэх шаардлага байхгүй; нэгийг нь, эсвэл нөгөөг нь дуудахад л хангалттай. Гэвч сэтгэл чинь аль нэг дээр нь тогтоогүй учраас та ээлжилж болно шүү дээ. Хэрэв та Буддагийн нэрийг дуудвал Түүний нэрийг бүтнээр нь дууд. Тэгээд “A Mi Tuo Fo (Амитаба Будда) Танд их баярлалаа” ингэж унш. (Асуултанд доторх тэмдэглэл) Тэр дотор нь дахиад өөр Буддаг нэмчихжээ. (Инээв) Ингэхээр би одоо танд алийг нь сонгохыг хэлэхэд бүр хэцүү болчихлоо. (Инээв) Долоо хоногт долоон өдөртэй байхад танд гурван Будда байна; тэгэхээр тус бүрийг нь хоёр өдөр унш, тэгээд Ням гарагийг надад үлдээчих. (Их Багш болон бүгд инээв.)

***Асуулт: 276:*** *Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай би нэг асуулт асуая. Унтлагын өрөөндөө бясалгал хийж болох уу?*

**Багш:** Тийм, бололгүй яахав, гэхдээ эхлээд эхнэртээ явж унт гэж хэлээрэй (Багш болон бүгд инээв.) Эсвэл нөхөртөө явж унт гэж хэлээрэй.

***Асуулт:*** *Орон дотроо бясалгаж болох уу?*

**Багш:** Тийм ээ, болно. Гэхдээ хажуу дахь хүн чинь таныг өшиглөхөд та Самадигаас их хурдан гарчих байх даа. (Инээв) Нөхөр чинь унтаж байхдаа сайхан зүүд зүүдлэж, зүүдэндээ хөл бөмбөг тоглох ч юм билүү. (Инээв.) Тэгэхээр ийм байдлаар самадид орно гэдэг их хэцүү. Өөр нэг бэрхшээл нь ор их зөөлхөн, унтахад уриалсан эд. Таван минут суусны дараа энэ нь нэг цаг суучихсан юм шиг санагдаж, “түр хажуулдчихья” гэмээр байдалд хүрдэг, тэгээд хэвтсэн л бол өглөө сэрүүлэг дуугарах хүртэл огт сэрэхгүй. (Их Багш инээв.) Тэгэхлээр ингэж бясалгана гэдэг хэцүү. Түүнээс биш

сайхан уур амьсгалтай, орчин нь чимээгүй, өшиглөж, эсвэл тэвэрч аваад байх хүн байхгүй л бол хаана ч бясалгасан зүгээр.

***Асуулт 277:*** *Маш олон асуудал бэрхшээл биднийг шаналгаж, бясалгал дээрээ төвлөрч чадахгүй бол яаж үүнийгээ давах вэ?*

**Багш:** Энэ нь ямар бясалгал хийж байгаагаас хамаарна. Амьсгалаа тоолдог бол тэр даруй амьсгалаа тоол; Будда, Есүс, Бурханы нэрийг дууддаг бол түүнийгээ дууд, миний заасан аргыг хийдэг бол билгийн төв дээрээ төвлөрөөд өөрийгөө тэндээ байлга. Тэгвэл бусад бүх санаа чинь алга болно. Мөн Бурханаас туслахыг гуйн залбир. Би таны ямар бясалгал хийдгийг мэдэхгүй байна, гэхдээ манай энэ арга бол төвлөрөхөд найдвартай, хамгаалах хүч болон адислал нь сайн, тиймээс танд төвлөрөхөд амархан байдаг.

Яагаад бид амархан төвлөрч чаддаггүй вэ? Учир нь бидний сэтгэл болон далд ухамсар өнгөрсөн төсөөлөл болон урд төрлийн сэтгэгдлүүдээр дүүрсэн байдаг. Тийм учраас нэгэн сайн Их Багш байгаа бол Тэр таны энэ бүх урьдны сэтгэгдлүүдийг танаас салган авснаар таны энэхүү уур уцаар, сэтгэгдлүүд багассан байх болно. Үүний дараа сэтгэлээ тогтоох нь хялбар болно. Тэгэхээр энэ бол авшиг юм, энэ нь таны хураасан өнгөрсөн сэтгэгдлүүдийг угааж, зүрх сэтгэл болон ухаан бодлыг тань амар амгалан болгоход туслана. Тиймээс л Арьяабалын аргын шавь нарт тайвшрах нь их амархан, уур уцааргүй болж, асуудал бэрхшээл багасдаг. Надтай хамт Арьяабалын аргаар бясалгаач хэмээн хүмүүсийг зоригжуулахын учир нь энэ юм. Түүнээс биш бүх арга сайн.

***Асуулт 278:*** *"A Mi Tuo Fo" (Их Багш; энэ бол Амитаба Будда гэсэн үг.) Их Багш аа, цагаан хоолтон хүн тахиа, нугасны өндөг идэж болох уу? Баярлалаа.*

**Багш:** Болно, та болно, гэхдээ үүнийг "өндөг иддэг цагаан хоолтон" гэж хэлнэ. (Инээв.) Өндөгний дотор тахиа байдаг учраас үүнийг бас "тахиа иддэг цагаан хоолтон" ч гэж нэрлэж болох юм байна. (Инээв.) Өндгийг тэр чигээр нь орхисон нь дээр. Өндөгний дотор хагас амь байдаг. Тэр байтугай зарим үр тогтоогүй өндөгний дотор аль хэдийн "Инь" хэсэг байдаг. "Инь, Янь" гэж та нар мэднэ шүү дээ. Тэгэхээр бид нэгэн төрлийн амь бүрэлгэж байна гэсэн үг. Мөн өндөг нь дур тачаалыг өдөөдөг. Тэгэхээр бясалгач хүний хувьд хамгийн эмээх зүйл нь дур хүслийг өдөөх явдал байдаг. Сэтгэл амар тайван байгаад бясалгая гэж бодож байгаа бол бид өндөг идэхийг бүр орхих хэрэгтэй.

Өөр нэг мэдээллийг би саналаа, та нарт хэлмээр байна. Эрт дээр үеэс шидтэнүүд чөтгөрт эзлэгдсэн хүний биенээс буг чөтгөрийг нь гаргахын тулд өндөгийг буг чөтгөрийг өдөөхөд байнга ашигладаг байжээ. Хэрэв та ходоодондоо өндөг хийчихвэл тэр чинь хадгалагдаж үлдэж магад шүү. Энэ нь та буг чөтгөрүүдийг ходоод руугаа өдөөн татаж байна гэсэн үг. (Их Багш инээв.) Тийм учраас л бид өндөг иддэггүй юм. Гэвч та юу хүссэнээ хий л дээ. Надаас асуусан учраас л би танд хэлж өгч байгаа юм. Маргааш олон өндөг зарж чадахгүй болчихвол намайг битгий буруутгаарай. (Инээв.) Би хэн нэгний бизнесийг нураах гээгүй юм шүү.

***Асуулт 279:*** *Хүн төрөлтөнд дэндүү их шаналал, бас хүсэл байдаг учраас энэ дэлхий дээр хэн ч төгс бясалгал хийх боломж эдэлдэггүй гэж би боддог. Та үүнийг юу гэж бодож байна?*

**Багш:** Бидэнд сайн арга байвал, чин сэтгэл байвал, сайн удам судартай бол төгс бясалгаж чадна. Будда нар, Шагжамуни Будда, Есүс болон бусад гэгээнтэн чадсан юм чинь бид яагаад чадахгүй гэж? Олон биш ч, зарим нь чадна.

***Асуулт 280:*** *Ши Фү (Англиар "их багш" гэсэн үг) та өөрөө гэгээрэлд хүрэв үү, эсвэл нэгэн багшаас авшиг хүртэж гэгээрэлд хүрэв үү?*

**Багш:** Би өөрөө гэгээрсэн. Гэхдээ надад олон багш байсан. Би үргэлж Их Багш байсаар ирсэн. Зарим хүн, та нарын зарим нь Намайг буцаж ирээсэй хэмээн залбирсан учраас Би дахин буцаж ирсэн юм.

***Асуулт 281:*** *Та Буддаг бүхнийг чадагч Бурхантай эн тэнцүү гэж үздэг үү? Будда нь бүхнийг чадагч Бурхантай адил бүтээгч үү?*

**Багш:** Өчигдөр орой би та нарт Бурхан болон Будда хоёрын ялгааг тайлбарлаж өгсөн. Та санаж байна уу? Тийм ээ, тэгэхлээр дахиж үүнийг ярих шаардлага алга. Би Бурханыг Буддатай дүйцүүлээгүй. Би өчигдөр Бурхан гэгддэг нь юу юм, Будда гэгддэг юу юм гэдгийг тодорхой тайлбарласан. Зарим хүн Бурханд, зарим нь Буддад итгэдэг болохоор тусламж авахын тулд Будда, эсвэл Бурханд залбирч болно л гэж би та нарт хэлсэн юм. Би нэг бүлгийг нь хасаж орхиод, зөвхөн нөгөөд нь заахыг хүсэхгүй. Надад тийм юм хийх сэтгэл байхгүй. Бурханд итгэдэг бол бололгүй яахав, Бурхандаа залбир; Буддад итгэдэг бол Буддадаа залбир. Харин би хоёуланг нь хэрэгтэй бол миний тусламж зөвлөгөөг авах гэж, эсвэл миний лекцэнд ирэхэд дуртайяа хүлээж авна.

***Асуулт 282:*** *Ямар ч шашинд итгэсэн ижилхэн гэж Та хэлэх гээд байна уу?*

**Багш:** Тийм ээ, ижилхэн. Зүгээр л жинхэнэ Христийн шашинтан бай, сайн Бурханы шашинтан бай, тэгвэл дэлхий маань амар амгалан болно. Гэвч ихэнх хүн тийм байж чаддаггүй. Олон хүн бие бие рүүгээ дайрч, нэг нэгнийхээ итгэл бишрэлд тус хүргэхгүй байна. Хэрэв Христүүд Буддистуудад тусалж, Буддистууд нь Христүүдэд тусалвал дэлхий энх амгалан болно. Есүс ч баярлана, Будда ч инээнэ. (Инээв, алга ташив.) Баярлалаа, тэгэх нь бие биендээ их урам өгнө. (Инээв.)

***Асуулт 283:*** *Будда биднийг мах идэх ёсгүй гэж ямар Дхарма, эсвэл аль Сударт хэлсэн бэ? (Дхарма гэдэг нь сургаал гэсэн Самгарьд үг, сутра гэдэг нь судар ном гэсэн үг)*

**Багш:** Дахиад л биш шүү! Та буцаж гараад миний ном, үлгэр дэвтрийг унш. "Ургамал хоолны ач тус" гэдэгт таны уншихийг хүссэн бүх судрын нэрийг би жагсаачихсан байгаа. Хэдэн арваараа байгаа.

***Асуулт 284:*** *Та өөрийгөө Буддатай холбогдож чаддаг гэж хэллээ. Будда нирваан руу явчихсан. Түүнд ямар ч хүсэл шунал гэж байдаггүй. Будда яаж Тантай холбогдож чаддаг юм бэ? (Их Багш инээв.)*

**Багш:** Надтай холбогдох шаардлага Буддад байхгүй. Тэр чинь Би! Би Будда надтай холбогддог гэж хэлээгүй. Би үүнийг зөвхөн та нарын төлөө л хэлсэн. Би бол Будда байна. Энэ болох уу? Үгүй юу? Болохгүй зүйл үү, зөвшөөрөхгүй юу? (Инээв.) Будда бид хоёр нэгэн цогц.

***Асуут 285:*** *Хүндэт Их Багш минь ээ, бясалгаад сууж байхдаа гурав дахь нүдэн дээрээ төвлөр гэж та ярьдаг. Ямар ч хүн ийм төвлөрөлд хүрч чадах уу? Энэ нь Арьяабал болон бусад Буддатай холбогдохыг боломжтой болгох зүйл нь үү? Сэтгэлийн ийм түвшинд хүрэхэд хэр их хугацаа шаардлагатай вэ? Бясалгалын үед чөтгөрүүд ирж үймүүлээд байвал яах вэ? Тэднийг яаж холдуулах вэ? Баярлалаа.*

**Багш:** Будда, Есүс, Арьяабал бодьсадва болон бусад гэгээнтэнтэй холбогдох нь зам мөрийн нэг л шат нь юм. Энэ төлөвийг туулсны дараа та өөрөө Будда (гэгээрсэн Их Багш) болчихно. Одоо бол та арай болоогүй байна, хараахан Буддатай холбогдоогүй байгаа, тэгэхлээр эхлээд та авшиг хүртээд гэгээр. Авшиг авсан эхний өдрөө ч та Буддаг харж магадгүй, агшин зуурт, эсвэл авшиг хүртсэний дараах олон долоо хоног, олон сар, олон жилийн дараа та Будда, эсвэл Арьяабал бодьсадваг харж магадгүй. Энэ бол хоёр дахь алхам. Эхний алхам нь авшиг хүртэж гэгээрэх. Магадгүй, агшин зуур та Буддаг харна, энэ нь олон өдөр, олон долоо хоног, олон жилийн дараа ч болж болно. Энэ бол хоёр дахь нь. Гурав дахь алхам нь та өөрөө Бодьсадва, эсвэл Будда болох явдал. Үүний дараа танд холбогдох шаардлага үгүй болно. Та өөрөө тэр юм. Та өөрөө Будда. Та бүхнийг мэднэ. Та бүхнийг хийхгүйгээр хийнэ. Та хаа сайгүй орших боловч бас хаана ч байхгүй. Та энд сууж байх боловч нэгэн зэрэг хаа сайгүй байж чадна. Танаас тусламж хүссэн хэнд ч та тусалж чадна. Та бүхийг мэдэж, бүгдийг сонсож, бүгдийг харна. Энэ бол Буддагийн (Гэгээнтний) төлөв.

Буддатай холбогддог болох нь өөрөө Будда (гэгээрсэн Их Багш) болохоос амархан, гэхдээ алхам алхмаар та тийм болно. Хэрвээ та бясалгадаг бас танд Будда (гэгээрсэн Их Багш) болох гэсэн найдвар байхгүй бол би танд бүү санаа зов гэж зөвлөе. Яагаад гэвэл, хэрэв та эмч болохоор суралцаж байгаа, гэтэл хэн ч, хэзээ ч эмч болж байгаагүй бол санаа зовох хэрэг байна уу? Гэхдээ бидэнд урам зориг бий, итгэл найдвар бий. Намайг та Будда мөн үү гэж асуусан учраас л би хариулж байна. Таныг асуусан болохоор л би “тийм ээ” гэж хариулсан, түүнээс биш би Будда (гэгээрсэн Их Багш) гэж буйгаараа онгирсон юм биш. Энэ нь надад сонин биш. Таныг зоригжуулж, та ч гэсэн Будда болж болох юм гэсэн эерэг үлгэр жишээг өгөх гэж л би үүнийг хэлсэн юм шүү. Энэ их амархан. Над шиг жижигхэн хүн, жижигхэн эмэгтэй Будда (Гэгээнтэн) болж чадаж байгаа юм чинь та бас чадалгүй яахав. Тиймээс л би хэлсэн юм. Өөрөөрөө бахархаж, эсвэл танд сэтгэгдэл төрүүлэх гэсэндээ биш. Энэ сонин биш. Учир нь таныг үүнд итгэж магадгүй, эсвэл итгэхгүй байж магадгүй гэдгийг

би мэдэж байгаа бөгөөд үүнд итгэх, эсвэл итгэхгүй байх эсэх тань надад огтхон ч нөлөөлөхгүй.

Би өөрийгөө тэднээс илүү дээр гэж хэлэхгүй. Би зүгээр л танд арай илүү ойр хүн нь байгаа юм. (Инээв.) Тэд Бурханы оронд байгаа, харин би танай дэлхийд байна. Ау Лакт (Вьетнамд) хүмүүс “хол байгаа төрөл саднаас хажууд байгаа хөрш дээр” гэж хэлдэг. Зовлон бэршээл тохиолдсон, эсвэл өвдсөн үед хөрш чинь л тусална, харин хол байгаа садан чинь ирэх гэж нэлээн удна. Тийм учраас л хэцүүдсэн үед чинь туслах амьд сайн найз, амьд Их Багш та нарт хэрэгтэй байдаг юм.

***Асуулт 286:*** *Жижиг сажиг бурханд, эсвэл лус савдаг гэх мэтэд залбирснаас хамгийн дээд Эрх мэдэлтэйд нь залбирах нь хавьгүй тустай гэж Та хэлсэн. Тэдний адис болон хүчнээс ч бид илүү их хүлээн авна. Тэгвэл тэр лус савдаг нь хамгийн дээд бурхадын шавь нь биш гэж үү?*

**Багш:** Тэр хүн газрын нутгийн бурхад бас л оройн дээд Бурханы шавь юм бол эхлээд лус савдгууд дээр очоод тэгээд тэднээр дамжин алхам алхмаар илүү дээдэд нь хүрчих нь бидэнд илүү дээр юм биш үү? гээд байна гэж би ойлголоо. (Их Багш болон бүгд инээв.) Тэр ингэж л асуужээ. Их хөөрхөн асуулт байна. Гэхдээ асуудал юунд байна вэ гэвэл лус савдгуудын хүч чадал тэгсэн ч хэмжээ хязгаартай, харин бидний хүсэл, хэрэгцээ шунал, бидний тэлэлт бол хязгааргүй, бид тийм байлгахыг л хүсдэг. Тиймээс лус савдгууд руу биш харин хязгааргүй нөөцтэй рүү нь очвол илүү дээр.

Үнэндээ бол лус савдагт хүч чадал байдаггүй. Цагдаа бол сайдаас өөр шүү дээ. Битгий харьцуул. Сайд бол ерөнхийлөгчөөс бүр ч ялгаатай. Тэгэхээр та ерөнхийлөгч юмуу, хааныг таньдаг байх чинь нэг булангийн цагдааг таньдагаас шал өөр. Тэгэхлээр энэ нь тун авцалдаж байгаа биз. Тэгэхээр алхам алхмаар ахиж залбирах бус, хамгийн дээд Бурханд залбирч, хязгааргүй хүчнээс нь авах нь илүү тустай. Магадгүй маргааш нь үхэх мөч тулсан чинь та дээшээ залбирч амжаагүй байж байх болно. Та олигтой хол явж, хүрч чадалгүй тэндээ л гацчихсан байж байх нь ээ.

***Асуулт 287:*** *Хүндэт Чин Хай Их Багш минь ээ, тодорхой нэг Их Багш, эсвэл Ши Фу-г хэт их алдаршуулж, шүтэх нь бид мухар сүсэгтэй байна гэсэн үг үү?*

**Багш:** Таны тэр багш чинь, эсвэл нутгийн бурхан буюу лус савдаг гэгч чинь хангалттай хүчтэй биш бол та өөрөө л мухар сүсэгтэн байх. (Их Багш инээв.) Багш чинь ердөө л ид шидийн хүчтэй, “Хо-ла-хоп” гэх маягийн юмс хийдэг байхад та түүнийг дэндүү их шагшин биширч байгаа бол та мухар сүсэгтэй юм байна. Харин тэр Их Багш чинь хэдийнээ хамгийн дээд төвшинд хүрч, хамгийн дээд Бүхнийг чадагч Бурханыг төлөөлдөг нэгэн болсон бол та мухар сүсэгтэн биш.

***Асуулт 288:*** *Эмэгтэй хүн Их Багшийн нөмрөг өмсөж болохгүй гэж нэгэн эрэгтэй Их Багш хэлж байгаа бол энэ нь зөв үү?*

**Багш:** Их Багшийн нөмрөг гэхээр ямаршуу юм байдаг бол? Эрэгтэй Их Багшийн нөмрөг, эмэгтэй Их Багшийн нөмрөг гэсэн загвар бий юу? Ингэж асууж байна уу? Ши

Фу бол Буддист Их Багшийн нөмрөг өмсдөг, харин Буддын шашны лам, гэлэнмаа нар бол лам, гэлэнмаагийнаа хувцсыг өмсдөг гэж энэ эмэгтэй хэлэх гээд байна, тийм үү? Гэхдээ надаас ийм юм асууж төвөг удах хэрэггүй. Би тэр байтугай ямар нэгэн онцгой юм ч өмсдөггүй. Би ердөө л шавь нараас надад юу өгнө, тэрийг л өмсдөг. Нөмрөг хувцас надад хамаагүй болсон зүйл. Тэгэхээр надтай энэ талаар хэлэлцэх хэрэггүй. Надад жийнс өгвөл бас л өмсчихөж магадгүй. (Их Багш инээв.)

***Асуулт 289:*** *Будда Тантай хэрхэн ярьдгийг хэлж өгч болохсон болов уу? Дуу хоолойгоороо юу, эсвэл мэдрэхүйгээр үү? Таны туршлага.*

**Багш:** Би үүнийг уншиж барахгүй нь ээ. Дараагийн удаа илүү тодорхой бичиж өгнө үү. Энэ хүн “намайг Буддатай яаж харилцдаг вэ?” гэж асуусан байх. Энэ бол зам дээрх нэг үе шат л төдий. Би аль хэдийн тайлбарлачихсан шүү дээ. Та Будда (гэгээрсэн Их Багш) болох үед Будда (Гэгээнтэн) ийм байдаг гэдгийг танд хүний хэлээр тайлбарлах аргагүй. Гэхдээ Будда (Гэгээнтэн) бас иднэ, унтана, ярина. Та нар Буддаг ингэж байгаагаар л харж чадна. Гэвч дотоод тал нь өөр байдаг, дотоод талыг нь бид тайлбарлаж чадахгүй. Би зүгээр л таныг Будда (гэгээрсэн Их Багш) болооч хэмээн урья, тэгээд та өөрөө олж мэдэх болно.

***Асуулт 290:*** *Би их удаан хугацааны турш муу сүнснүүдэд дарлуулж байгаа юм. Энэ байдлыг хэрхэн засахыг надад хэлж өгөөч.*

**Багш:** Энэ жаахан төвөгтэй л дөө. Эзэлсэн сүнсийг илааршуулах олон арга зам бий. Гэхдээ хамгийн сайн, хамгийн баталгаатай арга нь амьдралынхаа хэв маягийг өөрчлөх явдал. Ариун явдалт хүн болж, сахил сахиж, Бурханд, Буддад итгэж найдан өдөр бүр тусламж гуйн залбир. Мөн цэвэр ариун амьдрах ёстой. Тэгвэл бүх сүг сүнснүүд зугтаж одно. Буг чөтгөр зөвхөн харанхуй, таагүй уур амьсгалтай л хутгалдаж чаддаг. Цэвэр бөгөөд ариун байвал чөтгөр ойртож чадахгүй.

Тэгэхлээр амьдралынхаа хэв маягийг өөрчил. Сайн бай, өглөг өг, Буддаг бишир; Будда мөн чанараа шүт, гэхдээ Буддагийн баримлыг биш шүү. Будда, Бурханыг шүт, сахилаа сахь. Чадахын хэрээр, эсвэл бүр тэр чигтээ цагаан хоолтон бол. Танд ивээл хамгаалалт хүртээж, адислаж, тусалж чадах хамгийн их гэгээрсэн гэж боддог тэр Их Багшдаа залбир. Заримдаа сайн бясалгагч, сайн бясалгадаг хэсэг бүлэг хүн, эсвэл нэгэн сайн Их Багштай харилцах үед муу сүнснүүд өөрсдөө зугтаад явчихдаг. Их Багшийг, эсвэл хэсэг бясалгагчийг ширтэн харахад л та аяндаа ариусчихна, эсвэл тэдний уур амьсгал дунд байхдаа л ариусчихдаг.

***Асуулт 291:*** *Та хорхой шавжийг их муугаар ярьсан, гэтэл тэд ч бас амьд биес шүү дээ. Үүнтэй адилаар, антибиотикууд бактерийг устгадаг. Бидэнд шууд хор учруулж байгаа бактерийг бид бас хөнөөх ёсгүй юу?*

**Багш:** Асуугаад байх юм биш! Тэгвэл өт хорхойг ч гэсэн битгий хөнөө. Тэд ч гэсэн амьд биес гэж тэр хэллээ. Би өт хорхойг муулсан юм бишээ. Би зүгээр л эмчлэгддэггүй хүнд өвчин нь тэр хүнээ маш их зовоодог юм гэж л хэлсэн. Иймэрхүү маягаар асуух хэрэг юу байна даа. Ийм юмыг яахыгаа та мэдэж л байгаа шүү дээ. Та

өт шавжийг хөнөөх хүсэлтэй бол хөнөө; хүсээгүй бол бүү тэг. Гэвч зарим өт хорхой хөнөөлгүүлэх боломж өгдөггүй, үүнд л асуудал байна. Өчигдөр орой миний дурьдсан шиг тийм өтнүүдийг та нар хөнөөж ч чадахгүй. Тэр бол эмчлэгддэггүй өвчин. Хамгийн сайн зүйл бол ёс суртахуунтай, цэвэр ариун амьдрах явдал. Иймэрхүү зүйл тохиолдоход бүү хүргэ гэж та нарт хэлэх нь урьд оройны миний зорилго байсан юм. Бэлтгэлтэй бай! Эрхэм сайн, ариун явдлаар амьдар. Өөрийгөө иймэрхүү төрлийн хохирогч болгох боломж бүү гарга. Би сайн санаж л хэлсэн юм. Хэрэв та өт хорхойг хөнөөхийг хүсэхгүй тийм энэрэнгүй бол би ч бас зөвшөөрнө, өт хорхойг битгий хөнөө. (Өт хорхой таныг хөнөөхийг зөвшөөр.)

***Асуулт 292:*** *Роберт Адрейгийн "Агнах дуршил" (The Hunting Hypothesis) хэмээх алдартай бүтээлд үзэж буйгаар бол манай өвөг дээдэс ногоо жимсээр хооллохоосоо илүү хамтач, олсноо хуваалцдаг анчид байсан ажээ, бас хүний энэ чанарууд нь ан агнуурт амжилттай байснаас үүдэлтэй юм байна.*

**Багш:** Тийм байж болно, болно. Учир нь эрт дээр үед газар тариалан, эрдэнэ шиш, арвай будаа, идэх талх гэж байгаагүй. Ихэнх хүн амь зогоохын тулд ан хийдэг байжээ. Өнөөдөр биднийг ингэж урамшуулаад байгаа нь энэ үйлийн үр ч байж магадгүй, үүнээс маш олон харгис хэрцгий үйлдэл гарч байгаа. Тийм байж магадгүй шүү.

***Асуулт 293:*** *Төсөөлөл болон дүрслэл бясалгалд үүрэг гүйцэтгэдэг үү?*

**Багш:** Тийм ээ, тэгдэг. Төсөөлөл, дүрслэл таныг тайтгаралтай, бас завгүй байлгана. Хэрэв та жинхэнэ ахуй ойлголт олж чадаагүй бол төсөөлж таарна биз дээ. Энэ нь бид мөнгөгүй үедээ хоосон мөрөөдөөд л сууж байдаг шиг юм. Харин манай Арьяабалын бясалгалд төсөөлөх шаардлага байдаггүй, бид шууд л түүнийг авчихдаг. Төсөөлөл болон дүрслэл нь эдгээр зүйлийн нэг нь ч байхгүй, бид түүнд шунах үед гарч ирдэг зүйл. Тэгээд л бид ямар нэгэн юмыг төсөөлөх хэрэгтэй болдог. Гэхдээ төсөөлөл болон дүрслэл чинь хамгийн эцсийн цэг биш гэдгийг санаарай. Бид энэ хэмжээ хязгаартай тархины хүчээрээ хамгийн дээд ертөнцийг төсөөлж чадахгүй. Тэгэхээр бидний төсөөлсөн ямар ч зүйлд хүний согог шингэсэн байж магадгүй. Тиймээс өөрийнхөө төсөөллөөр дамжуулж биш, харин хамгийн дээд Дэс, Бурхан, Буддагаас түүнийгээ шууд авсан нь хамаагүй дээр. Учир нь бидний төсөөлөл дэндүү жижиг, дэндүү хязгаартай, нэгэн төрлийн хий хуурмаг зүйл байж мэднэ .

***Асуулт 294:*** *Гэгээрэл гэж юу вэ?*

**Багш:** Өчигдөр би танд хэлчихсэн шүү дээ. Энэ нь та хаана ч, хэдийд ч орчлон ертөнц дээрх бүх юмыг мэддэг, бүгдийг ойлгодог, бүгдийг хардаг, бүгдийг сонсдог, нэгэн зэрэг нэг байрандаа байж, бас хаа нэгтээ үзэгдэж байхыг хэлнэ.

***Асуулт 295:*** *Бүрэн гүйцэд ургамал хоолтон болоогүй хүн Арьяабалын аргаар бясалгаж болох уу?*

**Багш:** Тийм ээ, болно. Гэхдээ юуны төлөө? Ямар ч үр дүн байхгүй шүү дээ. Би аль хэдийн хэлсэн дээ, бид энгийн, анхан шатны бясалгал хийсэн ч үр дүнд хүрье л гэж

байгаа бол ургамал хоолонд ахиухан орсон байх хэрэгтэй. Гэтэл илүү дээд төвшний бөгөөд хүчтэй бясалгалыг нь хийх хүсэлтэй үед энэ бүр үүнээс ч илүү их шаардагдана биз дээ! Та ургамал хоолтон байх ёстой, тэгж чадахгүй бол сөрөг үр дагаврыг амсаж зовох болно. Жишээ нь та өвчин тусаад эмч дээр очиход эмч дарс ууж болохгүй, тамхи татаж болохгүй гэх мэтээр зөвлөдөг. Хэрэв та үргэлжлүүлэн дарс уугаад тамхи татаад байх юм бол өвчин чинь улам хүндэрч, бүр эмчид очих ч хэрэггүй болчихдог. Арьяабалын арга бол танд гэгээрч, Бурхантай өдөр бүр улам ойр болоход чинь тусалдаг юм.

***Асуулт 296:*** *Хүндэт Их Багш аа, Сурангама судартБудда хэлэхдээ амь таслуулж байхыг нь хараагүй, сонсоогүй, бидэнд зориулж алаагүй бол тэр амьтныг, махыг нь идэж болно гэжээ.*

**Багш:** Тийм ээ, тэр тэгж хэлсэн, гэхдээ энэ бол Түүний үүрэгт ажил дөнгөж эхэлж байсан үе бөгөөд хэн ч сахилын талаар сайн мэддэггүй, хүмүүс үүнд дасаагүй, зарим нь бүр ургамал ургадаггүй өндөр ууланд, эсвэл говь цөлд амьдарч байсан үе гэж Тэр бас хэлсэн. Тэгж хэлснийхээ дараа Тэрбээр “***Өнөөдрөөс эхлээд хэн ч ямар ч төрлийн мах идэж болохгүй, би үүнийг хориглож байна.”*** гэж хэлсэн. Та яагаад лавшруулж уншаагүй юм бэ? Та ердөө энэ хүртэл уншаад л больчихсон байна. Энэ ч их амар л даа. (Инээв.) Хүссэн хэсгээ л унших чинь тун амархан.

***Асуулт 297:*** *Би ямар ч шашин шүтдэггүй. Арьяабалын аргаар гэгээрэлд хүрч чадах уу?*

**Багш:** Чадна, чухамдаа чадна, чадах болно, чадах ёстой, чадах хэрэгтэй, агшин зуурт л. (Инээв.) Өөр ямар нэгэн шаардлага огт хэрэггүй. Бурхан бидний дотор байна. Бурханы орон, Будда дотор маань байна. Будда шашин дотор байдаг гэж хэн ч хэлээгүй. Буддаг ирэхээс өмнө ямар ч Буддын шашин байгаагүй, Христийг ирэхээс өмнө ямар ч Христийн шашин байгаагүй. Тэгээд тэд хаанаас гэгээрлийг олж авсан байх вэ? Будда бол Буддын шашинтан биш. Тэр буддист байгаагүй. Бид бол буддист, харин Тэр бол үгүй. Христ христийн шашинтан байгаагүй. Бид бол Христийн шашинтан, харин Тэр бол үгүй. Тэгэхээр та аль ч шашных биш юм бол хүрч ирээд Бурханы шавь бол. Энэ болж байна уу?

***Асуулт 298:*** *Эрхэм Их Багш аа, буддын шашинд Бурхан гэж байдаггүй, зөвхөн Будда л байдаг гэж ярьдгийг би сонслоо. Энэ үнэн үү? Тайлбарлаж өгнө үү.*

**Багш:** Тийм. Будда Бурхан байдаггүй ч гэж хэлээгүй, Бурхан байдаг ч гэж хэлээгүй. Тэр ердөө л чимээгүй байсан. Яагаад? Би ч бас чимээгүй л баймаар байна. Учир нь ихэнх хүн Бурханыг өөрийнхөө үзэл бодлоороо төсөөлдөг, нэн хязгаарлагдмал, хүч чадалгүй, тун бүтэл муутай бурханыг төсөөлдөг. Тийм учраас Будда юм хэлж, “бурхан” гэгдэх тэдний төсөөллийг дэмжихийг хүсээгүй юм. Гэхдээ тэр “Ануттара-Самяак-Самбудда” гэгдэх өөр нэгэн зүйл байна гэж хэлсэн. Энэ нь Хамгийн дээдийн Дээд нь, түүнээс илүү дээд хэн ч байхгүй гэсэн утгатай. Энэ нь хамгийн дээд байр суурь, хамгийн дээд Хүч гэсэн утгатай. “Бурхан” гэж Буддагийн хэлсэн зүйл нь энэ

юм. Нутгийн бурхад буюу лус савдаг, хувь хүний бурхан, энэ тэр гэх мэт бурхад гэсэн улигт үзэл бодолд хүмүүс хүлэгдэж суухыг нь Тэр хүсээгүй юм.

***Асуулт 299:*** *Хүндэт Их Багш аа, бидэнд бат нот үнэмшүүлэхийн тулд Та өөрийнхөө хүчийг үзүүлж, баталж болох уу? (Инээв.)*

**Багш:** Ху-ла-хоп! (Алга ташив.) Та нар миний хүчийг харсангүй юу? Юу ч гарч ирсэнгүй юу? Өө, өршөөгөөрэй. Өнөөдөртөө ажиллахгүй, эвдэрчихсэн юм шиг байна. (Их Багш болон бүгд инээв.) Хүч чадалд сэтгэл хүлэгдэхийн оронд та өөрийнхөө билиг ухаанаар явж, өөрийн билиг ухаанаар миний хэлсэн үгийг ойлгон дотоод руугаа гүн орж, өөрийнхөө Их Багшийг хай. Ямар ч төрлийн хүч чадал тун богино настай. Би шавь нараа татахын төлөө гэж хүч чадал ашигладаггүй. Гэхдээ надад хүч чадал их бий, арвин бий. Би тэрийг хангалттай их ашиглаж болохгүй, гэхдээ бусдад сайрхах гэж ашигладаггүй. Бусдад сайрхах гэж хүч чадлаа ашиглаж байгаа Их Багш энэ нэр цолыг зүүх гавьяагүй; ингэж хэлсэнд өршөөгөөрэй. Бид бол бясалгагч тул илбэ ид шидээр бус, харин учир зүй, билиг ухаан, чин сэтгэл, хайрын хүчээр л хүмүүсийг үнэмшүүлдэг. Би шидтэн биш. Энэ бол миний ажил биш. (Инээв.)

***Асуулт 300:*** *Архад (Гэгээнтэн) болон Будда (гэгээрсэн Их Багш) гэдэгт ямар ялгаа байдаг вэ?*

**Багш:** Заримдаа Архад бол Будда, заримдаа Будда бол Архад, харин заримдаа Будда нь Архад биш, заримдаа Архад нь Будда биш. (Инээв.) Энэ нь та яаж харахаас л шалтгаална. Маш оновчтой тодорхойлолтын дагуу гэвэл Архад гэдэг нь маш их шидийн хүчтэй, зэрлэг амьтдыг номхруулж чаддаг, бас салхи гаргах гэх мэт энэ тэр зүйлийг хийж чаддаг нэгэн юм. Харин Будда гэдэг нь нэгэн зэрэг хэдэн мянга, сая хувилгаан биетэй байж чаддаг, нэгэн зэрэг хаана ч бүгдийг сонсож чаддаг, нэгэн зэрэг хаана ч бүх юмыг харж чаддаг нэгэн юм. Тэр болон орчлон ертөнц хоёр нэгэн цогц. Тэр хаа сайгүй байдаг хэрнээ бас хаана ч байдаггүй. Үүнийг “Жу-Лай”, “Татагата” гэж нэрлэдэг. Энэ тодорхойлолтоор, эсвэл энгийн ойлголтоор Архад гэдэг нь зохих хэмжээний шидийн хүчтэй, өөрөө гэтлэгдчихсэн, гэхдээ хамгийн дээд хүч, хамгийн дээд билиг ухаанд хараахан хүрээгүй байгаа нэгэн юм.

***Асуулт 301:*** *Их Багш аа, Бурхан дэлхийг бүтээв үү, эсвэл дэлхий өөрөө оршдог юм уу?*

**Багш:** Энэ бол та өөрөө Бурханаас очиж асуух зүйл байна. Та Түүнээс очиж асуухыг хүсэхгүй байна уу? Авшиг хүрт, Арьяабалын аргаар бясалга. Тэгээд өөрөө шууд асуу. Өндөг, тахиа хоёрын аль нь түрүүлж бий болсон бэ? гэдэг билүү. (Инээв.)

***Асуулт 302:*** *Төгс цагаан хоолтон байх, төгс бус цагаан хоолтон байх хоёрын хооронд ямар ялгаа байна вэ? Ийм хоёр төрлийн хүний хувьд бясалгалын нөлөө гарах уу?*

**Багш:** Тийм, тийм, тийм. Цагаан хоолтон байх нь бясалгалд ямар нөлөө үзүүлдгийг мэдмээр байвал та гараад манай шавь нарт байгаа тэр номыг ав. Авшиг авсны дараа

мах идэж, сахилаа зөрчиж, ямар үр дагавар амссанаа шавь нар маань бичсэн байгаа. Үүнийг “Shin Tu Nei Hsin” (Хятад хэлээр) гэж нэрлэдэг зүйл, Шавь нар болон Их Багшийн сэтгэлийн дотоод дахь захидал харилцаа юм. Энэ бол ердийн захидлууд биш. “Та сайн байна уу, цаг агаар дажгүй байна” гэхчлэн асуусан төдий биш. Үгүй, тийм биш! Бид дотооддоо билиг ухаан, дотоодын олон заавруud, дотоод гэгээрлийг гүн гүнзгий хэлэлцдэг юм.

Түүн дотор Сахилууд гэсэн хэсэг байдаг, түүн дотроос та цагаан хоолтон байх, цагаан хоолтон биш байх нь ямар байдаг, энэ нь бясалгал болон хөгжилд хэрхэн нөлөөлдөг тухай туршлагуудаас уншиж болно. Тэгээд л та өөрөө мэдчихнэ. Би үргэлж танд хэлээд байвал, та нар “Өө, мэдээж, та Их Багш юм чинь өөрийнхөө барааг зарахыг хүсэлгүй яахав” гэж хэлнэ. Тийм биз? Үгүй ээ. Би бүгдийг өөрийнхөө туршлага, гэгээрлийн баталгаа, шавь нарынхаа ахуй ойлголтыг үндэслэн ярьдаг. Би хүмүүсийг итгүүлэх гэж хүчилдэггүй. Бидэнд нотолгоо байдаг юм.

***Асуулт 303:*** *Бясалгалын тусгай цаг гэж бий юу? Өдрийн хоолны дараа гурван цаг бясалгах ёстой юу?*

**Багш:** Нэг цаг хангалттай. Гурван цаг дэндүү урт байна; нэг цаг, 30 минут л хангалттай. Та бүр цадталаа идчихээгүй бол хагас цаг л хангалттай.

***Асуулт: 304:*** *Бясалгаж байх үед сэтгэлдээ юу агуулж байх вэ, эсвэл сэтгэлд юу ч байхгүй байдаг уу?*

**Багш:** Юу ч байдаггүй. Юу ч битгий хүс. Юуг ч тэгж их битгий бод. Зүгээр л арга дээрээ төвлөр.

***Асуулт 305:*** *Бясалгал хийхэд зорьж хүрэх обьект бий юу?*

**Багш:** Та сүр жавхлан, билиг ухаан, гэтлэгдэн чөлөөлөгдөх, дэлхийн амар амгалан, дотоодын амгалангийн төлөө залбир. Энэ л хамгийн сайн нь тийм үү? Эс бөгөөс та хүсвэл сугалаанд хожихын төлөө, сайхан эхнэртэй болохын төлөө залбирч болно. (Инээв.) Гэхдээ би таныг хамгийн дээдэд нь хүр гэж зөвлөе. Билиг ухаан, амар амгалан, аз жаргал, өөрийнхөө болоод хамаг амьтны төлөө залбир.

***Асуулт 306:*** *Хэрэв би бясалгахыг хүсвэл Та надад юу зөвлөх вэ? Таны хариултаас гэгээрлийг олно гэж би чинь сэтгэлээсээ найдаж байна.*

**Багш:** Та бясалгамаар байгаа юм уу? Би маш их баярлаж байна. Хэрэв танд бясалгалын арга байдаг, тэр чинь танд нэмэр болдог бол үргэлжлүүл. Хэрэв тус болдоггүй бол өчигдөр болон энэ орой миний заасан тэр бяцхан аргаар бясалгаад үз. Хэрэв энэ нь таны сэтгэлийг хангахгүй байвал, бас та илүү гүнзгий гэгээрэл, гүн билиг ухаан, эсвэл дотооддоо илүү орж, улам их хамгаалалт хүсч байвал авшиг хүртээрэй, тэгвэл би танд Арьяабалын аргыг зааж болно, энэ бол хамгийн аюулгүй бөгөөд хамгийн сайн үр дүнтэй нь байх болно.

***Асуулт 307:*** *Хүндэт Чин Хай Багш аа, бид билиг ухаанаас гадна өөр ямар сайн зүйлийг бясалгалаас авах вэ?*

**Багш:** Өө, зөндөө олон. Аз жаргал, амар амгалан, өөртөө болоод бусдад, тав, зургаан үеийнхэндээ туслах хүчийг авна. Дараа нь та Будда (гэгээрсэн Их Багш) болно, эсвэл Есүс шиг. Та бүгдийг мэддэг болно, бусдын нүглийг угааж чадна, зовлон гачигдал, гай гамшигт өртсөн хэнд ч та тусалж чадна. Та олон хүчтэй болно, олон олон хэтийдсэн-хүчтэй болно.

***Асуулт. 308:*** *Гэр бүлтэй хүн гэрээ орхиж, лам болохгүйгээр гэгээрэлд хүрч чадах уу?*

**Багш:** Тиймээ, чадалгүй яахав.

***Асуулт 309:*** *Их Багш аа, Хэрвээ хүн өөрийн хүмүүс, гэр бүл, улс орноо хамгаалахын тулд худал хэлбэл гэм нүгэл мөн үү?*

**Багш:** Үгүй. Энэ зүгээр. Энэ гэм нүгэл биш.

***Асуулт 310:*** *Бясалгал маань сайн байгааг би яаж мэдэх вэ?*

**Багш:** Хэрэв та амар амгалан, сэтгэл хангалуун болж байвал энэ сайн байна гэсэн үг.

***Асуулт 311:*** *Бясалгал хийх сайн цаг хэдийд байдаг вэ?*

**Багш:** Хэрэв тогтмол ажилладаг бол өглөө эрт 3-6 цагийн хооронд босоод хийж болно. Шөнө дунд болон түүнээс хойшхи цаг бол бясалгал хийх сайхан цаг, гэхдээ сайн унтаж амарсны дараа хий, тэгэхгүй бол та тэнд суугаад л бүгдийг зөвшөөрнө (суугаагаараа толгойгоо дохиод л!) [Инээв.] Та шөнө, эсвэл өглөө алинд нь ажилтай эсэхээс хамаарна. Шөнө сайн унтаж амарсны дараа хамгийн сайн цаг юм.

***Асуулт 312:*** *Дэлхий дээр өнөөдөр яагаад ийм олон шашин байна вэ? Яагаад тэдний сургаал, гүн ухаан зөрчилддөг вэ? Бурхан үүнийг яагаад зөвшөөрдөг вэ?*

**Багш:** Үгүй, үгүй, тийм биш! Тэд зөрчилддөггүй. Бидний билиг ухаан л энэ шашнуудын үндсэн санааг ойлгож чадахуйцаар нээгдээгүй байгаад л учир байна. Тэд зөрчилдөөгүй. Бурхан үүнийг хүсэхгүй. Бид өөрсдөө л ялгаж тусгаарладаг.

***Асуулт 313:*** *Их Багш Чин Хай, Та Бүтээгч, Бүхнийг Чадагч, Оройн Дээд Эзэн Бурхан болон бусад ариун Их Багш тухайлбал Будда, Есүс, Арьяабал гэхчлэн дурьдлаа. Оройн Дээд Бурхан болон Тэдний хоорондын уялдаа холбоо юу вэ? Хэрэв тэд Оройн Дээд Бурханы шавь нар юм бол шууд л Бүхнийг Чадагч Бурханд залбирах нь дээр биш гэж үү?*

**Багш:** Тийм, та Бүхнийг Чадагч Бурханд залбираарай. Гэхдээ энэ Их Багш нар Оройн Дээд Бурханы захиасыг дамжуулах гэж үе үе заларч ирсэн, учир нь Тэднийг ирэхээр л бид Оройн Дээд Бурханыг мэддэг болсон. Тэдний л холбоо, энэрэл нигүүсэл,

адислалын тусламжтайгаар бид Оройн Дээд Бурхантай холбогддог тул Тэдэнд талархан тэднийг шүтдэг. Энэ нь бас зөв биш юм.

Бид өнгөрсөн үеийн Их Багш нарыг бишрэн шүтэхэд хэт их төвлөрөх ёсгүй. Бид амьд сэрүүн Их Багшийг олох хэрэгтэй. Ингэж байж л Оройн Дээд Бурхантай шууд холбогдож чадна. Тэгэхлээр таны асуусан “Бид энэ багш нарыг бишрэн шүтэх хэрэгтэй юу” гэсэн асуултанд үгүй, хэрэггүй гэж хэлье. Бид Оройн Дээд Бурханыг бишрэн шүтэх хэрэгтэй, гэхдээ Их Багшид залбирах хэрэгтэй юм. Оройн Дээд Бурхантай холбогдох боломжийг олж мэдэхийн төлөө Их Багшаас тусламж гуй. Гэхдээ амьд, амьдарч буй Их Багшаас шүү. Өнгөрсөн үеийн Их Багш нар ажлаа хийчихсэн. Тэр явчихсан, өөр зүйл хийхээр явчихсан. Энэ ажлыг дахин хийхгүй.

***Асуулт 314:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, олон хүн шашнуудын үүсэл оршлын тухай маргалдаж байхыг сонссон. Зарим нь Христийн шашин эхэлж гарсан, зарим нь Буддын шашин эхэлж гарсан гэдэг. Миний бодлоор аль шашин нь эхэлж гарсан нь чухал биш, [Их Багш зөвшөөрөн “Тийм, тийм!”] тиймээс эрхэм хүндэт Их Багш та биднийг ухааруулна уу.*

**Багш:** Тийм, энэ чухал биш. Таны зөв. Хамгийн чухал нь бид итгэж сүсэглэдэг шашныхаа сургаалыг дагах явдал. Учир нь хэрэв та нэг шашин шүтлээ гэхэд бусдыг нь бүгдийг шүтэн дагаж байна гэсэн үг. Тэдний ихэнх сургаал нь адилхан байдаг.

***Асуулт 315:*** *Гэгээрлийн зам мөрт бясалгал хийх, тарни маани унших, эрхи эргүүлэх зэрэг нь хоорондоо ямар ялгаатай вэ?*

**Багш:** Бясалгал хийх нь нам гүм сууж, дотоод багшийнхаа буюу Бурханы заавар сургаалыг сонсоно гэсэн үг. Тарни мааниуншин эрхи эргүүлэхэд бид дэндүү завгүй болдог. Бид сонсохоо мартчихдаг. Маани уншиж, эрхи эргүүлэх нь залбирал бөгөөд Бурханыг бидэнд туслан сургаал номоо хайрлаж, энийг ч өгөөч, тэрийг ч өгөөч хэмээн залбирч буй хэрэг юм. Гэхдээ бид гуйсныхаа дараа нам жим тайван сууж сонсох хэрэгтэй биз дээ? Яг л би энд ирээд та нараас асуулт асууж байгаатай адил. Та нараас баахан асуулт асуучихаад хариултыг тань сонсохын тулд дуугүй болох ёстой. Тиймээс бясалгал бол залбирал уншиж, эрхи эргүүлсний дараах үйл явц юм. Тийм биш бол эрхи эргүүлэн маани унших нь тийм ч үр дүнтэй биш.

***Асуулт 316:*** *Гэгээрлийн зам мөрийг зааж чадах жинхэнэ Их Багшийг олсон гэдгээ бид яаж мэдэх вэ?*

**Багш:** Амархан. Тэр Их Багш чинь таныг гэгээрүүлэх ёстой, тэгж байж та энэ үнэхээр гэгээрлийн зам мөн байна гэж мэднэ. Гэгээрэлд хүрнэ гэдэг нь Гэрэл олж авсан гэсэн үг. Тиймээс аль нэг Их Багш танд ямар нэгэн Гэрэл, эсвэл Оройн Дээд Бурханаас ирсэн заавар чиглүүлэг, Бурхантай, Гэрэлтэй шууд холбогдохыг өгч байвал тэр хүн бол гэгээрсэн Их Багш мөн юм, бас та гэгээрсэн зам мөрд явж байна гэсэн үг.

***Асуулт 317:*** *Их Багш аа, Будда хэлэхдээ эмэгтэй хүн бол эрэгтэй хүний үйлчлэгч хэмээжээ. Та энэ талаар юу гэж бодож байна?*

**Багш:** Будда хэзээ ч тэгж хэлээгүй. Энэ бол их том буруу ойлголт. Бидэнд Будда байдаг, бидэнд эмэгтэй, бас эрэгтэй Будда нар байдаг талаар судар номд бичсэн байдаг шүү дээ. Тэгэхлээр Тэр яаж тэгж хэлэх билээ? Хэрэв тэр тиймэрхүү зүйл

хэлсэн юм бол энэ нь Энэтхэг улсын тухайн цаг үеийн ёс заншил буюу эмэгтэй хүн, эрэгтэй хүний хойно суух, эсхүл эмэгтэй хүн эрэгтэй хүнийг хүндлэх хэрэгтэй гэдгээс болсон байх. Тэр Энэтхэгийн ёс заншил, нийгмийн дэг жаягийг үймүүлж, эвдэхийг хүсээгүй учир ***эмэгтэй хүн эрэгтэй хүний ард зогсох буюу суух, эрэгтэй хүнийг хүндлэх хэрэгтэй*** гэсэн байна. Ингэж хэлсэн нь Тэрбээр нэгэнт тогтсон ёс заншлыг хүндэтгэсэн учраас юм.

Үүний адилаар бид энэ оронд ирвэл, хэрэв энд ирвэл бид энэ улс орны ёс заншил, хууль дүрмийг хүндэтгэх ёстой байдаг. Тиймээс хэрэв бид ямар нэгэн сургаалыг Буддын шашинтанд, Христийн шашинтанд, эсвэл шашинд итгэдэггүй хүмүүст хэлж болох ч Мусульман шашинтанд болохгүй. Учир нь бид энэ улсын хууль дүрмийг хүндэтгэж байна. Энэ миний тушаал гэж би хэлэх ёсгүй. Энэ бол тухайн улсын хууль учир бид мөрдөх ёстой. Үүний адил Будда Энэтхэгт байхдаа эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээ сонсож хүндлэх хэрэгтэй гэж хэлсэн нь тухайн нийгмийн хэв журам нь ийм учраас юм. Түүнээс биш эрэгтэй, эмэгтэй хүмүүс эн тэнцүү.

***Асуулт* 318:** *Хүмүүс сүнслэг ертөнц буюу үхлийн дараах амьдралын талаар ярьдаг. Энэ үнэн үү?*

**Багш:** Тийм ээ, энэ үнэн. Манай дэлхийгээс чанадад маш олон, үзэсгэлэнтэй, мөнхийн, хайрын, илүү амар амгалан ертөнцүүд байдаг.

***Асуулт 319:*** *Буддын сургаалд байдаг Нирваан гэдэг нь ямар утгатай вэ?*

**Багш:** Нирваан гэдэг нь туйлын аз жаргалтай, амар амгалан юм. Бид бясалгал хийгээд суухад бяцхан Нирвааныг мэдэрдэг. Аугаа гэгээрэлд хүрч, энэ дэлхийг орхисны дараа та илүү агуу Нирваанд хүрэх болно.

***Асуулт:*** *Энэхүү Нирваанд хүрэх нь Буддын шашинтнуудын амьдралын туйлын зорилго нь мөн үү?*

**Багш:** Тийм.

***Асуулт 320:*** *Их Багш аа, өөрийн нохойгоо мах, эсвэл муураа загасаар тэжээх нь буруу юу?*

**Багш:** Буруу биш, гэхдээ зөв биш. Хийх ёстойгоо хий, хамгийн сайн гэснийг хий. Хэрэв танд энэ буруу юм шиг санагдаж байвал, нохой, муураа өөртөө байлгах хэрэггүй. Өөр хүмүүст өгч, тэднээр тэжээлгээрэй.

***Асуулт 321:*** *Таны авшиг авах өргөдлийн маягт их урт бөгөөд сүрдмээр юм. [Инээв.] Энэ чинь авшиг авах урам зориг яаж өгөх вэ?*

**Багш:** Айж сүрдэж байгаа зүйлээ миний шавь нараас, эсвэл надаас асууж болно. Хүн болгонд аймаар биш байх. Хэрэв тийм аймаар байсан бол бид ийм олон шавьтай байхгүй байхсан. Бид маш олон хүнтэй. Ургамал хоолтон болох, мах идэхгүй байх, мансууруулах бодис хэрэглэхгүй байх, амь хороохгүй, хулгай хийгүй байхад айж сүрдээд байх юм юу ч алга. Үүнээс айж сүрдмээр юу ч байхгүй. Энэ талаар бодож үзээрэй.

***Асуулт 322:*** *Өвчтэй хүнийг эдгэрэхэд нь туслах нь буруу юу? Хэрэв буруу бол бидний нөгөө энэрэл нигүүлсэл хаана байна вэ?*

**Багш:** Хүмүүс өвчтэй болбол тэдэнд эмч олддог. Хэрэв тэд хүсвэл сүнслэг анагаагч нар дээр очиж болно. Гэхдээ бид өөр замаар явдаг. Бид хүмүүсийг ердөө жижиг сажиг өвчнөө эдгээх гэхээсээ илүү гэтлэгдэж чөлөөлөгдөөсэй гэж хүсдэг. Хэрэв хүмүүс өвдсөн бол тэднийг эмнэлэгт хүргэж, асран халамжил, бас таны тэднийг анагааж болох хэмжээ хязгаартай хүчинд найдахын оронд өөрийнхөө хүч болон өөртөө итгэж найд, залбир гэж хэлэх хэрэгтэй. Өчүүхэн энэрэл нигүүслэл, агуу том энэрэл нигүүслэл хоёр ялгаатай. Жишээ нь, хэрэв нэг хүн эмч болохоор сурч байгаа бол хараахан эмч болоогүй л байгаа, тэгтэл сувилагч нар өвчтөнүүдийг асран завгүй байхыг хараад тэдэнд туслая гээд хичээл номоо орхин сувилагч болжээ. Ингэж болно. Гэхдээ тэр хүн эмч болоогүй. Цаашдаа зөвхөн сувилагч л байх болно.

Хэрэв та хүнийг сүнслэг анагаах хүчээр эдгээвэл та анагаагч л болно, зөвхөн өвчтэй хүмүүст л тусалж чадахаас биш, хамаг төрөлтөнд бүгдэд нь тусалж чадахгүй. Та хүмүүсийг гэтлэхүй, эрх чөлөө, Будда болох тийш аваачиж чадахгүй. Хэрэв сүнслэг анагаагч болохыг хүсдэг бол ядуу хүмүүст сүнслэг анагаалт өг, ЗА! Ингэх бас л илүү энэрэнгүй. Харин би та нарт өөрөө хэрхэн Будда болох аргыг зааж өгье, ингэвэл та хүмүүсийг анагаахаар зогсохгүй, бас гэтэлгэнэ, дэлхийг гэтэлгэж чадна, ингэвэл энэ нь агуу том анагаагч зорилго болох юм. Та сувилагч биш, эмч болно.

***Асуулт 323:*** *Таныг амьд Бурхан гэж нэрлэдгийг хүлээн зөвшөөрдөг үү? Хэрэв үгүй бол Та энэ буруу мэдээлэгчдийг яадаг вэ?*

**Багш:** Би хүлээн зөвшөөрдөг бас үгүй. Тэд л намайг тэгж нэрлэдэг, би ингэж дууд гэж тэдэнд хэлээгүй. Мөн хэвлэлийнхэнд намайг Бурхан гэж дуудаарай гэж хэлэх их хэцүү. Тэд худалдагдахгүй. Тэд анх надтай уулзахад би тэднийг мэддэггүй байлаа. Тэгээд Коста Рикагаас явсны дараа тэд намайг тэгж дуудсан байсан. Тэд намайг явсны дараа миний ажлын талаар, миний талаар сэтгэгдлээ илэрхийлж, мөн миний тухай их олон нийтлэл гаргасан. Шавь нар маань тэдгээрийг цуглуулаад хүмүүст хэлжээ.

Энэ бол шавь нарын мэдээлэлд зориулагддаг, Их Багш нь хаана явж байна, юу болсон, яасан, аль улсад юу болов гэх мэт. Биднийг хүмүүс буруушаавал бид хүмүүст бас мэдээлдэг. Бид бас үүнийг мэдээлдэг. Шавь нартаа Их Багш нь хаана явж байна, юу хийж байгаа, хүмүүс юу хэлсэн талаар үнэн мэдээлэх өгөх л явдал юм. Тэгээд л болоо. Та нар намайг амьд Бурхан гэнэ үү, эсвэл амьд чөтгөр гэж дуудна уу, надад ялгаагүй. [Инээв.]

Гэвч бид бүгдээрээ л амьд Бурхан, би ганцаараа биш. Библи судартай байгаар бол бид чинь амьд Бурхан шүү дээ: ***Та бол Эзэн Бурханы сүм бөгөөд Ариун сүнс таны дотор оршдог.*** Бурхан энэ сүм дотор амьдардаг. Энэ чинь Бурхан гэсэн санаа. Энэ махан бие бол зөвхөн хуяг, сүм бөгөөд дотор нь Бурхан байдаг. Ойлгов уу? Бид бол Бурхан. Та энэ талаар юу гэж бодож байна даа? Хэн нь ташаа мэдээлэл авсан байна вэ? Та ташаа мэдээлэл авсан байна. Та өөрийнхөө хэн болохыг мэдэхгүй байна, та өөрийнхөө хэр агуу болохыг мэдэхгүй байна. Хэрэв та намайг ямар агуу гэдгийг мэдэж байгаа бол миний төлөө баяртай байвал зохино. [Алга ташив.]

***Асуулт 324:*** *Буддын шашинд хамгийн сэвтэй зүйл бол эго буюу "Би" гэх үзэл гэдэг. Та өөрийнхөө фото зургийг олон нийтэд зарагдаж байгааг юу гэж тайлбарлах вэ?*

**Багш:** Энэ чинь би үзэлтэй ямар холбоотой билээ? Хүмүүс миний фото зурагт дуртай учраас тэдний хүсэлтийг биелүүлдэг юм. Энэ бол бас л шавь нарын маань хийж байгаа ажил; надтай ямар ч холбоогүй. Би өөрийнхөө зургийг дардаггүй, өөрөө зургийн хальсыг боловсруулдаггүй, зарж борлуулдаггүй. Надад сайхан сэтгэл, та нарт туслах гэсэн сайн санаанаас өөр юу ч байхгүй. Би юу ч зардаггүй. Нэг ч мөнгө авдаггүй, ямар ч ашиг авдаггүй. Би өөрийн гараар хөдөлмөрлөж амьдралаа залгуулдаг гэдгээ танд хэлж болохсон болов уу? Надаас юу л авна, үнэ төлбөргүй, үнэгүй бэлэг юм. Энэ бүгдийг сайхан сэтгэлийн үүднээс хийдэг юм.

Би өдөр бүр хоёр гараараа хөдөлмөрлөдөг. Би хүзүүний ороолт хийдэг. Өөртөө хангалттай мөнгө олох гэж тэр. Бүр лекцтэй үедээ, лекц уншихынхаа өмнө ч гэсэн ийм ажлаа хийдэг. Аялж байхдаа, онгоцонд, галт тэргэнд, автобусаар явж байхдаа цаг л гарвал би амьдрахад хүрэлцэх мөнгө олохын тулд ажилладаг. Би юу ч зардаггүй. Ямар нэгэн мөнгө, ашиг орж ирвэл үнэ төлбөргүй буцаагаад зарцуулдаг, ном болгож хэвлэдэг. Бид үүнийг та бүхэнд үнэ төлбөргүй өгдөг, таныг лекцэнд үнэ төлбөргүй ирэхээр зохион байгуулдаг, таныг үнэ төлбөргүйгээр ирж авшиг хүртэхэд, энд ирж бидэнтэй хамт хооллох боломжоор үнэгүй хангахад зарцуулдаг юм. Энэ бүхэн бол та бүгдэд зориулагддаг болохоос надад биш. Хүмүүс фото зургийг дурсгал болгон авахыг хүсдэг юм. Хэрэв та хүсэхгүй бол авах хэрэггүй. Энэ бол миний би-үзэлтэй ямар ч хамаагүй зүйл. Би ийм юмыг тоохгүй.

Ийм ажил эрхлэх нь их аймшигтай. [Инээв.] Тийм. Миний ажилд битгий атаархаарай. Хэрэггүй. Битгий, битгий, битгий атаарх. Энэ бол их дарамттай, аймшигтай, шүүмжлэл хаа сайгүй, хэзээ ч гарч ирж болзошгүй байдаг. Та энэ бүх асуултыг сонссоны дараа аль хэдийн ойлгоо байлгүй дээ, та сонин сэтгүүл уншихад л ойлгочихно. Харин ч намайг шүүмжлэх бус, харин өрөвдөх хэрэгтэй. Намайг хамгаалах хэрэгтэй юм биш үү. Намайг илүүхэн хайрлаж, урам зориг өгвөл би та бүхэнд, бас улам олон хүнд үйлчилнэ шүү дээ, тийм ээ? Бүү дарамтла. Би зөвхөн үйлчилдэг бөгөөд юу ч авдаггүй.

***Асуулт 325:*** *Эрхэм аугаа Их Багш минь ээ, би Таны Арьяабалын аргаар бясалгамаар байна, гэхдээ ургамал хоолны шаардлагаас болоод би одоо чадахгүй юм шиг байна.*

**Багш:** Тийм бол та өнөө орой заасан тэр жижиг аргаар бясалга л даа. Аажмаар ургамал хоолтон байхыг оролдоод чадах эсэхээ хараарай, хэсэг хугацаанд оролдож үзээд амжилттай байвал ирж авшиг аваарай. Тэгж болох уу?

***Асуулт 326:*** *Эрхэм Их Багш аа, сонгино, сармис яагаад цагаан хоолонд тооцогддоггүй юм бэ?*

**Багш:** Энэ бол Буддын шашны нэг сахилаас болсон хэрэг. Буддын нэг судартсонгино, сармис нь таны хүсэл тачаалыг нэмэгдүүлдэг гэж бичсэн байдаг. Таны бэлгийн дур хүслийг. Тиймээс бид ямар нэгэн бясалгал хийж байгаа тохиолдолд бэлгийн ажлыг нэн багасгах хэрэгтэй. Хэрэв сонгино, сармис идвэл үүнийг илүү идэвхжүүлдэг. Тиймээс эдгээрээс зайлсхийх хэрэгтэй. Сонгино бас бөөрийг гэмтээдэг, бас ой

санамжийг муутгадаг гэж бас ярьцгаадаг. Тийм учраас лам, гэлэнмаа, эсвэл бясалгал сайн хийдэг хүмүүс үүнээс зайлсхийх нь дээр гэж үздэг. Багш нь үүнийг хориглоогүй.

***Асуулт 327:*** *Заримдаа бясалгал хийж байхад хөөр бахдлын байдалд орсон мэт бие маань хөдөлж, эсвэл чичирдэг. Та тайлбарлаж өгөөч?*

**Багш:** Тийм. Энэ бол таныг бясалгаж байхад сайн хүч болон муу хүч тэмцэлдэж байгаа хэрэг; нэг нь таныг дээш нь, нөгөө нь доош нь татахыг хүсч байгаа юм. Тиймээс л ийм байдалд байна. Та цааш бясалгалаа үргэлжлүүлвэл зохино; бас их багш чинь хэн байна, хэрвээ түүнд хүч байдаг бол түүнээс туслахыг хүсээрэй. Хэрэв түүнд хүч байхгүй бол Бурханд, Буддад, танд хэн л тусалж чадна гэж итгэж байна түүнээсээ тусламж гуйж залбираарай, тэгээд тууштай үргэлжлүүлээд байвал та аажмаар үүнийг даван гарах болно. Мөн ургамал хоолтон болох гэх мэтээр илүү цэвэр амьдрахыг улам хичээгээрэй,.

***Асуулт 328:*** *Хэрэв бид бясалгал сурахаас айдаг, бас Их Багшаа олж чадахгүй байгаа бол энэ айдас бидний цаашдын хөгжилд саад болж байгаа гэсэн үг үү?*

**Багш:** Тийм, бид энэ айдсаа даван туулах хэрэгтэй. Хэрэв та бясалгахыг хүсч байвал оролдоод үзэх хэрэгтэй, зориг гаргах хэрэгтэй. Бид юунаас ч айх ёсгүй. Хүн төрөлхтөн бол бүх бүтээлийн хамгийн дээд нь, бид айх ёсгүй.

***Асуулт 329:*** *Юмыг хараад байгаа зүйл нь нүд үү, эсвэл харахуй юу?*

**Багш:** Харахуй чинь л хараад байгаа юм. Тийм учраас бид бүр нүдээ аньчихсан байхдаа ч маш олон зүйлийг харж чаддаг, тэгэхээр юмыг хараад байгаа тэр зүйл чинь харагч чанар юм. Тиймээс хүн үхэхээр нүд нь аниастай, нээлттэй алин ч байлаа гэсэн, харах чадвар нь (нүднээс!) алга болчихдог учраас ахиж юу ч харж чадахгүй.

***Асуулт 330:*** *Нэг Их Багш шавийнхаа гэгээрэлд тус хүргэхийн тулд түүнд гараа хүргэх, эсвэл өөр арга хэлж өгч болох уу?*

**Багш:** Тийм, энэ боломжтой. Заавал гараа хүргэх албагүй; харц юмуу, нэр нь хангалттай. Хэрэв та итгэл бишрэлтэй, чин сэтгэлтэй, төлөв даруу байвал Их Багшийн нэрийг сонсох чинь л танд тусалхад хангалттай.

***Асуулт 331:*** *Би Буддагийн нэрийг дуудах, Ертөнцийн Эзний нэрийг чанга уншихад итгэдэг. Би хэрхэн Ертөнцийн Эзний нэрийг дуудангаа чимээгүй бясалгаж чадах вэ? Та хэлэхдээ уншсаныхаа дараа хэдэн минут бясалгах хэрэгтэй гэсэн.*

**Багш:** Хэрэв та чимээгүй, чимээтэй хоёрыг зэрэг хүсч байгаа бол надад арга зам алга. Та хэсэг уншаад дараа нь суугаарай. Тэгээд хэрэв хүсвэл дахин уншиж болно. Та 24 цагийн турш өдөржингөө чанга уншиж чадахгүй шүү дээ. Эзэн Бурханы адислалыг, Буддагийн тусламжийг авахын тулд нэг хэсэг дуу чимээгүй байхыг хичээгээрэй.

***Асуулт 332:*** *Амьтад сүнстэй юу?*

**Багш:** Тийм.

***Асуулт:** Нян бактер болон хортой нөлөөтэй шавж хорхойг хөнөөх нь юу вэ, аллагад тооцогдох уу?*

**Багш:** Тийм, гэхдээ та амьдралаа хамгаалахаар алж байна, харин амьтдыг идэхийн төлөө бол алах шаардлагагүй. Эхний болон сүүлийн тохиолдол хоорондоо ялгаатай. Эхнийхээр бол та хоол хүнсний төлөө хөнөөж байна, харин хоол хүнсийг бол өдгөө үед шар буурцаг, төрөл бүрийн ногоогоор хангах боломжтой байна. Тиймээс эхний тохиолдол заавал шаардлагагүй болчихож байна, амь насны хэмжээний асуудал биш, тиймээс нүгэл нь хүндэвтэр. Харин хоёр дахь  тохиолдол нь та өөрийнхөө амь насны төлөө тэмцэх хэрэгтэй болж байна. Хүний амь тун эрхэм зүйл. Эрүүл мэндийн шаардлагын дагуу бол бид ийм шавж, нян бактериас салж  ангижирч болно. Ийм аллагын нүгэл нь маш бага байдаг. Учир нь танд шалтгаан байна, мөн энэ амьтад, шавжууд бол бяцхан, тэдний амь насны үнэ цэнэ тийм агуу том биш, тийм учраас бид залбирал, гэмшил, бясалгалаар үүнийг цэвэрлэж болдог. Харин илүү том амьтдыг хөнөөсөн бол цэвэрлэх нь хэцүү байдаг.

***Асуулт 333:** Хүндэт Их Багш аа, ургамал хоолтон байх, эсвэл биш байх, алах эсвэл алахгүй байх, Буддист, эсвэл Христийн шашинтай байх, гэгээрлийн түлхүүрийг авах, авшиг хүртэх, Аялгуу ажих, эсвэл аялгуугүй байх зэрэг нь ердөө сэтгэл дэх ялгаварлах үзэл юм. Энэ бүх бодолд уягдах нь самсара**, энэ бүгдэд уягдаж хүлэгдэхгүй байх нь билиг ухаан юм. Энэ бүх хүлээс болон үл хүлэгдэх бодлоос чөлөөлөгдөх нь гэгээрэл юм. Миний ингэж хэлж байгаа нь зөв үү, буруу юу, надад зөвлөнө үү.*

**Багш:** Хэрэв би таны зөв гэвэл бас буруу, учир нь хэрэв та аль хэдийн билиг ухаан, гэгээрлийг олчихсон байсан бол надаас ингэж асуухгүй байсан. [Инээв.] Энэ нь таныг гэгээрээгүйг харуулж байна. Хэрэв та ингэж бодож байвал энэ хангалтгүй. Бид “Би шатанд сэтгэл хүлэгдээгүй, учир нь хоёрдугаар давхар бол шат биш” гэж хэлж чадахгүй, учир нь хоёрдугаар давхарт гарахын тулд бид зайлшгүй шатаар явна. Хоёрдугаар давхарт гарсныхаа дараа бид “одоо шат хэрэггүй” гэж хэлж болно. Дээд давхарт нь гараагүй байгаа тул бидэнд шат хэрэгтэй. За юу? Хэрэв та ийм агуу бодолтой бол их сайхан сонсогдож байна, гэсэн ч та бүрэн төгс гэгээрээгүй байна. Тийм учраас та надаас асуусаар л байгаа юм. Танд тодорхой болоогүй байна. Билиг ухаантай, гэгээрсэн хүн бол хэзээ ч эргэлздэггүй. Ялгаа нь энэ юм.

***Асуулт 334:** Аугаа Их Багш аа, Нирваан нь газар юмуу, оюун ухааны нэг төлөв юм уу?*

**Багш:** Энэ бол оюун ухааны төлөв.

***Асуулт 336:** Нирваанд хүрсэн хүн нас барахаараа хаашаа явдаг вэ?*

**Багш:** Нирваанд, Бурханы Оронд, бүхэл орчлон луу буцаж очно. Гэхдээ үүнийг нас барсныхаа дараа л мэднэ.

***Асуулт 337:** Үхлийн дараа амьдрал байдаг уу, дахин төрөл авах болон там, диваажин гэж байдаг уу? Эдгээрийг хэрхэн батлах вэ?*

---

* *САМСАРА, САНСАРА [самгарьд: сам хамтдаа + сарати гүйх, хөвөх, сэлэх] Энэтхэгийн шашин, гүн ухаанд: хойд дүр, сүнс өөр бие махбодын бүрхүүлд шилжихүй.*

**Багш:** Урьд шөнө би ярьсан шүү дээ. Бид тодорхой нэг төвшинд хүрэхээрээ өөрсдийн урьд төрлүүдийг, үхэж төрөхийн хүрдийг, үүний хуулийг харах болно гэж хэлсэн. Тэгснээр бид мэдэх болно. Бид там, Диваажинг ч бас харна. Бид эдгээрийг бясалгалынхаа явцад харна. Бид энэ газруудаар зочилж ч болно.

***Асуулт 337:*** *Үхсэний дараа сүнс хаашаа явдаг вэ? Шууд өөр нэг хүний биед шилжин ордог уу? Өмнөх амьдралд хийсэн үйлдлүүдээсээ болоод хүмүүний дээд болон доод төрлийг авдаг юм уу?*

**Багш:** Тийм. Хэрэв та энэ Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж яг энэ төрөлдөө өөрийгөө гэтэлгэвэл сүнс бүрэн гэтэлж чадна. Тэгээд үхлийн дараа танд ямар нэгэн ачаа дарамт, сүнсийг халхлах бүрхүүл байхгүй болно. Хэрэв та Арьяабалын аргаар бясалгадаггүй бол бүрхүүлтэй хэвээрээ байдаг. Энэ дэлхий дээр хүний махан бие нь сүнсний бүрхүүл юм, харин бусад ертөнцөд өөр бүрхүүл байдаг. Гэхдээ энэ нь үл мэдэгдэм нарийн, бүр нүдэнд харагдахгүй, гэсэн ч бүрхүүл л юм. Жишээ нь, бетон, эсвэл модоор байшин барихад нягтшил нь өөр ч гэсэн таны хараанд бас л ямар нэг хаалт болж үзэгдэж байна. Зөвхөн гэтлэгдсэн сүнс л үхэж, төрөхийн хүрднээс чөлөөлөгдөж чадна. Тэд амьд байхдаа аль дэс төвшинд хүрч чадсан байна тэр газраа очно. Та хаана очих нь мэдээж бас таны сүүлийн амьдралаас шалтгаална.

***Асуулт 338:*** *Их Багш аа, таны зургийг бусад Будда, эсвэл өөр Бурхадын зурагтай хамт залж болох уу? Үүнд ямар нэгэн асуудал бий юу?*

**Багш:** Болно, хүссэнээрээ залж болно. [Инээв.]

***Асуулт 339:*** *Чин Хай Багш аа, та яагаад эрүүл мэндэд тустай "Чи Кун" дасгал хийхийг хориглодог вэ?*

**Багш:** Би хориглосон юм биш. Та нарт "Чи Кун" юмуу, дуртай дасгалаа хий гэсэн. Биеэ эрүүл байлгах хэрэгтэй гэсэн. Би зөвхөн тэгж л дурьдсан, үгүй гэж үү? Би энэ дэлхий дээрх тэр бүх йогийн нэрсийг хэлж чадахгүй, би ердөө цөөн хэдийг л дурдсан, энэ хангалттай. Би "Чи Кун" гэж хэлээгүйгээс болоод та гомдчихсон байна. Би мартчихаж. Маш олон төрлийн йог байдгийг би мартчихаж.

***Асуулт 341:*** *Бясалгал хийх хамгийн тохиромжтой цаг хэзээ вэ?*

**Багш:** Хэрэв та өдрийн цагаар ажилладаг бол өглөөний 3-6 цагийн хооронд. Тийм биш бол сайн амарсны дараа. Учир нь 3-6 цагийн хооронд их нам гүм. Бидний ажил хэргүүд хараахан өрнөөгүй, эхнэр, нөхөр хүүхэд унтаж, гэрийн ажил хийх, эсвэл ажилдаа явах цаг болоогүй байдаг. Тиймээс бясалгал хийх боломжтой юм. Илүү нам гүм бөгөөд аюулгүй байдаг. Тиймээс энэ цаг тохиромжтой. Түүнээс биш та ядраагүй, тайван амгалан байх үедээ, бясалгал хиймээр санагдсан хэдийд ч хийж болно.

Өлссөн ходоодтой, эсвэл хоол идсэний дараа, өдрийн цагаар, шөнийн цагаар, ер нь таны ажлын хуваарь, чөлөөт цагаас л шалтгаална. Өлссөн ходоодтой байхад сайнгүй, цатгалан үед сайнгүй. Хоол идсэнийхээ дараа жаахан хүлээж байгаад өөрөөр хэлбэл 30 минут юмуу, цагийн дараа бясалгаарай. Хэрэв их өлсөж байхдаа бясалгавал та зөвхөн хоолон дээр анхаарлаа хандуулаад Буддаг мартаж орхино. (Их Багш болон бүгд инээв.) Тэгвэл та Буддаг/Бурханыг биш зөвхөн талх, (веган) масло, (веган) бяслаг харна. (Инээв.)

***Асуулт 342:*** *Эрхэм хүндэт Их Багш Чин Хай, Би Буддист гэр бүлд төрсөн, би бас Бахайн шашныг хүлээн зөвшөөрдөг, (Их Багш “сайн байна” гэв) Би чадахын хэрээр Буддагийн сургаалыг чанд дагадаг, жишээ нь зовлонгоос ангижрах 8 зарчим. Буддын шашинтнууд залбирч, маани тарни уншдагийг ойлгодоггүйдээ харамсаж явдаг. Үнэнийг хэлэхэд би Буддагаар ч Бахай Уллагаар ч дамжуулж Бурханаас адислалыг нь хүртдэг. Энэ аугаа хоёр шашнаас, эсвэл эдгээр шашны Их Багш нарыг нэгэн зэрэг зөвшөөрөх нь буруу зүйл үү?*

**Багш:** Үгүй, энэ буруу зүйл биш. Танд өөрт тань сайхан санагдсан, сүнсэнд тань өгөөжтэй, оюун ухааны хэрэгцээнд тань тустай зүйлсийг хийгээрэй. Таныг тайван, амар амгалан, аз жаргалтай, аюулгүй байлгахад туслах нь л Будда, эсвэл Бахай Улла энэ дэлхий дээр ирсэний зорилго нь шүү дээ. Таны итгэдэг хэн ч бай, ямар маани тарни ч бай нь танд тустай байгаа нь сайн хэрэг. Таныг жаргалтай байвал Будда баярлах болно.

***Асуулт 343:*** *Хэрэв Та болгоовол, би Их Багш Чин Хайг өөрийн бас нэг хамгаалагчаа болгомоор байна.*

**Багш:** Гурван хамгаалагчтай болмоор байгаа юм уу? (Багш болон бүгд инээв.)

***Асуулт:*** *Харин Их Багшийг хол байхад би Таны байгааг яаж мэдрэх вэ?*

**Багш:** Та мэдрэх болно. Бүр намайг бүр харж ч магадгүй. Ойлгож байна уу, хэрэв та үнэнхүү чин сэтгэлтэй, бас хангалттай ариуссан бол гэртээ байхдаа ч намайг одоо харж байгаа шигээ харна, ямар ч эргэлзээгүй.

***Асуулт:*** *Таныг сургаал номоо өөр улс оронд айлдаад явж байвал бид Таныг бидэнтэй хамт байгааг яаж мэдэх вэ?*

**Багш:** Би танд түрүүн хэлсэн шүү дээ. Та мэдэрч магадгүй. Та өдөр тутмын амьдралдаа хамгаалалт, тусламжийг мэдрэх болно. Та үүнийг бүр тов тодорхой мэдэрнэ. Үгүй юм гэхэд намайг өөрийнхөө нүдээр харж магадгүй, эсвэл бясалгал хийж байхдаа. Энэ нь хүн болгонд адилгүй байдаг, гэхдээ Их Багшийн хувилгаан биеийг хардаг хүмүүс цөөхөн биш, маш олон хүн харж чаддаг. Тийм биз дээ?

***Асуулт 343:*** *Намастэ, эндэхийн нутгийн иргэд Арьяабал бодьсадва болон Есөн Улсын эзэд гэх мэтийг шүтэх юм. Ийм итгэл бишрэлийн талаар Та юу хэлэх вэ?*

**Багш:** Зүгээр. Хэрэв танд тус болж л байгаа бол болно.

***Асуулт 344:*** *Зүүдний үйл явц ямар байдаг вэ? Бидэнд хэр чухал вэ?*

**Багш:** Зүүд их олон төвөгтэй үүрэгтэй бөгөөд маш олон янз байдаг. Заримдаа өдөр бодож байсан зүйлсээ орой нь зүүдэлдэг. Зүүд заримдаа ирээдүйд болох зүйлсийг, эсвэл өнгөрсөн зүйлсийг харуулдаг. Их төвөгтэй. Та зүүд тайлагчаас асуух юмуу, ном худалдаж авсан нь дээр байх. Надад үүнийг нарийвчлан ярих тийм их цаг алга. Даяан бясалгалын үеийн бичлэг бидэнд байгаа, зүүдний тухай ярьсан бичлэг бидэнд байгаа. Та тэрийг худалдаж аваад үзэж болох юм.

***Асуулт 345:*** *Гэгээрэлд хүрсэн хүн үхэж төрөхийн хүрдийг дахиж туулахгүй гэсэн үг үү?*

**Багш:** Тийм, тэгэхээ болино.

***Асуулт 346:*** *Есүс Христ жинхэнээсээ Эзэн Бурханы хүү байсан уу, эсвэл зүгээр л нэн их шидийн хүчтэй хүн байсан уу?*

**Багш:** Тэр бол Эзэн Бурханы Хүү. Та ч бас Эзэн Бурханы хүү. Харин та өөрийгөө тийм гэдгээ мэдэхгүй л байгаа юм. Тэр бол Хүү нь гэдгээ мэдэж байсан. [Инээв.]

***Асуулт 347:*** *Маш олон Хятад хүн өвөг дээдсээ шүтдэг. Энэ тал дээр та юу хэлэх вэ?*

**Багш:** Тэд тэгэг л дээ.

***Асуулт 348:*** *Хүндэт Чин Хай Ши Фү, Намастэ, миний асуултанд хариулж тус болно уу?* Арьяабал *гэж хэн бэ? Би Түүний байгаад итгэдэг, Түүнд их залбирдаг. Түүнийг амьдралдаа харах боломж гарах болов уу? Би Түүнийг яавал харах бол?*

**Багш:** Энэ хэцүү. Хамгийн сайн, хурдан арга бол та явж авшиг хүртэх. Та авшиг хүртэж байхдаа Түүнийг харж болно, бүр ийм хурдан шүү, эсвэл арай хожим хойно харж магад. Энэ Арьяабалын аргаар бясалгахгүйгээр та Түүнийг хэзээ харж болохыг би мэдэхгүй юм. Та харж магадгүй, үгүй ч байж магад.

***Асуулт 349:*** *Өөрийгөө нээх болон гэгээрэх талаар номлосон Сэтийн Хүүрнэл (Seth Speaks) болон Рамта (Ramtha) гэх мэт олон ном дэлгүүрт байна. Тэд хэн юм бэ? Тань шиг Их Багш нар юмуу, тэд Эзэн Бурханы хүчийг агуулдаг уу?*

**Багш:** Ном унших, эсвэл ямар нэг сургаал танд гэгээрлийг өгөхгүй. Энэ лавтай. Та амьд Их Багштай холбоо тогтоох ёстой.

***Асуулт 350:*** Арьяабалын *бясалгалын аргыг хэн нээж, сэдэж бүтээсэн бэ? Энэрэнгүй сэтгэлт Аръяабал Бодьсадва өөрөө юу?*

**Багш:** Үгүй. Тэр энэ аргаар бясалгаад Энэрэн нигүүлсэгч Бодьсадва төвшинд хүрсэн юм. Энэ бол эрт дээр үеийн арга бөгөөд Оройн Дээд Бурханаас, Бурханы Орноос ирсэн, түүнээс биш хэн нэгэн сэдэж бүтээсэн зүйл биш. Хэрэв бид үүгээр бясалгавал Аръяабал Бодьсадвагийн дайтай сайн болж чадна.

***Асуулт 351:*** *Бодит байдалд хүн бүрт гэгээрэлд хүрэх боломж байдаггүй. Онолоор бол, хэрэв хүн төрөлхтөн бүгд гэгээрээд үхэж төрөхийн хүрдээс ангижирвал эцэстээ энэ гараг дээрх хүн төрөлхтөн устаж алга болно гэсэн үг үү?*

**Багш:** Үгүй, үгүй, тэгэх шаардлагагүй. Бид эв найрамдалтайгаар хамтдаа гэгээрэлтэй амьдарч болно. Бид энэ дэлхийг орхих ч шаардлагагүй. Жишээ нь, би дэлхийг орхиогүй. Одоо хүртэл энд байж байна. Болдогсон бол би буцаж ирмээр байна. Гэгээрээгүй хүмүүс дэлхий дээр буцаж ирэхийг хүссэн ч тэд чаддаггүй нь асуудал юм. Энэ л асуудал юм. Хэрэв та энэ дэлхийг хүнтэй байлгахыг хүсдэг юм бол, гэгээрэлд хүрчих, тэгээд буцаж ирээрэй. Тэгээд хамтдаа эв түнжинтэй амьдраарай.

***Асуулт 352:*** *Эрхэм Хүндэт Гүрү, Та их том бүрэлдэхүүнтэй иржээ. Зардал их гарсан байх. Энэ аяллыг хэн дэмжсэн бэ? Та дургүйцэхгүй бол хариулна уу?*

**Багш:** Тэд өөрсдийгөө дэмжсэн юм. Та өөрийгөө дэмжээд энд ирсэнтэй адил тэд өөрсдийгөө дэмжиж тэтгэн ирсэн юм. Та миний санхүүгийн асуудлыг анхаарах хэрэггүй. Та тэгж санаагаа чилээх хэрэггүй. Баярлалаа.

***Асуулт 353:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, бид бие биедээ хайртай эхнэр, нөхөр хоёр бөгөөд* Арьяабалын *бясалгалаар бясалгадаг. Бид бэлгийн харилцаагаа зогсоох ёстой юу?*

**Багш:** Үгүй, та тэгээгүй байна, харин багасгаж болно, аажимдаа. (Инээлдэв.) Аажмаар болиорой. (Их Багш ба бүгд инээлдэв.)

***Асуулт:*** *Бид гэгээрэлд хүрэхийн тулд харилцаагаа өөрчлөх ёстой юу? [Инээв.]*

**Багш:** Үгүй, үгүй, үгүй. Зүгээр аажимдаа л зохицуул. Өөрсдийнхөө дэс түвшинд тааруулан мэдэрснээрээ л өөрчил; хүчлэх нь сайн зүйл биш. Гэнэтхэн дахиж бэлгийн харилцаа хүсэхээ больчихвол цаг нь болжээ гэсэн үг. Тэр болтол чадахын хэрээр хяналтандаа байлгаарай. Бясалгалдаа, бас хүн төрөлхтөнд сайн үйлс хийхэд цаг хугацаа эрч хүчээ зарцуулаарай. Гэхдээ бэлгийн харилцаатай байх нь нүгэл гэсэн үг биш. Зүгээр л илүү дээр, сайн зорилгод ашиглаж болохоор байхад их цаг эрч хүчээ дэмий үрнэ. Ийм л учраас бид тэрийг багасгах хэрэгтэй юм. Би юуг ч буруутгаагүй, зүгээр л зөвлөж байна. Эхнэр, нөхөр хоорондоо хайр сэтгэлтэй, сайн харилцаатай байх нь сайн зүйл. Гол нь үүнийг буруугаар ашиглах гэвэл энэ сайн зүйл биш.

***Асуулт 354:*** *Хүндэт Их Багш аа, та ургамал хоолтон байхыг шаардаж байна, гэвч би нэг шил сагамхай загасны элэгний тос, бас өөр нэг загасны тос худалдаад авчихсан. Би эдгээрийг хаях ёстой юу?*

**Багш:** Өөр хэн нэгэн хэрэглэдэг хүнд нь өгчих.

***Асуулт 355:*** *Ургамал хоолонд минь маш жаахан махтай юм орчихсон бол тэр хоолыг идэж болох уу? 100% өөрчилнө гэдэг хэцүү байна. Махнаас аажмаар гарвал амар байна. Та миний энэ аргыг зөвшөөрч болох уу?*

**Багш:** Та аажмаар оролдож үзээд өөрчлөөрэй, бүрэн ургамал хоолтон болсныхоо дараа ирж авшиг хүртээрэй. Хэрэв та аажмаар явмаар байвал аажим хий. Намайг өөртэйгөө хамт удаан яваад өг гэж битгий гуйгаарай. (Бүгд инээлдэв.)

***Асуулт 356:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, би Будда болон Есүс гэсэн хоёр багшид залбирдаг юм. Би нэгэн зэрэг Будда болон Есүс Христ хоёрыг бясалгаж болох уу?*

**Багш:** Тийм, та хоёуланг нь дуудаж болно. Тэд хоёулаа ирэх болно. Нэг л өдөр та Есүс, Будда хоёр нэг юм гэдгийг ойлгоно.

***Асуулт:*** *Ариун библид хоёр их багшид үйлчилж болохгүй гэсэн байдаг. Би Есүс Христээс татгалзаад Буддаг хайрлах уу, эсвэл эсрэгээр нь Есүсийг хайрлаад*

*Буддагаас татгалзах уу? Библийн сургаал Буддын судар бичгүүдийг үгүйсгэдэг бол уу? Таны хувийн бодол?*

**Багш:** Библид харин Эзэн Бурхан болон чөтгөр хоёрт нэгэн зэрэг үйлчилж болохгүй гэсэн санаа байдаг юм. Есүс болон Будда хоёр бол Гэгээнтнүүд, Эзэн Бурханы төлөөлөгч нар. Та хоёуланг нь, эсвэл илүү олныг хайрлаж болно, бололгүй яахав.

***Асуулт 357:*** *Их Багш аа, би урьд нь Тайландад лам байсан юм, харин одоо больчихсон. Тайландын ихэнх лам эрт үеэс одоог хүртэл мах иддэг. Учрыг нь тайлбарлаж өгнө үү?*

**Багш:** Учир нь тэд Буддагийн бусад судрыг уншиж судлаагүй байна. Тэд Буддын шашны нэг жижигхэн хэсгийг л уншиж судалжээ. Хэрэв тэд илүү ихийг уншсан бол ойлгох байсан.

***Асуулт:*** *Тэд гэгээрэлд хүрч чадах бол уу?*

**Багш:** Тийм, гэхдээ төгс гэгээрэлд биш. Буддын сургаал ёсоор бол мах идэж буй хэн боловч зөвхөн Маягийн хаан л болж чадна гэсэн байдаг. Тийм хүн хэзээ ч Будда (гэгээрсэн Их Багш) болж чадахгүй. Сурангама судартаа ингэж л бичсэн байдаг, намайг буруушаах хэрэггүй, за!

***Асуулт 358:*** *Ургамал хоолтон/цагаан хоолтон хүмүүс дун хясаа гэх мэт далайн амьтан идэж болох уу?*

**Багш:** Болохгүй, битгий идээрэй.

***Асуулт 359:*** *Сам хорхойтой хуурсан ногоо байвал (Бүгд инээв.) сам хорхойг нь орхиод дан ногоог нь идэж болох уу?*

**Багш:** Тийм, яах ч аргагүй нөхцөлд болно. Хэрэв танд өөр идэх юм олдохгүй, бас идэхгүй бол үхэх гэж байгаа бол (Инээв.) идээрэй, тэгээд гэртээ хурдан хариад угаагаарай.

***Асуулт 360:*** *Эрхэм хүндэт Их Багш аа, Энэтхэг улс үеийн үед гэгээнтнүүдийн орон байсан. Өнөөдөр олонд танигдсан аугаа Гэгээнтний нэг бол Сай Баба. Энэ Сатяа Сай Баба гэж хэн бэ?*

**Багш:** Тэр бол тэдний нэг нь, гэхдээ хамгийн агуу нь биш. Аугаа гэгээнтнүүдийн нэг нь байх, магадгүй, гэхдээ тэр ганцаараа тийм биш.

***Асуулт:*** *Энэ Сай Баба, тэр одоо дахин төрөх ёстой гэсэн.*

**Багш:** Тэр алдартай Хиндү Мусульман гэгээнтэн байсан бөгөөд маш олон гайхамшгийг үзүүлсэн. Тэр нэгэн зэрэг олон газар олон хүнд тусалдаг байсан бөгөөд сүсэгтнүүд нь хүссэн болгоноо авдаг байсан ч хүмүүст хэрхэн гэтлэгдэж, өөрөө Их Багш болох аргыг заагаагүй. Та хэн нэгнийг шүтээд түүнээс ашиг тусыг нь хүртэж болно, гэхдээ өөрөө Их Багш болно гэдэг нь өөр хэрэг билээ. Тиймээс Сай Баба маш олон хүнд тусалсан, нэн энэрэнгүй бөгөөд их ид шидтэй хүн байсан.

Одоо байгаа нэгэн Гэгээнтэн ч гэсэн их алдартай, их шидтэй бөгөөд хүмүүст тусалдаг. Гэхдээ миний олж мэдсэнээр бол тэрбээр хүмүүст өөрийгөө гэтэлгэх аргыг, хэрхэн өөрөө Их Багш болохыг заадаггүй. Тэгэхээр манай арга бол Их Багшийг шүтээд л болчих биш, харин Их Багш болох, өөрийнхөө Их Багш болохыг заадаг арга юм. Тиймээс намайг битгий шүт. Намайг шүтэхийг нь би шавь нартаа хэзээ ч зөвшөөрч байгаагүй. Би тэдэнд зөвхөн өөрийнхөө аугаа чанарыг, өөрийнхөө үнэ цэнийг хаанаас олох, хэрхэн өөрөө Их Багш болж болохыг заадаг. Хэрэв та нар намайг аугаа гэж бодоод биширдэг бол би та нарт өөрсдөө хэрхэн над шиг болохыг зааж өгье.

***Асуулт 362:*** *Эрхэм Их Багш аа, Эзэн Бурхан буюу Хамгийн Дээд Бүтээгч л бүх оршихуйг Бүхнийг Чадагч Супер Хүч гэдгээрээ бүтээсэн гэсэн яриаг би хүмүүсээс байнга сонсдог. Хэрэв энэ зүйлс үнэн юм бол гэм зэмгүй хүмүүсийг үхэж үрэгдэхэд хүргэхийнхээ оронд Тэр яагаад дайн, ад чөтгөрийн үзэгдлүүдийг тохиолдохоос нь өмнө зогсоож чаддаггүй юм бэ?*

**Багш:** Үгүй, тэд үнэндээ тийм гэм зэмгүй хүмүүс биш, тийм байх албагүй. Магадгүй тэр хүмүүс урьд насандаа тэднийг алж байсан байж болно. Тэгээд тэд нь энэ төрөлдөө буцаж ирэн алсан хэрэг. Дараагийн удаа эд нар нь буцаж ирээд нөгөөдүүлээ ахиад ална. Дараагийн удаад нь тэд буцан ирж ална, ахин дахин алалцана; ийм учраас л хойд төрөл авалт байнга үргэлжилсээр байдаг. Ийм учраас л Би та бүхэнд энэ бүхнийгээ зогсоо гэсэн Оройн Дээд Бурханы захиасыг хэлэх гэж ирсэн юм. Хэрэв таныг хэн нэгэн цохисон бол буцааж битгий цохь. Есүс үүнийг л хэлсэн. Ийм замаар л бид тэр сансрын хүрдийг зогсоон тасалж чадна. Учир нь хэрэв та эргүүлээд цохих юм бол дараагийн удаа тэд таныг цохино. Хэрэв та тэднийг алж хөнөөвөл дараагийн удаа тэд таныг алж хөнөөнө. Ийм маягаар л үргэлжлээд байдаг юм. Тиймээс битгий тэгээрэй. Зогсоо! Ургамал хоол ид, амь бүү тасал.

***Асуулт 363:*** *Их Багш аа, бид нас барсан өвөг дээдэстээ өөд болсон өдрийнх нь ойг тохиолдуулан гэртээ хоол, жимс гэх мэтийг өргөл болгож тавьдаг. Энэ нь тэдэнд тусалдаг болов уу?*

**Багш:** Би тэгж бодохгүй байна. Тэд чинь Бурханы оронд очсон, эсвэл Тамд очсон, эсвэл өөр газар хойд төрөл аваад шилжээд явчихсан. Хэрэв тэд Бурханы оронд оччихсон бол бидний энэ бохир хоол, хямд жимсийг тоохгүй. Хэрэв там руу явсан бол юм идэх гэж наашаа гарч ирж дийлэхгүй. Хэрэв амьтан юмуу ургамлын аймаг руу явсан бол таны юу хэлснийг сонсож чадахгүй. Хэрэв өөр нэгэн хүн төрөлтөн болчихсон байгаа бол тэдэнд жимсний хэрэг бас л байхгүй.

***Асуулт 364:*** *Хүндэт Их Багш аа, Гуан Инь буюу Арьяабалын бясалгалын аргаар бясалгаад гэгээрэлд хүрэх боломжтой юу? Гэгээрэлд хүрэхээр ямар мэдрэмж төрдөг вэ?*

**Багш:** Та гэгээрэх болно, асуух шаардлагагүй. Маш хурдан бөгөөд илт байх болно. Тэр мэдрэмжийг та хожим нь гэгээрснийхээ дараа мэднэ.

***Асуулт 365:*** *Хэрэв Та Будда бөгөөд бүгдийг, бүх юмыг мэддэг юм бол яагаад асуултуудыг унших танд төвөгтэй байгаад байна вэ, бас яагаад нэр заагдсан Японы шашны урсгалыг ямар байдаг тухай сонсогчдоос асуугаад байна вэ? [Инээв.]*

**Багш:** Тэгэхээр Би бүгдийг “мэддэг” байх нь ээ. Тэгэхлээр Будда (гэгээрсэн Их Багш) ч бас хэдэн асуулт асуух хэрэгтэй. Учир нь би өчигдөр орой хэлсэн шүү дээ, Будда бол Оройн Дээд Бурхан ч юм, бас хүн ч юм. Хүний төвшинд Тэр хүн шиг л үйлдэнэ, харин өөр төвшинд Тэр Будда шиг л үйлдэнэ, хоёулаа нэгэн ижил мөчид. Хүмүүстэй харилцахын тулд гэгээрсэн Их Багш нь хүн байх ёстой, тэгэхгүй бол бүх хүн над дээр цуглаад надаас шид бүтээхийг хүлээнэ. Хэрэв надтай хамт бясалгасны дараа та агшин зуур бүгдийг уншиж, бүгдийг мэдэж, бүх хэлийг ойлгон, бүх хүнд гайхуулж чаддаг болж байвал миний бодлоор нэг секундын дотор бүх дэлхийгээрээ Будда болчихно, тэгээд явчихна, эмээ, өвөө, хүүхдүүддээ баяртай гэж хэлэх хэрэгтэй болно. Ингэхийг зөвшөөрдөггүй.

Жишээ нь, хэрэв та аль нэг оронд, эсвэл аль нэг дургүй орондоо тагнуулч байя гэж үзье, тэгээд албан тушаал чинь хэдий өндөр байлаа ч та юу ч “мэдэхгүй”. Та таксины жолооч хийж байгаа. Та такси барих хэрэгтэй, тэгээд хэлнэ: “Энэ юу вэ? Би мэдэхгүй юм. Тэр юу вэ? Тийм үү? Түүний нэрийг хэн гэдэг вэ? Энэ юу вэ? Энэ ерөнхийлөгч нь юм уу? Ямар гээчийн ерөнхийлөгч вэ?” гэнэ. Гэхдээ та бүгдийг мэднэ. Та мэднэ, гэвч та мэдэхгүй, та мэдэх ёсгүй. Та нэгэн зэрэг бүгдийг мэдэж байгаа, та нэгэн зэрэг бүгдийг мэдэхгүй байгаа. Та үүнийг авшиг хүртээд мэдэх болно.

Хэрэв та нар намайг юу ч мэдэхгүй гэвэл энэ зөв биш, учир нь бясалгал хийж байхдаа та нар надаас өөрийн Малай хэлээр асуулт асуувал би Малай хэлээр хариулна. Гэхдээ энд бол би тэгэхгүй. Хэрэв та нар надаас Франц, Грек, Латин, аль ч эртний хэлээр, эсвэл өөрийн нутгийн хэлээрээ асуувал дотоодын Их Багш та нарт яг тэр хэлээр тань хариулах болно. Тийм учраас энэ нь Их Багш бүгдийг мэддэг гэсэн үг. Харин энд бол би тэгэхгүй. Жишээ нь, та нар өөрсдөө зүгээр л үзэх гэж намайг шид үзүүлээч гэвэл би үзүүлэхгүй, тийм үү? Хэн ч тэгж байгаагүй. Есүс хэзээ ч шид үзүүлж байгаагүй. Есүс бас л өөрт хэрэгтэй болсон зүйлээ гуйдаг байсан. Тэр ус гуйж байсан. Бас хоол гуйж байсан. Хөлийн уланд нь иллэг хийхийг хүмүүст зөвшөөрч байсан. Түүнд энэ хэрэггүй ч зөвшөөрч байсан. Үүнийг ойлгоход хэцүү.

***Асуулт 366:*** *Бүх ариун дээд Их Багш нар, жишээлбэл Будда, Есүс, Сай Баба болон бусдад нь нэгэн зүйл ижил байгааг би ажиглалаа. Тэд гараа буюу гарын алгаа дээшээ өргөдөг юм байна. Үүний цаана ямар нэгэн утга байна уу, бясалгалтай ямар нэг холбоотой юу?*

**Багш:** Адис өгөхийн тулд юм. Гэхдээ жинхэнэ Их Багш адис өгөхийн тулд заавал гараа өргөх шаардлагагүй. Ердөө нэг харц л хангалттай. Та бүр харах ч шаардлагагүй. Их багш гараа өргөх, эсвэл тэргүүнээ, хөлийн тавхайгаа ч юмуу, юугаа ч яах ч шаардлагагүй. Хүмүүсийг адислах маш олон арга бий, гэвч заримдаа энх тайван, эсвэл мэндчилгээний илэрхийлэл л болгож тэгдэг. Энэ бол нэгэн төрлийн зуршил юм даа.

***Асуулт 367:*** *Их Багш аа, Та амьд Эзэн Бурхан, Будда (бүрэн гэгээрсэн оршихуй) гэж мэдэгдсэн. Та ийн мэдэгдсэнээ яаж нотлох вэ? Гэгээрэл үү?*

**Багш:** Би Өөрийгөө мэднэ. Би хэн гэдгээ мэднэ. Та бол бас л Будда (*бүрэн гэгээрсэн оршихуй*). Та бидний хоорондох ялгаа бол би өөрийгөө хэн гэдгийг мэддэг, харин та хараахан мэдэхгүй байгаад л юм. Тэгэхээр үүнд тийм сүртэй юм бий гэж үү? Хэрэв та анагаахын чиглэлээр олон жил сурчихаад өөрийгөө төгссөн, эсвэл эмчийн зэрэг авч эмч болсон эсэхээ мэдэхгүй байгаа бол та өөр юу мэдэх болж байна? Хэрэв та

урт хугацаанд суралцаж анагаахын сургуулийг дүүргээд эмч болчихвол өөрийгөө эмч гэж хэлнэ, энэ тийм сүртэй хэрэг үү?

***Асуулт 368:*** *Ариун Дхармад өгүүлснээр бол гагцхүү бүх хүн төрөлтөн Оройн Дээд Бурханд, эсвэл гэгээнтнүүдэд итгэхээ больсон юмуу, бүх хүн төрөлхтөн амьтан болсны дараа л Майдар Бурхан энэ дэлхийд заларна гэж гэгээрсэн Будда хэлжээ.*

**Багш**: Хүн төрөлхтөн амьтан болох оо? Тэгвэл л Тэр ирэх юм уу? Өө, тэр сургаалаа амьтдад айлдах уу? Хүн төрөлхтөнд ном айлдаж, тэднийг аврахад хэцүү байхад бид яаж амьтдад ярьж өгч, гэгээрүүлэх гэж? Будда тэгж тийм удаан хүлээнэ гэж би бодохгүй байна. Гэвч энэ тухай ярьсан миний бичлэг байгаа, та очоод асуугаад олж аваарай. Тайлбарлах цаг алга байна.

***Асуулт 369:*** *Хүн төрөлхтнийг энэ гамшигт дэлхийгээс аврахаар ирдэг Жинхэнэ Их Багш эцэстээ заларч ил гарч ирсэн байна уу?*

**Багш:** Өө, Тэд байнга ил гарч ирдэг, байнга, цаг үргэлж.

***Асуулт 370:*** *Бидний махан биед ганц сүнс байдаг уу, эсвэл биенд хоргодсон өөр сүнс бас давхар байж болох уу?*

**Багш:** Заримдаа л. Заримдаа өөр сүнс бидний биед наалддаг. Зарим нь сайн сүнс байдаг бол зарим нь муу сүнс байдаг. Гэвч ямар ч сүнс бай, бидэнд огт наалдахгүй байсан нь дээр, тэгвэл бид чөлөөтэй, өөрөө өөрийнхөө Их Багш байх болно.

***Асуулт 371:*** *Миний толгой өдөр бүр өвддөг. Надад туслаач. Бас хөмсөгний хооронд шоргоолж мөлхөөд байх шиг мэдрэмж төрдөг. Энэ нь бясалгалаа буруу хийсэн гэсэн үг үү?*

**Багш:** Үгүй. Зүгээр л анхаарлаа эндээ байлга. Өдөр бүр хоёр чамархайгаа дээрээ хэсэг зуур хуруугаараа дарвал толгойн өвдөлт багасана. Эсвэл аспирин уугаарай.

***Асуулт 372:*** *Христийн шашныхан ганц боть Библи судартай, Мусульман шашныхан ганц боть Коран судартай. Буддын шашныхан бид ганц л ботьтой болж болох уу?*

**Багш:** Тийм, ганц боть болгочихож болно. Бүгдийг нь нийлүүлээд боочиход л та ганц боть болгочихно. (Бүгд инээв.)

***Асуулт 373:*** *Их Багш аа, Эрхэм хүндэт Их Багш аа, Таны зөвлөгөө хамгийн их хэрэгтэй байгаа үед Таны байж байгааг би хэрхэн мэдэрч чадах вэ? Хэрэв та Пенанаас тун хол байвал би Тантай хэрхэн зөвлөлдөж, Арьяабалын бясалгалыг хийгээд эхэлхээр гарч магадгүй олон асуудалдаа хэрхэн хариулт авах вэ?*

**Багш:** Над захиа бичиж болно, бүр утсаар ярьсан ч болно. Өдгөө энэ тийм хэцүү асуудал биш. Их Багшийн биед хүлэгдэх шаардлагагүй. Их Багшийн ирэхийг та харна, Их Багшийн оршин байгааг мэдрэх болно, аль ч нөхцөл байдалд Их Багш гараа сунган туслахыг мэдэх болно. Энэ бол маш тодорхой бөгөөд эргэлзээгүйгээр мэдэх болно. Танд тийм туршлага байхгүй болохоор л одоо эргэлзэж байгаа. Та авшиг

хүртчихвэл үүнийг мэдэж авна. Та хар, цагааныг ялгадаг шигээ мэдэх тул ийм зүйл асуух шаардлагагүй болно.

***Асуулт 374:*** *Та маш олон шавийнхаа асуултанд нэгэн зэрэг хариулж чадах уу?*

**Багш:** Чадна.

***Асуулт:*** *Таны хамгийн сайн туслахын хариулт Их Багш таных шиг сайн байж хэзээ ч чадахгүй.*

**Багш:** Мэдээж, Би танд бичиж илгээнэ, гарын үсгээ зурж явуулъя. (Их Багш болон бүгд инээв.)

***Асуулт 375:*** *Танд өөр орлуулах хувилбар байдаг уу? Бясалгал хийх үед ойлгох аргагүй маш олон үймүүлдэг зүйл, хий юм харах явдал тохиолддог гэж би боддог. Таны өөрийн тань чиглүүлэг зөвлөгөө зайлшгүй хэрэгтэй, тэгэхгүй бол олон шавь тань үнэний зам мөрөөсөө хазайж, оюун ухаан нь самуурна.*

**Багш:** Үгүй, хэзээ ч тэгэхгүй. Бидэнд тийм юм тохиолдож байгаагүй. Бидэнд оюун ухаан нь самуурсан, эсвэл хазайсан хүн байхгүй. Ийм зүйл болж байгаагүй. Тэр эмэгтэй над дээр ирэхээсээ өмнө тийм нөхцөлд орж байсныг эс тооцвол ийм зүйл болж байгаагүй. Хэрэв тийм хүн ирсэн бол бид асуудлыг нь аажмаар шийднэ. Хэрэв тэр тийм биш бол ийм зүйл хэзээ ч болохгүй!

***Асуулт 376:*** *Их Багш аа, жил ирэх тусам хүн амын тоо ихэсч байгаа нь тодорхой болж байна. Мөн Бурханыг-танин мэдэх зам мөрөөр явж байгаа, Гэгээнтний зэрэгт болон гэгээрэлд амжилттай хүрч буй хүмүүс нь цөөхөн байна. Та өөрийгөө ялагдал хүлээх тулаан хийж байна гэж бодохгүй байна уу? Та энэ насандаа хэр олон хүнд сургаал номоо айлдаж, тус хүргэж чадах вэ?*

**Багш:** Аль хэдийн маш олон болсон. Пенанд анхны удаа болж байгаа тул танд олон хүн харагдахгүй байгаа юм. Гэхдээ дэлхий даяар маш олон байгаа. Мянга мянгаараа байгаа. Буддад байснаас илүү олон шавь надад байдаг болжээ.

***Асуулт 377:*** *Үйлийн үрийн хуулийн дэмжлэгээр хүн амын тоо тэнцвэргүй өсөн нэмэгдэж, Арьяабалын Аргын бясалгалтай учрахгүй байгаа нь харамсалтай юм даа. Оройн Дээд Бурхан, Бүтээгч ийм арга замаар байлгах санаатай юм уу? Гэм нүгэлтэйнүүд нь мэдээжээр сайн сайхныг ялж чадахгүй байлгүй дээ. Та санал бодлоо илэрхийлнэ үү?*

**Багш:** Тийм, таны энэрэнгүй сэтгэлд баярлалаа. Хүмүүст хэлж ярих хэцүү бөгөөд хүмүүст гэтлэгдэхэд нь туслах хэцүү байдаг. Энэ бол тэдний өөрсдийнх нь урьд төрлүүдийн гэм буруугаас болдог. Жишээ нь, Есүс Христийг загалмай дээр хадсан, Буддаг гүтгэсэн гэх мэтийн хүмүүст бүр өдгөө цагт хүрч иртлээ л тэр үйл үрийг цэвэрлэхэд хэцүү байсаар ирсэн. Тиймээс ийм төрлийн зүйл хийсэн хүмүүс Оройн Дээд Бурхан луу очиж чаддаггүй, арай л болоогүй! Гэхдээ бид өөрсдийн бясалгалын бүлгээрээ мэдээг түгээж хуваалцан аажим аажмаар тэнд очих болно. Тэгээд бид билиг ухааныхаа гэрлээр энэ харанхуй дэлхийг гэрэлтүүлэх болно. Ганц ч гэсэн гэрэл огт гэрэлгүй байснаас шүү дээ. Тиймээс одоо биднээс эхэлж байгаа юм, хүлээх хэрэггүй. Бусад хүн цаг нь болохоор хожим ирэх болно.

***Асуулт 378:*** *Оройн Дээд Бурхан хаанаас ирсэн бэ, хүний төсөөллөөр бий болсон уу?*

**Багш:** Үгүй, бид Оройн Дээд Бурханыг төсөөлж чадахгүй, учир нь бидний төсөөлөл дэндүү өчүүхэн. Оройн Дээд Бурхан дангаараа оршин байдаг, үүрд мөнх, үүрд.

***Асуулт 379:*** *Хүндэт Их Багш Чин Хай, өмнө нь та биднийг уг гарлаараа Оройн Дээд Бурханы хүүхдүүд гэж хэлсэн. Хэрэв энэ үнэн бол Оройн Дээд Бурхан яагаад биднийг энэ физик дэлхийд зовлон зүдгүүр амсахыг болгоодог вэ? Бид энэ дэлхий дээр амар амгалан, аз жаргалтай амьдрах хэрэгтэй бус уу? Энэ тал дээр намайг ухааруулж өгөөч?*

**Багш:** Тийм, хэрэгтэй. Бид энэ дэлхий дээр амар амгалан, аз жаргалтай амьдрах хэрэгтэй. Гэвч бид Оройн Дээд Бурханы тааллын эсрэг, Оройн Дээд Бурханы хуулийн эсрэг маш олон буруу зүйлийг хийж ирсэн тул одоо үүнийгээ төлөх хэрэгтэй болж байгаа юм. Гэхдээ үүнээс гарах арга зам байдаг. Бид гэмшиж наманчлаад одоо Оройн Дээд Бурхан луу буцаж очих хэрэгтэй. Бидэнд ингэх хугацаа байна. Та бүхний тэвчээр, хайранд талархаж байна. Та бүхэнд сайн сайхныг хүсэн ерөөе. Ургамал хоолтон болохыг хичээж, бясалгал хийгээрэй. Оройн Дээд Бурханыг санаж дурсаарай. Буддаг (Гэгээнтэнг) санаж дурсаарай. Та бүгдийг адислах болтугай!

* * *

*Гэлээ ч гэсэн, энэ бүх саад тотгор болон хүн төрөлхтний талархалгүй байдлыг үл ажран бид сайн үйлсээ үргэлжлүүлдэг. Зөв зүйтэй зүйлийг нь хийхийн төлөө бид үргэлжлүүлэн өөрийгөө төгөлдөржүүлсээр байдаг, яагаад гэвэл ингэх нь зөв, энэ дэлхийн үүрэг нь бид Оройн Дээд Бурханы замналыг үргэлжид дагаж мөрдөхөд оршдог, бид ухамсрын сахил шаардлагуудыг ямагт чандлан мөрддөг. Гагцхүү ингэж л бид бүхий л ялгаа, магтаал сайшаал, буруушаал зэмлэлийг даван гарж эрхэм дээд төрөлтөн болох билээ. ("Гэгээнтэн-сэтгэл хариу нэхдэггүй" айлдварын эшлэл)*

*– Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*

*Та бүрэн гэгээрснийхээ дараа бүх зүйлийг мэдэх болно, тэр байтугай олон удаагийн төрлөө ганц гялсхийх төдийд л харчихна; учир нь бид цаг хугацаа болон орон зайн хязгаарыг гэгээрлээр нэвтэлчихдэг юм. Цаг хугацааг хөндлөнгөөс оролцуулахаа болиход бид олон зүйлийг маш их цаг зарцуулахгүйгээр мэдчихдэг. Тэгээд л заримдаа бид олон цагаар бясалгаж суусан байхад хэдхэн минут өнгөрсөн мэт санагддаг. Ойлгохын тулд олон зуун жилийг зориулдаг их олон зүйлийг бид мэдэж авдаг. Тийм учраас л бид энэхүү дотоод билиг ухаанаа эрэх ёстой юм. Бүх хариулт дотоодод чинь байдаг. ("Өрийнхөө дотоодоос Эрдэнэсийн санг олох Арга зам" айлдварын эшлэл)*

*– Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай –*

# АВШИГ ХҮРТЭХҮЙ - АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажих” гэдэг нь Хятадаар амарлин сууж аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэхүү бясалгалын аргад дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажихуй багтдаг юм. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон сүнслэг бясалгалын ном судартм дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: *“Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан юм.”* гэжээ. (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг) Энэхүү аялгуу гэдгээр дотоодын аялгууг заан хэлжээ. Мөн “Бурханы хэл”, “Shadb”, “Дао”, “Аялгууны урсгал”, “Ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: *“Тэрээр түмэн бодисын дотор хэлбэлзэн бүхий л орчлон ертөнцийг тэжээн тэтгэдэг. Энэхүү дотоодын хэмнэл хэлбэлзэл нь аливаа шархыг эмнэн бүхий л хүсэл эрмэлзлэлийг хангаж, эгэл ертөнцийн элдэв дур хүслийг намжаадаг. Тэрээр бүхнийг чадагч бөгөөд хайраар бялхаж байдаг юм. Бид энэхүү аялгуунаас үүссэн болохоор түүнтэй холбогдвол сэтгэл ханаж амарлина. Энэхүү аялгууг сонссоноор бид бүхэлдээ хувирч, аж амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.”* гэжээ.

“Билиг нээгдэх” гэдгээр дотоодын гэрэл - “Оройн Дээд Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авахуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх, авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл шинэ шашинд орж буй хэрэг биш. Авшиг хүртэх үеэр гэрэл болон аялгуу ажихад онцгойлон анхаарах зүйлсийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ. Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь авшиг уламжлах юм.

Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй. Авшиг хүртэх үед та тэр даруйдаа дотоодын аялгууг сонсож, дотоодын гэрлийг харна. Үүнийг “Агшин зуур гэгээрэх” юмуу “Агшин зуур билиг нээгдэх” гэдэг. Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

Насан туршдаа веган хоолтон байх нь авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.

Авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.

Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахилыг сахих нь авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм. Сахил нь өөртөө болон өрөөлд

хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж, Будда болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын төвшинд эргэж очдог.

Өөрөө сүнслэг дадал бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө дадуулан бясалгаж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрдэггүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж хугацаат татвар хураадаггүй. Их Багш Чин Хай сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй.

Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод сүнслэг дадал бясалгалдаа өөрийгөө дэвшүүлэн гэгээнтэн болохыг хүсэх тэрхүү чин сэтгэлийг чинь л хүлээж авна.

## ТАВАН САХИЛ

*1. Аливаа амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ.**

*2. Үнэн бус зүйл ярихыг цээрлэнэ.*

*3. Өөрийн бус юмыг авахыг цээрлэнэ.*

*4. Бэлгийн зүй бус харилцааг цээрлэнэ.*

*5. Согтууруулах, мансууруулах бодис болон хорт зүйл хэрэглэхийг цээрлэнэ. ***

**Энэ сахил нь веган хоолны дэглэмийг хатуу мөрдөхийг шаардана. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, шувууны мах, өндөг (өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, жигнэмэг, зайрмаг) гэх мэт амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.*

***Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи, тамхи, хар тамхи, мөрийтэй тоглоом, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг, уран зохиол, цахим тоглоом тоглох зэрэг аливаа хортой зүйлээс зайлсхийх явдал багтана.*

*Авшиг бол үнэндээ авшиг  биш юм... та ердөө л энд ирээд, өөртөө туслахад тань намайг туслахыг зөвшөөрч буй юм. Би таныг шавь болгох гэж энд ирсэн юм биш ... Би таныг Их Багш болоход туслахаар ирсэн юм."*

*~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*

*"Мэдээж яаж бясалгахыг хүн бүхэн мэднэ. Гол нь  буруу зүйл дээр л бясалгаад байдаг. Зарим хүн хөөрхөн бүсгүйчүүд, зарим нь мөнгө, зарим нь ажил бизнесээ бясалгадаг. Нэгэн үзүүрт сэтгэлээр, хамаг сэтгэлээсээ нэг зүйл дээр анхаарлаа маш их төвлөрүүлэх бүр нь бясалгал юм. Тэгвэл би анхаарлаа зөвхөн дотоод Хүч, өршөөл нигүүсэл, хайр энэрэл, Бурханы өршөөнгүй чанар дээр л тавьдаг, энэ л миний бясалгал."*

*~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*

*"Авшиг гэдэг нь шинэ зам мөрд орж шинэ амьдрал эхлэх гэсэн утгатай. Энэ нь Их Багш таныг Гэгээнтнүүдийн хүрээлэлд багтах төрөлтөн хэмээн хүлээн зөвшөөрсөн гэсэн утгатай. Ингээд та жирийн л нэг төрөлтөн байхаа больж, өсөж дэвшсэн байх болно. Эртний цаг үед үүнийг "Баптизм" эсвэл "Их Багшийн авралд багтах" хэмээн нэрлэж байжээ."*

*~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*

# ҮГИЙН ХЭЛХЭЭС

*Үгсийг хуудасны дугаар биш асуултын дугаараар жагсаав.*

**А**
Аврагдах – Чөлөөлөлт гэдгийг үз
Аврагч /Messiah - 179
Авшиг - 5, 23, 69, 71, 97, 129, 130, 142, 160, 172, 174,202, 203, 254
Авшиг хүртэх насны хязгаар - 38, 69, 122
Авшиг, шаардлагууд - 5, 38, 69, 101, 122, 156, 297, 308, 321
Агаарт хөвөх - 19
Агшин зуурын гэгээрэл - 88, 142, 254
Адислал - 11, 51, 131, 227
Айдас - 34, 329
Аз жаргал - 4, 141, 144, 180, 204, 217
Аллага - 27, 40, 55, 58, 104, 109, 110, 133, 147, 152, 164, 183, 184, 245, 291, 292, 333, 364
Амбиц - Би үзэл ба Шунал гэдгийг үз
Аминч үзэл - 195
Амитаба буюу Авида бурхан - 204, 275, 278
Амьдралын зорилго - 15, 41, 319
Аниргүй дамжуулалт - Авших өгөх гэдгийг үз
Амьдралын асуудлууд - 64, 269
Амьсгаа - 27,109,184,277
Амьтад - 2, 32, 42, 58, 70, 78, 100, 124, 166, 183, 333
Амиа хорлох - 32, 95
Ануттара-Самяак-Самбудда/Хамгийн Дээдийн Дээд - 298
Арван сахил - 147, 156, Таван сахил гэдгийг үз
Ариун Мария - 157
Арьяабал/Гуан Инь Бодьсадва - 135, 268, 275, 350, 352
Арьяабал/Гуан Инь арга - 20, 22, 29, 33, 63, 68, 84, 169, 173, 183, 210, 242, 246, 253, 268, 295, 352
Арьяабалын арга ба харьцуулалт - 252, 267, 277
Архи - 5, 115, 147
Астрал аялал - 220
Аялгууны урсгал - 130, 132, Дотоод аялгуу гэдгийг үз

**Б**
Бадамлянхуа Судар - 7
Баптизм хүртэх - 25, 203
Баптист Жон - 105, 203
Бардам - 144, 179
Бахей шашин - 343
Би - Би үзэл
Би үзэл, Хүсэл шунал гэдгийг үз
Би үзэл - 8, 34, 73
Библи - 163, 198, 372
Бие хамгаалах урлаг - 55
Биеэ тоох - 236, Би үзэл гэдгийг үз
Биеэс гарах үзэгдэл - Астрал аялал гэдгийг үз
Билгийн мэлмий - Дотоод нүд гэдгийг үз
Билгийн нүд - Дотоод нүд

Билиг ухаан - 75, 136
Билгийн чих - Дотоод чих
Бон шашин - 77
Будда - 3, 32, 56, 77, 78, 97, 105, 114, 164, 208, 251,253, 272, 281, 284, 300, 317
Буддагийн шашин - Багшийг үз
Буддизм - 3Өвөг дээдсийн шүтлэг - 349, 365
Бурханы орон - 78
Бурхан чанар - 32, 68, 251, 257
Бурханы магтуу / Маани- 26, 135, 315, 331
Бурхан - 68, 157, 190, 251, 281
Бурхан - 298, 379
Бурханы хүч чадал -200
Бурхан /Их Багш/Буддатай холбогдох - 7, 53, 63, 142, 148, 153, 180, 199, 202, 267, 289
Бурханы хүч - 33, 36, 68, 136, 195, 251, 263
Бурханы адислал – Адислал гэдгийг үз
Бурханаас тусгаарлагдах - 53, 54
Бурханы хайр - 143, 195
Бурханы ивээл - 156, 184
Буян - 37, 83, 155,185, 216, 290
Бүтээл - 273, 301
Бэлгийн харилцаа - 96, 124, 149, 211, 353
Бэлгийн харилцаа, гэрлэхийн өмнөх - 119
Бясалгал - 36, 46, 48, 75, 109, 174, 180, 199, 241, 242, 246, 249, 271, 276, 277, 279, 293, 302, 303, 304, 305, 306, 307, 310, 311, 315, 328, 329, 341
Бясалгалын өдрийн тэмдэглэл - 35

**Г**
Гайхамшиг - 19, 50, 239
Ганди - 13
Гүрү - 1, 65
Гүрү Нанак- 131
Гэгээнтэн - 300
Гэгээрэл - 32, 58, 60, 67, 74, 75, 126, 145, 156, 176,201, 207, 227, 243, 250, 294, 334, 366
Гэр бүл - 50, 221
Гэрлэлт - 112, 149, 211, 233, 247
Гэрийн тэжээвэр амьтан - 87, 320, Амьтан гэдгийг үз
Гэрэл - 1, 50, 71, 176

**Д**
Далдын хүч - 43
Дамжуулах /уламжлах - 22, 29, 142, 175
Дандар йог - 72
Дао - 127, 128
Дао Чи Чан - 231
Даоизм - Дахин төрөл авах - 6, 16, 107, 108, 150, 160, 173, 192, 214,218, 227, 229, 232, 248
Даруу - 236, 239
Диваажин - 188
Дотоодын Их багш - 144, 159, 179, 190
Дотоод чих - 1, 60
Дотоод нүд - 1, 244
Дотоодын Гэрэл - 22, 29, 32, 132, 181,253
Дотоодын хүч - Бурханы хүч гэдгийг үз
Дотоодын Аялгуу - 1, 22, 29, 30, 32, 58, 132, 181, 210, 253
Дулааны урсгал ба Аялгууны урсгал - 130
Дүрслэл - 162, 293
Дэлхийн хүн ам - 70, 351
Дэлхийн төгсгөл - 182, 191, 219

**Е**
Еврейчүүдийн Библи - 179
Есүс Христ - 7, 21, 25, 32, 56, 97, 104, 105, 132, 146, 147, 161, 164, 177, 178, 179, 208, 348

**Ё**
Ёс зүй - Буяныг үз
**Ж**
Жинхэнэ Багш - Жинхэнэ Их Багш гэдгийг үз
Жинхэнэ Би - 32, 36, 60, 76

**З**
Залбирах - 135, 170, 245, 264, 286, 305
Зовлон - 33, 141, 171, 177, 255
Зовлон, хүн төрөлхтний - 171, 186, 191, 260, 379
Зугаа цэнгэл - 96, 102, 103, 205
Зүүд - 120, 344
Зэн - 32

**И**
Их Багш - Амьд Будда болох- 198, 285
Их Багш, амьд сэрүүн - 72, 97, 146, 313
Их Багшийн амьдрал - 114, 144, 186, 240, 280, 325
Их Багшийн зорилго - 31, 97, 125, 145, 177, 189, 213, 227, 285
Их Багш, гэгээрсэн - 66, 91, 266, 280
Их Багш, жинхэнэ - 1, 72, 76, 189, 224, 266, 287, 316
Их багш, нэгээс их - 59, 113, 241
Их Багшийн хайр - 195, 196
Их Багшийн хувилгаан бие - 224
Их Багшийн хүч - 50, 367, 375
Их Багшийн сургаал - 261, 262, 323, 376, 378, 379
Их Багш, эрт цагийн - 72, 125, 151, 231, 313
Ид шидийн хүч - 81, 125, 299, 300
Итгэл үнэмшил, үл зохицол - 185, 7, 77, 104, 114, 275, 288, 357

**Й**
Йог - 130
**К**
Католик шашин - 7, 14
Кришна - 151, 157
Кундалин - 226

**Л**
Лам - 89, 114, 308
Лус - 265, 286
Лууз - 190

**М**
Мартин Лютер Кинг - 13
Мансууруулах бодис - 5, 197, 209
Мах идэх - 77, 78, 103, 104, 118, 121, 133, 147, 164, 166, 208, 222, 272, 283, 296, 359
Мөнх нас - 4
Мөнхийн амьдрал - 62, 158
Мөргөх / залбирах - 134, 144, 313
Мөрийтэй тоглоом - 5,37
Мухаммед - 151, 157, 261
Мэдрэлийн өвчин - 18, 49, 180

Мял богд - 178

**Н**
Найдвар - 207
Нирваан - 126, 145, 319, 336
Нүгэл - 125, 184, 216, 333

**О**
Очироор огтлогч судар- 253

**Ө**
Өвчин - 121, 166, 205, 222, 322
Өгөөмөр хайр - Бурханы хайр гэдгийг үз
Өмнөх төрөл - Дахин төрөх гэдгийг үз
Өнгө - 90, 237
Өндөг - 278
Өөд болоочтой харьцах - 223
Өөрийгөө хамгаалах - 41
Өршөөл - 234

**С**
Садар самуун - 119
Сайн ба муу/зөв ба буруу - 37
Сай Баба - 360
Самади - 93, 94, 212, 226, 249, 270
Сармис - Сонгины төрөл
Сатан - Чөтгөрийг бас үз
Сатори /мөн чанарыг ухаарах/ - 213, Самади гэдгийг үз
Сахил - Таван сахилыг үз
Сахиусан тэнгэрийн элч - 70, 232
Сонгино - 57, 326
Сократ/Платон - 157
Сөрөг хүч - 71, 79, 80, 200, 263
Сөрөг бодол/ хэлбэлзэл - 35, 171, 200
Судар - 67, 185, 198
Сумо бөх - 52
Сурангама судар - 78, 272, 296
Сүнс - 17,78,106,232,265, 333,370
Сэтгэл - 74, 128, 304
Сэтгэл мэдрэлийн эмч - 49

**Т**
Таван сахил - 37, 107, 118, 156, 193, 252, 274
Там - 155, 177, 200
Тамхи - Хар тамхи 5, 197, 209
Татагата - 97, 300
Туслах бусдад - 136
Түвд - 73, 77, 78, 162

**У**
Удам - 231
Уй гашуу - 24
Ургамал хоолтон - 40, 42, 55, 78, 100, 103, 104, 112, 121, 147, 166, 170, 208, 225, 259, 272, 278, 295, 302, 356, 360, 361
Уураг - 121, 225
Учир шалтгаан ба холбоо хамаарал 117
Учир шалтгаан ба үр дагавар - Үйлийн үр гэдгийг үз 116

**Ү**

Үг –Дотоодын аялгуу гэдгийг үз
Үйлийн үр - 6, 55, 83, 84, 108, 116, 125, 138, 173, 184, 187,229, 233, 244
Үйлийн үрийн цэвэрлэгээ - 27, 40, 55, 58, 84, 109, 177, 184,187, 277, 333
Үнэнч сэтгэл - 238
Үхэл - 30, 62, 123, 155, 188
Үхэл, амьдралын хязгаарыг давах - 30
Үхлийн дараах амьдрал - 82, 188, 318, 336, 337
Үхлийн ирмэгт очих - 30

**Х**

Хаа сайгүй оршигч - 61, 189, 224, 294
Хамтын бясалгал - 126
Хайр- 99, 143, 149, 195, 211, 269
Харанхуйн хүч - see Сөрөг хүч гэдгийг үз
Харах - 330
Хий юм үзэгдэж сонсогдох - 120
Хонсим бодьсад - Гуан Инь Бодисадва гэдгийг үз
Хувраг – Түвд гэдгийг үз
Хувь төөрөг- 114, 137, 173
Христийн шашин – Багш гэдгийг үз
Христосын шашинтан - 7, 39
Ховсдуулах - 270
Хувилгаан бие - 19, 300 Биеийн илрэл гэдгийг үз
Худал хэлэх - 309
Хулгай хийх - 28
Хурмаст тэнгэр /ether, Хятадаар Chi/ - 47
Хүлэгдэх- 206, 253
Хүрэх түвшин - 214, 248, 285
Хүсэл - 144, 204
Хүсэл тачаал - 57, 256
Хүүхдүүд - 107, 123, 228, 229
Хэлбэлзэл – Дотоод аялгуу гэдгийг үз

**Ц**

Цагаан ахан дүүгийн барилдлага - 154

**Ч**

Чакра - 130
Чи Кун - 340
Чод йог - 73
Чөлөөлөлт - 30, 56, 150, 221, 250, 337
Чөлөөлөгдөх - Чөлөөлөлт гэдгийг үз
Чөлөөт хүсэл - 150
Чөтгөр - 19, 31, 45, 98,200, 290

**Ш**

Шагжамуни Будда - 78, 275, 279 Будда гэдгийг үз
Шашин - 25, 52, 247, 261, 274, 282, 297, 312, 314, 342
Шашингүйн үзэл - 148
Шашны зан үйл - 72, 77, 162, 315, 365
Шаналах – Зовлонг үз
Шинжлэх ухаан - 47, 165
Шунал - Мэдрэхүйн таашаал гэдгийг үз
Шунал- 235

**С**

Сэрэлт – Гэгээрлийг үз
Сэтгэл гутрал - 180

**Э**

Эдгэрэх - 222, 322
Энэрэн нигүүлсэх - 42, 166, 322
Энх тайван - 183
Эрлэг – Чөтгөр гэдгийг үз
Эрэгтэй, эмэгтэй хүн - 204, 230, 317
Эссенес - 104, 161

*Бид Алтан Эринд хөл тавьж байна, тиймээс бид өөрчлөгдөх хэрэгтэй болжээ. Гэгээнтэн иим байх хэрэгтэй гэсэн тэр бүх хуучны, хэрэгцээгүй үзэл ойлголтоо орхиж хаях хэрэгтэй байна; бид хар бараан бодол, өөрийн болоод дэлхийн тухай сөрөг таамаглалуудаа орхих хэрэгтэй.*
*Ямар нэгэн юм хий!*

*(“Бид Алтан Эринд хөл тавьж байна” айлдварын эшлэл)*
*~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*

*Бид юу л бодно түүгээрээ энэ дэлхийг илүү дээр болгодог, наанадаж л өөрийнхөө бас хөршийнхөө төлөө илүү тав тухтай газар болгож, бусадтай хуваалцаж болно. Хуваалцахаас эхэл, тэгвэл бид өөртөө нарийн өөрчлөлт гарахыг мэдэрнэ – бидний ухамсарт илүү их хайр урсан орж ирнэ.*

*(“Бид Алтан Эринд хөл тавьж байна” айлдварын эшлэл)*
*~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*

*Бид орчлонгийн нууцыг танин мэдсэний дараа, Диваажингийн бүхий л эрдэнэсийг эзэмшдэг болчихоороо өөр юу ч хүсэхээ больдог. Бид дотроосоо жаргалтай болдог; юмс ирэх ёстой бол ирдэг. Бид хүүхэд мэт болдог. Бид шунан хүсэхгүй, энэ хорвоогийн шунал хүсэл зүрх сэтгэлийг шархлуулахаа болино, бидэнд хяналт тогтоохоо болино. Энэ бол гэгээрсэн байхын давуу тал юм.*

*(“Сүнслэг бясалгал дадуулах нь манай Дэлхийг улам бүр соёл иргэншилтэй болгоно” айлдварын эшлэл.)*
*~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*

# НОМ ХЭВЛЭЛ

## Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн

## оюун санааны сургаал айлдварын номууд

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр**
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекцийн эмхтгэл. Англи (1-5), Ау Лак (1-15), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-10), Португал (1-2), Польш (1-2), Солонгос (1-11), Тай, Төвд (1), Унгар (1), Финн (1), Франц (1-2), Хятад (1- 10), Швед (1), Япон (1-4) хэлээр.

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт**
Их Багшийн лекцийн асуулт хариултын эмхтгэл. Англи (1-2), Ау Лак (1-4), Болгар, Герман, Индонез (1-3), Монгол (1-2), Орос (1), Португал, Польш, Солонгос (1-4), Унгар, Франц, Хятад (1-3), Чех, Япон хэлээр.

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - 1993 онд Дэлхийг тойрон ном айлдсан аялал**
Тусгай хэвлэл: Их Багш Чин Хайн 1993 оны Дэлхий даяар ном тайлах аяллын лекцийн 6 цуврал эмхтгэл. Англи, Хятад хэлээр.

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - "Долоон өдрийн даяан" тусгай хэвлэл**
1992 онд Их Багш Формосагийн Сан Ди Мунд хийсэн долоон өдрийн даяаны лекцийн эмхтгэл. Англи, Ау Лак хэлээр.

**Багш шавийн хоорондын захидал**
Англи (1), Ау Лак (1-2), Испани (1), Хятад (1-3) хэлээр.

**Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд**
Ау Лак (1-2), Хятад (1-2)

**Их Багшийн ярьсан үлгэр түүх**
Англи, Ау Лак, Испани, Монгол, Солонгос, Тай, Хятад, Япон хэлээр.

**Амьдралаа солонгоруулъя**
Их Багшийн ном сургаалын эмхтгэл Англи, Монгол, Хятад хэлээр.

**Бурхан бүхнийг зохицуулдаг - Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд**
Англи, Ау Лак, Солонгос, Франц, Хятад, Япон хэлээр

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч Хошигнол-Таны Гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!**
Англи, Хятад хэлээр.

**Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд**
Англи, Ау Лак, Монгол, Хятад хэлээр

**Эзэн Бурхантай шууд холбогдохуй – Энх тайванд хүрэх зам**
Их Багш Чин Хайн 1999 оны Европ даяар ном тайлах аяллын илтгэлийн эмхтгэл. Ау Лак, Англи, Хятад хэлээр

**Бурханых ба хүмүүсийн тухай - Библийн үлгэрүүдээс**
Энэхүү тусгай эмхэтгэлд Их Багшийн янз бүрийн тохиолдлуудад дахин давтагдашгүй байдлаар хэлсэн Библийн арван гурван өгүүллэг багтсан. Англи, Хятад хэлээр

**Эрүүл мэндээ ухаарахуй – Жам ёсны, зөв амьдралын хэв маягт эргэн орохуй**
Англи, Ау Лак, Монгол, Хятад хэлээр

**Гэрт чинь хүргэж өгөхөөр би ирлээ**
Их Багш айлдсан сүнслэг сургаалын эмхэтгэл. Англи, Араб, Ау Лак, Болгар, Герман, Грек, Индонез, Итали, Испани, Солонгос, Монгол, Орос, Польш, Румын, Турк, Унгар, Франц, Хятад, Чек хэлээр

**Онч мэргэн үгс I**
Хятад, Англи болон Ау Лак/Англи/ Хятад, Испани/Португали, Франц/Герман, Япон/Англи, Солонгос/Англи хос хэлээр гарсан эмхэтгэл

**Онч мэргэн үгс II**
Англи, Хятад хэлээр.

**Тэнгэрлэг зоог (1): Олон улсын ургамал хоолны гал тогоо**
Авшигтан бясалгагч нарын санал болгосон дэлхийн өнцөг булан бүрийн амтат хоолнуудын цуглуулга.  Ау Лак, Япон болон Англи/Хятад хос хэл дээрх хэвлэл.

**Тэнгэрлэг зоог (2): Олон улсын ургамал хоолны гал тогоо**
Гэрийн хоолны амтат сонголт. Англи/Хятад хэл дээр нэгтгэсэн хэвлэл.

**Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй**
Калифорнийн Лос Анжелес хотод зохиогдсон хандивын концертонд тоглогдсон хөгжмийн бүтээлүүд ба ярилцлагуудын эмхтгэл. Англи/Ау Лак/ Хятад хос хэл дээр нэгтгэсэн.

## Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог
Англи ба Хятад хэл дээр

## S.M. Тэнгэрийн хувцас (6)
Англи ба Хятад хэл дээр унших боломжтой.

## Миний амьдрал дахь нохoд (1-2)
500 хуудастай энэхүү 2 боть бүхий багц номонд Их Багш Өөрийн нохой анд нөхдийн бодит домог түүхүүдийг гайхалтай сайхан өгүүлжээ. Англи (нэг боть), Ау Лак (нэг боть), Герман, Испани, Монгол, Польш, Солонгос, Хятад, Япон хэл дээр унших боломжтой.

## Шувууд миний амьдралд
Энэхүү үзэсгэлэнтэй зурагтай, бодит түүх өгүүлсэн номонд Их Багш бидэнд амьтдын дотоод ертөнцөд нэвтрэх нууцыг дэлгэжээ. Англи, Араб, Ау Лак, Герман, Индонез, Монгол, Орос, Солонгос, Франц, Хятад хэл дээр унших боломжтой.

## Эрхэм ариун амьтад
Их Багш Өөрөө гэрэл зургуудыг буулгаж, зохиомжилсон энэхүү ном тансаг яруу шүлэг найргууд ба үзэсгэлэнтэй зургуудаар арвин юм. Энэхүү зурагт ном дахь түүхүүдээр  Их Багшийн нуурын эрэг дээрх нээлтүүдийнхээ тухай өгүүлж, амьтан анд нөхдийн төрөлхийн эрхэм ариун чанаруудыг бидэнд илчилж өгсөн  байна. Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад хэл дээр унших боломжтой.

## Диваажингийн Урлаг
*Диваажингийн урлаг* бол Зохиолч нь Үнэн, Буян, Диваажингийн Үзэсгэлэнгийн тусгал илэрхийллийг сүнслэг үүднээс тайлбарладаг онцгой гайхамшигтай боть ном юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн хязгааргүй ертөнцөд уригдаж, тэнгэрлэг хөг хэмнэлээр өргөгдөн дэвших уншигч бүхэн яруу найрагчийн гүн сэтгэл хөдлөл, уран зураачийн нарийн мэдрэмж, загвар зохион бүтээгчийн өвөрмөц санаа, хөгжимчний оргилуун зүрх сэтгэлийг мэдэрч, сэтгэлийн утас нь хөндөгдөх болно. Уншигч хүмүүн юу юунаас илүүтэй  гол нь оюун санааны аугаа их багшийн билиг ухаан, энэрэн нигүүлсэгч сэтгэлтэй танилцан адислагддаг билээ.
Англи, Монгол, Хятад хэл дээр унших боломжтой.

## Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган хүнс
Англи, Ау Лак, Голланд, Норвеги, Индонез, Испани, Монгол, Орос, Португал, Польш, Румын, Солонгос, Тайланд, Унгар, Франц, Хятад, Швед, Япон,

## Амьдрал болоод ухамсрын тухай бодрол
Доктор Жанезын бичсэн ном, Хятад хэл дээр

## Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
## Шүлэг яруу найргийн цоморлог

**Чимээгүй нулимс**
Ау Лак, Англи, Герман, Филлипин, Франц, Монгол, Солонгос, Португал, Испани, Хятад хэлээр

**Вуу Зуу шүлгүүд**
Ау Лак, Хятад, Англи хэлээр

**Эрвээхэйн мөрөөдөл**
Ау Лак, Хятад, Англи хэлээр

**Өмнөх амьдралын зам мөр**
Ау Лак, Хятад, Англи хэлээр

**Хуучны цаг үе**
Ау Лак, Хятад, Англи хэлээр

**Хайрга ба Алт**
Ау Лак, Хятад, Англи хэлээр

**Мартагдсан дурсамж**
Ау Лак, Хятад, Англи хэлээр

**Эртний хайр**
Их Багшийн яруу найргийн ном. Англи, Ау Лак, Франц, Испани, Монгол, Португал, Солонгос, Хятад хэлээр

**Жинхэнэ хайр**
Хятад, Англи хэлээр (MP4)

**Аниргүйхэн нулимсыг хайрлахуй**
Хятад, Англи хэлээр, (MP3, DVD, MP4)

**Урьд төрлийн зам мөр**
Ау Лак хэлээр 1-3 (MP3)

**Хайрын домгийн зам**
Ау Лак хэлээр 1-3 (MP3)

**Цаг хугацаанаас ангид**
Ау Лак хэлээр 1-3 (MP3)

**Анхилам сайхны мэдрэмж**
Ау Лак хэлээр (MP3, DVD, MP4)

**Энэ өдөр, тэр өдөр**
Ау Лак хэлээр (MP3)

**Шөнийн зүүд**
Ау Лак хэлээр (MP3, DVD, MP4)

**T-L-C, гуйя**
Ау Лак хэлээр (MP3)

**Үүрд хайрлаарай**
Ау Лак хэлээр (MP3)

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн өөрөө зохиож дуулсан дуу**
Англи, Ау Лак, Хятад хэлээр (MP3, DVD, MP4)

**Хайрын дуу**
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дуулсан мөнхийн дуунууд
Англи ба Ау Лак хэлээр (MP4)

**Эрдэнийн хэлхээ**
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Ау Лак хэлээр дуулсан дуу шүлгүүд, Ау Лакийн алдарт яруу найрагчдын бичсэн яруу найргууд (MP3, DVD, MP4)

**Алтан бадамлянхуа**
Яруу наргийн дууллууд Ау Лак хэлээр (MP3, DVD, MP4)

**Эртний хайр**
Ау Лак хэлээр уншсан яруу найраг (MP3, DVD, MP4)

## DVD, MP3, MP4

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, хөгжим, концертын DVD, MP3, MP4 хэлбрээр Англи, Араб, Армен, Ау Лак, Болгар, Герман, Голланд, Грек, Дани, Еврей, Зулу, Индонез, Испани, Итали, Камбож, Кантон, Малай, Мандарин, Монгол, Непал, Норвеги, Орос, Перс, Польш, Португал, Румын, Сингал, Словени, Солонгос, Тай, Турк, Унгар, Филиппин, Финлянд, Франц, Хорват, Хятад, Чех, Швед, Япон хэлээр үзэж танилцах боломжтой. Дэлгэрэнгүй каталогийг хүсэлт гарган авч болно. Бүх лавлагааг шууд авахыг урьж байна. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлүүдийн жагсаалт болон сүүлийн үеийн ном хэвлэлийн агуулгын хураангуйг татаж авахын тулд манай номын дэлгүүрийн вэб хуудсанд зочилно уу:

http://www.smchbooks.com/
http://www.theCelestialShop.com
Eden Rules: http://www.edenrules.com

Дээр танилцуулсан видео, аудио, мэдээний сэтгүүл болон цахим номуудыг Eden Rule веб сайтаас үнэ төлбөргүй татан авч болно:
http://edenrules.com/

http://edenrules.com гэсэн хаягтай Edenrules веб сайт нь хүмүүний эрхэм дээд ухамсар болон оюун санааг дэвшүүлэн хөгжүүлэхэд зориулагджээ Энэ сайтаас та лекц яриа, видео-аудио бичлэг, мэдээний сэтгүүл болон цахим ном зохиол, түүнчлэн манай эрин үеийн оюун санааны аугаа удирдагч Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бүтээл туурвилыг олж үзнэ. Сайт дээрх бүх материалыг үнэ төлбөргүйгээр татаж авч болно.

Сайтын агуулга нь хүмүүний билиг ухаан өргөжин тэлэхэд туслахын зэрэгцээ гайхалтай сайхан эрхэм дээд Алтан Эрин лүү хамтдаа урагшилж буй энэ үед биднийг Орчлонгийн нууцыг улам илүү ухаарч ойлгоход ойртуулж өгнө гэж бид найдаж байна.

## Агшин зуур Гэгээрэхийн түлхүүр Үлгэр дэвтрийг үнэ төлбөргүй татаж авах хаяг:

(80 хэлээр)
http://sb.godsdirectcontact.net/
http://www.direkter-kontakt-mit-gott.org/booklet/

## Арьяабалын бясалгалын WWW сайтууд

Бурхантай шууд холбогдохуй – Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн дэлхий дахины Интернэт хаяг:

http://www.Godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm

Энэ порталд олон хэлээр дээрх "Гуан Инь" веб сайтын холбоосуудын жагсаалт, мөн түүнчлэн *"Урлагийн Ертөнцөөр Аялахуй"* телевизийн хөтөлбөрийг бүтэн хоногийн турш үзэж болно.

Та мөн "*Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр Үлгэр дэвтэр*"*-ийг* олон хэл дээр татаж авах, эсвэл *"The Supreme Master Ching Hai News*" мэдээний сэтгүүлийг цахим ном эсвэл хэвлэхэд зориулсан хэлбрээр татаж авах буюу захиалах, эсвэл зүгээр л цахим сайтын агуулгыг үзэж сонирхох боломжтой.

# БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг
Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса, БНХУ (36899)
Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе, Калифорни муж, 95173-0247, АНУ

Суприм Мастер Телевиз
И-мэйл: peace@SupremeMasterTV.com
Утас: 1-626-444-4385
Факс: 1-626-444-4386
http://www.suprememastertv.com

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани
И-мэйл: smchbooks@Godsdirectcontact.org
Утас: 886-2-23759688 / Факс: 886-2-23757689
http://www.smchbooks.com

Номын хэлтэс:
И-мэйл: divine@Godsdirectcontact.org
(Та Их Багшийн номыг олон хэл дээр орчуулах ажилд оролцож болно.)

Мэдээний баг:
И-мэйл: lovenews@godsdirectcontact.org

Асуулт хариултын баг:
И-мэйл: lovewish@godsdirectcontact.org

Онлайн дэлгүүр
Celestial Shop: http://www.theCelestialShop.com

S.M. Celestial Co., Ltd:
И-мэйл: smclothes123@gmail.com;  Vegan999@@hotmail.com
Веб сайт: http://www.smcelestial.com, http://www.sm-celestial.com
Утас: 886-3-4601391 / Факс: 886-3-4602857

"Loving Hut" Олон улсын Веган хоолны Сүлжээ ресторан
И-мэйл: info@lovinghut.com
Утас: 886-3-4683345
Факс: 886-3-4681581
Веб сайт: http://www.lovinghut.com/tw/
http://www.lovingfood.com.tw/

**АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР**
***АСУУЛТ ХАРИУЛТ 1***

**The Key of Immediate Enlightenment**
***Questions & Answers 1***

**Зохиогч:** Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

**Галиг бичиг:** Формоса дахь Ном айлдварыг галиг бичгийн баг

**Хянан толилуулсан:** Мэдээний баг, Ном хэвлэлийн баг

**Загвар, эх бэлтгэл:** Номын хэлтэс

**Хэвлэсэн газар:** Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Хэвлэлийн компани

БНХУ, Формоса, Тайбэй хот,

Жүнзэн дүүргийн баруун замын 1-р хэсэг, 72-8-16

Утас: 886-2-23759688 / Факс: 886-2-23757689

И-мэйл: smchbooks@Godsdirectcontact.org

http://www.smchbooks.com

**Анхны хэвлэл:** 1993 оны 11 дүгээр сар

**Хоёр дахь хэвлэл:** 1993 оны 12 дугаар сар

**Гурав дахь хэвлэл:** 2009 оны 9 дүгээр сар

**Анхны цахим ном:** 2016 оны 3 дугаар сар

**Монгол хэлнээ орчуулсан:** 2023 оны 4 дүгээр сар

**Монгол хэл дээр цахим номыг байршуулсан хаяг:**
http://www.gegeerel.mn/

ISBN 978-986-6895-43-2

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1993~2016**
Зохиогчийн бүх эрх хамгаалагдсан.

Энэхүү номын агуулгыг хэвлэлийн компаниас зөвшөөрөл авсны дараа дахин хэвлэж болно.

# Өөрөөр амьдарцгаая




**Амьдралаа шинэчилцгээе**
**Зүрх сэтгэлээ ариусгацгаая**
**Хоол хүнсээ өөрчилцгөөе**
♥~~~~~~~♥
**Ахин амь хөнөөхгүйгээр**
**Эрүүл, энэрэнгүй амьдарцгаая**




**Тэжээллэг бөгөөд амьтны амь таслаагүй хоол хүнсний жишээ:**

| Хүнсний бүтээгдэхүүн | Жинд эзлэх уургийн хэмжээ %-иар |
|---|---|
| Дүпү (шар буурцгийн бяслаг) | 16 % |
| Гурилаас гаргасан уураг буюу глутин | 70% |
| Эрдэнэ шиш | 13 % |
| Будаа | 8.6 % |
| Шар буурцаг, хүрэн буурцаг, ангаахай шош, сэвэг зарам г.м | 10 - 35 % |
| Бүйлс, хушга, кешью, хушны самар, ойн самар г.м | 14 - 30 % |
| Хулууны үр, гүнждийн үр, наран цэцгийн үр г.м | 18 - 24 % |

- Олон төрлийн амин дэмийн шахмал үрлүүд (мультивитамин) нь амин дэм, эрдэс бодис, хэт исэлдлийн эсрэг бодисын хангалттай сайн эх үүсвэр мөн.
- Жимс болон хүнсний ногоо нь амин дэм, эрдэс бодис, хэт исэлдлийн эсрэг бодисуудаар тун баялаг бөгөөд эрүүл саруул, урт удаан амьдралыг тэтгэгч сайн чанарын эслэгүүдийг агуулж байдаг.
- Өдөрт авах уургийн зөвлөмж: 50 гр (Дундаж насны хүнд).
- Ургамлын гаралтай кальци нь үхрийн сүүнийхээс илүү шингэц сайтай.

- **Дэлхий нийтэд заналхийлж буй шувууны ханиадны халдварт тархалтыг арилгах**
- **Үхрийн галзуу(BSE), гахайн өвчин (PMWS) гэх мэт өвчний аюулыг зайлуулах**
- **Энхрийлж өсгөсөн мал сүрэг, гэрийн тэжээвэр болон лусын амьтад, өдтөн жигүүртэн анд нөхдөө өдөр бүр тэрбум тэрбумаар нь хэрцгийлэн хорооож буй явдлаа эцэс болгохын төлөө**

**Ногоон хоолтон болох нь зөв мэргэн алхам юм.**

**Эрүүл мэндэд тустай**
**Эдийн засагт хэмнэлттэй**
**Байгаль орчинд ээлтэй**
**Энэрэл нигүүлсэлтэй**
**Амар амгалан**
**Ариун гэгээн сонголт**







**Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах веб сайтуудаар зочлоорой:**
**http://AL.Godsdirectcontact.org.tw/, http://www.gegeerel.mn/, http://www.vrg.org/**
**болон http://www.vegsource.com/ эсвэл энэ хаягаар захиа бичээрэй! AL@Godsdirectcontact.org**
**Лавлах утас: 11341896**

Энэ дэлхийд залран буй Төгс гэгээрсэн Их багшийг олж учрах хэцүү, жинхэнэ дээд номыг хүртэхэд бэрх гэдгийг үнэнийг эрж хайсан бидний бэрхшээлт аялалууд гүнзгий ухааруулсан юм. Арьяабалын бясалгалын арга нь эртний жинхэнэ багш нараас уламжлагдан ирсэн охь дээд номын дамжлага мөн учраас хүмүүний мөн чанарын билиг билгүүнийг сэрээж, үнэн номыг ухааруулж чадна. Энэхүү номын ёсоор бясалгаад бид хэмжээлшгүй их ач тусыг хүртсэн тул Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн олон оронд айлдсан дээдийн номын айлдваруудыг эмхтгэж, энэ төрөлдөө сансрын хүрднээс ангижрахыг хүсэж, жинхэнэ үнэн номыг хайж, үхэх ба төрөх, бясалгах, гэгээрэх, үнэн мэдлэгийн тухай асуултууддаа хариулт эрж буй хүмүүст туслахыг зорин энэхүү номыг өргөн барьж байна.